

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ "ЭКО-ЭРҮҮЛ ДҮҮРЭГ" ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
2021-2024 ОНЫ ДӨРВӨН ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр

Улаан баатар хот, Хан-Уул дүүрэг

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
НЭГ. ЭКО ДҮҮРЭГ – НОГООН ХӨГЖИЛ								
1.1. Ногоон байгууламж								
1.1.1 Нийтийн эзэмшлийн гудамж талбайд эко бичил цэцэрлэгт хүрээлэнг бий болгож иргэд олон нийт чөлөөт цагаа ая тухтай өнгөрөөх амралт зугаалгын бүсийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	Нийтийн эзэмшлийн талбайд бичил цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбай байгуулна.	Байгуулсан ногоон байгууламж тохижилт бүхий бичил цэцэрлэгт хүрээлэн	8 бичил цэцэрлэгт хүрээлэн, 168 тоглоомын талбай.	8-аас доошгүй бичил цэцэрлэгт хүрээлэн, 17-оос доошгүй тоглоомын талбай байгуулсан байна.	УТХО 1.2 НТХО 10,795.6 НОНХС 324.9 УБЗАА 360.0 ДТХО 9623.6 ДОНХС 699 ААНБ 5242	2021-2024 онд улс, нийслэл, дүүргийн төсөв хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 4 байршилд цэцэрлэгт хүрээлэн байгуулах, тохижилт, засвар шинэчлэлт хийх, 10 байршилд бичил цэцэрлэгт хүрээлэн, 38 байршилд тоглоомын талбай тохижилтын ажлыг хэрэгжүүлж хүртээмжийг нэмэгдүүлсэн. 2021 онд Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 14, 20-р хороо, дүүргийн төсвийн хөрөнгөөр 2, 9-р хороонд нийт 4 тохижилтын ажил ашиглалтад орсон Дүүргийн аж ахуйн нэгж байгууллагуудын хөрөнгө оруулалтаар 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт Туул голын эрэг дагуу 110 га талбайд "Мишээл байгаль орчин, танин мэдэхүйн ботаник хүрээлэн" байгуулагдаж, иргэдийн амарч, зугаалах бүсийн хүртээмж нэмэгдлээ. 2022 онд Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийн хөрөнгөөр 1, 2, 10, 11, 12, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 24-р хороодын нийт 14 байршилд тоглоомын талбайн тохижилтын ажил ашиглалтад авсан. Хувийн хэвшлийн 2.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 8-р хорооны нутаг дэвсгэрт 35 га талбайд "Олон улсын соёлын цэцэрлэгт хүрээлэн" байгуулах төслийн хүрээнд 3.47 га талбайд экспо талбай байгуулж, мод, зүлэг шинээр тарьж тохижуулсан. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 15 дугаар хороо Төв цэнгэлдэх хүрээлэн орчимд 18100 м.кв талбайг зүлэгжүүлж, шинээр 77 ширхэг нарс тарьж цэцэрлэгжүүлж, 5907 м.кв талбай бүхий авто зогсоолыг шинэчлэн 1074 м.кв талбайд тойрог замын болон амралтын талбайг бүрэн тохижуулсан. 2023 онд Тоглоомын талбай, тохижилтын ажил: Дүүргийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3, 5, 7, 10, 12, 13, 14, 18, 19, 20, 22-р хороодын нийт 12 байршилд тохижилтын ажил хэрэгжсэн. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 10, 12, 14-р хороонд 3 бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил, дүүргийн төсвийн хөрөнгөөр 1-р хорооны дүүргийн өндөрлөг орчмын засвар тохижилт, 8-р хорооны цэцэрлэгт хүрээлэнгийн засвар, 10-р хорооны 7-р байрны гадна талбайн бичил цэцэрлэгт хүрээлэнг засварлаж тус тус ашиглалтад оруулсан. 2024 онд Тоглоомын талбай: Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1, 3, 12, 14, 15, 19, 25-р хороодын нийт 8 байршилд тоглоомын талбай, тохижилтын ажил ашиглалтад орсон бол 15, 21-р хорооны нийт 4 байршилд хэрэгжих 2 төсөл арга хэмжээ он дамжин хэрэгжинэ. Бичил цэцэрлэгт хүрээлэн: Улсын төсвийн хөрөнгөөр 5 дугаар хорооны 41-р сургуулийн баруун талд, Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 24 дүгээр хорооны Вива сити хорооллын ард Туул гол дагуу талбай, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 1-р хорооны Эрэл хотхоны 38, 43-р байрны ард, 13-р хорооны 4 дүгээр хэсэг, 14-р хорооны 156-р бага сургууль, 300-р цэцэрлэгийн гадна талбай, дүүргийн төсвийн хөрөнгөөр 21-р хорооны цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, засвар, шинэчлэлтийн ажил нийт 6 байршил бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил хэрэгжиж дууссан бол Хан-Уул дүүргийн 22-р хороо Туул гол дагуух 5 га талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил он дамжин хэрэгжинэ.	100%
			Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд иргэд, аж ахуйн нэгж байгууллагын идэвх оролцоог нэмэгдүүлэх аян зохион байгуулна.			Зохион аян байгуулсан	"Манай хороо - Миний гудамж" аяныг зохион байгуулж ААН ахуйн нэгж байгууллагуудын оролцоотойгоор тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	"Манай хороо - Миний гудамж" аяныг зохион байгуулж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоотойгоор тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байна.

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
				чиглэлээр 29 байршилд тоглоомын талбай, 6 байршилд цэцэрлэгт хүрээлэн 7175м2 явган зам болон 1600м/урт дугуйн замыг хийж гүйцэтгэсэн.			7 байршилд тохижилт, ногоон байгууламж бүхий тоглоомын талбай, амралтын талбай, спорт талбай, 6 байршилд 3х3 сагсан бөмбөгийн талбай, 2 байршилд хөлбөмбөгийн талбай байгуулсан. Аяны нэгдсэн шалгаруулалтад "Шилдэг дүүрэг" номинацид дэд байр эзэлж, "Шилдэг хороо" номинацид 1-р хороо-тэргүүлж, 16-р хороо-тусгай байр тус тус эзэлсэн. 2023 онд Тусгай хэрэгцээний ногоон байгууламжийг 8.4 га талбайгаар нэмэгдүүлж, нийт 75424 ширхэг мод, бут, сөөгийг шинээр тарьж, 24192.8 м.кв сул шороон хөрс бүхий талбайг шинээр зүлэгжүүлж, 479620 ширхэг гоёл, чимэглэлийн цэцэг тарьж, 3 байршилд бичил цэцэрлэг, 9 байршилд иргэд олон нийтэд зориулсан тоглоомын талбай, амралтын талбай байгуулсан. 2024 онд Аяны хүрээнд нийт 206419 ширхэг мод, бут, сөөгийг шинээр тарьж, 18852 м.кв сул шороон хөрс бүхий талбайг зүлэгжүүлж, 478730 гоёл чимэглэлийн цэцэг тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн.	
	3	Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн ногоон байгууламжийг тоолж, бүртгэж мэдээллийн сан үүсгэж, баяжуулж ажиллана.	Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн мэдээллийн сан үүсгэж, ногоон байгууламжийг тоолж, бүртгэх ажлын хувь	-	Шинээр хийгдсэн ногоон байгууламжийг бүртгэлжүүлж, мэдээллийн сангийн баяжилтыг 95% -д хүргэнэ.	ДТХО 549.6	2021-2024 онд 282000 ширхэг мод, бут, сөөг, 260,869 м.кв зүлэгт талбай, 18959 урт метр ургамлан хашлагыг тоолж бүртгэлжүүлсэн. Ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалт дүүрэгт шилжсэнтэй холбогдуулан нутаг дэвсгэрийн ногоон байгууламжийн тооллого, бүртгэлийн мэдээллийн санг шинэчлэхээр "Говийн улиас" ХХК шалгарч, агаарын зургийг ашиглан ногоон байгууламжийн хил, заагийг дахин засварлаж, зураглах, ногоон байгууламжийн нэгж талбар тус бүрээр мэдээллийн сан үүсгэх ажилбар гүйцэтгэсэн. 2021 онд Дүүргийн нутаг дэвсгэрийн суурьшлын бүс газрын 0.9 хувь буюу 156.1 га талбайд ногоон байгууламж бүхий талбай эзэлж байсан бөгөөд 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн ногоон байгууламжийг ургамлын төрөл зүйлээр ангилан нарийвчлан судалж, тоолон бүртгэлжүүлж газарзүйн мэдээллийн системд суурилсан орон зайн цахим мэдээллийн сан үүсгэсэн. 2022 онд "Ногоон хот-Иргэний оролцоо" аяны хүрээнд тарьсан 260361 ширхэг мод, бут, сөөг бүртгэлжүүлсэн. 2023 онд Ногоон байгууламжийн хяналтын "Ногоон Агула" ТББ-тай хамтарч Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай гэрээтэй 9 байгууллага нийтийн эзэмшлийн 28 гудамж, талбайн ногоон байгууламжийн бүртгэл, тооллогоор 260,869 м.кв зүлэгт талбай, 21639 ширхэг мод, бут, 18959 урт метр ургамлан хашлагыг бүртгэсэн. 2024 онд Хот нийтийн аж ахуйн үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах, оновчтой хуваарилах ажлын хүрээнд ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалт дүүрэгт шилжсэнтэй холбогдуулан ногоон байгууламжийн тооллого, бүртгэлийн ажлыг зохион байгуулж, мэдээллийн санг шинэчлэхээр "Говийн улиас" ХХК шалгарч, агаарын зургийг ашиглан ногоон байгууламжийн хил, заагийг дахин засварлаж, зураглах, ногоон байгууламжийн нэгж талбар бүрээр мэдээллийн сан үүсгэх ажилбарыг гүйцэтгэж байна.	70%
1.1.2 Туул, Дунд голыг түшиглэн иргэд 4 улирлын турш амарч, зугаалах зориулалт бүхий тохилог орчныг бүрдүүлнэ.	4	Туул, дунд голын дагуу байршилд иргэдийн амарч, зугаалах бүс байгуулна.	Шинээр байгуулсан иргэдийн амарч, зугаалах бүсийн тоо	3 амралт зугаалгын бүс байгуулсан.	3-6 байршилд амралт зугаалгын бүс байгуулсан байна.	ДТХО 1,420.0 БХОЦ Зардал 257.2 Гадаадын хөрөнгө оруулалт 204.5 ААНБ 2,700.0	2021-2024 онд туул, дунд голын дагуух 2, 8, 13, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрийн нийт 4 байршилд дүүргийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар иргэд амарч сархилах зориулалт тохижилт бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлсэн бол 22 дугаар хороо туул голын дагуух 5 га талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил он дамжин хэрэгжинэ. 2021 онд 20 дугаар хороо Мишээл экспогоос Яармагийн гүүр хүртэл гүйлтийн болон дугуйн зам, гэрэлтүүлэг, амралтын талбай бүхий нийт 1.4 км урт эко зурвас байгуулан ашиглалтад оруулсан. Мөн аж ахуйн нэгж байгууллагуудын хөрөнгө оруулалтаар дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт Туул голын эрэг дагуу 110 га талбайд "Мишээл байгаль орчин, танин мэдэхүйн ботаник хүрээлэн"-г байгуулж, иргэдийн амарч, зугаалах бүс бий болгосон. 2022 онд Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт Дунд голын урд хэсэгт тохижилт хийж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт 3.47 га талбайд ОУ-ын Соёлын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт хийгдсэн. 2023 онд Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 13 дугаар хорооны 7 дугаар хэсэг Туул гол дагуу "Төгсөгчдийн төгөл"-ийн 1.2 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлын хүрээнд 1950 ширхэг суулгац, 299 ширхэг мод, бут, сөөг тарьсан. 2024 онд Хан-Уул дүүргийн 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт Туул гол дагуу эрсдэлтэй бүсээс 28 айл өрхийг нүүлгэн шилжүүлж, чөлөөлөгдсөн 5 га талбайд Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаатай 2023 онд санамж бичиг байгуулсаны дагуу цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын гүйцэтгэгчээр "Гарден сити" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Тус төсөл арга хэмжээ он дамжин хэрэгжинэ.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
1.1.3 Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд мод тарих, ногоон байгууламж байгуулахыг дэмжих, “Эко ногоон дүүрэг” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	5	“Эко ногоон дүүрэг” дэд хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжилт, үр дүнг тооцно.	Дэд хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжүүлсэн хувь	-	Хөтөлбөрийн хэрэгжилт 90 хувь.		2021-2024 онд “Эко ногоон дүүрэг” дэд хөтөлбөрийн хүрээнд 4 зорилт 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар 98 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Үүнд; Бүрэн хэрэгжсэн-13, Хэрэгжих шатанд (30%)-3, Хэрэгжээгүй-1 арга хэмжээ байна. 2021 онд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор 4 зорилт 17 арга хэмжээтэй “Эко ногоон дүүрэг” дэд хөтөлбөрийг батлуулсан. 2022 онд 4 зорилт 10 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 7 төсөл арга хэмжээ хэрэгжих шатанд, хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт 81.2 хувийн гүйцэтгэлтэй байна. 2023 онд 4 зорилт 17 арга хэмжээний хэрэгжилт 80 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн. Үүнд; Бүрэн хэрэгжсэн-13, Хэрэгжих шатанд (30%)-2, Хэрэгжээгүй-2 арга хэмжээ байна. 2024 онд Төсөв шийдэгдээгүйн улмаас Биокомбинат, Туул, Өлзийт хороодод нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг суурь судалгаанд үндэслэн боловсруулж, Бүс нутгийн газар ашиглалтыг сайжруулах 1 арга хэмжээ хэрэгжээгүй.	90%
	6	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоотойгоор “Бүх нийтээр мод тарих өдөр” арга хэмжээг зохион байгуулна.	Шинээр тарих бут, сөөг, мод, тоо	Бүх нийтээр мод тарих арга хэмжээг 5, 10 дугаар сард зохион байгуулж, 21,841 ш мод бут сөөг тарьсан.	Бүх нийтээр мод тарих 2 удаагийн арга хэмжээгээр 80,000-аас багагүй мод бут сөөг тарина.	УБЗАА 53.1 ДТ 1,090.6 БХОЦ Зардал 444.7 ААНБ 59.6	2021-2024 онд нийтийн эзэмшлийн гудамж, талбайд 113625, тусгай хэрэгцээнд 332766, хязгаарлагдмал хэрэгцээ буюу 5411 өрхийн хашаанд 50418, аж ахуйн нэгж байгууллага 148729, нийт 645538 ширхэг мод, бут, сөөг тарьж, 106330 м.кв сул шороон хөрс бүхий талбайг зүлэгжүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. Үүнд: 2021 онд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд 18306, тусгай хэрэгцээний 3144, хязгаарлагдмал хэрэгцээний буюу 566 өрхийн хашаанд 4250, аж ахуйн нэгж байгууллага 77634, нийт 103334 мод, бут, сөөг тарьж, 16944 м.кв сул шороон хөрс бүхий талбай зүлэгжүүлсэн. 2022 онд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд 50385, тусгай хэрэгцээний 153537, хязгаарлагдмал хэрэгцээний буюу 1300 өрхийн хашаанд 11143, аж ахуйн нэгж байгууллага 45296, нийт 260361 ширхэг мод, бут, сөөг тарьж, 46341.2 м.кв сул шороон хөрс бүхий талбай зүлэгжүүлсэн. 2023 онд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд 25645, тусгай хэрэгцээний 30169, хязгаарлагдмал хэрэгцээний буюу 1895 өрхийн хашаанд 18450, аж ахуйн нэгж байгууллага 1160, нийт 75424 ширхэг мод, бут, сөөг тарьж, 24192.8 м.кв сул шороон хөрс бүхий талбай зүлэгжүүлсэн. 2024 онд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд 19289, тусгай хэрэгцээний 145916, хязгаарлагдмал хэрэгцээний буюу 1650 өрхийн хашаанд 16575, аж ахуйн нэгж байгууллага 24639, нийт 206419 ширхэг мод, бут, сөөгийг шинээр тарьж, 18852 м.кв сул шороон хөрс бүхий талбайг зүлэгжүүлж, тоосжилтыг бууруулсан.	90%
	7	Цэцгийн үрсэлгээ хийх, нийтийн эзэмшлийн талбайд цэцгийн мандал байгуулна.	Үрслүүлсэн цэцэг, тоо	149,100 цэцгийн үрсэлгээг бойжуулж, нийтийн эзэмшлийн талбайг чимэглэсэн.	800,000-аас доошгүй цэцгийн үрсэлгээг бойжуулж, нийтийн эзэмшлийн талбайг чимэглэнэ.	УБЗАА 718.9 ДТХО 841.1 ДТ 70.0	2021-2024 онд давхардсан тоогоор 137 байршилд нийт 1616491 гоёл чимэглэлийн цэцэг тарьж, ногоон байгууламжийн өнгө үзэмжийг сэргээн иргэдийн амарч, салхлах ая тухтай орчныг бүрдүүлсэн. Үүнд; 2021 онд 21 хорооны гадна талбай, Шинэ Хан-Уул цэцэрлэгт хүрээлэн, Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэн зэрэг 32 байршилд 388,822 ширхэг цэцгийг тарьж, цэцгийн мандал байгуулсан. 2022 онд дүүргийн нутаг дэвсгэрийн 17 байршилд нийт 2805 мкв талбайд 267519 цэцэг тарьж, цэцгийн мандал байгуулсан бөгөөд нийслэлийн Хот тохижилтын газар ЧӨЧ-ны авто замын 5 бульварт 1800 ширхэг гоёл чимэглэлийн байцаан цэцэг, нийт 269319 ширхэг гоёл чимэглэлийн цэцэг тарьсан. 2023 онд дүүргийн нутаг дэвсгэрийн 28 байршлын 3993 м.кв талбайд 332,370 ширхэг цэцэг, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, ногоон байгууламжийн мэргэжлийн байгууллагуудтай хамтарч 7 байршилд 147,250 ширхэг цэцэг тарьж цэцгэн байгууламж хийсэн бөгөөд нийт 479620 гоёл чимэглэлийн цэцэг тарьсан. 2024 онд нөхөн тарилт хариуцсан 10 байгууллага нийтийн эзэмшлийн гудамж, талбайн 48 байршилд 478,730 гаруй цэцэг тарьж, усалгаа, арчлалт хамгаалалтыг тогтмол хуваарийн дагуу гүйцэтгэсэн.	100%
1.2. Агаар, орчны бохирдол								
1.2.1 Гэр хорооллын айл, өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангаж, агаарын бохирдлыг бууруулна.	8	Гэр хорооллын айл өрхүүдийг стандартын шаардлага хангасан түлшээр хангах борлуулалтын цэг, хангамжийн баазуудыг байгуулж, хэвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллана.	Байгуулсан хангамжийн бааз, тоо Байгуулсан борлуулалтын цэг, тоо	3 хангамжийн бааз, 57 борлуулалтын цэг байгуулсан.	1 хангамжийн бааз, 55-аас доошгүй борлуулалтын цэг ажиллуулна.	ДТХО 189.1 ДТ 2.0	2021-2024 онд 50 орчим борлуулалтын цэгээс дүүргийн гэр хорооллын 15300 орчим айл өрхийг 113226.85 тн сайжруулсан түлшээр хангасан. 2021 онд Дүүргийн 10-р хороо Морингийн даваанд байрладаг “Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан түлш савлах бааз байгуулан 60 борлуулалтын цэгээр дамжуулан 28,590.4 тн түлшээр гэр хорооллын айл өрхүүдийг хангасан. 2022 онд борлуулалтын 53 цэгээс нийт 32,147.3 тн сайжруулсан шахмал түлшээр айл өрхүүдийг хангаж, түлш нөөцлөх 7 агуулахад 11,120 тн сайжруулсан шахмал түлш нөөцөлсөн. 2023 онд борлуулалтын 50 цэгээс нийт 20899.15 тн сайжруулсан түлшээр айл өрхүүдийг ханган 215.85 тн түлшний үлдэгдэгтэй. 2024 онд 45 борлуулалтын цэгээр 15341 өрхийг 31590 тн сайжруулсан түлшээр хангасан. 10120 тн сайжруулсан түлш нөөцөлсөн.	90%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
1.2.2 Төрийн өмчийн халаалтын зуухнуудыг үе шаттайгаар төвлөрсөн дулаанд холбоно.	9	Төрийн өмчийн халаалтын зуухнуудыг төвлөрсөн дулаанд холбох ажлыг талуудтай хамтран хэрэгжүүлнэ	Төвлөрсөн дулаанд холбогдоогүй халаалтын зуухны тоо	Төвлөрсөн дулаанд холбогдоогүй төрийн өмчийн 11 халаалтын зуух.	3-аас доошгүй халаалтын зуухыг төвлөрсөн дулаанд холбоно.	УТХО 1,321.0 ГХО 1,170.0 ДТХО 280.0	2021-2024 онд 5, 6, 12, 14 дүгээр хорооны хэрэглэгчдийн /түлш болон түүхий нүүрсээр галладаг/ дулааныг хангадаг байсан 6 уурын зуухыг буулгаж агаарын бохирдол үүсгэгч эх үүсвэрийг бууруулсан бол 2024-2025 онд 5 дугаар хороо Яармаг худалдааны төвийг төвлөрсөн бохир, цэвэр ус, дулааны шугам сүлжээнд холбох ажлыг хэрэгжүүлнэ. 2021 онд 5, 7, 12, 14, дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 19, 20, 22, 118 дугаар халаалтын зуух, 165-р цацэрлэгийн 2-р байрны түлшээр галладаг нийт 5 уурын /яндан/ зуухыг буулгаж агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажилласан. 2022--2023 онд "Цэвэр агаар төсөлийн хүрээнд Дэлхийн банкны хөнгөлөлттэй эзлээр дүүргийн 6 дугаар хороонд байрлах "Хоёулаа хүү" ХХК-ны зуухыг буулгаж, халаалт авдаг 6 төсөвт байгууллагыг төвийн дулаанд холбох шугам сүлжээний ажлыг хэрэгжүүлсэн. 2024 онд Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5 дугаар хороонд байрлах Яармаг худалдааны төвийг төвлөрсөн бохир, цэвэр ус, дулааны шугам сүлжээнд холбох ажил худалдан авах ажиллагааны шатанд байна.	100%
1.2.3 Агаарын бохирдлын эх үүсвэр, хор уршиг, дэвшилтэт техник технологи, ногоон амьдралын хэв маягийн талаар танин мэдүүлэх, зөв дадал хэвшилд сургах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, зэрэг мэдээлэл сурталчилгааны ажил зохион байгуулна.	10	Агаарын бохирдлыг бууруулах, зөв дадал хэвшүүлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Цэвэр агаар – Цэлмэг тэнгэр" арга хэмжээг бүсчлэн зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	1 арга хэмжээ зохион байгуулсан.	8-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулж, 10 төрлийн зөвлөмж сэрэмжлүүлэг тараана.		2021-2024 онд 3 удаагийн сургалт, нэгдсэн арга хэмжээ, "Байгальд ээлтэй дэвшилтэт технологи" өдөрлөг 3 удаа, "Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх" нэгдсэн арга хэмжээ 2 удаа, "Ногоон технологи" үзэсгэлэн арга хэмжээг 1 удаа, нийт 9 арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 35 аж ахуйн нэгж, 66171 орчим иргэдийг хамруулан 8 төрлийн зөвлөмж, сэрэмжлүүлэг нийт 129000 ширхэгийг тараасан. 2021 онд Түүхий нүүрсийг хориглож, сайжруулсан шахмал түлшээр айл өрхийг хангах ажлын хүрээнд 525 орон тооны бус ажилтан ажиллуулж, Мэргэжлийн хяналтын хэлтсийн 23 улсын байцаагч хамтран "Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх 30000 ширхэг зөвлөмжийг тараан айл өрхүүдэд зөвлөгөө мэдээлэл өгөхийн зэрэгцээ, "Өнтэй өвөлжье", Яндангаа хөөлөх", "Угаарын хийнээс сэрэмжлэе" сэдэвт 3 удаагийн сургалт, өдөрлөг зохион байгуулж, нийт 17171 айл өрхөд урьдчилан сэргийлэх зөвлөмж өгсөн. 2022 онд гэр хороололтой 10 хороог 3 бүсэд хуваан 2 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд "Байгальд ээлтэй дэвшилтэт технологи" өндөрлөгөөр 7 аж ахуйн нэгж байгууллагын дэвшилтэт технологи бүхий бүтээгдэхүүнийг 2000 гаруй иргэдэд танилцуулж, 3 төрлийн 48000ш гарын авлагыг 16000 өрхөд тараан холбогдох бусад мэдээлэл зөвлөмжийг өгсөн. 2023 онд Дүүргийн нутаг дэвсгэрт цахилгаан хийн халаалт, дулаалга үйлдвэрлэл импортын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 13 аж ахуйн нэгж байгууллагатай хамтран "Байгальд ээлтэй дэвшилтэт техник технологийн үзэсгэлэн худалдаа" зохион байгуулж, 12 хорооны 16,000 гаруй иргэд хамруулсан. Мөн "Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх" 2 удаа нэгдсэн арга хэмжээнд, нийт 324 иргэн хамруулж, гэр хорооллын 17000 гаруй өрхөд 3 удаа 51000 гаруй гарын авлага, өгч зөвлөмж хүргүүлсэн. 2024 онд "Ногоон технологи" үзэсгэлэн арга хэмжээг 2024 оны 09 дүгээр сарын 17,18-ны өдөр зохион байгуулж, гэр хорооллын 15 хорооны 273 иргэд 15 аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулсан.	100%
	11	Дүүргийн хэмжээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг зохион байгуулж, цахим бүртгэлийн санд оруулна.	"Орчны бохирдлын эх үүсвэрийн мэдээллийн сан бүрдүүлж, зохион байгуулсан тооллого, тоо (2020 онд Ердийн галлагаатай 3-15 кВт хүчин чадалтай 12552 зуухыг тоолсон)	Ердийн галлагаатай 3-15 кВт хүчин чадалтай 12552 зуухыг тоолж, хаягдлын тооллогын мэдээллийн сан" цахим мэдээллийн системд бүртгэсэн.	Эх үүсвэрийн тооллогыг зохион байгуулж, "Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогыг жилд 1 удаа зохион байгуулж мэдээллийн сан"-г шинэчилсэн байна.		2021-2024 онд жил бүр "Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллого" зохион байгуулж, мэдээллийн санг шинэчилсэн бөгөөд 2024 оны байдлаар 3-15 кВт хүчин чадалтай 14039 зуух, 15-100 кВт хүчин чадалтай зуухтай 1209 өрх, аж ахуйн нэгж, байгууллага, 100-4200 кВт хүчин чадалтай уурын халаалтын зуухны байгууламжтай 22 аж ахуйн нэгжийн 41 зуух тоологдсон нь 2023 оны тооллогын дүнтэй харьцуулбал, 5-100 кВт хүчин чадалтай зууны тоо 504-өөр өсч, 3-15 кВт хүчин чадалтай зуухны яндангийн тоо 2189-өөр, 100-4200 кВт хүчин чадалтай уурын болон усан халаалттай зуухны байгууламжийн тоо 12-оор буурсан. 2021 онд Агаарын бохирдол үүсгэгч эх үүсвэрийн тооллого зохион байгуулахад нийт бүртгэгдсэн ердийн галлагаатай 3-15 кВт хүчин чадалтай 12552 зуух хэрэглэгч өрхийн 39.1 хувь буюу 4906 нь сайжруулсан, 60.9 хувь буюу 7646 нь ердийн зуух ашиглаж байсан. 2022 онд ердийн зуухтай гэрт 4420, ердийн зуухтай байшинд 5688, сайжруулсан зуухтай гэрт 2848, сайжруулсан зуухтай байшинд 3877 нийт 17090 айл өрх, 15-100 кВт хүчин чадалтай нам даралтын зуухтай 116, 100 кВт-аас дээш хүчин чадалтай уурын халаалтын зуухтай 18, нийт 134 аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг шинэчлэн цахим санд оруулсан. 2023 онд 3-15 кВт хүчин чадалтай зуухтай 16,228, 15-100 кВт хүчин чадалтай зуухтай 705 өрх, аж ахуйн нэгж, байгууллага, 100-4200 кВт хүчин чадалтай уурын халаалтын зуухны байгууламжийн 53 зуухыг тоолж, цахим мэдээллийн санд оруулсан. Дүүргийн хэмжээнд 3-15 кВт хүчин чадалтай зуухтай 16,228 тоологдсон нь өмнөх онтой харьцуулахад 862 буюу 5%-иар буурчээ. 2024 онд дүүргийн нутаг дэвсгэрт 3-15 кВт хүчин чадалтай 14039 зуух, 15-100 кВт хүчин чадалтай зуухтай 1209 өрх, аж ахуйн нэгж, байгууллага, 100-4200 кВт хүчин чадалтай уурын халаалтын зуухны байгууламжтай 22 аж ахуйн нэгжийн 41 зуухыг тоолж, цахим мэдээллийн санд оруулсан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
	12	Гэр хорооллын айл өрхүүдийг угаартах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, мэдээлэл хүргэх ажил зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан өрх, тоо	Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, галлагааны чиглэлээр зөвлөмж мэдээлэл хүргүүлэх ажлыг 6 удаа зохион байгуулж, гэр хорооллын 17,464 өрхийг хамруулсан.	Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж мэдээлэл хүргэх ажлыг жилд 1-2 удаагийн давтамжтай хүргэх ажлыг зохион байгуулж, 16,000-аас доошгүй өрхийг хамруулна.	ДТХО 45.9	<p>2021-2024 онд Мэргэжлийн хяналтын хэлтсийн 23 улсын байцаагч хамтран 3 удаагийн сургалт, "Байгальд ээлтэй дэвшилтэт технологи" өндөрлөг 3 удаа, "Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх" нэгдсэн арга хэмжээ 2 удаа, "Ногоон технологи" үзэсгэлэн арга хэмжээг 1 удаа, нийт 9 арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 66171 орчим иргэдийг хамруулан 8 төрлийн зөвлөмж, сэрэмжлүүлэг нийт 129000 ширхэгийг тараасан.</p> <p>2021 онд Түүхий нүүрсийг хориглож, сайжруулсан шахмал түлшээр айл өрхийг хангах ажлын хүрээнд 525 орон тооны бус ажилтан ажиллуулж, Мэргэжлийн хяналтын хэлтсийн 23 улсын байцаагч хамтран "Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх 30000 ширхэг зөвлөмж тараан айл өрхүүдэд зөвлөгөө мэдээлэл өгөхийн зэрэгцээ, "Өнтэй өвөлжье", "Яндангаа хөөлөх", "Угаарын хийнээс сэрэмжлэе" сэдэвт 3 сургалт, өдөрлөг зохион байгуулж, нийт 17171 айл өрхөд урьдчилан сэргийлэх зөвлөмж өгсөн.</p> <p>2022 онд гэр хорооллолтой 10 хороог 3 бүсэд хуваан 2 арга хэмжээ зохион байгуулж, "Байгальд ээлтэй дэвшилтэт технологи" өдөрлөгөөр 7 аж ахуйн нэгжийн дэвшилтэт технологи бүхий бүтээгдэхүүнийг 2000 гаруй иргэнд танилцуулж, 3 төрлийн 48000ш гарын авлагыг 16000 өрхөд тараан холбогдох бусад мэдээлэл зөвлөмж өгсөн.</p> <p>2023 онд "Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх" 2 удаа нэгдсэн арга хэмжээнд 324 иргэн, Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх сургалтад 948 өрхийг тус тус хамруулан зохион байгуулж, 17000 гаруй өрхөд 3 удаа 51000 гаруй гарын авлага, өгч зөвлөмж хүргүүлсэн. Мөн 16228 өрхөөс судалгаа авч, угаарын хийн мэдрэгчгүй 1969 өрхийг угаар мэдрэгчээр бүрэн хангаж, 9, 10, 12, 14 дүгээр хорооны өндөр настай 566 иргэний зууханд дулаан баригч бортого суурилуулсан. Дүүргийн Шуурхай штаб ажиллах хугацаанд 40 иргэн угаарын хийн хордлогод өртөж, эрүүл мэндийн байгууллагад хандан 31 иргэн тусламж авч буцсан, 9 иргэн хэвтэн эмчлүүлсэн.</p> <p>2024 онд Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, зөв галлагааны чиглэлээр зөвлөмж мэдээлэл хүргүүлэх ажлыг 11, "Галлагаандаа анхааръя" аяныг 2 удаа зохион байгуулж, 15 хорооны 15248 өрхийг хамруулсан бөгөөд 6 төрлийн 72000 ширхэг гарын авлагыг иргэдэд хүргэсэн. Европын холбооны Switch Asia хөтөлбөрийн санхүүжилттэй "Дулаан шийдэл" төслийн хүрээнд Жэрэс ОУТББ-ын Монгол дахь Төлөөлөгчийн газартай хамтран 8, 9, 10, 13, 16 дугаар хорооны 50 байшинтай өрхийн дээвэр дулаалж, өрх толгойлсон 50 эмэгтэйн байшингийн хаалга, цонхыг дулаалсан.</p>	100%
1.2.4 Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.	13	Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.	Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо	350 ариун цэврийн байгууламж нэвтрүүлсэн.	Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг 1650-аар нэмэгдүүлнэ.	УТХО 3,193.0	<p>2021-2024 онд нийтийн эзэмшлийн талбай, авто зам дагуу байрлуулсан 9 ил задлгай нүхэн жорлонг буулгаж, төсвийн хөрөнгө оруулалт, иргэдийн оролцоотойгоор стандартын шаардлага хангасан, хөрсөнд нэвчилтгүй ариун цэврийн байгууламж 1510-аар нэмэгдсэн бөгөөд 2024 оны байдлаар дүүргийн хэмжээнд 1828 хөрсөнд нэвчилтгүй ариун цэврийн байгууламж байна.</p> <p>2021 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Туул голын сав дагуу 12 дугаар хорооны 850, 13 дугаар хорооны 150, нийт 1000 өрхөд MNS 5924:2015 стандартын шаардлага хангасан, хөрсөнд нэвчилтгүй нүхэн жорлон суурилуулах ажлыг гүйцэтгэсэн.</p> <p>2022 онд Дүүргийн гэр хорооллын хороодод барьсан стандарт бус нүхэн жорлон 10475, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж 1304 ширхэг байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалгаар хэрэгжүүлж буй Туул гол орчмын хөрсний бохирдлыг бууруулах эко нойлын гүйцэтгэгчээр "Оргил-Өргөө" ХХК шалгарч 8, 9, 10 дугаар хороодод нийт 551эко нойл барихаас 534 ширхэг нойлын нүх ухаж, 164 нүхэнд колыцо суулгаж, 18 ширхэгт нь бүхээг тавьж ашиглалтанд оруулсан.</p> <p>2023 онд Кувейтын ам, Жаргалантын ам, Айцын даваа зэрэг газруудад авто зам дагуу байрлуулсан ил задгай 9 нүхэн жорлонг буулгаж, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ авсан. Дүүргийн хэмжээнд гэр хорооллын айл өрхийн стандартын шаардлага хангасан, хөрсөнд нэвчилтгүй, стандартын шаардлага хангасан нүхэн жорлон 1523 болж өмнөх оны мөн үеэс 219 ширхэгээр нэмэгдсэн байна.</p> <p>2024 онд Хан-Уул дүүргийн хэмжээнд 2023 онд гэр хорооллын айл өрхийн стандартын шаардлага хангасан, хөрсөнд нэвчилтгүй 1523 ширхэг нүхэн жорлон байсан бол 2024 онд 1828 ширхэг болж 305-аар нэмэгдсэн.</p>	100%
	14	Нүхэн жорлон, бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүүлж, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажиллана.	Ариутгаж халдваргүйжүүлсэн нүхэн жорлон, бохирын цооногийн тоо	13496 нүхэн жорлон, 8042 бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүүлсэн.	13855 нүхэн жорлон, 8340 бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүүлсэн байна.	ДТ 496.5	<p>2021-2024 онд гэр хорооллын 11086 нүхэн жорлон, 5914 бохирын цооногийг жил бүр ариутгаж халдваргүйжүүлсэн.</p> <p>2021 онд дүүргийн 13 хорооны нутаг дэвсгэрт 13,855 ширхэг нүхэн жорлон, 8,340 ширхэг бохирын цооногийг бохир задлах, үнэр дарах, халдваргүйжүүлэх био бэлдмэлээр ариутган халдваргүйжүүлсэн.</p> <p>2022 онд 10475 ширхэг нүхэн жорлон, 5575 ширхэг бохирын цооногийг бохир задлах, үнэр дарах, халдваргүйжүүлэх био бэлдмэлээр ариутган халдваргүйжүүлсэн.</p> <p>2023 онд 12,099 нүхэн жорлон, 5732 бохирын цооног ариутгаж халдваргүйжүүлсэн.</p> <p>2024 онд гэр хорооллын айл өрхийн 11086 нүхэн жорлон, 5914 бохирын цооногийг "Түвшинбилэг төгөлдөр" ХХК, "Баяндэмбэрэл" ХХК ариутгаж халдваргүйжүүлсэн.</p>	100%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
1.3 Хүнс, хөдөө аж ахуй, инноваци								
1.3.1 Дүүргийн өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжих "Эко хүлэмж" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	15	"Эко хүлэмж" арга хэмжээг хэрэгжүүлж, тарвасын тариалалтыг дэмжин ажиллана.	Нэмэгдсэн тарвас тариалсан хүлэмжийн хэмжээ, га талбайн	Зуны 3000м2 талбай бүхий хүлэмжид тариалж нийт 1.0 тн ургац хураан авч байна.	Хүлэмжийн талбайг 1-ээс доошгүй га-аар нэмэгдүүлнэ.	ДТ 9.6	2021-2024 онд дүүргийн хэмжээнд 2020 онд 0.3 га талбайд тарвас тариалж, 1 тн ургац авч байсан бол 2024 онд 4.8 га-д тарвас тариалж, 250.8 тн ургац авснаар тарвасын тариалалт 4.5 га талбайгаар нэмэгдсэн. 2021 онд дүүргийн хэмжээнд тариалан эрхлэгчид нийт 21 га талбайд хүлэмжийн тариалалт эрхэлж байна. Үүнээс БНСУ-ын Хаман дүүрэгтэй хамтын ажиллагааны хүрээнд хандивласан 50х6 м хэмжээтэй 8 хүлэмжид нийт 0.24 га талбай, 13 дугаар хорооны 3 иргэн аж ахуйн нэгж 0.37 га талбайд зуны нийлэг хүлэмжид оруулан тарвасын тариалалт нийт 0.61 га талбайд хийгдэж 9.2 тонн ургац хураасан. 2022 онд дүүргийн хэмжээнд тариалан эрхлэгчид 23.3 га талбайд хүлэмжийн тариалалт хийсэн. Үүнээс 2.8 га талбайд тарвас тариалж 18.8 тн ургац авсан. 2023 онд дүүргийн хэмжээнд тариалан эрхлэгчид 25.5 га талбайд хүлэмжийн тариалалт хийсэн. Өмнөх онтой харьцуулвал 2.2 га талбайгаар хүлэмжийн тариалалт нэмэгдсэн байна. Үүнээс 0.96 га талбайд тарвас тариалж, 12 тн ургац хураан авсан. Хүлэмжийн аж ахуй эрхэлж буй 32 аж ахуйн нэгж, 155 иргэнийг газар тариалангийн нэгдсэн санд бүртгэж, тариалалт, арчлалт, ургац хураалтын явцад хяналт тавьж, дэмжлэг үзүүлсэн. 2024 онд Дүүргийн хэмжээнд тариалан эрхлэгчид 28.2 га талбайд хүлэмжийн тариалалт хийсэн. Үүнээс тарвасын тариалалтыг дэмжих ажлын хүрээнд 7 га талбайд тарвас тариалснаас 4.8 га талбайгаас 250.8тн ургац хураан авсан.	100%
	16	Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгжийг мэргэжил арга зүйн сургалт, туршлага судлах арга хэмжээнд хамруулна.	Сургалтад хамрагдсан газар тариалан эрхлэгч ААН, иргэдийн тоо	20 иргэнийг сургалтад хамруулсан.	90-ээс доошгүй иргэнийг хамруулж хүлэмжийн тариалалт нэмэгдсэн байна.	ДТ 0.8	2021-2024 онд Өрхийн тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлж буй иргэдэд мэргэжлийн байгууллагатай хамтран нийт 17 удаагийн сургалт, туршлага судлуулах арга хэмжээ зохион байгуулж 489 тариалан эрхлэгчийн туршлага, мэдлэгээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлсэн байна. 2021 онд хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлого, онолын суурь мэдлэг олгох сургалтад 42, Ургамлын гарал үүсэл, пестицидийн бүртгэл хяналтын систем /https://plant.mofa.gov.mn/-ийг ногоочдод танилцуулах сургалтад 23, нийт 2 удаагийн сургалтад 65 тариалан эрхлэгч хамрагдсан. 2022 онд "Хүнсний ногооны үр үрслэг хийх агротехноло"-ийн 2 удаагийн сургалт, хүлэмжийн тариалалт эрхэлдэг 30 газар тариалан эрхлэгч, дүүргийн 3-р хороонд байрлах орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлсэн "Фор Ви Ар Грийн" ХХК-ны дээврийн хүлэмжний аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах сургалтад 20, газар тариалангийн үйлдвэрлэлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн систем, цахим гарал үүсэл олгох 3 удаагийн сургалтад хүлэмжийн болон ил талбайн тариалалт эрхэлдэг 107, нийт 6 удаагийн сургалт зохион байгуулж, 157 тариалан эрхлэгч хамрагдсан. 2023 онд дээврийн хүлэмжийн аж ахуйн үрсэлгээ, суулгац бэлтгэх онол, дадлага хосолсон сургалтад 30, "Хүлэмжийн аж ахуйн зохистой дадал ба Японы хүлэмжийн аж ахуйн тэргүүн туршлага" сургалтанд хүлэмжийн тариалалт эрхэлж буй 20, "Тариалангийн сэргэлт-2023" чуулганы Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн салбар хуралдаанд 10, тариалалт, ургац хураалт, ангилалт, хадгалалт, тээвэрлэлтийн үед хөрсний нэмэлтүүдийн хэрэглээний талаар мэдлэг олгох сургалтад 30, "Хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэх нь" сургалтад 50, хүлэмжийн аж ахуйн туршлага судлах аялалд 10, нийт 6 удаагийн арга хэмжээнд, 150 тариалан эрхлэгчийг хамруулсан. 2024 онд "Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн мод тариалах технологи", "Малчин, мал бүхий иргэд, газар тариалан эрхлэгчдэд хууль тогтоомж танилцуулах уулзалт", "Мал аж ахуй эрхлэгчдийг чадавжуулах" зэрэг 3 удаагийн сургалт зохион байгуулж, 117 эрчимжсэн аж ахуй, газар тариалан эрхлэгч хамруулсан.	100%
	17	Газар тариалан эрхлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх үзэсгэлэн зохион байгуулна.	Үзэсгэлэн худалдаанд хамрагдсан газар тариалан эрхлэгч иргэдийн тоо	20 тариаланчийг намрын үзэсгэлэн яармаг худалдаанд хөнгөлөлттэй хамруулсан.	80-аас доошгүй тариаланчийг намрын үзэсгэлэн яармаг худалдаанд хөнгөлөлттэй хамруулна.	ДТ 21.5	2021-2024 онд Газар тариалан эрхлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 302 тариалан эрхлэгчдийг дэмжин "Намрын ногоон өдрүүд", "Монгол ногоо", "Хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа" зэрэг 25 үзэсгэлэн худалдаанд оролцуулж 2007.9 тн хүнсний ногооны борлуулалтыг дэмжсэн. 2021 онд үйлдвэрлэл эрхлэгч, ногоочдыг дэмжих ажлын хүрээнд 3*3 хэмжээтэй 19.6 сая төгрөгийн үнэ бүхий 8 ширхэг асрыг хийлгэж, үзэсгэлэн болон өргөтгөсөн худалдаанд 50 хонго 16 ногоочинд түрээсийн төлбөргүйгээр ашиглуулсан. Мөн "Монгол ногоо" өргөтгөсөн худалдааг нийт 5 байршилд зохион байгуулан дүүргийн 7, хөдөө орон нутгийн 28, нийт 35 ногоочны 312 тн ногооны борлуулалтад дэмжлэг үзүүлсэн. 2022 онд газар тариалан эрхлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Амралтын өдрийн худалдаа", "Улаанбаатар марафон", "Монгол ногоо-2022", "Намрын ногоон өдрүүд-2022" зэрэг 8 удаагийн үзэсгэлэн худалдаанд 144 газар тариалан эрхлэгчийг оролцуулж, 939.9 тонн төмс, хүнсний ногоо худалдан борлуулж, 955.1 гаруй сая төгрөгийн борлуулалт хийхэд дэмжлэг үзүүлсэн. 2023 онд хүнсний ногооны өргөтгөсөн худалдааг 9 байршилд түрээсийн төлбөргүйгээр зохион байгуулж, нийт 115 газар тариалан эрхлэгчдийн 756 тн төмс, хүнсний ногоог худалдан борлуулахад дэмжлэг үзүүлэн, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилсан. 2024 онд Газар тариалан эрхлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 3 байршилд "Намрын ногоон өдрүүд" үзэсгэлэн худалдааг зохион байгуулж нийт 20 газар тариалан эрхлэгчийг оролцуулан, борлуулалтыг дэмжин ажилласан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
1.3.2 Газар тариалан эрхлэгчдэд экологийн цэвэр бордоо ашиглах, экологийн цэвэр тариалан эрхлэхэд нь мэргэжлийн дэмжлэг үзүүлэн “Хан-Уулд тариалав” брэнд бий болгоно.	18	“Хан-Уулд тариалав” брэнд бий болгоно.	Брэнд бүтээгдэхүүний тоо	-	15-аас доошгүй Брэнд бүтээгдэхүүнтэй болсон байна.		2021-2024 онд бүтээгдэхүүний брэнд бүтээхэд дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд Хан-Уул дүүрэгт эко орчинд техник технологийн дэвшлийг ашиглан тарьж, ургуулж, үйлдвэрлэсэн хүний эрүүл мэндэд хэрэгцээтэй 15 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг үзэсгэлэн худалдаа, өдөрлөгийн арга хэмжээнд дэмжин оролцуулах, “Хан-Уулд үйлдвэрлэв” сэтгүүлд нийтлүүлэх замаар олон нийтэд сурталчлан таниулж ажилласан. Үүнд: 2021 онд Хан-Уул брэндийг бий болгох, шинэ сортын ногоо тарьж ургуулан нутагшуулах зорилгоор БНСУ-ын Гэнсан аймгаас хандивласан үрээр тарвас, улаан лооль, өргөст хэмх тариалж 10.3 тонн ургац хураан авахын зэрэгцээ, нийслэлийн байцааны тариалалтын 60 хувийг тус дүүрэгт тарьж ургуулдаг тул брэнд болгох зорилгоор “Намрын ногоон өдрүүд” арга хэмжээнд тариаланчдыг хамруулж, бүтээгдэхүүнийг нь олон нийтэд сурталчилсан. 2022 онд “Фор Ви Ар Грийн” ХХК-ийн дээврийн хүлэмжид ургуулсан “Гүнждийн навч”, “Улаан лооль”, “Амаркатеринг” ХХК, “Монголын эмэгтэйчүүдийн сан”-тай хамтарсан төслийн хүрээнд 4 улиралд гарах боломжтой өвлийн хүлэмжид тарьж ургуулсан 6 төрлийн нарийн ногоог брэнд болгон олон нийтэд сурталчилсан. 2023 онд Стандарт барагшун ХХК-ийн “Барагшун” Үлэмж органик ХХК-ийн “Сүү, сүүн бүтээгдэхүүн”, Тинц ХХК-ийн “Ногоодой” жимсний шүүс, Амаркатеринг ХХК-ийн “82 төрлийн салат навч” зэрэг 5 аж ахуйн нэгжийн 5 төрлийн бүтээгдэхүүнийг брэнд болгохоор зорилт тавин нийслэл, дүүргээс зохион байгуулсан үзэсгэлэн худалдаанд түрээсийн төлбөргүй оролцуулж дэмжсэн. 2024 онд “Оюу фамили” ХХК-ийн зөгийн бал, 3-р хорооны иргэн А.Атарцэцэгийн үйлдвэрлэж буй “Даршилсан сармис”-ыг Эко дүүргийн баялаг бүтээгчдийн “Бүтээгч Хан-Уулчууд-2024” 4 удаагийн өдөрлөг арга хэмжээнд олон нийтэд таниулан сурталчилсан.	100%
1.3.3 Орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бага, дунд оврын жишиг загвар бүхий үйлдвэр байгуулахыг дэмжиж, үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг олон нийтэд таниулан сурталчилна.	19	Бага, дунд оврын жишиг загвар бүхий үйлдвэр байгуулахыг дэмжиж, үйл ажиллагааг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулна.	Дэмжлэгт хамрагдсан жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо	1 арга хэмжээ зохион байгуулж, 20 үйлдвэрлэл эрхлэгчийг оролцуулсан.	Жилд дунджаар 30-аас доошгүй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийг “Хан-Уулд үйлдвэрлэв” сэтгүүлээр сурталчлах ажлыг зохион байгуулна.	ДТХО 19.8	2021-2024 онд “Хан-Уулд үйлдвэрлэв” сэтгүүлийн 4 дугаарыг 4500 ширхэгийг хэвлүүлж, 168 аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан, туршлага судлах аялал, арга хэмжээг 3 удаа зохион байгуулж 96 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч хамруулсан. Үүнд: 2021 онд Монголын Жижиглэн худалдаа эрхлэгчдийн холбооноос эрхлэн гаргадаг “ХУДАЛДААЧИН” сэтгүүлтэй хамтран тус дүүрэгт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 38 иргэн, ААН-ийн бараа бүтээгдэхүүний талаарх мэдээллийг нийтлэн нийт 1200 ширхэг сэтгүүл хэвлүүлж дүүргийн 21 хороо, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадаар дамжуулан иргэдэд хүргэж сурталчилсан. 2022 онд дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 60 иргэн, аж ахуйн нэгжийн бараа бүтээгдэхүүнийг “Хан-Уулд үйлдвэрлэв” сэтгүүлийн 2022 оны дугаарт нийтлэн 1200 ширхэг хэвлүүлж олон нийтэд танилцуулсан. Богд банктэй хамтран жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор сарын 1.2-1.9 хувийн хүүтэй зээлд дүүргийн шаардлага хангасан 88 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг холбон зуучилснаас жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 58 иргэн, аж ахуйн нэгж 4.6 тэрбум төгрөгийн зээл авчээ. 2023 онд дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 38 иргэн, аж ахуйн нэгжийг “Хан-Уулд үйлдвэрлэв” сэтгүүлийн 2023 оны ээлжит дугаарт нийтэлж нийт 1000 ширхэгийг хэвлүүлэн бараа бүтээгдэхүүнийг сурталчилж, олон нийтэд танилцуулах ажлыг зохион байгуулсан.	100%
							Дүүргийн нутаг дэвсгэрт жижиглэн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Дэлхийн конвениенс сүлжээ дэлгүүрийн бизнесийн шилдэг туршлага, нөү-хау, үйлчилгээний соёл, “CU” хоолны үйлдвэрлэлийн зохистой дадал, ханган нийлүүлэлт, ложистикийн талаарх сайн туршлагыг танилцуулах туршлага судлах аялал, аж ахуйн нэгж, орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлж, Африкийн хар загасны ялгадасаар ургамлаа бордож, экологийн цэвэр бүтээгдэхүүн гаргаж авч байгаа бөгөөд Монголд ховордсон гүнждийн навчийг хоол хүнсэнд ашиглах уламжлалыг сэргээсэн “Фор Ви Ар Грийн” ХХК-ийн дээврийн хүлэмжийн аж ахуй, “Гоёл кашмер” ХХК-ийн үйлдвэрийн байртай танилцаж, туршлага судлах 3 удаагийн арга хэмжээ зохион байгуулж 96 үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулан ажилласан. 2024 онд нийт 1100 ширхэг “Хан-Уулд үйлдвэрлэв 2024” сэтгүүлийн цуврал дугаарыг хэвлүүлж, 32 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах ажлыг зохион байгуулсан.	
1.3.4 Мэдээлэл технологийн старт ап компаниудад зориулсан инкубатор төвийг нээнэ.	20	Мэдээлэл технологийн старт ап компаниудад зориулсан инкубатор төвийг нээнэ.	Инкубатор төвийн барилгын гүйцэтгэлийн хувь		Барилга ашиглалтад орж, үйл ажиллагаа эхэлсэн байна.		Мэдээлэл технологийн старт ап компаниудад зориулсан инкубатор төв газрын асуудал шийдвэрлэгдээгүйн улмаас хэрэгжээгүй.	0%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
1.4. Аялал жуулчлал								
1.4.1 Дүүргийн байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн "Их түүхийн жимээр" аяллын маршрутыг бий болгоно.	21	Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн явганаар аялах аяллын маршрут бий болгоно	Шинээр бий болсон аяллын маршрут	Богд уул руу алхах 1 маршрут	Явган аяллын 1-2 маршрут ашиглалтад орсон байна.	УТХО 392.0 ДТХО 14.0	2021-2024 онд дүүргийн 11-р хороо "Ар зайсангийн гудамжнаас Дугуй цагаан хүртэлх уулын алхалтын замын угтах хэсгийн амралт зугаалгын бүсийн тохижилтын ажил хийгдэж ашиглалтад орсон бол 8, 21, 23, 24-р хорооны хил заагт хамаарах Богдхан уулын 6 амны нийт 19 км урт явганаар аялах жим, авто зогсоол, эдгээрийг холбосон 13.2 км дугуйн болон гүйлтийн зам бүхий явганаар аялах маршрутын тохижилт хийх ажлын зураг төсөв батлагдсан. Дүүргийн үүсэл хөгжил, байгаль түүхийн дурсгалт газар болон бүтээн байгуулалтын ажлуудыг иргэдэд сурталчилан таниулах зорилгоор "Их түүхийн жимээр" аялалын маршрут боловсруулан, маршрутын дагуу 2 аялал зохион байгуулсан. 2021 онд Монголын явган алхалтын холбоотой хамтран дүүргийн 8-р хороо Жаргалантын ам дагуу 8.2 км явган аяллын маршрут гаргасан ба 2022 онд алхалтын замд стандартын шаардлага хангасан тэмдэг, тэмдэглэгээ, тохижилт хийх зураг төсвийн ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн. Мөн дүүргийн явган алхалтын холбоо салбар зөвлөлийг байгуулан "Хамтдаа алхаад эрүүлжэе" уриан дор 4 удаагийн алхалтыг маршрутын дагуу зохион байгуулж, нийт 450 хүн хамруулсан. 2022-2023 онд 11-р хороо, "Ар зайсангийн гудамжнаас Дугуй цагаан хүртэлх уулын алхалтын замын угтах хэсгийн амралт зугаалгын бүсийг ашиглалтад хүлээн авсан бөгөөд дүүргийн Засаг даргын 2023 оны А/394 дүгээр захирамжаар талбайн ашиглалт, арчлалт хамгаалалтыг Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-т хариуцуулж, цэвэрлэгээ үйлчилгээг өдөр бүр гүйцэтгэж, хяналт тавьж ажиллаж байна. Дүүргийн 8, 21, 23, 24-р хорооны хил заагт хамаарах Богдхан уулын Хүүш, Арцатын амны 8 км, Нүхт, Ташгайн амны 6.5 км, Жаргалант, Тайны амны 4.5 км, нийт 19 км урт явганаар аялах жим, авто зогсоолыг холбосон 13.2 км дугуйн болон гүйлтийн зам бүхий явганаар аялах маршрутын зураг төсөл боловсруулагдаж батлагдсан. Дүүргийн үүсэл хөгжил, байгаль түүхийн дурсгалт газар болон бүтээн байгуулалтын ажлуудыг иргэдэд сурталчлан таниулах зорилгоор "Их түүхийн жимээр" маршрутын дагуу 2 удаагийн аяллыг дүүргийн ерөнхий боловсролын 10, 26, 59-р сургуулийн ахлах ангийн 90 сурагчдад зохион байгуулсан. 2024 онд Дүүргийн 8, 21, 23, 24-р хорооны хил заагт хамаарах Богдхан уулын 6 амны нийт 19 км урт явганаар аялах жим, авто зогсоол, эдгээрийг холбосон 13.2 км дугуйн болон гүйлтийн зам бүхий явганаар аялах маршрутын тохижилт хийх хөрөнгийг улс, нийслэлийн 2025 оны төсөвт тусгуулахаар дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 03/1365 дугаар албан бичгээр уламжилсан.	90%
1.4.2 Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд анхаарч хүйтний улиралд иргэд олон нийт чөлөөт цагаа өнгөрүүлэх өвлийн баазыг Яармаг, Сонгино, Жаргалантын аманд байгуулна.	22	Хүйтний улиралд иргэд амарч, зугаалах зориулалт бүхий орчныг бүрдүүлнэ.	Иргэдийн амралт, чөлөөт цагт зориулсан өвлийн баазын ажлын явцын хувь	-	Иргэдийн амралт, чөлөөт цагт зориулсан 1-2 өвлийн бааз нээгдсэн байна.		2021-2024 онд Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Богдхан уулын Дугуй цагааны аманд явган аяллын маршрутын дагуу тохижуулж, дүүргийн 8, 21, 23, 24-р хороо, Богдхан уулын Хүүш, Арцатын амны 8 км, Нүхт, Ташгайн амны 6.5 км, Жаргалант, Тайны амны 4.5 км, нийт 19 км урт явганаар аялах жим, авто зогсоол, эдгээрийг холбосон 13.2 км дугуйн болон гүйлтийн зам бүхий явганаар аялах маршрутын зураг төсөл боловсруулж, улс, нийслэлийн 2025 оны төсөвт тусгуулахаар дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 03/1365 дугаар албан бичгээр холбогдох байгууллагад уламжилсан. 2022 онд дүүргийн төсвийн хөрөнгөөр 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн 13.5 га талбайд зуслангийн 282 зуны сууц, 120 өвлийн сууц, 14 ширхэг ариун цэврийн байгууламж, 5 тоглоомын талбай, 2 сагсан бөмбөгийн талбай, 300 авто машины зогсоол, 95000 м.кв ногоон байгууламж бүхий "Эко зуслан" төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр зураг төсөл боловсруулж байгаа бөгөөд загвар зургийг Хот байгуулалт хөгжлийн газраар 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр батлуулсан. 2023 онд Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Богдхан уулын Дугуй цагааны аманд явган аялалын маршрутын дагуу тохижилт ажил дууссан. Мөн "Эко зуслан" төслийг 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хэрэгжүүлэхээр 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан. 2024 онд дүүргийн Засаг даргын 2023 оны А/769 дүгээр захирамжаар тус дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 1 га газрыг өвлийн цанын бааз байгуулах газрын асуудлыг шийдвэрлэсэн.	50%
1.4.3 Богдхан уулын дархан цаазат газрын биологийн олон янз байдлын судалгаанд үндэслэн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөө шинжлэх ухааны үндэстэй боловсруулж, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	23	Богдхан уулын байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөө боловсруулан, байгалийн аялал жуулчлал хийх бүрдүүлнэ.	Холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулсан Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөө	-	Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөг үндэслэн амралт жуулчны баазуудтай хамтран хэрэгжүүлнэ.	УТХО 400.0	2021-2024 онд "Богдхан уулын дархан цаазат газрын 2022-2026 оны менежментийн 9 бүлэг 58 хуудас төлөвлөгөө" батлагдсан. Мөн энэ ажлын хүрээнд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Ар зайсангийн гудамжнаас Дугуйн цагаан хүртэлх уулын алхалтын замын угтах хэсгийн амралт, зугаалгын бүсийг тохижуулж, талбайн ашиглалт, арчлалт хамгаалалтыг "Хан-Уул агро" ОНӨААТҮГ-т шилжүүлсэн. 2022-2023 онд "Богдхан уулын дархан цаазат газрын 2022-2026 оны менежментийн 9 бүлэг 58 хуудас төлөвлөгөө"-ний дагуу 8, 21, 23, 24 дүгээр хорооны хил заагт хамаарах Богдхан уулын Хүүш, Арцатын амны 8 км, Нүхт, Ташгайн амны 6.5 км, Жаргалант, Тайны амны 4.5 км, нийт 19 км урт явганаар аялах жим, авто зогсоол, этгээрийг холбосон 13.2 км дугуйн болон гүйлтийн зам бүхий явганаар аялах маршрутын зураг төсөл батлагдсан. 2024 онд Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уул уурхайн 5 компани, улсын хөрөнгө оруулалтаар 1 компани 2024 онд Богдхан уулын дархан цаазат газрын Түргэний ам, Зайсангийн ам, Нүхтийн ам, Эхнхтийн ам, Ихтэнгэрийн амны 136 га талбайд ойжуулалтын ажил хийж, 133545 ширхэг, нийт 145916 ширхэг мод, бут, сөөг тарьсан байна.	90%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
1.4.4. Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад стандартыг мөрдүүлнэ.	24	Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад стандартыг мөрдүүлнэ.	Хамтарсан үзлэг шалгалтын тоо	1 удаагийн хамтарсан зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	8-аас доошгүй удаа хамтарсан үзлэг шалгалтад ААН-100% хамруулж, зөвлөгөө мэдээлэл өгнө.	ДТ 10.8	2021-2024 онд давхардсан тоогоор 151 аж ахуйн нэгжийг хамруулан зөвлөн туслах болон хяналт шалгалтын ажлыг 20 удаа зохион байгуулж, 181 зөрчил илрүүлэн 12 зөрчлийг газар дээр нь арилгуулан 12 мэдэгдэл, заавал биелүүлэх 28 албан шаардлага хүргүүлж, 16 аж ахуйн нэгжид хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулсан. Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, үр чадварыг дээшлүүлэх сургалтад давхардсан тоогоор 124 аж ахуйн нэгж байгууллагын 310 ажилтан албан хаагчийг хамруулан 16 удаа зохион байгуулсан. 2021 онд Ковид-19 цар тахлын дэгдэлтийг бууруулах ажлын хүрээнд дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй зочид буудал 22, дэн буудал 5, амралтын газар 9, жуулчны бааз 5, нийт 41 аж ахуйн нэгжийн удирдлагуудад түр заавар, зарим үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлагыг танилцуулан хариуцлагын гэрээ байгуулж, зөвлөн туслах үйлчилгээг 3 удаа, хяналт шалгалтын ажлыг 1 удаа зохион байгуулж, Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн 4 мэдэгдэл, заавал биелүүлэх 4 албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, зөрчлийг арилгуулсан. 2022 онд дүүрэгт дээрх үйлчилгээ эрхэлж буй 35 аж ахуйн нэгжид мэргэжлийн байгууллагуудтай хамтран нийт 6 удаагийн хяналт шалгалт зохион байгуулж, давхардсан тоогоор 138 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж, 65 зөрчил илрүүлэн 5 зөрчлийг газар дээр нь арилгуулан гал түймрийн улсын хяналтын байцаагчийн 8 албан шаардлага хүргүүлсэн. Мөн Хотын стандартыг танилцуулах, иргэдэд амрах аялах таатай нөхцлийг бүрдүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр нийт 4 удаагийн сургалт уулзалтад 28 аж ахуйн нэгжийг хамруулсан. 2023 онд дүүрэгт энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг 32 аж ахуйн нэгжид 6 удаагийн зөвлөн туслах, хяналт шалгалт зохион байгуулж, зөрчил илэрсэн 16 аж ахуйн нэгжид хугацаатай үүрэг даалгавар өгч, гүйцэтгэлд хяналт тавин 122 ажилтан албан хаагчдад мэргэжлийн байгууллагуудтай хамтран хотын стандартыг танилцуулах, мэдлэг үр чадварыг нэмэгдүүлэх туршлага солилцох үзүүлэх сургуулиуд, уулзалтыг зохион байгуулж, зөвлөмж өгсөн. 2024 онд Нийт 11 удаагийн арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдалд хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулсан. Үүнд: Стандартын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр давхардсан тоогоор 43 аж ахуйн нэгж байгууллагад 4 удаагийн шалгалтаар 116 зөрчлийг илрүүлэн газар дээр нь 7 зөрчлийг арилгуулж, гал албан шаардлага 16, мэдэгдэл 8 хүргүүлсэн. Мөн давхардсан тоогоор 57 аж ахуйн нэгж байгууллагын 160 ажилтанд 9 удаагийн сургалт зохион байгуулсан.	100%
1.4.4. Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад стандартыг мөрдүүлнэ.	25	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах, ой хээрийн түймэртэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулсан арга хэмжээний тоо	2 удаагийн сургалт зохион байгуулсан.	8 удаагийн дадлага сургалт зохион байгуулна.		2021-2024 онд "Ногоон бүсийн ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах дадлага сургууль"-ийг батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу Цагдаагийн газар, Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах ангиуд хамтран хороодын Засаг дарга нар, болон мэргэжлийн анги байгууллагын давхардсан тоогоор 51 техник хэрэгсэл, 744 хүн хамруулан 7 удаа зохион байгуулсан. 2021 онд Жаргалантын аманд "Ногоон бүсийн ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах дадлага сургууль"-ийг 2 удаа батлагдсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу дүүргийн Цагдаагийн газар, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагчид, хорооны Засаг дарга, ажилтнууд, Чингисийн хүрээ аялал жуулчлалын бааз, бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран давхардсан тоогоор 209 хүн, 24 техник хэрэгсэлтэй зохион байгуулсан. 2022 онд эхний сургуулилыг Түргэний аманд нийт 19 байгууллагын 300 гаруй алба хаагчдыг хамруулан зохион байгуулсан бөгөөд гал түймэр унтраах сорил дадлагын уралдаанд 16 багийн 64 тамирчид өрсөлдөн дадлага, сургуульд амжилттай оролцсон "Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮгазар", "Витафит" ХХК, "Мөнхийн үсэг" ХХК зэрэг байгууллагуудыг өргөмжлөл үнэ бүхий зүйлээр урамшуулсан. Хоёр дахь сургуулилыг Чингисийн хүрээ аялал жуулчлалын бааз, бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах ангудад дадлага хийж байгаа Хууль сахиулах их сургуулийн Ахлагчийн сургуулийн 32 сонсогч оролцуулан нийт 189 хүн, 15 техник хэрэгсэлтэй ажилласан. 2023 онд "Ногоон бүсийн ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах дадлага сургууль"-ийг Цагдаагийн газартай хамтран 2 удаа зохион байгуулж, Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах ангиудад дадлага хийж байгаа Хууль сахиулах их сургуулийн Ахлагчийн сургуулийн 15 сонсогч, нийт 132 хүн, 12 техник хэрэгсэлтэй ажиллаж, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын дунд гал түймэр унтраах сорил дадлагын уралдаан зохион байгуулан 8 багийн 24 тамирчид өрсөлдсөнөөс 1 дүгээр байранд "Мишээл групп" ХХК шалгарч, Засаг даргын өргөмжлөлөөр шагнагдсан. 2024 онд Ой хээрийн түймэр унтраах дадлага сургуулийг 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Кувейтын аманд дүүргийн гамшгаас хамгаалах 13 мэргэжлийн ангийн 150 гаруй ажилтан алба хаагчдыг хамруулан зохион байгуулсан.	85%

НЭГ. ЭКО ДҮҮРЭГ – НОГООН ХӨГЖИЛД ШААРДАГДАХ ТӨСӨВ

44,222.3

90.2%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
ХОЁР. ЭРҮҮЛ ДҮҮРЭГ – ХҮНИЙ ХӨГЖИЛ								
2.1. Биеийн тамир, спорт								
2.1.1 Дүүргийн "Иргэдийн спортын их наадам"-ыг жил бүр өргөн хүрээнд зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	26	Дүүргийн спортын их наадам"-ыг жил бүр зохион байгуулна.	"Иргэдийн спортын их наадамд" хамрагдсан иргэдийн тоо	Иргэдийн наадамд 3500 иргэн хамрагдсан.	Иргэдийн наадамд 15000 иргэн хамруулсан байна.	ДТХО 224.3	2021-2024 онд дүүргийн иргэдийн спортын наадмыг 3 удаа, 8-10 төрлөөр зохион байгуулж, давхардсан тоогоор 18206 иргэн хамруулсан бөгөөд иргэдийн спорт арга хэмжээнд оролцох оролцоо жил бүр өсөн нэмэгдэж байгаа эерэг үзүүлэлт гарч байна. Нийслэлийн иргэдийн X, XI, XII наадамд багийн дүнгээр 3 удаа тэргүүлж, нийт 12 алт, 6 мөнгө, 7 хүрэл медаль хүртсэн байна. 2021 онд Ковид-19 цар тахлын улмаас иргэдийн наадмын 8 төрлөөс хийн дасгал, аэробик, явган аялал, софт волейболын 4 төрлийн тэмцээнийг зохион байгуулах боломжгүй болж сагсан бөмбөг, волейбол, орс таталт, шагайн наадгай гэсэн спортын 4 төрлөөр зохион байгуулж, 860 гаруй иргэнийг хамруулсан. 2022 онд Иргэдийн спортын X их наадмыг явган аялал, орс таталт, сагсан бөмбөг, волейбол, хийн дасгал, аэробик, софт волейбол, ширээний шагай наадгай гэсэн 8 төрлөөр зохион байгуулсан. Хороо, дүүрэг 2 үе шаттай тэмцээнд давхардсан тоогоор нийт 5880 гаруй иргэд хамрагдсан бөгөөд шалгарсан 200 гаруй тамирчид нийслэлийн иргэдийн спортын их наадмаас 4 алт, 2 мөнгөн 2 хүрэл нийт 8 медаль хүртэж багийн дүнгээр Тэргүүн байранд шалгарсан. 2023 онд Дүүргийн Иргэдийн спортын XI их наадмыг 2023 оны 05 сараас 11 сарын хооронд 3-үе шаттайгаар явган аялал, орс таталт, сагсан бөмбөг, волейбол, хийн дасгал, аэробик, софт волейбол, ширээний шагайн наадгай, дартс зэрэг спортын 9 төрлөөр зохион байгуулж, 25 хорооны нийт 4900 иргэн хамруулсан. Нийслэлийн иргэдийн спортын XI их наадмын нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнд шалгарсан 150 баг тамирчид оролцож, алтан медаль-4 ширээний шагай /эм/, хийн дасгал, сагс бөмбөг /эр/, дартс, мөнгөн медаль-1 явган аялал, хүрэл медаль-3 орс таталт /эр, эм, сагсан бөмбөг /эм/ нийт 7 медаль 38 оноогоор 1-р байр эзэлсэн. 2024 онд Дүүргийн Иргэдийн спортын XI их наадмыг 2024 оны 05 сараас 11 сарын хооронд 3 үе шаттайгаар спортын (явган аялал, орс таталт, сагсан бөмбөг, волейбол, хийн дасгал, аэробик, софт волейбол, ширээний шагайн наадгай, дартс, И-спорт) гэсэн 10 төрлөөр зохион байгуулж 24 хорооны нийт 6558 иргэн хамруулсан. Дүүргээс шалгарсан 116 тамирчин 2024 оны 09 дүгээр сарын 07-ноос 11 дүгээр сарын 27-ны хооронд спортын 9 төрлөөр зохион байгуулагдсан Нийслэлийн Иргэдийн спортын XII наадамд өрсөлдөж алтан медаль 4, мөнгөн медаль 3, хүрэл медаль 2 хүртэж багийн дүнгээр 9 дүүргээс тэргүүн байрт шалгарсан.	100%
	27	Нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг хөгжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. /Улаанбаатар Марафон, автомашингүй өдөр, спортлог Улаанбаатар өдөрлөг, гүйлт гэх мэт/	Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн тоо	Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаанд 4727 хүн оролцсон.	Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаанд 21100 аас доошгүй хүн хамруулна.	УТХО 14.91 ДТХО 295.86	2021-2024 онд Нийтийн биеийн тамирын томоохон арга хэмжээг 243 удаа зохион байгуулж хамрагдсан иргэдийн тоо 265992 хүрсэн байна. 2021 онд "Эрүүл мэндийн цахим гүйлт-2021" 14 хоногийн аян, "Дасгал хөдөлгөөн хийцгээ" идэвхтэй хөдөлгөөн дэмжих сарын аян, "Үндэстнээрээ нэг баг болон гүйцгээ" дэлхийн аварга шалгаруулах цахим гүйлт, "Хамтдаа алхаад эрүүлж" явган алхалтын аян, "Хан-Уул лиг" сагсан бөмбөгийн тэмцээн, "Цахим гимнастрида" арга хэмжээ, нийт биеийн тамир спортын 11 арга хэмжээнд 19,562 иргэн хамруулсан. 2022 онд "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аян, "Улаанбаатар марафон-2022" ОУ гүйлт, "Автомашингүй өдөр", "Хамтдаа алхаад эрүүлж" аян, "Алхацгаая гүйцгээ" явган алхалт, "УБ лиг" Волейболын фестиваль, дүүргийн ЕБС багш нарын тэмцээн, "Улаанбаатар Марафонд нэгдэцгээ" цом аялуулах аян, Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын аян, Иргэдийн спортын наадамд, ахмадууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулсан биеийн тамирын арга хэмжээ зэрэг нийт 92 арга хэмжээнд давхардсан тоогоор 125,286 иргэн хамрагдсан. 2023 онд "Хамтдаа хэвшүүл" 21 хоногийн аян, хороод болон ӨЭМТ-ийн ажилтан албан хаагчдын дундад спортын 3 төрөлт тэмцээн, СӨБ багш нарын тэмцээн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спорт арга хэмжээ, "Цаг гаргаа" аян, "Эрүүл мэндийн цахим гүйлт", дүүргийн аж ахуй нэгжүүдийн 3 төрөлт тэмцээн, цэцэрлэгийн хүүхдийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээн, дүүргийн залуучуудын сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн, "Улаанбаатар марафон 2023", Бүтээгч Хан-Уул өдөрлөг, Хамтдаа алхаад эрүүлж аян, Нийслэлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 6 төрөлт тэмцээн, Хан-Уул дүүргийн иргэдийн спортын XI их наадам, автомашингүй өдөр нэгдсэн арга хэмжээ, "Хүмүүнлэгийн од" волейболын тэмцээн зэрэг нийт 73 томоохон арга хэмжээнд 1016 байгууллагын 64,527 иргэдийг хамруулсан. 2024 онд "Хамтдаа хэвшүүл" 21 хоногийн аян, "Эко дүүргийн спортлог иргэн" өдөрлөг, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээн, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "cheerleading" хөгжөөн дэмжигчдийн аварга шалгаруулах тэмцээн, "Улаанбаатар Марафон-2024", "Хамтдаа алхаад эрүүлж" явган алхалт, Хөжөйн тэмцээн, "Авто машингүй өдөр 2024", Нийслэлийн Иргэдийн спортын XII наадам, Соёлын бүтээлч сар 2024 явган аялалын тэмцээн, спортын 12 төрлийн сургалт зэрэг нийт 67 арга хэмжээнд 690 байгууллагын 56617 иргэнийг хамруулсан	100%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
	28	Өвлийн спортын үйл ажиллагааг өргөжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	Өвлийн улиралд зохион байгуулагдсан арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо	Өвлийн улиралд зохион байгуулагдсан арга хэмжээнд 3500 хүн хамрагдсан.	Оролцогчдын тоог 15600-аас доошгүй хүн хамруулна.	ДТХО 22.35	2021-2024 онд Монголын хүүхдийн өвлийн спортын VII наадам, Монголын Бүх ард түмний өвлийн спортын XVI наадам, "Мөнгөн Хан-Уул", "Илүүдэл жингүй эртэч Монгол", "Хамтдаа алхаад эрүүлжэе" зэрэг өвлийн спортын 16 арга хэмжээнд давхардсан тоогоор 61451 иргэд хамрагдсан. Үүнд; 2021 онд Коронавирусын халдварт (ковид19) цар тахлын улмаас зохион байгуулах боломжгүй болсон. 2022 онд Дүүргийн хэмжээнд өвлийн спортын чиглэлээр биеийн тамирын "Илүүдэл жингүй эртэч Монгол" аяны хүрээнд зохион байгуулсан 3 удаагийн спорт өдөрлөгт 26 байгууллагын 2025 иргэн, Үндэсний спортын их наадмын Шагайн харваа, Сурын харваанд 260 иргэн, "Хамтдаа алхаад эрүүлжэе" алхалтыг өвлийн улиралд 4 удаа зохион байгуулж 261 иргэн, нийт 9 арга хэмжээнд 2546 иргэн хамруулсан. 2023 онд "Мөнгөн Хан-Уул" өвлийн биеийн тамир спортын арга хэмжээг 4 удаа зохион байгуулж, 79 байгууллагын нийт 1153 иргэн, албан хаагч, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмын 4 төрөлд 53 тамирчин, Монголын Бүх ард түмний өвлийн спортын XVI наадмын шигшээ тэмцээний 3 төрөлд 9 тамирчин тус тус оролцсон бол дүүргийн хэмжээнд цанын бааз-1, мөсөн гулгуурын задгай талбай -1, битүү 2 талбайд 27720 иргэн, хүүхэд, залуусыг хичээллүүлж, өвлийн спортын арга хэмжээнд нийт 28.935 иргэн хамрагдсан. 2024 онд Зайсангийн аманд амарч чөлөөт цагаа өнгөрүүлж буй хүүхэд залуусын дунд зохион байгуулсан өвлийн арга хэмжээ, байгууллагын цасны баяр, "Эко дүүргийн спортлог иргэн" өдөрлөг зэрэг 3 арга хэмжээнд 250 иргэнийг хамруулж, "Мисшээл танин мэдэхүйн төв"-ийн бэсрэг 1 цанын бааз, 4 мөсөн гулгуурын талбайд давхардсан тоогоор 29,720 иргэд, хүүхэд, залуусыг хичээллүүлсэн. Өвлийн спортын арга хэмжээнд нийт 29,970 иргэн хамрагдсан.	100%
2.1.2 Дүүргийн төрийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд Засаг даргын нэрэмжит нээлттэй тэмцээнийг жил бүр зохион байгуулна.	29	Дүүргийн Засаг даргын нэрэмжит нээлттэй тэмцээнийг ААН-үүдийн дунд жил бүр зохион байгуулна.	Хамрагдсан албан хаагчдын тоо	Тэмцээнд дүүргийн төрийн болон хувийн аж ахуй нэгж байгууллагуудын 860 албан хаагчид хамрагдсан.	Спортын арга хэмжээнд дүүргийн төрийн болон хувийн аж ахуй нэгж байгууллагуудын 3500-аас доошгүй албан хаагчийг хамруулсан байна.	ДТХО 20.0	2021-2022 онд Коронавирусын халдварт (ковид19) цар тахлын улмаас зохион байгуулах боломжгүй болж, хойшлуулсан. 2023 онд дүүргийн Засаг даргын нэрэмжит тэмцээнийг спортын 3-5 төрлөөр ахмад, залуучууд, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжийн дунд зохион байгуулж, давхардсан тоогоор 84 байгууллага, аж ахуйн нэгжийн 1164 ажилтан, албан хаагч, иргэд хамрагдсан. 2024 онд Хан-Уул дүүргийн "Спортлог багш-2024" тэмцээнд дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн 35 сургуулийн 1250 гаруй багш ажилчид 6 төрлөөр ороцож, багийн нийт дүнгээр "Орчлон" сургууль тэргүүн байр эзэлж, амжилттай зохион байгуулсан.	90%
2.1.3 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор фитнес болон спорт клубүүдийг бодлогоор дэмжиж, иргэдийн эрэлт хэрэгцээ, сонирхолд нийцсэн спорт клуб байгуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлнэ.	30	Фитнес болон спорт клубүүдтэй хамтран иргэдийн эрэлт хэрэгцээ, сонирхолд нийцсэн спорт клуб байгуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлнэ.	Шинээр байгуулсан клуб, тоо	3 клубтэй хамтран ажилласан.	4-8 төрлийн сайн дурын клуб байгуулсан байна.		2021-2024 онд Хан-Уул дүүргийн хэмжээнд тогтмол үйл ажиллагаа явуулж буй спорт клуб жил бүр нэмэгдсээр 2024 оны байдлаар нийт 84 болж спортоор хичээллэх орчны хүртээмж нэмэгдсэн байна. 2021 онд тус дүүрэгт фитнес клуб-23, усан бассейн-12, спорт заал-67 нийт 102 байгууллага үйл ажиллагаагаа явуулж байсан. 2022 онд Шинээр жүдогийн 3, шатрын 1, таеквондогийн 1, фитнесийн 2 нийт 7 спорт клуб нээгдэн дүүргийн хэмжээнд спортын 13 клуб үйл ажиллагаа явуулж 887 иргэн спортоор хичээллэдэг болсон. 2023 онд Дүүрэгт тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа 77 спорт клубээс магадлан итгэмжлэгдсэн клуб 1 ажиллаж байна. Шинээр 8 дугаар хороонд волейбол, бужиг, гийр, кардио дасгалын клуб, 11 хороонд буудлагын SNIPER клуб, 1 дүгээр хороонд Таеквондогийн "Эхлэл" клуб тус тус байгуулагдсан. 2024 онд 3 дугаар хороонд "Хос аварга" таеквондогийн клуб, "Сүлд" бужигийн клуб, 9 дүгээр хороонд шинээр боксын "Radiance boxing club", 15 дугаар хороонд Жүдо бөхийн "Эхлэл" клуб, 20 дугаар хороонд "Өргөө гирийн академ", "Хантайшир" үндэсний бөхийн клуб, "Алдартан" таеквонда клуб, "Хобби" боксын клуб зэрэг 8 спорт клуб шинээр байгуулагдан хамтран ажиллаж байна.	100%
2.1.4 Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийг өргөжүүлэн өсвөр үе, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх замаар дэмжлэг үзүүлж, амжилтыг ахиулна.	31	Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийн үйл ажиллагааг нь дэмжин ажиллана.	Шинээр байгуулагдсан шигшээ багийн тоо	Спортын 10 төрлөөр шигшээ баг байгуулж спортын үйл ажиллагааг нь дэмжсэн.	Спортын 16-аас доошгүй төрлийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжсэн байна.	УТХО 40.4 ДТ 170.3 Бусад 18.1	2021-2024 онд дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ баг спортын 11-12 төрлөөр хичээллэж, Улсын чанартай 39 тэмцээнээс алтан медаль-148, мөнгөн медаль-127, хүрэл медаль-190 нийт 465 медаль хүртсэн амжилт үзүүлсэн. 2021 онд Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ баг нь 10 спортын төрлөөр 250 тамирчдын бүрэлдэхүүнтэйгээр бэлтгэл сургуулилтаа хийж, шигшээ багийн 54 удаагийн цахим хичээлийг пйж хуудсуудад байршуулан 20,050 хүнд хүргэсэн байна. Өсвөрийн шигшээ багийн тамирчид жүдо бөхийн УАШТ-ээс 5 алт, 2 мөнгө, 6 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр I-р байр, Софт теннисний УАШТ-д багийн дүнгээр II байрт шалгарсан. . 2022 онд Засаг даргын дэргэд өсвөрийн хөлбөмбөг, сагс, волейбол, чөлөөт бөх, жүдо, тэшүүр, ширээний тэннис, даам, софт теннис, крикетийн шигшээ баг хичээллэж байсан бол 2022 онд хоккей, боксын спортын баг шинээр байгуулагдаж спортын 12 төрлөөр 376 тамирчин бэлтгэл сургуулилтаа хийж байна. 2023 онд Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ баг нь хоккей, бокс спортын 2 төрлийн багш сонгон шалгаруулж авснаар нийт 11 төрлөөр 310 тамирчин бэлтгэж байна. Дүүргийн өсвөрийн шигшээ багийн тамирчид улсын хэмжээнд спортын 11 төрлөөр 37 удаагийн тэмцээнд 687 тамирчин оролцож алтан медаль 69, мөнгөн медаль 54 хүрэл медаль 93 нийт 216 багц медаль хүртээд байна. 2024 онд Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ баг спортын 10 төрлөөр 64 дасгалжуулагч багштай, 641 тамирчин бэлтгэж байна. Өсвөрийн шигшээ баг улсын чанартай тэмцээнд спортын 16 төрлөөр 699 тамирчин оролцож алтан медаль 74, мөнгөн медаль 71, хүрэл медаль 91 нийт 236 багц медаль хүртсэн.	100%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
	32	Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийг Олон улсын уралдаан тэмцээнд бэлтгэж оролцуулна.	Оролцсон олон улсын спортын наадмын тоо		Дүүргийн өсвөрийн шигшээ баг тамирчдыг 2 оос доошгүй Олон улсын чанартай уралдаан, тэмцээнд бэлтгэн оролцуулна	ДТ 84.5	2021-2024 онд Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ баг спортын 11 төрлөөр хичээллэж, Олон улсын чанартай 28 тэмцээнд 110 тамирчин оролцож алтан медаль-26, мөнгөн медаль-23, хүрэл медаль-27 нийт 76 медаль хүртэн амжилт үзүүлж, тив, дэлхийд эх орныхоо нэрийг дуурсгаад байна. 2022 онд Засаг даргын дэргэдэх Өсвөр үе, залуучуудын шигшээ багаас олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах 7 тэмцээнд 29 тамирчин оролцож алтан медаль-10, мөнгөн медаль-5, хүрэл медаль-4 нийт 19 медаль хүртсэн амжилт үзүүлсэн. 2023 онд Засаг даргын дэргэдэх Өсвөр үе, залуучуудын шигшээ багаас олон улс, тив, дэлхийн 9 тэмцээнд 34 тамирчин оролцуулж, 5 алт, 3 мөнгө 12 хүрэл, нийт 20 медаль хүртсэн. 2024 онд Засаг даргын дэргэдэх Өсвөр үе, залуучуудын шигшээ багаас Олон улсын 12 тэмцээнд 47 тамирчин оролцож алтан медаль 11, мөнгөн медаль 15, хүрэл медаль 11, нийт 37 багц медаль хүртсэн.	100%
2.1.5 Иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулсан стандарт талбай, спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	33	Дүүргийн спорт цогцолборын барилга шинээр барих ажлыг хэрэгжүүлнэ.	Спорт цогцолборын барилгын ажлын явц		Спорт цогцолборын барилга ашиглалтад орсон байна.		2021-2024 онд 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт "Оюуны спортын ордон"-ы барилга /шатрын их танхим 2, жижиг танхим 2, спортын холбоодын 6, амрах өрөө 18, хоолны заал, бие тамирын заал болон бусад оффис өрөө тасалгаатай/ "85%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Мөн дүүргийн спорт хорооны барилгын спорт заалны иж бүрэн засвар болон дотор болон гадна фасад, дээвэр засварын ажлыг гүйцэтгэсэн. 2021-2022 онд Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт, Яармагийн урд дэнж, Нүхтийн замын баруун талд Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/891 дүгээр захирамжаар "Спорт цогцолбор"-ын зориулалтаар 2.5 га газар олгогдож, зураг төсвийн зөвлөх үйлчилгээний тендер зарлагдаж гүйцэтгэгээр "Классик хаус" ХХК шалгарч гэрээ байгуулсан. 2023 онд Сагсан бөмбөг, бокс, ресторан, фитнес, хурлын заал, ширээний теннис, ханын теннис, байт харваа, усанд сэлэлт, шатар даам, бөхийн танхимууд болон бусад дагалдах өрөө тасалгаануудтай, 586 үзэгчийн суудалтай Спорт цогцолборын загвар зураг батлагдсан. Ажлын зураг төсөв боловсруулах шатанд газрын маргааны улмаас түр зогссон. Газрын асуудал шийдвэрлэгдсэний дараа зураг төсвийн ажлыг үргэлжлүүлнэ. 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хэрэгжиж буй Оюуны спортын ордны барилгын гүйцэтгэгчээр "Бианконэро констракшн" ХХК шалгарсан, барилга угсралтын ажил 85%-ийн гүйцэтгэлтэй байна. Тус барилга нь шатрын их танхим 2, жижиг танхим 2, спортын холбоодын 6, амрах өрөө 18, хоолны заал, бие тамирын заал болон бусад оффис өрөө тасалгаатайгаар тус тус төлөвлөгдсөн. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн спорт хорооны барилгын спорт заалны иж бүрэн засвар болон дотор засварын ажлыг "Сонгинотамир" ХХК гүйцэтгэж дууссан. Мөн тус барилгын гадна фасад дээвэр засварын ажлыг "Тод Олз" ХХК гүйцэтгэж дууссан.	30%
2.1.5 Иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулсан стандарт талбай, спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	34	Нийтийн эзэмшлийн талбай болон Ерөнхий боловсролын сургуулийн гадна талбайд спорт талбай байгуулна	Шинээр болон сэргээн засварлагдсан спортын талбайн тоо	Нийт 8 спорт талбай байна.	15 байршилд спорт талбай байгуулсан байна.	НТХО 2,009.0 ДТХО 3,203.7 ДОНХС 900.0 ААНБ 80.0	2021-2024 онд 1 спорт заалны барилга, 5 спорт заалны иж бүрэн засвар, 3х3 сагсан бөмбөгийн 34, 5х5 сагсан бөмбөгийн 5, хөлбөмбөгийн 2, 3 цэцэрлэгийн гадна талбайд мини спорт талбай, 5 байршилд олон төрөлт спорт талбай нийт 55 байршилд спортын барилга байгууламж, спорт талбай ашиглалтад оруулж хүртээмжийг нэмэгдүүлнэ. 2021 онд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 3-р хороо, 15-р сургуульд иж бүрэн спорт заал, 14-р хороонд 3х3 сагсан бөмбөгийн талбай, дүүргийн төсвийн хөрөнгөөр 9-р хороо, 114-р сургуулийн гадна талбайд сагсан бөмбөгийн талбай тус тус ашиглалтад орсон. 2022 онд Нийслэл, дүүргийн төсөв болон төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд 2, 12, 13, 17-р хорооны 6 баршилд байршилд 3х3 сагсан бөмбөгийн талбай, 1, 2, 12, 16 дугаар хорооны 4 байршилд 5х5 сагсан бөмбөгийн талбайн ажил, 1, 4-р хорооны 34, 52-р сургуулийн хөлбөмбөгийн талбай нийт 12 спорт талбай ашиглалтад орсон. 2023 онд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1, 13, 21-р хорооны 4, дүүргийн төсвийн хөрөнгөөр 10, 14-р хорооны 2, нийт 6 байршилд 3х3 талбай, 5, 7, 14-р хорооны 3 цэцэрлэгийн гадна талбайд мини сагсан бөмбөг, хөл бөмбөгийн талбай, 60 дугаар сургуулийн спорт талбай, 7-р сургуулийн спорт заалны иж бүрэн засварын ажил тус тус хийгдсэн. 2024 онд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1, 8, 12, 14, 17, 24, 25 дугаар хорооны 12 байршилд 3х3 сагсан бөмбөгийн талбай, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна талбайд 5х5 сагсан бөмбөгийн талбай, талбайн теннис, чийрэгжүүлэлтийн талбай бүхий спорт талбай, дүүргийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 4, 12, 14, 15, 20, 24, 25 дугаар хорооны 8 байршилд 3х3 сагсан бөмбөгийн талбай, 130 дугаар сургуулийн гадна газар чөлөөлж спорт талбай байгуулах, 7, 89 дүгээр сургуулийн гадна спорт талбайн засвар, шинэчлэлт хийх, дүүргийн Спорт хороо, 10, 34, 156 дугаар сургуулийн спорт заалны иж бүрэн засварын ажил тус тус хэрэгжиж дууссан.	100%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
2.2. Эрүүл мэнд								
2.2.1 Иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх, зөвлөгөө, мэдээллээр хангах, зорилгоор "Цахим эмч" онлайн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлнэ.	35	Иргэд өөрсдөө чихрийн шижин, цусны даралт зэрэг зонхилон тохиолдох өвчний өдөр тутам хянах, онлайн зөвлөгөө, үйлчилгээ авах цахим системийг нэвтрүүлнэ.	Онлайн зөвлөгөө өгөх үйлчилгээний хувь	-	"Цахим эмч" систем ашиглаж эхэлсэн байна.		2022 онд Эрүүл мэндийн яамны дуудлагын нэгдсэн "Цахим эмч 119" дугаартай холбох CallPro үйлчилгээг Эрүүл мэндийн төвийн 341003, Нэгдсэн эмнэлгийн 70049255 дугаарын утсанд холбон нарийн мэргэшсэн Цахим эмч ажлын байранд 4 эмч 24 цагаар "ковид, томуу, зөвлөгөө мэдээлэл" гэсэн 3 үндсэн үйлчилгээний цэцстэй зөвлөмж үйлчилгээ үзүүлсэн. 2023-2024 онд Нэгдсэн эмнэлгийн салбар Амбулаторийн 2 давхарт 9 өрөөтэй "Телемедицин төв" байгуулагдаж, насанд хүрэгчдийн зайн үзлэг оношилгоо хийх иж бүрэн компьютеруудын, сүлжээ, тоног төхөөрөмжөөр хангагдан үйл ажиллагаа явуулах бэлтгэл хангаж байна.	80%
2.2.2 Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулан өвчлөлийг бууруулна.	36	Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, өвчлөлийг бууруулна.	Артерийн даралт, чихрийн шижин, Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлгийн хувь	Артерийн даралт, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт 80 хувь, Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 37,6 хувь, хөхний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 78 хувьд хүргэж эрт хувь хамрагдсан.	Артерийн даралт, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт 80 хувь, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 37,6 хувь, хөхний хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтыг 80 хувьд хүргэж эрт үед нь эмчилсэн байна.		2021-2024 оны 4 жилийн дунджаар Артерийн даралт эрт илрүүлэг үзлэгт 74%, Чихрийн шижин хэв шинж-2 давтан үзлэгт 75.9%, Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгт 37.7%, хөхний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 72.2% хамрагджээ. 2021 онд дүүргийн 18 дээш насны 112848 иргэнээс Артерийн гипертензийн анхны үзлэгт 74,325 /65.8%, Чихрийн шижин хэв шинж-2 эрт илрүүлгийн анхны үзлэгээр 60381 /53.5%/, Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгт 10380 эмэгтэй хамрагдахаас 2642 (25%), Хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт зорилтот бүлгийн 46519 эмэгтэй хамрагдахаас 28469 (61%) 2022 онд Артерийн даралтын эрт илрүүлэг үзлэгт 118527 хүн хамрагдахаас 97861 буюу 82.5%, Чихрийн шижин хэв шинж эрт илрүүлэг үзлэгт 86821 буюу 73.2%, Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 14,450 эмэгтэй хамрагдахаас 5,501 буюу 38%, Хөхний хавдрын илрүүлэг үзлэгт 60,436 эмэгтэй хамрагдахаас 42,891 буюу 71% тус тус хамрагдсан. 2023 онд Хан-Уул дүүргийн 18-аас дээш насны эрэгтэй 64631, эмэгтэй 78943 нийт 143574 хүн амаас Артерийн даралт ихсэх өвний эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд 104971 буюу 72%, "Чихрийн шижин, хэв шинж 2" эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 35-аас дээш 89860 хүн амаас үзлэг оношилгоонд 93%, Умайн хүзүүний /3 жилийн давтамжтай / эрт илрүүлэг үзлэг, оношилгоонд хамрагдвал зохих 30-аас 60, түүнээс дээш насны 14301 зорилтот эмэгтэйчүүдээс 7100 буюу 50%, Хөхний үзлэг оношилгоонд хамрагдвал зохих 20-оос дээш насны зорилтот 58138 эмэгтэйгээс 49644 буюу 85%-ийн хамрагдсан. 2024 онд дүүргийн хэмжээнд халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг оношилгоонд хамрагдвал зохих 18-аас дээш насны нийт 153324 хүн амаас эрэгтэй 69000, эмэгтэй 84324 байна. Үүнээс; Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд 116209 буюу 75.7%, "Чихрийн шижин, хэв шинж" эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 35-аас дээш насны 99164 иргэний 83511 иргэн буюу 84%, Умайн хүзүүний /3 жилийн давтамжтай / эрт илрүүлэг үзлэг, оношилгоонд хамрагдвал зохих зорилтот бүлгийн 30-60 насны 16484 нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдээс 6287 эмэгтэй буюу 38%, Хөхний үзлэг оношилгоонд 20-с дээш насны хамрагдвал зохих 55864 эмэгтэйгээс 40275 буюу 72%-нь хамрагдсан.	90%
	37	БЗДХ/ДОХ, сүрьеэ халдварт гепатит болон бусад халдварт өвчний илрүүлэлтийг нэмэгдүүлж, эмчилгээнд хамруулна.	ХДХВ/БЗДХ-ын идэвхтэй эрт илрүүлэгэд хамрагдсан иргэдийн тоо	ХДХВ/ДОХ/БЗДХ-ын идэвхтэй эрт илрүүлэг 5960, гепатитын тохиолдлын түвшин-0.8.	Халдварт өвчний урьдчилан сэргийлэх үзлэгт 6500 иргэнийг хамруулж, эрт үед нь эмчилсэн байна.		2021-2024 онд нийт 63845 иргэн урьдчилан сэргийлэх үзлэгээс 35817 хүн идэвхтэй илрүүлэгт хамрагдаж, 416 шинэ тохиолдол илэрч, 100% эмчлүүлэн эдгэрсэн байна. 2021 онд Эрүүл мэндийн төвийн ДОХ/БЗДХӨ-ний кабинетаар урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 3,049 иргэнийг хамруулж, 18 өвчлөлийг эрт илрүүлэн, 100 хувь эмчилгээнд хамруулсан. 2021 онд Нийт 4,939 иргэн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсанаас тохиолдлын түвшин 0.37 байгаа нь өмнөх оны түвшнээс 0.43-р буурсан байна. 2022 онд Эрүүл мэндийн төвийн кабинетын үзлэгт 9498 иргэн хамрагдсан нь өмнөх оны суурь түвшингээс 38%-иар илүү байгаа бөгөөд 101 өвчлөл бүртгэгдсэнийг 100% эмчилсэн. 2023 онд 2023 оны статистик тоо мэдээгээр сүрьеэ, халдварт, БЗДХ/ДОХ -ын кабинетээр диспансерийн хяналт-2223, урьдчилан сэргийлэх үзлэг -19032, амбулаторын үзлэг-8115, дуудлага-3, нийт 29373 иргэнд үзлэг хийж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн. Үүнээс: Идэвхтэй эрт илрүүлэгт хамрагдсан 15335 иргэнээс 157 шинэ тохиолдол илэрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бэлгийн замаар дамжих халдварт өвчлөл 58 тохиолдлоор буюу 2.1 промилоор өссөн үзүүлэлттэй байна. Шинэ илэрсэн тохиолдлоос Тэмбүү -103 /жирэмсэн 27/, Заг хүйтэн-41, Трихомониаз-13 халдвар илэрснийг 100% эмчилсэн. 2024 онд 2024 оны байдлаар ДОХ/ХДХВ/БЗДХ-үзлэгт 20035 иргэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлснээс идэвхтэй эрт илрүүлэгт 6045 иргэн хамрагдаж, шинэ илэрсэн өвчлөлийн 140 тохиолдол илэрснээс Тэмбүү -84 /жирэмсэн 23/, Заг хүйтэн-45 /жирэмсэн-1/, Трихомониаз-11 /жирэмсэн-3/ халдвар илэрснээс эрүүлжүүлэлт 100% эмчилсэн.	100%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
	38	Сүрьеэгийн эрт илрүүлгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг хангах зорилгоор сүрьеэгийн төвийн тоног төхөөрөмжийн хүчин чадал, тоог нэмэгдүүлнэ.	Сүрьеэ өвчний тохиолдлын түвшин	Сүрьеэгийн шинэ тохиолдлын түвшин 10000 хүн тутамд 11.9 байна.	Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, шинэ тохиолдлын түвшин 10000 хүн тутамд 11.5-д хүргэнэ.		2021-2024 онд Сүрьеэгийн тохиолдлын түвшин 10000 хүн тутамд 5.7 промилль болж эрс буурсан боловч 2022-2024 онуудад 124-143 тохиолдолд бүртгэгджээ. 2021 онд Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх амбулаторийн үзлэгт 5066 хүн хамрагдсан байна. Үүнээс илэрсэн уушгины сүрьеэ 305 хүн байгаагаас эмэнд мэдрэг сүрьеэтэй 269 хүн, эмэнд тэсвэртэй сүрьеэтэй 36 хүн хяналтад байна. шинэ сүрьеэгийн тохиолдлын түвшин 6.0 промилль буюу 10,000 хүн тутамд 6.0 болж буурсан байна. 2022 онд Дүүргийн хэмжээнд 141 шинэ сүрьеэ бүртгэгдэж, эмчлүүлсэн бөгөөд тохиолдлын түвшин 10000 хүн тутамд 7.2 промилль байна. Сүрьеэгийн эрт илрүүлэг 23%-тай байгаа нь өмнөх оныхоос 3 хувиар нэмэгдлээ. 2023 онд амбулаторийн үзлэг 3566, Диспансерийн үзлэг 1633, Урьдчилан сэргийлэх үзлэг 6612, дуудлага-3, нийт 11814 иргэнд үзлэг хийсэн. Үүнээс шинэ сүрьеэтэй-124, дахилт-14, шилжиж ирсэн-4, бусад-8, эмэнд тэсвэртэй сүрьеэ-13, нийт 168 тохиолдлыг эмчилгээнд хамруулан эмчилгээг 6-8 сар хяналтад байна. Сүрьеэгийн 124 шинэ тохиолдол илрүүлж эмчилсэн нь 10000 хүн амд 5.5 промилль байна. Энэ нь 2022 онтой харьцуулахад 4 тохиолдол буюу 0,8 промилльээр буурсан. 2024 онд Амбулаториор 2251, диспансерийн хяналтаар 3216, урьдчилан сэргийлэх 4617 нийт 10084 иргэнд үзлэг хийж, оношилгоо, шинжилгээнд хамруулсан. Үүнээс шинэ сүрьеэгийн 143 тохиолдол илрүүлж эмчилгээнд хамруулсан нь 10000 хүн амд 5.7 промилль байна. Энэ нь 2023 оны мөн үетэй харьцуулахад 19 тохиолдол / 0.2 промилль/-ээр өссөн байна.	100%
	39	Товлолт дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдлыг бууруулна.	Халдварт өвчний товлот дархлаажуулалт, ковид-19 халдварын эсрэг вакцины хамралтын хувь	Тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний товлот дархлаажуулалтын хамралт 96.7 хувь.	Товлолт дархлаажуулалтын хамралтыг 98.5 хувьд хүргэсэн байна. ковид-19 халдварын эсрэг вакцины хамрагдалтыг нэмэгдүүлэх.		2021-2024 онд хүүхдийн товлот дархлаажуулалтад 95-98.8 хувийн хамрагдалтай байсан бол "Ковид-19" халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 2021-2023 онд давхардсан тоогоор /1-р тунд 153,188,776, 2-р тунд 160,146,015, 3-р тунд 77,625, 4-р тунд 11,241, 5-р тунд 162/ нийт 313,423,819 иргэн хамрагдсан. 2021 онд 0-2 насны хүүхдийн товлот дархлаажуулалтад хамрагдвал зохих нийт 29,142 хүүхдээс 28,810 хүүхэд буюу 98.8%, коронавирусийн халдварын /КОВИД-19/ эсрэг дархлаажуулалтад хамрагдвал зохих 133544 хүнээс 1 тунд 177,427, 2 тунд 175,325, 3 тунд 45,825 хүн хамрагдаж дархлаажуулалтын 1, 2-р тунгийн хамрагдалт 99.7%-д хүрсэн. 2022 онд товлотт вакцины бүрэн тунгийн хамралт 95%, ковид-19 халдварын эсрэг дархлаажуулалтын 11 цэгийг ажиллуулан 1-р тунд 761, 2-р тунд 991, 3-р тунд 10136, 4-р тунд 11083, 5-р тунд 115 иргэнийг хамруулж өссөн дүнгээр 1-р тунд 153,188,761, 2-р тунд 160,145,991, 3-р тунд 77,538, 4-р тунд 11,214, 5-р тунд 158 иргэнд үйлчилсэн. 2023 онд Товлолт дархлаажуулалтанд давхардсан тоогоор 70330 хүүхэд хамрагдахаас 70063 хүүхэд 99.6% хамрагдсан. "Ковид-19" халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 1-р тунд 15, 2-р тунд 24, 3-р тунд 87, 4-р тунд 27, 5-р тунд 4 иргэн, нийт-157 иргэнийг хамруулсан. 2024 онд Халдварт болон халдварт бус өвчний товлот дархлаажуулалтад давхардсан тоогоор товлот дархлаажуулалтад давхардсан тоогоор 66003 хүүхдээс 65653 хүүхэд буюу 9.5% хамрагдсан байна.	100%
2.2.3 Дүүргийн Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет байгуулна.	40	Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинет байгуулна.	Байгуулсан эрэгтэйчүүдийн кабинетын тоо	Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийн кабинетгүй байна.	Кабинет тохижуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	ДТ 22.0	2023 онд Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэгт Эрчүүдийн кабинетийг байгуулах бэлтгэл ажлын хүрээнд мэс заслын 1 эмчийг урологийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх 6 сарын сургалтад хамруулж, төгссөн бөгөөд 943 иргэнд үзлэг оношлогоо хийж, мэс засал хийлгэх шаардлагатай нийт 103 иргэнийг лавлагаа шатлалын эмнэлэгт илгээсэн. Мөн цэргийн насны залуучуудад урьдчилан сэргийлэх үзлэг хийж 46 үйлчлүүлэгч өвчтэй буюу мэс засал эмчилгээ хийлгэх шаардлагатай болохыг илрүүлсэн бөгөөд эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна."Жендэрийн эрх тэгш байдлыг хангах" дэд хөтөлбөрийн санхүүжилтээр Нэгдсэн эмнэлгийн яармаг амбулаторт эрэгтэйчүүдийн кабинет шинээр байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлсэн. 2024 онд Эрэгтэйчүүдийн кабинетын амбулаторын үзлэгт Эрүүл мэндийн төв 287, Нэгдсэн эмнэлэг 1316, нийт 1603 иргэн хамрагдсан. 5 иргэнд мэс ажилбар хийж, онош тодруулах шаардлагатай 20 иргэнийг лавлагаа шатлалд илгээсэн. Андрологийн кабинетэд шаардлагатай коагуляцын түлэгч аппарат, мэс заслын хажуугийн гэрэл, отсос, орхиодометр аппарат нийлүүлснээс гадна давсагны үлдэгдэл шээс хэмжих bladder scanner аппараттай болсоноор давсагны эргэшгүй өөрчлөлтээс урьдчилан сэргийлж, түрүү булчирхайн томролын зэргийг эрт үед нь оношлох боломж бүрдсэн.	100%
2.2.4. Эх хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулна.	41	Эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	Жирэмсний эхний 3 сарын хяналтад орсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь	Жирэмсэн эмэгтэйчүүдийн 90.9 хувь нь жирэмсний эхний 3 сард хяналтад хамрагдсан.	Жирэмсний эхний 3 сарын хяналтыг 90,9 хувьд хүргэнэ.		2021-2024 онд шинээр жирэмсний хяналтад орсон 16200 эмэгтэйн 14839 буюу 91.5% нь эрт хяналтад орсон. 2021 онд Шинээр жирэмсний хяналтад орсон 4172 эхээс 3796 буюу 91 хувь эрт хяналтад орсон. 2022 онд Шинээр жирэмсний хяналтад орсон 2667 эхээс 2466 буюу 92.5% нь эрт хяналтад хамрагдсан. 2023 онд Шинээр жирэмсний хяналтад орсон 4598 эхээс 4189 буюу 91.1 хувь нь эрт хяналтад орсон байна. 2024 онд Дүүргийн хэмжээнд жирэмсний хяналтад бүртгэгдсэн 4,763 эмэгтэйдээс 4,388 буюу 92.1% нь 0-3 сартай эрт хяналтад орсон байна.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
	42	Хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулна.	0-1, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин	0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 6.2 байна. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1.0 байна.	0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 6.2 байна. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 0.97 байна.		2021-2024 онд 0-1 насны хүүхдийн эндэгдэл дунджаар 7.8 промилль, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 1.2 промилль байгаа бөгөөд эндэгдлийн гол шалтгаан нь амьсгалын тогтолцооны өвчлөл эрс нэмэгдсэн, мөн ахуйн осол гэмтэл, төрөлхийн эмгэг гажиг, хожуу төрөлт, эрүүл мэндийн боловсрол дутмаг, ахуйн нөхцөл байдал, эхийн эрүүл мэндийн байдал зэргээс хамаарч байна. 2021 онд 0-1 хүртэлх насны нярайн эндэгдлийн түвшин 6.8 промилль, 1-5 насны хүүхдийн эндэгдлийн түвшин 0.7 промилль байна. Энэ нь амьсгалын тогтолцооны өвчлөл эрс нэмэгдсэн, мөн ахуйн осол гэмтэл, төрөлхийн эмгэг гажиг, хожуу төрөлт, ахуйн нөхцөл байдал зэргээс хамаарч байна. Эндэгдлийг бууруулах урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд нярайн асааргаа, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг асран хамгаалагч болон эцэг эхчүүд, эмч эмнэлгийн албан хаагчдад тогтмол зохион байгуулж байна. 2022 онд 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 28, өмнөх оноос 2 тохиолдлоор нэмэгдэж 7.6 промилль, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 7, өмнөх оноос 4 тохиолдлоор нэмэгдэж 1.7 промилль болсон байна. 2023 онд 0-1 насны хүүхдийн эндэгдлийн 35 тохиолдол бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 7.2 промилль, 1-5 насны хүүхдийн эндэгдлийн 4 тохиолдол бүртгэгдсэн нь 0.7 промилль байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 4 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. 2024 онд 0-1 насны хүүхдийн эндэгдлийн 37 тохиолдол бүртгэгдсэн нь 9.4 промилль, 1-5 насны хүүхдийн эндэгдлийн 4 тохиолдол бүртгэгдсэн нь 1.5 промилль байна. 0-1 насны хүүхдийн эндэгдлийн 40%-ийг төрөлхийн гажигтай хүүхэд, 60%-ийг эхийн эрүүл мэндийн байдал 40-өөс дээш насны хожуу төрөлт, эрсдэлт бүлэг эзэлж байна.	0%
2.2.5. “Эрүүл шүд - Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, амны хөндийн өвчлөлийг эрүүлжүүлэх, бууруулах арга хэмжээг зохион байгуулна.	43	СӨБ болон ЕБС-ийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл ахуйн боловсрол олгох сургалт, үзлэг зохион байгуулна.	Үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо	Үзлэгт 18628 хүүхэд, 189 багшийг сургалтад хамруулсан.	8000 хүүхэд, 8 үзлэг, 8 сургалт.	ДТ 23.6	2021-2024 онд дүүрэгт бүртгэлтэй 2-7 насны 91960 хүүхдээс давхардсан тоогоор 115860 хүүхэд амны хөндийн үзлэг хийлгэж, 81732 хүүхэд амны хөндийн эрүүл ахуйн сургалтад хамрагдан 68636 хүүхэд буюу 74,6% эмчлүүлсэн. 2021 онд амны хөндийн эрүүл мэндийн үзлэгт нийт 2925 хүүхэд хамрагдсан байна. Энэ жил хүүхдийн үзлэгийн эзлэх хувь өмнөх оноос даруй 27%-аар өссөн байна. Анхдагчаар 1945 хүүхэд үйлчлүүлснээс 816 буюу 42% эрүүлжүүлсэн байна. Энэ нь өмнөх оноос 12,1%-р өссөн байна. Нийт урьдчилан сэргийлэх үзлэгээс 131 хүүхэд буюу 7,2 % нь эрүүлжсэн бөгөөд сургалт, зөвлөгөөг 849 хүүхэд өгсөн Үзлэгт хамрагдсан нийт 2925 хүүхдээс 947 хүүхэд эмчлүүлж, эдгэрсэн. 2022 онд Амны хөндийн амбулаторийн үзлэгээр Эрүүл мэндийн төвд 2324, Нэгдсэн эмнэлэгт 2934 нийт 5258 хүүхэд хамрагдсан нь өмнөх жилээс 2333 хүүхдээр, нэмэгдэж, эмчилгээ үйлчилгээ хийлгэсэн. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд урьдчилан сэргийлэх үзлэгийн 6 удаагийн нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж нийт 20,343 хүүхэд үзлэг оношилгоо хийж, зөвлөгөө өгснөөс 8% нь эмчлүүлсэн. Нийт 25601 хүүхэд үзлэг хийж, 6885 хүүхэд эмчилж, эдгээсэн. 2023 онд Амбулаторийн шүдний үзлэгт 11265 хүүхэд, урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт 18316 хүүхэд, Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн шүдний үзлэгт 547 гаруй хүүхэд, нийт 30128 хүүхэдэд амны хөндийн үзлэг хийж, 18295 хүүхдийг эмчилж, 1785 хүүхдэд фторт түрхлэг түрхсэн. Мөн 100 орчим багш, эцэг эх, асран хамгаалагчдад амны хөндийн эрүүл ахуйн зөвлөгөө өгсөн. 2024 онд Хан-Уул дүүргийн хэмжээнд 2-17 насны 91960 хүүхдээс 57,206 хүүхдийг үзлэгт хамруулж, 88% эмчилсэн. Үүнд: "Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөрийн хүрээнд алслагдсан хороодын 4 цэцэрлэгийн 918 хүүхдүүдийг амны хөндийн үзлэгт хамруулж, фторт түрхлэг түрхэж Эрүүл мэндийн төвийн амбулаторийн үзлэгт 9,958, Нэгдсэн эмнэлгийн амбулаторын үзлэгт 5124, эрүүл мэндийн өдөрлөгөөр 106 хүүхэд, урьдчилан сэргийлэх үзлэгт ерөнхий боловсролын 23 сургуулийн 29811 сурагч, 38 цэцэрлэгийн 11289, нийт 57206 хүүхдийг амны хөндийн үзлэг оношилгоонд хамруулж, 50341 хүүхэд буюу 88% анагаасан.	100%
2.2.6. Үйлчилгээний жишигт нийцсэн Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг тодорхой бүсүүдэд барьж байгуулна.	44	Стандартын шаардлага хангасан байртай өрхийн эрүүл мэндийн төвийн тоог нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмж, хүчин чадлыг сайжруулна.	Шинээр баригдах өрхийн эрүүл мэндийн төвийн тоо	5 өрхийн эрүүл мэндийн төв түрээсийн байранд үйл ажиллагааг явуулж байна.	6 ӨЭМТ-ийн барилгыг барьж ашиглалтад оруулсан байна.	УТХО 3,409.5 ДТХО 7422.4	2021-2024 онд Хан-Уул дүүргийн 8, 12, 14, 15, 16, 21 дүгээр хороодод 6 Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга ашиглалтад оруулсан бол 11,17, 19, 20, 23, 24 дүгээр хороодод 6 /орон сууцны 1 давхарт/ хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн байр худалдан авч, нийт 12 байраар өрхийн эрүүл мэндийн төвүүдийг ханган анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн. 2021 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж буй 12 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын ажил дуусаж, ашиглалтад орсон. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 11, 19 дүгээр хороонд Хороо, өрхийн эрүүл мэндийн төв үйлчилгээ явуулах байр худалдан авсан. 2022-2023 онд Улсын төсвийн хөрөнгөөр 14 дүгээр хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн барилга, дүүргийн төсвийн хөрөнгөөр 21 дүгээр хороонд хэрэгжүүлсэн хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн цогцолбор барилгын ажил, 20, 23, 24 дүгээр хороонд хороо, өрхийн эмнэлгийн байр худалдан авах төсөл арга хэмжээг хэрэгжүүлээ. 2024 онд Улсын төсвийн хөрөнгөөр 8, 16-р хорооны өрхийн эрүүл мэндийн төв, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 15-р хорооны хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн цогцолбор барилгыг ашиглалтад оруулж, 17-р хороонд өрхийн эрүүл мэндийн төв үйл ажиллагаа явуулах байр худалдан авах төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн бол 10-р хороонд баригдаж буй өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын ажил 40%-ийн гүйцэтгэлтэй үргэлжиж байна.	100%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
2.2.7. Жишиг нэгдсэн эмнэлгийн загвараар дүүрэгт нэгдсэн эмнэлэг байгуулна.	45	Жишиг загвараар нэгдсэн эмнэлэг байгуулах хамтран зохион байгуулна.	Нэгдсэн эмнэлгийн барилгын ажлын явц	-	Нэгдсэн эмнэлэг ашиглалтад орсон байна.	ДТХО 327.9	Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээр болон зээлийн гэрээний дагуу Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороонд /Нэгдсэн эмнэлгийн хашаан дотор/ 11545 м2 цэвэр талбай бүхий төмөр бетон цутгамал хийцлэлтэй, зоориин давхраас гадна 4 давхар, 200 ор, 250 машины зогсоол, байгальд ээлтэй, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах технологи бүхий эмнэлгийн барилгын ажил явагдаж байна. Дүүргийн зүгээс барилгажих талбайд өртсөн 8 барилга байгууламж буулган газар чөлөөлснөөр эмнэлгийн барилга угсралтын ажил 2024 оны 05 сарын 20-ны өдрөөс эхэлсэн. 2024 оны 12 сарын 05-ны өдрийн байдлаар техникийн барилгын карзак үндсэн барилгын А блокын карзак цутгалт хийгдэж, ажлын гүйцэтгэл 30 хувьтай үргэлжилж байна. Эмнэлгийн барилга нийт 34.5 сая долларын санхүүжилттэйгээр хэрэгжих бөгөөд барилга угсралтаас гадна 64 нэр төрлийн 7,8 сая долларын эмнэлгийн тоног төхөөрөмж, тусламж үйлчилгээ явуулахад зайлшгүй шаардлагатай тавилга, хэрэгслүүд энэхүү хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдэхээр багтсан болно.	30%
2.2.8. Дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудыг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах, эмч, сувилагчдын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэжил дээшлүүлэх, иргэдэд чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээ хүргэх зорилгоор "Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	46	"Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	-	Хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна.		2021-2024 онд хөтөлбөрийн хүрээнд ковид 19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, эмч, эмнэлгийн ажилтны ур чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөлийг сайжруулах, эрүүл зөв дадал хэвшүүлдэд чиглэсэн спортын арга хэмжээ зэрэг 22 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Хан-Уул дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор 5 зорилт 12 төсөл арга хэмжээтэй "Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөрийг батлуулж, Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг авах, өвчлөлийг бууруулах зорилгоор Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо Туул тосгонд "100 ортой эмнэлэг бэлтгэх", Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн албан хэрэгцээнд "Автомашин худалдан авах", "Эмнэлгийн ор нэмж дэлгэх" болон "Өрхийн эрүүл мэндийн төвийн шуурхай алба" төслүүдийг хэрэгжүүлсэн. 2022 онд төлөвлөсөн 5 зорилтын 12 төсөл арга хэмжээнээс 10 арга хэмжээг бүрэн хэрэгжиж, 2 арга хэмжээ хэрэгжих шатанд, хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт 84 хувийн гүйцэтгэлтэй байна. 2023 онд хөтөлбөрийн 4, 5 дугаар зорилтын хүрээнд "Тусгай олимпын Дэлхийн зуны наадамд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлэх" төсөлд 4,5 сая, "14 дүгээр хорооны Өрхийн эрүүл мэндийн төвд тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх" төсөл 13,2 сая, нийт 17.7 сая төгрөгөөр 2 төсөл хэрэгжүүлсэн. 2024 онд "Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд 5 арга хэмжээ, 3 дугаар зорилтын хүрээнд 3 төсөл, 5 дугаар зорилтын хүрээнд 7 төсөл, арга хэмжээ, нийт 15 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн.	90%
	47	Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо	Гадаад сургалтад хамрагдсан эмч эмнэлгийн мэргэжилтний тоо 13 байна.	Үндсэн мэргэшлийн сургалтад 15-25 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдсан байна.	ДТХО 102.3	2021-2024 онд Итали, Вьетнам улсад 2, ОХУ-д 2 эмч мэргэшил дээшлүүлэх курсэд, 71 эмч, сувилагч, эмнэлгийн ажилтныг нарийн мэргэжлийн болон мэргэшүүлэх сургалтад хамрагдаж мэргэжил, ур чадвараа дээшлүүлжээ. 2021 онд эрчимт эмчилгээ-1, дотор судлал-1/ суралцаж, байгууллагын захиалгаар 1 эмч эрчимт эмчилгээгээр мэргэшиж, 1 туслах сувилагчийг сувилагчийн түргэвчилсэн дамжаанд, 2 үйлчлэгчийг туслах сувилагчаар тус тус суралцуулсан. 2022 онд Итали, Вьетнам улсад 2, ОХУ-д 2 сувилагч мэргэжил дээшлүүлж, нийт 18 эмч, эмнэлгийн ажилтан үндсэн мэргэшлийн сургалтанд, 86 эмч, эмнэлгийн ажилтан туршлага солилцох арга хэмжээнд хамрагдсан. Үүнд: Эрүүл мэндийн төвийн 45 эмч, эмнэлгийн ажилчид ОХУ-д, Нэгдсэн эмнэлгийн 41 эмч, эмнэлгийн ажилчид Турк улсад туршлага солилцох арга хэмжээнд хамрагдсан. 2023 онд төрөлжсөн болон нарийн мэргэжлээр 21, гадаад сургалтад 9, богино хугацааны чадавхжуулах сургалтад давхардсан тоогоор 249 эмч сувилагчид хамрагдсан. 2024 онд "Хавдрын хими эмчилгээ", "Тархины доплер", "Арьс судлал" гэсэн 3 чиглэлээр нарийн мэргэжлийн, сургалтанд 18 ерөнхий мэргэжлийн эмч, сувилагчийг сургасан.	100%
	48	Дүүргийн эрүүл мэндийн төсөвт байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах зорилгоор "Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах зорилгоор "Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2021 оны төсөвт тоног, төхөөрөмжөөр хангах арга хэмжээ тусгагдсан.	Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна.	УТХО 1602.7 НТХО 860.2 ДТХО 953.7 НОНХС 527.0	2021-2024 онд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн байгууллагуудыг 509 эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангаж, Эрүүл мэндийн төв болон Нэгдсэн эмнэлгийн албан хэрэгцээнд 2 автомашин хүлээлгэн өгч тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн. 2021 онд Улсын төсвийн 350.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн төвд 18 төрлийн 268 ширхэг эмчилгээний болон цахилгаан тоног төхөөрөмж, Хаш чагнуур ӨЭМТ-д 10 сая төгрөгийн 6 төрлийн тоног төхөөрөмж, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 527.0 сая төгрөгөөр Эрүүл мэндийн төвд 14 нэр төрлийн 34 ширхэг тоног төхөөрөмж, НЭ-т 10 ширхэг компьютер, 1 ширхэг принтер, 7 хорооны ӨЭМТ-д 418 ширхэг эмчилгээний төхөөрөмж, тавилга, хэрэгсэл, Эрүүл дүүрэг дэд хөтөлбөрөөс ЭМТ, НЭ-т тус бүр Приус-30 маркын автомашин, Засаг даргын нөөц хөрөнгөөс 13.89 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тус тус нийлүүлсэн.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
							<p>2022 онд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Нэгдсэн эмнэлэгт 397 сая төгрөгийн өртөг бүхий 6 нэр төрлийн эмчилгээний тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн төвд 7.2 сая төгрөгийн төсөв бүхий ЭХО аппарат, сүрьеэгийн Gene Expert аппарат тус тус хүлээлгэн өгсөн.</p> <p>2023 онд НОНХС-ийн хөрөнгөөр яаралтай тусламж, гэрийн эргэлт, эмчилгэнд зориулж, 3, 4, 7 дугаар хорооны 3 ЭӨМТ-д тус бүр 1 автомашин, дүүргийн төсвийн 13.2 сая төгрөгөөр 14 дүгээр хорооны ЭӨМТ-д эмнэлгийн тоног төхөөрөмж, дүүргийн нэгдсэн эмнэлгийн төсвөөс Био салбарт 7 ширхэг эмчилгээний тоног төхөөрөмж тус тус нийлүүлсэн.</p> <p>2024 онд дүүргийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 425 ширхэг 2,333,0 төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Үүнд: Улсын төсвийн хөрөнгөөр Нэгдсэн эмнэлэгт 15, Эрүүл мэндийн төв 2, Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 18, нийт 35 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн бол дүүргийн төсвийн хөрөнгөөр Нэгдсэн эмнэлэгт хэвлийн хөндийн дурангийн 4 ширхэг иж бүрдэл тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн төв 7 нэр төрөл, Өрхийн эрүүл мэндийн төвүүд 6 төрлийн 9 ширхэг тоног төхөөрөмж нийт 20 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлсэн.</p>	
	49	Эрүүл мэндийг дэмжих төв болон нийгмийн эрүүл мэндийн төвийг дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудыг түшиглэн байгуулах ажлыг зохион байгуулна	Шинээр байгуулсан Эрүүл мэндийн төвийн тоо	Эрүүл мэндийг дэмжих төв болон нийгмийн эрүүл мэндийн төвийн тоо 0.	Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулсан байна.	УТХО 1530 ДТХО 601.0	<p>221-2024 онд Эрүүл мэндийн төвд байгуулагдсан "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих төв"өөр төвийн бүсийн 9 хороо, алслагдсан 12,13-р хорооны эрт илрүүлэг үзлэг, оношлогоонд хамрагдвал зохих 71979 иргэнээс 30266 иргэн, Нэгдсэн эмнэлэгт байгуулагдсан "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих төв" өөр 4,5,6,7,8,9,10,14,16,21-р хороодын эрт илрүүлэг, үзлэг оношилгоо, шинжилгээнд хамрагдвал зохих 142043 иргэнээс 6097 иргэн тус тус хамрагдаад байна.</p> <p>2021 онд Эрүүл мэндийн төвийн "Б" корпусын 500м2 талбайд их засвар хийж, 11 нэр төрлийн тоног төхөөрөмжийг суурилуулж, дүүргийн хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, аливаа өвчлөлөөс сэргийлэх мэдлэг, мэдээлэлтэй болгох, хувь хүн, байгууллага, хамт олны урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ хийж өвчлөлөөс эрт үед нь сэргийлэх чиг үүрэг бүхий "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийг байгуулсан.</p> <p>2022 онд Нэгдсэн эмнэлгийн Эрүүл мэндийг дэмжих төвийн засварын ажлын гүйцэтгэгчээр "ТИ ЭЙЧ ЭН" ХХК шалгарч, Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн хэсгийн нэгдүгээр давхарын баруун жигүүрт буулгалтын ажил, цахилгааны ажил, ариутгалын 4 өрөө, лабораторийн 5 өрөөний их засвараас гадна дулааны магистрал шугамыг солих засвар хийсэн.</p> <p>2023 онд Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн дэргэд Эрүүл мэндийг дэмжих төв 2022 оноос үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс тус төвд "иргэн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулан ажиллаж байна. 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар 209,524 иргэн хамрагдахаас 116,078 иргэн буюу 55.4 хувийн хамрагдалттай, нийслэлийн хэмжээнд 2-рт байна.</p> <p>2024 онд Эрүүл мэндийг дэмжих төв 6 кабинет, 10 эмч, ажилчинтай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд төвийн бүсийн 9 хороо, алслагдсан 12,13-р хорооны эрт илрүүлэг үзлэг, оношлогоонд хамрагдвал зохих 71979 иргэнээс 30266 иргэн хамрагдаж 42%-н ирцтэй байна.</p>	90%
2.2.9 Харшлын өвчин үүсгэгч ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах зорилгоор "Харшилгүй эрүүл дүүрэг" аян жил бүр зохион байгуулна.	50	"Харшилгүй эрүүл дүүрэг" аян жил бүр зохион байгуулж, олон нийтийн оролцоог хангана.	Хамрагдсан иргэдийн тоо	2 удаагийн сургалт өдөрлөг зохион байгуулж, 3878 иргэнийг хамруулсан.	Сургалтыг зохион байгуулж, 14000-аас доошгүй иргэнийг хамруулна.		<p>2021-2024 онд Аяны хүрээнд 60 гаруй сургалтад давхардсан тоогоор 17672 иргэн хамруулж, 1848 зөвлөмж, гарын авлага тараан 18125 иргэнд цахимаар мэдээлэл өгч ажилласан.</p> <p>2021 онд "Шарилжгүй Улаанбаатар" аяныг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс 08 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулж, дүүргийн нутаг дэвсгэрийн аж ахуй нэгж байгууллагууд болон сууц өмчлөгчдийн холбооны нийт 4700 иргэнийг хамруулан харшил үргэлж хамруулах үр дүнд хэвлэж, хөл газрын ургамлыг цэвэрлэж устгасан.</p> <p>2022 онд Харшлын эрсдэлт хүчин зүйлсийг бууруулан, урьдчилан сэргийлэлт, харшлын шалтгаант өвчлөл, түүний хүндрэлийг бууруулах зөвлөгөөг 31 удаагийн сургалтаар 4,972 иргэн, урьдчилсан сэргийлэх үзлэгт 2,584 иргэн хамруулж, 1823 зөвлөмж гарын авлага тараахын зэрэгцээ ХУЭМТ болон ЭӨМТ-ийн цахим хуудсуудаар харшлаас сэргийлэх зөвлөмжийг 3,584 хүнд түгээсэн.</p> <p>2023 онд Анагаахын Шинжлэх ухааны үндэсний их сургууль, Арьсны өвчин судлалын үндэсний төвийн хамтарсан тус бүр 10 эмчийн бүрэдхүүнтэй 2 баг ЭӨМТ-үүдэд ажиллан иргэдэд харшлын өвчний талаарх ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж, харшлын сорилд 1500 гаруй иргэнийг хамруулсан.</p> <p>2024 онд "Харшлаас сэргийлье" аян зохион байгуулж, Өрхийн эрүүл мэндийн төвийн 20 эмчийг сургалч багшаар бэлтгэн "Харшлын үед үзүүлэх тусламж үйлчилгээ" сэдэвт 28 удаагийн сургалтад 6,500 гаруй иргэн хамруулан харшлаас сэргийлэх 25 төрлийн хэвлэмэл хуудсыг 1204 иргэнд олгож, цахимаар 18,125 хүнд мэдээлэл өгсөн.</p>	100%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
	51	Харшлын өвчин үүсгэгч шарилж, газрын хөл ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах арга хэмжээ авч ажиллана.	Цэвэрлэгээ хийсэн талбайн хэмжээ	692175 м2 талбайн шарилж хог ургамлыг цэвэрлэсэн.	"Шарилжгүй эрүүл дүүрэг аян"-г зохион байгуулж, 280000 аас доошгүй м2 талбайн шарилж хог ургамлыг устгасан байна.	ДТ 81.6	2021-2024 онд 8 удаагийн аян зохион байгуулж 1280 аж ахуйн нэгж, байгууллага, 268 сууц өмчлөгчдийн холбооны 4700 ажилтан, албан хаагч оролцож, 2,031,484 мкв талбайгаас 601.4 тн шарилж, хөл газрын ургамлыг цэвэрлэн тоосонцорын дэгдэлтийг бууруулах, харшил үүсгэхээс сэргийлэх арга хэмжээ авч ажилласан. 2021 онд ХАРШЛЫН ЭСРЭГ ХАМТДАА УРИАТАЙ "Шарилжгүй Улаанбаатар 6" болон "Шарилжгүй эрүүл дүүрэг" аяны хүрээнд шарилж, хөл газрын ургамлыг цэвэрлэхэд иргэдийг идэвхтэй оролцох"-ыг цахимаар уриалж, постер байршуулан бүх нийтийн их цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулж, 1280 аж ахуйн нэгж, байгууллага, 268 сууц өмчлөгчдийн холбооны 4700 ажилтан, албан хаагч оролцож, нийт 108,450 м.кв талбайгаас 282.6 тн шарилж хөл газрын ургамлыг цэвэрлэж устгасан. 2022 онд "Шарилжгүй Улаанбаатар" аяныг дүүргийн хэмжээнд "Шарилжгүй эрүүл дүүрэг" уриан дор 2 үе шаттайгаар зохион байгуулж, нийт 328,968 м.кв талбайгаас 105,9 тонн шарилж хөл газрын ургамлыг цэвэрлэж, хяналт тавьсан. 2023 онд Хоггүй Хан-Уул аяны хүрээнд шарилж, хөл газрын ургамлыг цэвэрлэх их цэвэрлэгээний ажлыг 2 удаа зохион байгуулж, нийт 452,652 м.кв, буюу 0,45 сая мкв талбайг цэвэрлэж, 80.3 тонн шарилж, хөл газрын ургамлыг устгасан. 2024 онд Дүүргийн хэмжээнд "Шарилжгүй Улаанбаатар" аяныг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 09 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулж, нийт 1,141,414 м.кв талбайгаас 132,6 тн шарилж, хөл газрын ургамлыг цэвэрлэсэн	100%

2.3. Цар тахлын үеийн бэлэн байдал

2.3.1. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, нөөцийн бэлэн байдлыг хангана.	52	Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.	Шаардлагатай нөөцийг бүрдүүлж, Хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ	Хариу арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан.	Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан шаардлагатай нөөцийг бүрдүүлж, төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.		ЭМС-ын 2020 оны А/30 тоот албан даалгавар, НЭМГ-ын даргын А/01, ЭМС-ын 2021 оны А/03 тоот албан даалгавартай уялдуулан Гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөө, Коронавируст халдварын цар тахлын үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөнд 8 удаа тодотгол хийж бэлэн байдлыг ханган ажилласан. Коронавирусын халдварын талаар ЭМЯ, ХӨСҮТ, нийслэл дүүргийн тамгын газар, НЭМГ-аас ирүүлж буй тушаал, захирамж, заавар зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллах чиглэлээр ЭМТ-ийн даргын нийт 4 тушаал, 18 заавар журмыг гарган хэрэгжүүлэн ажиллалаа. "Ковид-21" эмчилгээний 3 тасаг бүхий 150 ортой эмнэлгийг нээж 2021.04.25-2021.11.18-ний байдлаар нийт 2,435 хүлээн авснаас эмчлүүлээд гарсан үйлчлүүлэгчийн тоо 2,271, дээд шатлалд эмчлүүлсэн 68, нас барсан 53. Туул 100 ортой ковидын эмнэлгийг 2021 оны 06 дугаар сараас 11-р сарын 27-ийг хүртэл нээн ажиллуулж нийт 1,536 хүнийг хэвтүүлэн эмчилж, хүндэрсэн 23 хүнийг дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлэв. Био-Асралт өрхийн эрүүл мэндийн төвд 50 ортой ковидын эмнэлэг нээн ажиллуулахаар бэлтгэл ажлыг хангасан. Яармаг салбар амбулаторийн нэг давхарт засвар үйлчилгээг өөрийн санхүүжилтээр хийж, шаардагдах шинэ тоног төхөөрөмжүүдийг ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлж суурилуулан Микробиологийн лабораторийг нээн ажиллуулж 1 эмч, 5 лаборантыг ХӨСҮТ, НЭМҮТ, ЗӨСҮТ-д 10 хоногийн сургалт, дадлагад хамруулж 2021 оны 02 сард үйл ажиллагааг эхлүүлж нийт 348,484 сорьцыг хүлээн авч шинжиллээ. УОК, ЭМЯ, НОК, ДОК –ын шийдвэрийн дагуу COVID-19-ын халдварын нийт 14 шинжилгээний цэг нээн ажиллуулав. Монгол Улсын Засгийн Газрын шийдвэрээр 2021 оны 02 дугаар сарын 11-ны өглөөний 06:00 цагаас бүх нийтийн бэлэн байдлыг зарлаж Улаанбаатар хотын 6 дүүрэгт "Нэг хаалга-нэг шинжилгээ" арга хэмжээг зохион байгууллаа."Нэг хаалга, Нэг шинжилгээ" арга хэмжээг 14 блок хэлбэрээр бүсчлэн нийт 123 баг, мэргэжлийн 921 албан хаагчдын бүрэлдэхүүнтэй 41,256 өрх, иргэнээс тандалт, шинжилгээг хийсэн.	100%
2.3.2 Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, заавар, зөвлөмж өгөх замаар ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ.	53	Худалдаа үйлчилгээний байгууллага, зах, томоохон худалдааны төвүүдийн эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэмийн мөрдөлт, халдваргүйжүүлэлтэд хяналт тавина.	Халдвар хамгааллын үйлчилгээний байгууллага	Хүнсний худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний 1600 аж ахуйн нэгж байгууллага халдвар хамгааллын дэглэм мөрдөн ажиллаж байна.	Худалдаа, үйлчилгээний 1600-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн ажиллана.		Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед зах худалдааны төвд халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэх чиглэлээр: 1. Ариутгал халдваргүйтгэлийг 14 хоног тутам хийж хэвшүүлсэн. 2. Үйл ажиллагаа эрхэлж буй 21 зах худалдааны төвийн 3500 гаруй ажилчдыг ПГУ шинжилгээ, дархлаажуулалтын 3 түнд хамруулах ажлыг дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран 6 удаагийн давтамжтайгаар зохион байгуулсан. 3. Эдийн засгийн хямралыг давж гарах хүрээнд түрээсийн хөнгөлөлт үзүүлэх уриалгыг зах худалдааны төвийн удирдлагуудад уламжилсны дүнд 7 зах худалдааны төв түрээслэгч иргэдэд 20-50%-ийн хөнгөлөлт үзүүлсэн. 4. Халдвараас урьдчилан сэргийлэх, дэглэм мөрдөх 2000 брошюр хэвлүүлж, иргэн, аж ахуйн нэгжид хүргүүлсэн. 5. УБХЕМ-ийн баталсан удирдамжийн дагуу дүүргийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран худалдаа үйлчилгээний газруудад халдвар хамгааллын дэглэм, түр журам, тусгай нөхцөл шаардлагын хэрэгжилтэд байнгын хяналт тавин ажиллаж байна. 2021 онд давхардсан тоогоор 158 албан хаагч, 5345 иргэн, аж ахуйн нэгжид хяналт тавьж, илэрсэн зөрчлийн тухай бүр арилгуулж ажилласан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
2.3.3 Гамшгийн үеийн бэлэн байдалтай холбоотой Хүнсээр хангах албаны мэргэжлийн ангийн тоог нэмэгдүүлж, хүнсний хангамжийг тогтворжуулна.	54	Дүүргийн хүнсээр хангах албаны төлөвлөгөөнд тодотгол хийж, хүнсээр хангах мэргэжлийн ангиудтай хамтран ажиллаж, хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлнэ.	Хүнс ханган нийлүүлэхээр байгуулсан аж ахуйн нэгж	Хүнс ханган нийлүүлэхээр 27 байгууллагатай гэрээ байгуулсан.	45-аас доошгүй аж ахуйн нэгжтэй болзошгүй гамшиг ослын үед хүнс нийлүүлэх гэрээ байгуулж, шаардлагатай хүнсний нөөцийг бүрдүүлсэн байна.		2021 онд Дүүргийн хүнсээр хангах албаны төлөвлөгөөнд тодотгол хийж, дүүргийн хэмжээнд хүнсний үйлдвэр 18, зоорь 1, хүнсний худалдаа 21, хоол үйлдвэрлэлийн 7, нийт 47 аж ахуйн нэгжтэй гамшиг ослын үед хүнс нийлүүлэх гэрээ байгуулж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөц, үнийн судалгааг тогтмол авч нийслэл, дүүргийн онцгой комисс, улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлж, мэдээллээр хангаж ажилласан.	100%
2.3.4 Гол нэрийн хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор эрэлт хэрэгцээнд тулгуурлан тохиромжтой байршлуудад худалдан борлуулах ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулна.	55	Гол нэрийн хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор эрэлт хэрэгцээнд үндэслэн худалдаа үйлчилгээ зохион байгуулж ажиллана.	Зохион байгуулсан арга хэмжээ	2020 онд нөөцийн махны өргөтгөсөн худалдаа 2 удаа 5 байршилд зохион байгуулсан.	Иргэдийн эрэлт хэрэгцээнд үндэслэн 8-аас доошгүй удаа худалдаа үйлчилгээ зохион байгуулж ажиллана.	ДТ 2.5	2021 онд дүүргийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр нөөцийн махны худалдааг 2021.03.17-2021.06.30 хүртэл нийт 34 дэлгүүрт, өргөтгөсөн худалдааг 2021 оны 05, 06 дугаар сарын амралтын 11 өдөр давхардсан тоогоор 26 байршилд гаргаж нийт 598.6 тонн нөөцийн мах худалдан борлуулах ажлыг зохион байгуулсан. Мөн ногооны үзэсгэлэн худалдааг 2021.08.10-2021.09.30-ны өдөр хүртэл нэгдсэн 5 байршил, томоохон хороолол дунд зохион байгуулж, 35 ногоочны 312 тонн ногооны борлуулалтыг дэмжин ажилласан.	100%
2.4. Хотын соёл								
	56	"Монгол үндэсний бахархлын өдөр"-ийг тохиолдуулан "Иргэний андгай өргөх ёслол"-ыг зохион байгуулах	Ёслолд хамрагдсан иргэдийн тоо	350 сурагчийг хамруулсан.	350 сурагч хамруулна.	ДТ 11.6	2021-2024 онд Улс тунхагласны ойг тохиолдуулан 4 удаа "Иргэний андгай өргөх ёслол"-ыг зохион байгуулж, 16 нас хүрч буй 367 иргэний үнэмлэхийг гардуулсан. 2021 онд Улс тунхагласны 97 жилийн ойг тохиолдуулан Төрийн ордонд зохион байгуулагдсан "Иргэний андгай өргөх ёслол"-д Хан-Уул дүүргийн сурлага, хөдөлмөрөөрөө тэргүүлж, амжилттай суралцаж буй төрийн болон төрийн бус өмчийн 18 сургуулийн 16 нас хүрсэн 50 сурагчид иргэний үнэмлэхийг гардуулсан. 2022 онд Монгол Улсын иргэний үнэмлэх гардуулах "Иргэний андгай өргөх ёслол"-ыг 2022 оны 5 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж 85 сурагч, 2021 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан "Иргэний андгай өргөх ёслол"-д 32 сурагч, нийт 117 сурагчдыг хамруулсан. 2023 онд "Монгол Улсын Иргэний үнэмлэх гардуулах, андгай өргөх" ёслолын үйл ажиллагаанд Хан-Уул дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын 19 сургуулийн 80 сурагч, иргэний үнэмлэх гардан авсан. 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр дүүргийн Соёлын ордонд "Иргэний андгай өргөх ёслол"-ыг зохион байгуулж, 120 хүүхэд иргэний андгай өргөн, иргэний үнэмлэхээ гардан авсан.	100%
2.4.1 Бүх шатны боловсрол соёлын байгууллагууд олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд олон нийтийн сүлжээг ашиглан соёлын боловсрол олгох "Хотын соёл" олон нийтийн аян өрнүүлэх	57	"Хотын соёл" цуврал контент, видео шторк бэлтгэж, цахим аяны талуудтай хамтрах хэрэгжүүлнэ.	Зохион байгуулж хэрэгжүүлсэн нөлөөллийн арга хэмжээ /контент/	Сургалт, өдөрлөг нийт 9 нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан.	Цуврал контент, видео шторк 12-оос доошгүй нэмэгдүүлсэн байна.	ДТ 5.8	2021-2024 онд 22 удаагийн сургалтад ерөнхий боловсролын сургуулийн 358 сурагч Их, дээд сургуулийн 1045 оюутан, 206 иргэн хамруулж, "Хотын соёл-Хорт зуршил", "Хотын соёлд - Бидний үйлдэл" сэдэвт 2 илтгэлийн уралдаанд 22 багийн 135 оюутан оролцсон. "Хотын соёл" аяны хүрээнд 3 шторк, 16 постерыг төрийн байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн пэйж хуудас болон иргэд, байгууллагын албан хаагчдын групп байршуулснаар 11441 иргэнд түгээсэн байна. Мөн "Хотын соёлд-Бидний оролцоо" цахим контентийн уралдаанд ЕБС-иас 14, СӨББ-аас 28 бичлэг хүлээн авч, 14 хоногт 86647 иргэнд түгээсэн. 2021 онд "Хотын соёл" хичээлийн хөтөлбөр боловсруулан 12 сургалтаар дүйцсэн хөтөлбөрийн бага, суурь, ахлах бүлгийн 107 сурагч хамруулсан. "Биеэ авч явах соёл" сургалтад ерөнхий боловсролын 32, 34, 52, 18-р сургуулийн дунд ангийн 251 сурагч хамруулж, цахим сайтад байршуулж 2038 иргэний хандалт авсан. 2022 онд "Хотын соёл-Хан-Уул"-аас олон нийтийн соёлын арга хэмжээг 2 үе шаттайгаар 25 хороодын цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулан нийт 3466 иргэдийг хамруулсан. "Хотын соёл" аяны хүрээнд 3 шторк, 16 постер хийж байгууллагын пэйж болон группт байршуулж, 8963 иргэний хандалт авч, "Хотын соёл-Хорт зуршил" сэдэвт илтгэлийн уралдаанд 7 багийн 60 оюутан сурагчдыг хамруулсан. 2023 онд "Биеэ зөв авч явах соёл" сэдэвт сургалтаар төр, хувийн хэвшлийн нийт 7 байгууллагад 7 удаагийн сургалтад 206 иргэн, "Хотын соёл-Хорт зуршил" сургалтад нутаг дэвсгэрийн 6 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Коллежийн нийт 1045 оюутан, "Хотын соёлд - Бидний үйлдэл" сэдэвт илтгэлийн уралдаанд 15 багийн 75 оюутан, 6 удирдагч багш оролцсон. Хотын соёлыг түгээх 3 бичлэг, 16 постерыг төрийн байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн пэйж хуудас болон иргэд, байгууллагын албан хаагчдын группт байршуулснаар 2478 иргэн хандаж, 327 лайк дарж, 154 шэйр хийгдсэн байна. 2024 онд "Хотын соёлд-Бидний оролцоо" цахим контентийн уралдаанд Ерөнхий боловсролын сургуулиудаас 14 бичлэг, СӨБ байгуулгаас 28 бичлэг тус тус хүлээн авч Насан туршийн боловсролын төвийн фэйс хуудсанд байршуулж, 14 хоногийн хугацаанд давхардсан тоогоор 86647 хүнд түгээн 10,566 лайк, 7,768 иргэн comment, 13,052 иргэн шэйр хийж олон нийтэд хүргэсэн.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелтийн хувь	
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)			
2.4.2 Иргэдэд соёлын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх үүднээс үндэсний бахархал, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж хэвшүүлнэ.	58	Соёл, гоо зүйн боловсролын агуулгын хүрээнд Богцон дахь соёлын өв сэдэвт олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулна.	Үйл ажиллагаанд хамруулсан иргэдийн тоо	2 удаагийн үйл ажиллагаанд 100 хүнийг хамруулсан.	400-аас доошгүй хүнийг хамруулна.	ДТ 3.7	2021-2024 онд иргэдэд үндэсний өв соёл, уламжлалыг таниулан сурталчилах чиглэлээр сургалт 5, уулзалт 1, өв соёлтой танилцах аялал 1, олон нийтийг хамарсан "Дээлтэй монгол", "Нүүдэлчин монгол", "Соёлын бүтээлч сар" зэрэг арга хэмжээнд давхардсан тоогоор 6939 иргэн оролцуулахын зэрэгцээ, "Өв соёл-Эко дүүрэг" цахим хуудсыг нээж, мэдээ мэдээлийг олон нийтэд тогтмол түгээж байна. 2021 онд "Өвийн жим" клуб байгуулж, клубийн сурагчид болон "Хангай" МСҮТ-ийн Аялал жуулчлалын нэгдүгээр ангийн суралцагчдад "Богцон дахь өв соёл" өвийн боловсролын сургалт, " Эко дүүргийн өв соёлоороо бахархъя" сэдэвт уулзалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 101 сурагчийг хамруулсан. 2022 онд Соёлын биет болон биет бус өвийг сурталчлан таниулах, хадгалж хамгаалах зорилгоор "Өв соёлоо танин мэдье" аяллын хүрээнд "Дэлхийн өв ба ач холбогдол", "Дэлхийн өв ба хүрээлэн буй орчин", "Өвийн боловсрол" сургалтад 165 иргэн, "Дээлтэй монгол", "Нүүдэлчин Монгол" их наадам, Түүх соёлын хөшөө дурсгалын тооллого, "Соёлын бүтээлч сар" зэрэг улс, нийслэл, дүүргийн томоохон арга хэмжээнд 2300 гаруй иргэн тус тус хамруулсан. 2023 онд "Богцон дахь соёлын өв" төслийн хүрээнд "Өв соёлоо танин мэдье" сэдэвт сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, төрийн өмчийн ерөнхий боловсролын 23 сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн 6 төв, 25 хорооны нийт 1081 хүнийг хамруулсан. Сургалтад хамрагдагсдын дунд цахим контент болон бүтээлийн уралдаан зарлаж, шилдэг оролцогчдыг шагнаж урамшуулан "Өв соёл-Эко дүүрэг" 1800 гаруй гишүүнтэй цахим хуудсыг нээж, мэдээ мэдээлийг тогтмол хүргэсэн. 2024 онд Дүүрэгт бүртгэлтэй 151 өв уламжлагчийн судалгааг шинэчлэн гаргаж, "Богцон дахь соёлын өв" төслийн хүрээнд ерөнхий боловсролын 163, 34, 52, 161, 165 дугаар сургуулиудад ардын хөгжмийн зэмсэг нийлүүлснээс гадна өвийн соёлыг дэлгэрүүлэх, олон нийтийн 3 арга хэмжээнд 1191 хүн, "Богцон дахь соёлын өв" цуврал хичээлд 301 хүн хамруулсан.	100%	
	59	Дүүргийн хүүхэд, залуучуудыг үндэсний дуу, хөгжим, бүжгийн сургалтад хамруулна.	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	4 төрлийн сургалтад 100 хүнийг хамруулсан.	400-аас доошгүй хүнийг хамруулна.			2021-2024 онд Морин хуур, төгөлдөр хуур, бүжиг, ёочин, ятга зэрэг 4-6 төрлийн авъяас хөгжүүлэх дугуйланд 740 хүүхэд хамруулсан. 2021-2022 онд Хан-Уул дүүргийн Соёлын ордны авъяас хөгжүүлэх морин хуур хөгжмийн сургалтад 100 хүүхэд, төгөлдөр хуур хөгжмийн сургалтад 90 хүүхэд, ятга хөгжмийн сургалтад 30 хүүхэд, бүжгийн сургалтад 30 хүүхэд, нийт 250 хүүхдийг сургалтад хамруулсан. 2022-2023 онд морин хуур, төгөлдөр хуур, бүжиг, ёочин, ятганы 5 дугуйланд 137 хүүхэд суралцсан. 2023-2024 онд нийт 166 хүүхэд сургахаар төлөвлөснөөс эмэгтэй - 96, эрэгтэй-39 нийт 135 хүүхэд бүртгүүлсэн. Насны ангиллаар нь авч үзвэл 7-16 насны 127, 17-38 насны 8 суралцагч байна. 2024-2025 онд Соёлын ордны авъяас хөгжүүлэх 6 төрлийн сургалтанд нийт 218 хүүхэд хамрагдан хичээллэж байгаа ба өмнөх жилийнхээс 57 хувиар нэмэгдсэн байна.	100%
	60	Түүх, соёлын үл хөдлөх өвийг хамгаалах, сэргээн засварлах ажлыг хэрэгжүүлнэ.	Сэргээн засварласан түүх, соёлын зүйлийн дурсгалт тоо	Дүүрэгт сэргээн засварлах шаардлагатай соёлын өв байна.	3-аас доошгүй соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээ авна.	НТХО 237.0 ДТ 988.0		2021-2024 онд түүхийн дурсгалт 18 соёлын өвийг сэргээн засварлаж, хамгаалалтад авсан. Үүнд: Хүннүгийн үед хамаарах 8 булш, хиргэсүүр, Их тэнгэрийн аманд байрлах хүрэл зэвсгийн үеийн хадны зосон зураг болон 13-р зууны үед холбогдох бэхэн зураг, Монгол, Хятад, Төвд бичээс бүхий Монголын түүх, соёлын үнэт өв газрыг хамгаалалтад авч, Махатма Гандигийн хөшөө, Сүхбаатарын хөшөө, "Дүүргийн 50 жилийн ойн өндөрлөг" "Чингис хааны сэрэг дүр", Соёмбот толгой, Зайсан толгой дахь "Зөвлөлтийн дайчдын дурсгалын цогцолбор", "Хувьсгалт Монгол" танкны хөшөөний иж бүрэн тохижилт, засварын ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 2021 онд сэргээн засварлах, хамгаалалтад авах шаардлагатай соёлын өвийн жагсаалтыг холбогдох байгууллагуудад хүргүүлснээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас Махатма Гандигийн хөшөө, Сүхбаатарын хөшөөг иж бүрэн зассан. 2022 онд Түүх соёлын, үл хөдлөх өвийн улсын тооллогод 44 соёлын биет өвийг хамруулж, 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах эрсдэлт нөхцөлд байсан Хүннүгийн үед хамаарах 8 булш, хиргэсүүрийг хамгаалалтад авсан. Улсын төсвийн хөрөнгөөр дүүргийн 22 дугаар хорооны Их тэнгэрийн аманд байрлах хүрэл зэвсгийн үеийн хадны зосон зураг болон 13-р зууны үед холбогдох бэхэн зураг, Монгол, Хятад, Төвд бичээс бүхий Монголын түүх, соёлын үнэт өв газрыг сэргээн засварласан. 2023 онд Дүүрэг дэх соёлын үл хөдлөх өвийн судалгааг шинэчилсэн судалгаагаар улсын хамгаалалтад 2, нийслэлийн хамгаалалтад 4, дүүргийн хамгаалалтад 39, нийт 45 түүх, соёлын өв хадгалагдаж байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 50 жилийн ойн өндөрлөг, "Чингис хааны сэрэг дүр, "Ажилчны алдар талбайг засварлаж сэргээх ажлыг тус тус хэрэгжүүлсэн. . 2024 онд дүүргийн төсвийн хөрөнгөөр 22 дугаар хороонд байрлах Соёмбот толгой, Чингис хааны сэрэг дүрийн гэрэлтүүлгийг засварлаж шинэчлэх ажлыг хэрэгжүүлсэн. Мөн Зайсан толгой дахь "Зөвлөлтийн дайчдын дурсгалын цогцолбор", "Хувьсгалт Монгол" танкны хөшөөний иж бүрэн тохижилт, засварын ажлыг 2024 оны 07-09 дүгээр сард ОХУ-ын Ленинград мужийн Засгийн газрын санхүүжилтээр "Шидэт Орос байшин" ХХК хийж гүйцэтгэсэн.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
	61	Дүүргийн Соёлын ордны барилгыг шинээр барих ажлыг талуудтай хамтран хэрэгжүүлнэ.	Дүүргийн Соёлын барилгын ажлын явц	Хуучин барилгын ашиглалтын шаардлага хангахгүй дүгнэлт гарсан.	Барилга ашиглалтад орсон байна.		2022 онд Улсын болон Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналд дүүргийн Соёлын ордны барилгыг буулгаж шинээр барих саналыг 2022 оны 06/161 тоот албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. 2023 онд тус барилгын чанар аюулгүй байдлын дүгнэлт баталгаажиж, улсын байцаагчийн ашиглалтын шаардлага хангахгүй гэсэн дүгнэлт гарсан. Улс, нийслэлийн төсөвт хөрөнгө батлагдаагүй тул 2024 онд дүүргийн төсөвт барилгыг буулгаж барих зураг төсөв боловсруулах хөрөнгийг тусган батлуулж, Хот байгуулалт, хотын стандартын газраас архитектур төлөвлөлтийн даалгавар хүссэн. Даалгавар батлагдсаны дараа зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар бэлтгэж байна.	10%
ХОЁР. ЭРҮҮЛ ДҮҮРЭГ – ХҮНИЙ ХӨГЖИЛД ШААРДАГДАХ ТӨСӨВ					26.356.5		88.1%	
ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ – ИРГЭН БҮРТ								
3.1 Иргэн төвтэй үйлчилгээ								
3.1.1 Иргэдэд зориулсан амьдрах ухаанд сургах, зөвлөгөө мэдээллээр хангах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх зориулалт бүхий хөгжлийн төвүүдийг нээн ажиллуулна.	62	Ахмад залуучуудын болон иргэдийн хөгжлийн төвийн барилгыг барьж байгуулах талуудтай хамтран хэрэгжүүлнэ.	Хөгжлийн төвийн барилга	4 хороонд ахмадын хөгжлийн төв ажиллуулж байна.	Иргэдийн хөгжлийн төвийн 6 барилга ашиглалтад орно.	УТХО 5,441.8 ДТХО 75.0	2021-2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хүүхэд залуучууд, ахмадын хөгжлийн төвийн барилгын 5, дүүргийн төсвийн хөрөнгөөр 1, нийт 6 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөнөөс 12, 16-р хорооны хөгжлийн төвийн барилга угсралтын ажил, 19-р хороонд дээрх зориулалтаар байр худалдан авах, 6-р хороонд хуучин халуун усны барилгыг засварлаж тусгай хэрэгцээт иргэдийн хөгжлийн төв болгон засварлаж тохижуулах ажил тус тус хэрэгжиж дууссан бол 5, 12-р хороонд хэрэгжиж буй хөгжлийн төвийн барилгын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. -12 дугаар хорооны "Иргэдийн хөгжлийн төв"-ийн барилгыг ашиглалтанд орсон. -16 дугаар хороо, Хүүхэд залуучууд, ахмадын хөгжлийн төвийн барилгын ажлыг "Бүрэн-Одод" ХХК гүйцэтгэн Улсын комисст хүлээлгэн өгсөн. Үйл ажиллагаа явуулж эхлэх шатанд байна. -6 дугаар хороо, ашиглагдахгүй байсан хуучин халуун усны барилгыг засварлаж тусгай хэрэгцээт иргэдийн хөгжлийн төв болгон засварлаж тохижуулах ажил хэрэгжиж, тоног төхөөрөмж тавилга эд хогшил нийлүүлэгдсэн. -Хүүхэд залуучууд, ахмадын хөгжлийн төвийн барилга худалдан авах ажил хэрэгжиж, 19 дүгээр хороонд худалдан авалт хийгдсэн. -5 дугаар хороо, Хүүхэд залуучууд, ахмадын хөгжлийн төвийн барилгын ажлын гүйцэтгэгчээр "Экстракт" ХХК ажиллаж байна. Дотор засал, гадна холболт, тохижилтын ажил үлдсэн. Ажлын явц 70 хувьтай хэрэгжиж байна. -12 дугаар хорооны нутаг дэвсгэрт хэрэгжиж буй Хүүхэд залуучууд, ахмадын хөгжлийн төвийн барилгын ажлын гүйцэтгэгчээр "Харганы ус констракшн" ХХК ажиллаж байна. Ажлын явц 70 хувьтай хэрэгжиж байна.	90%
3.1.2 Байгууллагын гүйцэтгэлийг сайжруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор "Чанарын удирдлагын тогтолцоо"-г нэвтрүүлэх ажил зохион байгуулж, хороодын үйл ажиллагааны чадавхийг сайжруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн "Хороодын хөгжил" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	63	"Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандарт нэвтрүүлнэ	"Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандарт нэвтрүүлнэ		"Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 стандарт нэвтрүүлсэн байна.		2022-2023 онд Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015, Үйлчилгээний төгөлдөршлийн ISO 23592:2021 стандартыг дүүргийн "Монсертф" Тохирлын үнэлгээний байгууллагын баталгаажуулалтын зөвлөлийн хурлын 2023 оны D-23/049 дүгээр тогтоолоор стандарт нэвтрүүлсэн анхдагч гэрчилгээ 22, 23 дугаар хороонд 1 жил, 25 дугаар хороонд 3 жилийн хугацаатай олгогдсон.	10%
	64	Хороодын хөгжил дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	"Хороодын хөгжил" дэд хөтөлбөрийн хэрэгжилт		Дэд хөтөлбөрийн хэрэгжилт 90-ээс доошгүй хувь.		2021-2024 онд хөтөлбөрийн хүрээндковид цар тахлын үед хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, алслагдсан хороодыг тээврийн хэрэгслээр хангах, хороодоо цахим үйлчилгээний төхөөрөмж нийлүүлэх, чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандарт нэвтрүүлэх, албан хаагчдын компьютер техник хэрэгсэл шинэчлэх, албан хаагчдын үйлчилгээний соёл, чадварыг нэмгдүүлэхэд чиглэсэн нийт 25 арга хэмжээг хэрэгжүүлсэн. 2021-2022 онд Хөтөлбөрийн хүрээнд ковид-19 цар тахлын үед шуурхай арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор дүүргийн алслагдсан 12,14,9,10,16 хороодод 5 автомашин худалдан авч, хүлээлгэн өгсөн. Тохижилт, ногоон байгууламж, хороодын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээний хүртээмж, албан хаагчдын цахим ур чадвар, хороо болон СӨХ-дын уялдаа холбоо нэмэгдүүлэх, албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулах, төрийн үйлчилгээний стандарт, техник хэрэгслээр хангах, цахим үйлчилгээг нэмэгдүүлэх, иргэдийг мэдээ, мэдээллээр тасралтгүй хангах чиглэлээр нийт 11 арга хэмжээг хэрэгжүүлсэн. 2023-2024 онд 25 хорооны нийгмийн ажилтны компьютерийг шинэчлэх, төрийн үйлчилгээний батлагдсан стандартыг хэрэгжүүлэх, хороодод цахимаар үзүүлэх үйлчилгээний тоног төхөөрөмж нийлүүлэх, хороодын албан хаагчдын үйлчилгээний соёл, ур чадварыг нэмэгдүүлэх 8 удаагийн сургалтад, 22, 23, 25 дугаар хороодын үйл ажиллагаанд Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015, Үйлчилгээний төгөлдөршлийн MNS ISO 23592:2021 стандартуудыг нэвтрүүлэх дүүргийн 12, 19, 21 дүгээр хорооны цогцолбор байрыг налуу шаттай болгох зэрэг нийт 14 арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.	90%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
3.2. Ухаалаг төрийн үйлчилгээ								
3.2.1 Дүүргийн иргэд болон гадаадад амьдарч байгаа иргэдэд зориулж төрийн үйлчилгээг хялбаршуулах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор мобайл аппликейшнийг хөгжүүлэн, цахимаар үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.	65	Мобайл аппликейшнийг хэрэглээнд бүрэн нэвтрүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ	Үзүүлэх үйлчилгээ	Мобайл аппликейшний хөгжүүлэлт хийгдсэн.	5 үйлчилгээ үзүүлж эхэлсэн байна.		"И Монголиа цахим үйлчилгээний нэгдсэн портал" системийн ашиглалтыг сайжруулж төрийн байгууллагууд нэгдсэн нэг системтэй байх чиглэлийн дагуу апплейкшнийг нэвтрүүлэх хэрэгцээ үүсээгүй болно.	-
3.2.2 Засаг захиргааны анхан шатны нэгж хорооноос иргэдэд хүргэж буй үйлчилгээний төрлийг үе шаттайгаар нэмэгдүүлж, зарим үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	66	Хорооноос үзүүлж буй төрийн үйлчилгээний нэр төрлийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ	Нэмэгдсэн үйлчилгээний нэр төрөл	1 хороонд УБХ-ийн 4 төрлийн үйлчилгээ үзүүлдэг.	2-5 хороонд 5-9 төрлийн үйлчилгээ үзүүлнэ.	ДТ 12.7	2021-2024 онд төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулж хороодод үзүүлж буй төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх хүрээнд 25 хороонд 115 нэр төрлийг үйлчилгээг цахимаар авах боломжтой КИОСК автомат машин, 15, 18, 21 дугаар хороонд Улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээг нээж Зайсангийн бүс буюу 11,15,17,18,19,22 дугаар хорооны 85 мянган иргэд, яармаг, нисэх алслагдсан бүсийн 15 хорооны 200 мянга орчим иргэдэд төрийн үйлчилгээ ойртож, иргэний болон эд хөрөнгийн, хуулийн зэрэг улсын бүртгэлийн бүх төрийн үйлчилгээг харьяалал харгалзахгүй авах боломж бүрдсэн. Дүүргийн 25 хороонд "Хурдан цэг" нээснээр төрийн 43 байгууллагын 478 үйлчилгээг ойроос шуурхай авах боломжийг бүрдүүлсэн. 2021 онд хороодоос улсын бүртгэлийн 8, нийгмийн халамжийн 69, нийтлэг үйлчилгээний 4 нэр төрлийн үйлчилгээ үзүүлсэн. 2022 онд 25 хороонд КИОСК автомат машин байршуулснаар дээрх төрийн үйлчилгээний төдийгүй, бусад төрлийн нийт 115 нэр төрлийн татвар, төлбөр хураамжийн үйлчилгээг иргэд шуурхай авдаг болсон. 21 дүгээр хороонд Улсын бүртгэлийн нэг цэг нээснээр яармаг, нисэх алслагдсан бүсийн 15 хорооны 200 мянга орчим иргэдэд төрийн үйлчилгээ ойртож, иргэний болон эд хөрөнгийн, хуулийн зэрэг улсын бүртгэлийн бүх төрийн үйлчилгээг харьяалал харгалзахгүй авах боломжтой болсон. 2023 онд 21 хороонд 12 нэр төрлийн улсын бүртгэл хийгдэж байгаа бөгөөд 18 дугаар хороонд Улсын бүртгэлийн нэг цэг нээснээр 24 нэр төрлийн үйлчилгээ, 16 дугаар хороо "Хан Плаза"-д "Хурдан" төрийн үйлчилгээний цэг нээснээр 291 төрлийн үйлчилгээг тус тус авч байна. Мөн 25 хороонд байршуулсан киоск машин болон egazar.gov.mn цахим хуудас, egazar аппликейшн, emongolia -аар дамжуулан газрын харилцаатай холбогдолтой 36, нийгмийн халамжийн 69, нийгмийн даатгалын 9, ИТАХ цахим системээр, улсын бүртгэл, даатгал, татвар хураамжийн гээд нийт 174 нэр төрлийн үйлчилгээг иргэд цахимаар авах боломжтой болсон. 2024 онд дүүргийн 25 хорооны цогцолбор байранд төрийн үйлчилгээний "Хурдан" цэгийг нээснээр төрийн 43 байгууллагын 478 нэр төрлийн үйлчилгээг авах боломжтой болсон. 15 дугаар хороонд Улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээг нээж Зайсангийн бүс буюу 11,15,17,18,19,22 дугаар хорооны 85 мянган иргэдэд төрийн үйлчилгээ ойртож, иргэний болон эд хөрөнгийн, хуулийн зэрэг улсын бүртгэлийн бүх төрийн үйлчилгээг харьяалал харгалзахгүй авах боломж бүрдсэн.	100%
3.2.3. Дүүргээс аж ахуйн нэгж байгууллагуудад үзүүлж буй үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулах ажлыг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	67	Цахим бүртгэлийн системд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийг бүрэн хамруулна.	Цахим бүртгэл ашиглалт	"Хан-Уул эко дүүрэг" цахим системд 1100 иргэн, аж ахуйн нэгж.	Цахим санд нийт аж ахуйн нэгж байгууллагын 90-ээс доошгүй хувийг хамруулна.		2021-2024 онд Худалдаа, үйлчилгээ эрхлэх цахим бүртгэлийн системд худалдаа үйлчилгээ эрхлэх, тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгах хүсэлт нийт 2183 аж ахуйн нэгж байгууллагаас хүлээн авч дундажаар 92.5 хувийг шийдвэрлэн бүртгэлийг үүсгэж худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд үйлчилсэн байна. 2023 онд Дүүргийн нутагт дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй нийт 24378 татвар төлөгч, иргэн, аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэйгээс 24216 буюу 99.3 хувь нь ИТАХ цахим бүртгэлд хамрагдаж цахим системээр татвар төлж байна. 2024 онд Худалдаа, үйлчилгээ эрхлэх цахим бүртгэлийн системд 2024 оны байдлаар 1224 иргэн, аж ахуйн нэгж хүсэлт ирүүлснийг магадлан шалгаж, 1011 хүсэлт буюу 82.6 хувийг шийдвэрлэн бүртгэлийг баталгаажуулсан.	100%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
3.2.4 Захын болон алслагдсан гэр хороолол, амралт зугаалгын бүс, иргэд олноор цуглардаг газруудад утасгүй интернетийн сүлжээ суурилуулах ажлыг үргэлжлүүлнэ.	68	Иргэд олноор цуглардаг бүсүүдэд утасгүй сүлжээ суурилуулах ажлыг үргэлжлүүлнэ.	Шинээр утасгүй интернэт суурилуулсан байршил	2020 онд 4 байршилд утасгүй интернэтийн сүлжээ суурилуулсан.	6 байршилд утасгүй интернэтийн сүлжээ суурилуулна.	ДТХО 20.0	2021-2021 онд 1, 2, 14, 15, 19, 21 дүгээр хорооны иргэд олноор цугларч амарч салхилдаг 5 байшилд утасгүй интернэтийн сүлжээ суурилуулсан. Нэг байршилд өдөрт дундажаар 60 иргэн утасгүй интернэтийг ашиглаж байна. 2022 онд Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны гаднах бичил цэцэрлэгт хүрээлэн, 2 дугаар хорооны 7, 8 дугаар байрны бичил цэцэрлэгт хүрээлэнд утасгүй интернэтийн сүлжээ суурилуулсан. 2023 онд Хан-Уул дүүргийн 19 дүгээр хорооны Богд жавзандамбын цэцэрлэгт хүрээлэн, 21 дүгээр хорооны цэцэрлэгт хүрээлэнд тус тус утасгүй интернэтийн сүлжээ суурилуулсан. 2024 онд Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны 8, 18-р байрны голын хүүхдийн тоглоомын талбайд утасгүй интернэт суурилуулсан. Мөн 15 дугаар хороо, 120-н автобусны буудлын 2 талд байршсан дулаахан автобусны зогсоолд Юнител ХХК-ийн өндөр хурдны утасгүй интернэтийн сүлжээ суурилуулсан.	100%
3.2.5 Дүүргийн худалдаа үйлчилгээний цэг салбарыг нэгдсэн цахим системд оруулж, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй түргэн шуурхай болгоно.	69	Худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдтэй хийх гэрээ, олгох батламжийн үйл ажиллагааг цахимжуулна.	Үйлчилгээний цахимжсан байдал	-	Цахимаар гэрээ батламж олгох үйл ажиллагаа 90%-д хүргэнэ.		2021-2024 онд Худалдаа, үйлчилгээ эрхлэх цахим бүртгэлийн системд худалдаа үйлчилгээ эрхлэх, тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгах хүсэлт нийт 2183 аж ахуйн нэгж байгууллагаас хүлээн авч дундажаар 92.5 хувийг шийдвэрлэн бүртгэлийг үүсгэж, 63 иргэн, аж ахуйн нэгжид тамхи худалдаа, 780 аж ахуйн нэгжид архи согтууруулах ундаа худалдаалах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгосон байна. 2022 онд Цахим бүртгэлийн системд 2022 онд 1018 иргэн, аж ахуйн нэгж гэрээ, батламж олгох хүсэлт илгээснээс шаарадлага хангасан 519 аж ахуйн нэгж буюу 50.9%-д қг код бүхий бүртгэлийн хуудсыг олгосон. 2023 онд Худалдаа үйлчилгээ эрхлэх "Онлайн бизнес төв" цахим бүртгэлийн системд 2023 онд нийт 1172 иргэн, аж ахуйн нэгж хүсэлт ирүүлснийг хүлээн авч, 99%-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан. 2024 онд 1224 иргэн, аж ахуйн нэгж хүсэлт ирүүлснийг магадлан шалгаж, 1011 хүсэлт буюу 82.6 хувийг шийдвэрлэн бүртгэлийг баталгаажуулсан. Мөн согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл авахаар 844 аж ахуйн нэгж хүсэлт ирүүлснийг магадлан шалгаж, дүүргийн Засаг даргын А/460 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсгийн 16 удаагийн хурлаар хэлэлцүүлж 780 буюу 92.4 хувийг шийдвэрлэн ажилласан.	100%
3.3. Мэргэшсэн тогтвортой төрийн алба								
3.3.1 Төрийн албан хаагчдыг чадавжуулах, мэргэшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, албан хаагчдын чиг үүргийн давхардлыг арилгах, хэлтэс, албадын ажлын уялдаа холбоог сайжруулах ажлыг зохион байгуулна.	70	Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж, дотоод болон гадаадын богино дунд хугацааны сургалтад хамруулж мэргэшүүлнэ	Мэргэшүүлсэн, мэргэжил дээшлүүлсэн албан хаагчдын тоо	2020 онд 49 албан хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан.	90 албан хаагчийг сургалтад хамруулж мэргэжил, ур чадварыг дээшлүүлнэ.	ДТ 1,048.1	2021-2024 онд "Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ын хүрээнд Удирдлагын академийн мэргэшүүлэх дунд хугацааны болон ахлах түшмэлийн сургалтад 19, богино хугацааны чадавхжуулах болон чиглүүлэх сургалтад 9, Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтад 33, архив, албан хэрэг хөтөлбөрийн мэргэшүүлэх дунд хугацааны хөтөлбөрт 3, баг хорооны Засаг дарга нарыг чадавхжуулах сургалтад 22, нийт 86 албан хаагчийг мэргэшүүлж, бусад богино хугацааны чадавхжуулах сургалтуудад давхардсан тоогоор 500 гаруй албан хаагчийг хамруулсан. 2021 онд Удирдлагын академийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2 албан хаагч, "Албан хэрэг хөтөлбөр", "Ес зүй", "Excel программ", "Өргөдөл гомдлын системийн ашиглалт", "Худалдан авах ажиллагааны АЗ" зэрэг сургалтад давхардсан тоогоор 200 албан хаагч хамруулан 3 албан хаагчид сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн. 2022 онд Албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх чиглэлээр Удирдлагын академийн чиглүүлэх богино болон мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 5, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 6, магистрын зэрэг горилсон гарагийн сургалтад 4 албан хаагчийг хамруулж мэргэжил, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Нийслэлийн Хүний нөөцийн Хөгжлийн төвөөс зохион байгуулсан 20 төрлийн сургалтад давхардсан тоогоор 96 албан хаагч, "АЗ" гэрчилгээ олгох сургалтад 11 албан хаагчийг тус тус хамруулж, нийт 25 төрлийн сургалтад 122 албан хаагчийг хамруулсан. 2023 онд Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад 3, чиглүүлэх дунд хугацааны сургалтад 1, "АЗ" гэрчилгээ олгох сургалтад 13, архив, албан хэрэг хөтөлбөрийн мэргэшүүлэх дунд хугацааны хөтөлбөрт 3, Төрийн албан хаагчдад зориулсан үндэсний бичгийн сертификат олгох сургалтад 29 албан хаагчдыг хамруулж, нийт 5 төрлийн мэргэшүүлэх сургалтаар 37 албан хаагч сертификат авсан. 2024 онд Удирдлагын академийн төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны багц сургалтад 4, дунд хугацааны давтан сургалтад 3, шинэ томилогдсон төрийн албан хаагчийг чиглүүлэх 40 цагийн сургалтад 3, чадавхжуулах богино хугацааны сургалтад удирдах 2, гүйцэтгэх 2, Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтад 20 албан хаагч, баг хорооны Засаг дарга нарыг чадавхжуулах сургалтад 22 нийт 56 албан хаагч мэргэшүүлэх сургалтад хамрагдсан.	100%
	71	Төрийн албаны тухай хууль болон холбогдон гарсан журмын хүрээнд бүтэц орон тоог шинэчилэн баталж, ажлын уялдаа холбоог сайжруулна	Бүтэц орон тооны шинэчлэл (хувь)	Бүтэц орон тоо шинэчлэн батлаагүй.	Шинэ бүтэц орон тооны дагуу ажлын уялдаа холбоог сайжруулах ажлыг хэрэгжүүлсэн байна.		Чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр дүүргийн Засаг даргын 2021 оны А/306, А/441 дүгээр захирамж, 2022 оны А/129, А/527 дугаар захирамжаар 2023 оны А/104 дүгээр захирамж, 2024 оны А/320 дугаар захирамж, нийт 6 удаагийн захирамжаар удирдах дээд шатны байгууллагаас баталсан орон тооны хязгаарын хүрээнд чиг үүргийн давхардалгүй, уялдаа холбоог хангуулан бүтэц орон тоог баталж ажилласан. 2024 оны байдлаар Засаг даргын Тамгын газрын бүтэц 10 хэлтэс, 5 тасгийн нийт 64 албан тушаалтан, төрийн үйлчилгээний 31 албан тушаалын бүтэц орон тооны хүрээнд чиг үүргээ хэрэгжүүлж байна.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
3.3.2 Төрийн байгууллага, албан тушаалтныг авилгын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, шуурхай, нээлттэй байдлыг хангана.	72	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын албан хаагчдыг авилгаас урьдчилан сэргийлэх сургалтад хамруулж, дүүргийн цахим хуудас, болон хороодоор дамжуулан авилгаас ангид байх нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээний тоо	2020 онд 2 удаагийн сургалтад нийт 49 албан хаагчдыг хамруулж, 3 контент байршуулсан.	7 удаагийн сургалт зохион байгуулж, 6 контент байршуулна.	ДТ 6.19	2021-2024 онд Авлига, хүнд суртлыг таслан зогсоох авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг жил бүр батлан 85-90-тай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн чиглэлээр нийт 8 удаагийн сургалтад 423 албан хаагч хамруулан, "Мэдьё, Нэгдье", "Авлигатай тэмцэх таван "Ш" ажиллагаа" зэрэг аян, арга хэмжээг дүүргийн хэмжээнд зохион байгуулж, видео шторкийг цахим хуудсаар олон нийтэд түгээн сурталчилж, 7575 ном товхимол, гарын авлагыг иргэдэд танилцуулж, тараасан. 2021 онд Дүүргийн Засаг даргын 2021 оны А/503 дугаар захирамжаар дүүргийн хэмжээнд авлига, хүнд суртлыг таслан зогсоох арга хэмжээ авах, авлигаас урьдчилан сэргийлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Авлигын эсрэг хууль тогтоомж, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтад 11 албан хаагчийг хамруулж, Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн 4 төрлийн тв шторк, видео график, теле зохиомжийг дүүргийн www.khanuul.mn цахим хуудасны авлигын эсрэг үйл ажиллагааны ил тод буланд байршуулж иргэд, олон нийтэд хүргэсэн. 2022 онд Авлига, хүнд суртлыг таслан зогсоох, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд 2 сургалт, 1 судалгаанд нийт 110 албан хаагчийг хамруулсан. 2023 онд авлигатай тэмцэх газартай хамтран 3 удаагийн сургалт зохион байгуулж нийт 140 төрийн албан хаагч, 80 иргэн, ажилтнуудыг хамруулсан. "Мэдьё, Нэгдье" аяны хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг ЗДТГ-ын даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан 10 арга хэмжээний биелэлт 85 хувьтай үргэлжилж байна. Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарлаж, "Авлигатай тэмцэх таван "Ш" ажиллагаа"-ны "Шүгэл ажиллагаа"-ны хүрээнд авлигын эсрэг үйл хэрэгт хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авлигыг мэдээлж, шүгэл үлэхийг үриалсан Авлигатай тэмцэх газрын "...НЭГДЬЕ" соён гэгээрүүлэх аянд нэгдэж тв шторк, постерыг байгууллагын сайт, Хан-Уул Эко дүүрэг албан ёсны фэйсбүүк хуудсаар дамжуулан 1180 ширхэг зурагт хуудас, 1000 ширхэг тараах материал, 500 ширхэг стикерийг хүн амын төвлөрөл ихтэй байршуулаад байрлуулж, олон нийтэд сурталчилсан. 2024 онд Албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон "Шудрага байдлын үнэлгээ"-г сайжруулах 2024 оны төлөвлөгөөг балан 400 ширхэг хуулийн товхимолыг төрийн албан хаагчид тараан 2 сургалтад 162 албан хаагчийг хамруулсан. Иргэдэд үйлчлэх төв байрны нэг цэгийн үйлчилгээний байранд 1 өдөрлөг зохион байгуулж, 304 иргэнд 18 төрлийн 4495 ширхэг ном, наалт, гарын авлагыг тарааж, "Товш" аппликэйшн, видео шторкийг сурталчилж, төрийн үйлчилгээ авахаар ирсэн 304 иргэний гар утсанд Товш аппликэйшн суулгасан.	100%
3.3.3 Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэлээр, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	73	Засаг даргын Тамгын газар болон хороодын албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ, ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг харгалзан, холбогдох журмын дагуу үнэлгээг тооцож, цахим хуудаст ил тод мэдээлнэ.	Журмын хэрэгжилтийн хувь	Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй.	Ёс зүйн зөрчилгүй хамт олонг бий болгоно.		2021-2024 онд төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл үр дүнг Засгийн газраас баталсан журмын дагуу тухай бүр үнэлж дүгнэн ажиллаж байна. Тайлант хугацаанд Ёс зүйн зөвлөл болон Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хороо 22 албан хаагчид холбогдох 25 гомдлыг 15 удаагийн хурлаар хэлэлцэн 3 албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэн 6 албан хаагчид ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргүүлж, 8 албан хаагчид сануулах арга хэмжээ, 2 албан хаагчид сахилгын арга хэмжээ, ёс зүйн зөрчил тогтоогдсон 1 албан хаагчид холбогдох арга хэмжээ авч тайланг www.khanuul.mn цахим хуудаст байршуулсан. 2021 онд Засаг даргын Тамгын газрын 10 хэлтэс, тасаг, албадын 67, хороодын 51 нийт 118 албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэж, 3 албан хаагчид сануулах сахилгын шийтгэл ногдуулж ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд тусгасан. 2022 онд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйтэй холбоотой нийт 7 өргөдөл ирүүлсэнээс 5 албан хаагчтай холбоотой асуудлыг байгууллагын Ёс зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дээрх 5 албан хаагчид сануулах хариуцлага хүлээлгэсэн. Хорооны 1 албан хаагчид 1 сарын цалингийн 20 хувь, 1 хэсгийн ахлагчид 1 сарын цалингийн урамшууллын 20 хувиар буулуулах сахилгын шийтгэл тус тус ногдуулсан байна. 2023 онд тайлант хугацаанд Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн 2 удаагийн хурлаар 6 албан хаагчид холбогдох 7 иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хэлэлцэж, ёс зүйн зөрчил тогтоогдсон 1 албан хаагчид зөвлөлийн шийдвэрээр холбогдох арга хэмжээ авч тайланг www.khanuul.mn цахим хуудаст байршуулсан. 2024 онд тайлант хугацаанд Ёс зүйн дэд хорооны 5 удаагийн хурлаар 11 албан хаагчид холбогдох гомдол, мэдээллийг хэлэлцэн шийдвэрлэж, 3 албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэн 6 албан хаагчид ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргүүлж, мэдээллийг www.khanuul.mn цахим хуудаст ил тод байршуулсан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
3.3.4 Засаг захиргааны анхан шатны нэгж болох хороог ажлын албатай болгон санхүүгийн хувьд бэхжүүлснээр төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	74	Хороодыг ажлын албатай үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Өдөр тутмын үйл ажиллагаанд зориулсан төсөвтэй хороо		21 хорооны өдөр тутмын үйл ажиллагаанд зориулсан төсөвтэй болсон байна.	ДТ 15,645.0	2021-2024 онд дүүргийн 25 хороодын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулан нийт 18.8 тэрүм төгрөгийн төсөв батлуулан 15.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. 2022 онд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 12/36 дугаар тогтоолоор дүүргийн зарим хорооны нутаг дэвсгэр, хилийн заагийг шинэчлэн, 5 хороог шинээр байгуулж, нийт 25 хороо үйл ажиллагаа явуулж байна. Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар 25 хороодын өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай хангамжийн зардал болох сар тутмын 500,0000 төгрөг букуу нийт хороодын жилийн зардалд 156,9 сая төгрөгийн төсөв батлагдаж, зардлыг хороодод тогтмол олгож хэвийн үйл ажиллагааг нь хангасан. 2023 онд Төсвийн тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16.4 дэх хэсэгт заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн хуралдааны 2023 оны 08 дугаар тогтоолд хорооны үйл ажиллагааны зардал 8.55 тэрбум төгрөгийн төсвийг батлуулж, тайлант хугацаанд 6.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгон хорооны хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. 2024 онд Төсвийн тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16.4 дэх хэсэгт заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 26 дугаар тогтоолд 25 хорооны үйл ажиллагааны зардал 10,3 тэрбум төгрөгийн төсвийг батлуулж, 3 дугаар улирлын байдлаар 8,9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгон хорооны хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.	100%
3.4 Иргэдийн аюулгүй, амар тайван байдал								
3.4.1 Авто замын шаардлагатай бүс, гэр хорооллын гудамж талбай болон орон сууцны хорооллуудын эмзэг бүсийг хяналтын камерын системд бүрэн хамруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	75	Хороодын нутаг дэвсгэрийг камержуулах ажлыг үргэлжлүүлнэ.	Суурилуулсан камерын тоо	Дүүргийн дэвсгэрт ширхэг байна.	нутаг 1435 камер	НОНХС 419.9 ДТХО 1,398.0 ДОНХС 4,789.6	2021-2024 онд Нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар нийтийн эзэмшлийн гудамж, талбай, шаардлагатай байршлуудад нийт 499 камер суурилуулсан. 2021 онд 32 дугаар сургуулийн гадна болон дотор орчинд нийт 51 камер, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс ерөнхий боловсролын 15, 18, 52, 60, 75, 115, 118 зэрэг 7 сургуулийн орчимд 32 камер, нийт 83 камер суурилуулсан. 2023 онд "Нийтлэг үйлчилгээний алба" ОНӨААТҮГ 1110 камерын 192 камерыг засварлаж, шинээр 122 камер суурилуулснаар 1232 ширхэг хяналтын камерын ашиглалтыг хариуцсан. 2024 онд "Нийтлэг үйлчилгээний алба" ОНӨААТҮГ Иргэдэд үйлчлэх төв байр, хороодын байр болон нийтийн эзэмшлийн гудамж талбайд 123 хяналтын камерыг засварлаж, 114 хяналтын камерыг шинээр суурилуулсан. Мөн Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд шинээр нийт 715 камер суурилуулахаар төлөвлөгдсөнөөс 4 төсөл арга хэмжээ туршилт, тохируулгын шатанд, 2 төсөл арга хэмжээ хэрэгжих шатанд 10-15 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Камер суурилуулж туршилт, тохируулга хийгдэж буй 4 төсөл, арга хэмжээ: 1. "Нийтийн эзэмшлийн талбайн камержуулалт 1, 2, 3, 6, 7, 8, 17, 1-р хороо" - 53 ширхэг камер, 2. "Камержуулалт 1-5, 9-11, 13-21-р хороо" - 117 ширхэг камер, 3. "Хайрга, дайрга олборлолт, тээвэрлэлтийг хянаж, зохицуулах цэгүүдийн камержуулалт" төсөл арга хэмжээний хүрээнд 12, 13, 14, 16, 21-р хороодод тусгай зориулалтын 10 ширхэг камер, 4. "Камерын хяналтын төв рүү шилэн кабел татах, засвар хийх" төсөл, арга хэмжээний хүрээнд серверийн ерөөний тоноглол сууриуулалтын ажил. Хэрэгжих шатанд 2 төсөл, арга хэмжээ: 1. "Нийтийн эзэмшлийн талбайн камержуулалт 4-10, 12, 13, 14, 16, 21-р хороо" - 80 ширхэг камер 2. Камержуулалтын хяналтын нэгдсэн төв, камержуулалтын ажил /9, 10, 16, 21-р хороо/ - 314 ширхэг камер Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Телекамерын нэгдсэн төвийн техник, тоног төхөөрөмж, систем, программ хангамжийн ажил"-ын гүйцэтгэгчээр "Бодь электроникс" ХХК шалгарсан бөгөөд дотор засал, тоног төхөөрөмж суурилуулах ажил бүрэн дуусч, гадна цахилгааны 2 дахь эх үүсвэрт холбох ажил хэрэгжиж байна. Тус ажлын хүрээнд дүүргийн өвөлжилтийн бэлтгэл хангах зардлаас 13.6 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, хяналтын төвийн цонх, цахилгаан, цэвэр усны насосыг засварласан. "Тайван хот - Таны оролцоо" нэгдсэн арга хэмжээний хүрээнд улсын төсвөөр болон иргэд аж ахуйн нэгжийн дэмжлэгтэйгээр суурилуулсан камерын байршил, мэдээллийг "CAMERA.POLICE.GOV" программд шивж оруулж байна. Тус ажлын хүрээнд аж ахуй нэгжийн 881,787,121 төгрөгийн нийт 6809 камерын мэдээллийг бүртгэсэнээс 361 нь тэмдэгтэй, 6431 нь тэмдэглээгүй суурилуулсан байна.	100%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
3.4.2 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, "Олон нийтийн цагдаа", "Оюутан цагдаа" арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	76	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Олон нийтийн цагдаа", "Оюутан цагдаа" арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	Зохион байгуулсан арга хэмжээнд ажилласан албан хаагчийн тоо	50 хэв журмын урамшуулалт эргүүл 25 олон нийтийн цагдаа 15 оюутан цагдаа ажилласан.	50 хэв журмын урамшуулалт эргүүл 25 олон нийтийн цагдаа 15 оюутан цагдаа ажилласан байна.	НТХО 265.4 ДТ 23.5	2021-2024 онд Тус дүүргийн хэмжээнд 12 олон нийтийн цагдаа ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд урамшуулалт эргүүлээр 33 иргэн ажилласан. Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны А/48 дугаар тогтоолоор "Оюутан эргүүл ажиллуулах журам"-ын хүрээнд "Хөдөө аж ахуйн их сургууль"-ийн 1500, бусад сургуулийн 2300 нийт 3800 орчим оюутнуудыг сургалтад хамруулж, олон нийтийг хамарсан арга хэмжээ, баярын өдрүүдээр заасан чиглэл, газарт нийт 711 оюутан цагдаа эргүүлээр ажиллуулж гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлж ажилласан байна. 2021 онд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтийн цагдаа 13, хэв журмын урамшуулалт эргүүлээр 33 иргэн, 2022 онд 25 олон нийтийн цагдаа, 15 оюутан цагдаа ажилласнаас гадна дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны А/48 дугаар тогтоолоор "Оюутан эргүүл ажиллуулах журам" батлуулж журмын хэрэгжилтийг хангах зорилгоор замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам сахиулах чиглэлээр 650 оюутан эргүүл ажилласан. 2023 онд 21 олон нийтийн цагдаагийн орон тоо батлагдсан. Олон нийтийн цагдаагийн 7 сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зарлаж, болзол шалгуур хангасан 2 иргэнийг цагдаа мэргэжил олгох сургалтад хамруулж цагдаагаар томилон ажиллуулснаар нийт 16 олон нийтийн цагдаа, 8 оюутан эргүүл, цагдаагаар ажилласан. 2024 онд Тус дүүргийн Цагдаагийн газарт нийт 21 олон нийтийн цагдаагийн орон тоо батлагдсанаас нэгдүгээр хэлтэст 6, хоёрдугаар хэлтэст 6, нийт 12 олон нийтийн цагдаа үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд 1 олон нийтийн цагдаа хүүхэд асрах чөлөөтэй байна. Богд Хааны музей орчимд 2024 оны 06 дугаар сарын 10 наас 08 дугаар сарын 10-ны хооронд өдөр бүр 4 оюутан цагдаа 40 хоног, Улсын их баяр наадмын хамгаалалтад Төв цэнгэлдэх хүрээлэнд 34 оюутан цагдаа 2 өдрийн турш 280 цагийн үүрэг гүйцэтгэсэн.	70%
3.4.3 Иргэд, өсвөр үе, залуучуудыг согтууруулах ундаа, мансууруулах төрлийн бодис хэрэглэх хорт зуршлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	77	Согтууруулах ундаа, хар тамхи, мансууруулах бодисын хор уршиг аюулын талаар мэдлэг олгох хичээлийг ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулах, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж сурталчлах	Зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээ	5 удаагийн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж нийт 348 сурагч хамруулсан.	10 удаагийн сургалтын үйл ажиллагаа зохион байгуулж нийт 950 сурагч хамруулсан байна.	ДТ 1.7	2021-2024 онд Мэргэжлийн байгууллагуудтай хамтран согтууруулах болон мансууруулах бодисын хор нөлөө, түүнээс урьдчилан сэргийлэх 102 сургалт сургалт, 4 аян, 5 өдөрлөгт дүүргийн нутаг дэвсгэрийн ерөнхий боловсролын 23 сургууль, 11 их дээд сургуулийн давхардсан тоогоор 17547 оюутан сурагч, 2125 иргэдийг хамруулан архи согтууруулах ундаа, мансууруулах бодисын хор уршигийг таниулах арга хэмжээ зохион байгуулсан. 2021 онд Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан "Нийслэлийн Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, тогтоомжийг сурталчлах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хууль зүйн Үндэсний хүрээлэн, дүүргийн ИТХ, дүүргийн Прокурорын газартай тус тус хамтран Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль болон "Цахим гэмт хэргээс өсвөр насны залуучуудыг урьдчилан сэргийлэх" сэдэвт цахим сургалтуудыг ЕБ 10, 32, 52, 75, 114 дугаар сургуулийн ахлах ангийн нийт 650 сурагчдыг хамруулан зохион байгуулж, мэдээлэл хүргэж ажилласан. 2022 онд Иргэд, өсвөр үе, залуучуудыг согтууруулах ундаа, мансууруулах төрлийн бодис хэрэглэх хорт зуршлаас урьдчилан сэргийлэх 16 удаагийн сургалт, арга хэмжээ зохион байгуулж 1065 сурагч, 1625 иргэдийг оролцуулсан. 2023 онд "Электрон тамхины хор нөлөө", "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь", "Үе тэнгийн гадуурхалт", "Хүүхэд хамгаалал", "Цахим болон бусад орчинд өөрийгөө хамгаалах" "Архины хор уршиг" "Мансууруулах бодисын хор нөнөө", "Архины хор нөнөө", "Тамхинаас татгалзъя", "Дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлэх нь", "Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх" зэрэг 15 сэдвээр 68 сургалт, 4 аян, 5 өдөрлөг байгуулсан. Сургалт арга хэмжээнд 20 ерөнхий боловсролын сургууль, 11 их дээд сургуулийн давхардсан тоогоор нийт 12682 оюутан, сурагч, иргэн хамруулж, 6 төрийн, 2 төрийн бус байгууллага, 132 цагдаагийн албан хаагч хамтран ажилласан. 2024 онд Ерөнхий боловсролын 23 сургуулийн дунд, ахлах ангийн нийт 3150 сурагчдад "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь", "Үе тэнгийн гадуурхалт", "Тамхи, электрон тамхины хор нөлөө" сэдвүүдээр 12 удаагийн сургалт зохион байгуулсан. Мөн ахлах ангийн сурагчдын 500 эцэг, эх, асран хамгаалагч нарт Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаагийн сургалт зохион байгуулан ажилласан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
	78	Цахим сүлжээ ашиглан хар тамхи, мансууруулах бодисоос хүүхэд, залуучуудыг сэрэмжлүүлэх зорилго бүхий оюутан, залуусын дунд мэдээ мэдээлэл, сурталчилгаа явуулна.	Цахим сүлжээнд тогтмол байршуулсан урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийн тоо		Цахим сүлжээнд мэдээ мэдээллийг тогтмол оруулна.		2021-2024 онд нийт 160 орчим мэдээ, мэдээллийг олон нийтийн сүлжээгээр тархаан давхардсан тоогоор 258543 иргэнд хүргэж, хүүхэд, залуусыг сэрэмжлүүлэх хар тамхи, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн. 2021 онд Төрийн болон аж ахуй нэгж байгууллагуудыг хүүхэд хамгааллын бодлоготой болгох, цахим гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Таны хүүхэд цахим орчинд хэнтэй нөхөрлөж байгааг мэдэж байна уу?", "Таны хүүхэд аюулгүй биз, Хүүхэд тань цахим орчинд аюулгүй байж чадаж байна уу?" зэрэг подкастуудыг идэвхттэй үйл ажиллагаа явуулдаг 11 цахим хаягт байрлуулснаар 66,319 иргэнд хүрсэн. Мөн "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга" сургалтыг цахим болон танхимын хэлбэрээр 9 удаа зохион байгуулж 342 хүнийг хамруулан, видео хичээл цахим орчинд байршуулж 10800 иргэнд мэдээлэл хүрсэн. 2022 онд Дүүргийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн төвийн пэйж хуудсаар 15 удаагийн постер мэдээлэл, khanuul.child.gov.mn сайтад 12 постер, нийт 27 мэдээллийг түгээж 1238 хүнд түгээсэн. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 16 телевиз, радио, сайтаар 45 мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг иргэд олон нийтэд хүргэсэн. "Мансууруулах эм, сэтгэцэд сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх" сэдвээр 21 удаагийн сургалт зохион байгуулсан. 2023 онд "Архидан согтуурахаас сэргийлье" мэдээлэл сургалт, сурталчилгааны цахим аяныг зохион байгуулж, "Архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхээс сэргийлье!", Архийг зөв зохистой хэрэглэцгээе! "Архийг хэтрүүлэн хэрэглэх нь хортой", "Баасан гараг тэмдэглэлт өдөр биш #намайг алгас", "Яагаад архи, согтууруулах ундааны хэрэглээ их байна вэ? Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ", "Мансуураагүй ирээдүйн төлөө" зэрэг 17 төрлийн архи, согторуулах ундааны хор хөнөөлийн талаар ухуулан таниулах постер, мэдээллийг телевиз, цахим сайтад тус тус байршуулж, 52364 иргэнд хүргэсэн. 2024 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ухуулга, нөлөөллийн ажлын нийт 89 мэдээ мэдээлэл, Электрон тамхины хор хөнөөлийн талаар 2 зурагт хуудас, "Тагагдаж болохгүй" уралдааны 14 бичлэг, нийт 105 мэдээлэл, сурталчилгааг цахим хуудас, олон нийтийн сүлжээнд байршуулан давхардсан тоогоор 245822 иргэнд хүргэжээ.	100%
3.4.4 Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрсдэлд өртөхөөс хамгаалах "Хүүхэд хамгаалагч" төслийг хэрэгжүүлж, хүүхдийг гэмт хэрэгт өртөх, хохирогч болох эрсдэлийг бууруулна.	79	Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрсдэлд өртөхөөс хамгаалах "Хүүхэд хамгаалагч" төсөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	Хүүхэд хамгаалагчаар ажиллуулсан иргэнийн тоо	Хүүхэд хамгаалагчаар хүн ажилласан.	Хүүхэд хамгаалагчаар 21 хүн ажилласан байна.	УТХО 73.0 ХЭДСан 26.6 ДТ 27.0	2021-2024 онд "Хүүхэд хамгаалагч-Эргүүл" журмыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 47 тогтоолоор батлуулсан. "Хүүхэд хамгаалагч" төслийн хүрээнд 2021 онд 120, 2022 онд 29, 2023 онд 21, 2024 онд 18 иргэнтэй гэрээ байгуулж, тайлант хугацаанд давхардсан тоогоор 6039 хүүхэд хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй 4 хүүхдийг Цагдаагийн газарт бүртгүүлж, ажилласан. 2021 онд Хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс сэргийлэх, хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж байгаа олон талт ажлыг эрчимжүүлэх зорилгоор "Хүүхэд хамгаалагч-Эргүүл" журмын төсөл боловсруулж дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 47 тогтоолоор батлуулсан бөгөөд журмыг хэрэгжүүлэх хүрээнд гэр хороолол бүхий Яармаг, Нисэхийн хороодод өдөрт 120 цэгт хүүхэд хамгаалагч ажиллуулахаар бэлтгэл ажлыг хангасан. 2022 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Цагдаагийн ерөнхий газартай хамтран хэрэгжүүлж буй "Хүүхэд хамгаалагч" төслийн хүрээнд хүүхэд хамгаалагчаар 29 иргэнтэй гэрээ байгуулсан. Хүүхэд хамгаалагчид хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 526 хүүхэд хууль, эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан. 2023 онд 21 Хүүхэд хамгаалагч хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн 8 сэрэмжлүүлэг, зурагт хуудсыг хариуцсан нутаг дэвсгэрийн ерөнхий боловсролын сургуулиудын мэдээллийн самбарт байршуулж, нийт 65 удаагийн сургалтад давхардсан тоогоор 3680 сурагч, асран хамгаалагч, багш нарыг хамруулан холбогдох мэдээ, мэдээллийг хүргэн гэмт хэрэг, зөрчилд холбогдож болзошгүй 4 хүүхдийг Цагдаагийн газарт бүртгүүлж, ажилласан. 2024 онд Хүүхдийг гэмт хэрэг зөрчил, аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 18 хүүхэд хамгаалагч эргүүл ажиллаж байна. Хүүхэд хамгаалагч нарт 6 удаагийн сургалт зохион байгуулж, "Хүүхэд хамгаалагч эргүүл" ажлын үр дүнд дээрлэхэлт үйлддэг 3, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байж болзошгүй 2, гэмт хэрэгт холбогдох магадлалтай насанд хүрээгүй 6, нийт 11 хүүхдийг бүртгэл судалгаанд хамруулан хяналтанд авч ар гэрт нь хүлээлгэн өгсөн. Хүүхэд хамгаалагч эргүүлүүд үүрэг гүйцэтгэх явцдаа нийт 1833 хүүхэд урьдчилан сэргийлэх чиглэлээр дэмжлэг үзүүлсэн байна.	100%
ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ – ИРГЭН БҮРТ ШААРДАГДАХ ТӨСӨВ					28,109.9			92%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
ДӨРӨВ. НИЙГМИЙН ХӨГЖИЛ - ӨРХ БҮРТ								
4.1. Боловсрол								
4.1.1. Боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хүрээнд 20-иос доошгүй сургууль, цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	80	Боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, сургууль, цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Шинээр болон өргөтгөл баригдсан сургуулийн суудлын тоо	2020 оны байдлаар нийт цэцэрлэг, сургуулийн хүртээмж 13740 суудал, 5810 ор тус тус байна.	7360 суудалтай 12 сургууль, 2580 ортой 14 цэцэрлэг байгуулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	АХБ 7,944.7 УТХО 67,810.2 НТХО 50,796.7 ДТХО 28,480.9	<p>2021-2024 онд БНХАУ, Япон улсын буцалтгүй тусламж, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл, Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 6960 суудалтай 11 сургуулийн барилга, 4530 ортой 26 цэцэрлэгийн барилга, 13, 16-р хороонд 360 суудал, 200 ор бүхий 2 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга тус тус ашиглалтад орсон бол Улс, нийслэл, дүргийн төсвийн хөрөнгөөр 2, 3, 4, 8, 16, 17, 18, 23-р хороонд баригдах 5760 суудал бүхий 8 сургуулийн барилгын явц 5-90 хувь, 1, 5, 8, 9, 14, 18, 20, 23-р хороонд баригдаж буй нийт 1490 ортой 9 цэцэрлэгийн барилгын ажлын явц 30-85 хувийн гүйцэтгэлтэй байна. Мөн 8, 9, 12, 14, 24-р хороонд баригдаж буй 1080 суудал, 600 ор бүхий 6 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын ажлын явц 85%-ийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>2021 онд Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн 75-р сургуулийн барилгыг буулгаж 920 хүүхдийн суудал бүхий сургуулийн барилга барих, БНХАУ-ын буцалтгүй тусламжаар 15-р хорооны 130-р сургуулийн барилга 920 суудал, 9-р хороо, 114-р сургуулийн барилга 320 суудал, нийт 2160 суудал бүхий 3 сургуулийн барилга, Улсын төсвийн хөрөнгөөр 21-р хороо, 290 дүгээр цэцэрлэгийн барилга 280 ор, 4-р хороо, 12-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга 280 ор, 6-р хороо, 189-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга 200 ор, нийт 760 ор бүхий 3 цэцэрлэгийн барилга ашиглалтад орсон.</p> <p>2022 онд 21-р хороо 163-р сургуулийн барилга 1200 суудал, 8-р хороо, 118-р сургуулийн өргөтгөл 320 суудал, нийт 1520 суудал бүхий 2 сургуулийн барилга, 23-р хороо, 308-р цэцэрлэгийн барилга 300 ор, 2-р хороо, 65-р цэцэрлэгийн өргөтгөл 120 ор, 3-р хороо, 4-р цэцэрлэгийн барилга 280 ор нийт 700 ортой 3 цэцэрлэгийн барилга ашиглалтад орсон.</p> <p>2023 онд Улсын төсвийн хөрөнгөөр 4-р хороо, 34-р сургуулийн өргөтгөлийн барилга 400 суудал, 21-р хороо, 161-р сургуулийн барилга 960 суудал, нийт 1360 суудал бүхий 2 сургуулийн барилга ашиглалтад орсон. 3-р хорооны 322-р цэцэрлэгийн барилга 100 ор, /худалдан авсан/, 4-р хорооны, 34-р сургуулийн өргөтгөлийн 80 ортой цэцэрлэгийн барилга, 9-р хорооны 134-р цэцэрлэгийн барилга 240 ор, 11-р хороо, 324-р цэцэрлэгийн барилга 150 ор, /худалдан авсан/, 21-р хорооны 326-р цэцэрлэг барилга 100 ор, 24-р хороо, 313-р цэцэрлэг барилга 200 ор, 14-р хороо, 300-р цэцэрлэгийн барилга 100 ор, 17-р хороо, Содон цэцэрлэг 180 ор, 3-р хороо, "Гэрэлт өргөө" цэцэрлэгийн барилга 75 ор, 24-р хорооны, "Бива сити" цэцэрлэгийн барилга 75 ор, 21-р хороо, "Гэгээн ертөнц" цэцэрлэгийн барилга 100 ор нийт 1400 ор бүхий 11 цэцэрлэгийн барилга, 13-р хороо, 165-р бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /180 суудал, 100 ор/ барилга тус тус ашиглалтад орсон.</p> <p>2024 онд АХБ-ны санхүүжилтээр 3-р хороо, 18-р сургуулийн өргөтгөл 320 суудал, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 12-р хороо, 10-р сургуулийн барилга 640 суудал, 16-р хорооны сургуулийн барилга 640 суудал, 19-р хороо, 115-р сургуулийн бүхий өргөтгөлийн барилга 320 суудал нийт 1920 суудал бүхий 4 сургуулийн барилга, 2-р хороо, 72-р цэцэрлэгийн өргөтгөл 150 ор, 4-р хороо, 12-р цэцэрлэгийн ёс заншлын өргөө 100 ор, 5-р хороо 145-р цэцэрлэгийн өргөтгөл 150 ор, 10-р хороо, 49-р цэцэрлэгийн барилга 240 ор, 15-р хороо, 336-р цэцэрлэгийн барилга 200 ор , 20-р хороо 342-р цэцэрлэгийн барилга 240 ор, 23-р хороо, цэцэрлэгийн барилга 150 ор (худалдаж авсан), 25-р хорооны цэцэрлэгийн барилга 240 ор (худалдаж авсан), 335-р цэцэрлэгийн барилга 200 ор, нийт 1670 ортой 9 цэцэрлэгийн барилга, 16-р хорооны бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /180 суудал, 100 ор/ барилга тус тус ашиглалтад орсон.</p>	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
4.1.2 Сургууль, цэцэрлэгийн багш нарын ур чадварыг хөгжүүлэх, чадварлаг багш нарыг урамшуулах, дэмжих тэдний тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Багш" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	81	Сургууль, цэцэрлэгийн багш нарын ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр үр дүнтэй үйл ажиллагаа явуулах төсөл, арга хэмжээг шалгаруулан хэрэгжүүлнэ.	Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Үйл ажиллагааны хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгагдсан.	Хэрэгжилт 90-ээс доошгүй хувьд хүрсэн байна.		2021-2024 онд хөтөлбөрийн хүрээнд багш нарыг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах, багш, сурагчдын ур чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөлийг сайжруулах, эрүүл зөв дадал хэвшүүлэхэд чиглэсэн спортын арга хэмжээ зэрэг 24 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. 2021 онд Хан-Уул дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор "Багш" дэд хөтөлбөрийг батлуулж, хөтөлбөрийн хүрээнд "Боловсролд ээлтэй Хан-Уул", "Цахимд суурилсан боловсрол", "Цахим орчинд бүтээмжийг нэмэгдүүлэх нь", "Багш ажилтны ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх нь" төслүүдийг хэрэгжүүлсэн. 2022 онд тус хөтөлбөрийн хүрээнд "Орчин анхдагч байх зарчимд суурилан сургалтанд дэвшилтэт технологиудыг нэмэгдүүлэх, эрүүл ахуй, орчны аюулгүй байдалд шаардагдах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх" зорилтын хүрээнд ерөнхий боловсролын 15 дугаар сургууль 5 зөврийн компьютер нийлүүлсэн. 2023 онд Бүгд Найрамдах Болгар Улсад зохион байгуулагдсан "Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй" Олон Улсын хуралд төлөөлөгч оролцуулж, БНСУ-ын Өмнөд Кёонсанн аймгийн Кёоннам Их сургуультай хамтарсан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэн "Боловсролын салбар дахь шинэ санаачилга, шилдэг туршлага" анхдугаар зөвлөгөөн, Ерөнхий боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, "Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулиудын багш, ажилчдын спортын 5 төрөлт тэмцээн" зохион байгуулах болон Сургуулийн менежментийг сайжруулах зорилгоор сайн туршлага түгээн дэлгэрүүлэх ажлыг дүүргийн 17 сургуульд зохион байгуулах зэрэг 5 төсөл, арга хэмжээ; Сурагчдын хөгжил төлөвшлийг дэмжих чиглэлээр 15, 75 дугаар сургууль "Амжилт өөд-Алхам алхмаар" 52 дугаар сургууль "Шинэ арга зүй-Шилдэг хичээл", 63 дугаар сургууль "Хүүхэд бүхэн эрхэм", 118 дугаар "Сургалтын өрөөг тохижуулах" 5 төсөл арга хэмжээнүүдийг тус тус хэрэгжүүлсэн. 2024 онд Төрийн өмчийн 23 сургууль, 38 цэцэрлэгийн 3,015 багш ажилчдыг хамруулан "Ур чадвар"-ын уралдаан, БНСУ-д зохион байгуулагдах багш нарын ур чадварыг дээшлүүлэх сургалт, Өвийн боловсролын сургагч багш бэлтгэх, Хятад улсын эдийн засгийн хөгжил, сургалтын шинжлэг арга зүй, технологид суралцуулах, мэргэжлийн ур чадварыг нь нэмэгдүүлэх, хамтарч ажиллах боломжийг бүрдүүлэх, харилцан сайн туршлага судлах, 18 дугаар сургуульд Биологийн кабинет байгуулах, боловсролын байгууллагуудын техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт төсөл, арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын 23 сургуулийн 700, 40 цэцэрлэгийн 300 багш нарт 1000 зөврийн компьютерээр хангах төслүүдийг хэрэгжүүлсэн.	80%
4.1.3. Хүүхдийг эрсдэлээс хамгаалах, авто замын ачааллыг бууруулах зорилгоор сургуулийн автобусны үйлчилгээг нэмэгдүүлж, богино эргэлтийн шуурхай автобус бий болгох үйлчилгээг нэвтрүүлнэ.	82	Хүүхдийг эрсдэлээс хамгаалах, авто замын ачааллыг бууруулах зорилгоор сургуулийн автобусны тоог нэмэгдүүлнэ.	Ашиглалтад өгсөн автобусны тоо	Төрийн өмчийн 6 сургуульд 7 автобус	64 автобусаар нэмэгдүүлнэ.	ДТ 8.4	2021-2024 онд Хан-Уул дүүргийн хэмжээнд 2021 онд 7, 10, 26, 59, 118, 156-р сургуулиудад 7 автобус байснаас (7, 26, 63, 156-р сургуулийн) 4 автобус 2022 онд ачлагдаж, 3 автобус сурагчдад үйлчилж байсан. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах хэрэгцээ шаардлагын дагуу нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2024 онд (7, 15, 32, 34, 114, 135, 26, 59, 52, 63, 10, 26, 156, 165 дугаар сургуульд) 14 автобус шинээр авснаар нийт 17 автобустай болсон. 2021 онд Нэн шаардлагатай сургуулийн автобусны хэрэгцээг тодорхойлж, 114-р сургуулийг "Сургуулийн автобус" төсөлд хамруулах хүсэлт Нийслэлийн боловсролын газарт хүргүүлсэн. 2022 онд 161, 163-р сургуульд дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжилтыг шийдвэрлэж түрээсээр 1 жижиг, 2 том автобусаар БУ-2 хороололос 89, 60, 118-р сургууль чиглэлд 2022 оны 11 сарын 21-ний өдрөөс 300 хүүхэд автобусаар үйлчлүүлж, нийт 12 автобусаар 1094 хүүхэд үйлчлүүлсэн. 2023 онд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 хичээлийн жилд төрийн өмчийн ерөнхий боловсролын 7, 15, 32, 34, 114, 135 сургуульд 6 ширхэг 2023-2024 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 26, 156-р сургуульд 2 шинэ автобус тус тус худалдан авсан. Дүүргийн хэмжээнд төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг нийт 13 автобусаар баталсан маршрутын дагуу 6 рэйсээр 416 хүүхдийн аюулгүй байдлыг ханган үйлчилсэн. 2024-2025 оны хичээлийн жилд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 6 автобус шинээр хуваарилагдсан бөгөөд 2023 оны 8, нийт 14 автобусыг нийслэлийн Нийтийн тээврийн газарт хүлээлгэн өгч төрийн өмчийн сургуулиудад үйлчилгээнд явж байна.	100%
4.1.4 Сургууль, эцэг эх, сурагчдын хооронд мэдээлэл солилцох, сурагчийн аюулгүй байдлад хяналт тавих цахим системийг хөгжүүлнэ.	83	Сурагчийн аюулгүй байдалд хяналт тавих цахим системийг хөгжүүлнэ.	Скүүл Алерт төхөөрөмжийн RFID tag бүхий үнэмлэх олгож, төхөөрөмж суурилуулсан сурагчдын тоо	Судалгааны ажил хийгдсэн.	Скүүл Алерт төхөөрөмжийн RFID tag бүхий үнэмлэх 17364-өөс доошгүй сурагчдад эзэмшүүлнэ.	НТХО 639.0	2021-2024 онд НЗДТГ-аас хэрэгжүүлсэн Хүүхэд хамгаалал, аюулгүй байдлыг хангах "Скүүл алерт" төслийн хүрээнд ерөнхий боловсролын нийт 17 сургуулийн 17559 бага ангийн сурагчдад ухаалаг үнэмлэхийг олгож, төрийн өмчийн ерөнхий боловсролын 17 сургууль, автобусны буудал, хүүхэд ихээр зорчдог гудамж талбайд 174 уншигч төхөөрөмжийг байрлуулсан байна.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
4.1.5 Тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт хөгжих боломжийг нэмэгдүүлнэ.	84	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарыг тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад хамруулж, ХБХ-ийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад хамрагдсан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, Боловсролын үйлчилгээнд хамрагдсан тусгай хэрэгцээт хүүхдийн тоо	2 удаагийн сургалтад 200 захирал, эрхлэгчийг хамруулсан.	18 сургалтад 1000 багшийг хамруулж 1000 хүүхдийг хамруулна.	ГТ 15.0	2021-2024 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах, ажиллах арга зүйн чиглэлээр 15 сургалт зохион байгуулж, Төрийн өмчийн 24 сургууль, 38 цэцэрлэгийн давхардсан тоогоор 1927 багш, удирдах ажилтныг хамруулсан. 2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургууль 554, цэцэрлэгт 211, нийт 765 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд боловсролд хамрагдсан. 2024 онд 1-р ангид элсэн суралцах 98 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг гаргаж 80 хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулаад байна. 2021 онд Төрийн өмчийн 19 сургуулийн захирал, 28 цэцэрлэгийн эрхлэгч нарт "Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийн онцлог, дэмжих арга замууд, сургалтын орчин-хамтын ажиллагаа"-тай танилцах сургалт зохион байгуулсан. "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг СӨБ-ын Үйлчилгээнд хамруулах журам"-ын хүрээнд цэцэрлэгүүдэд "Дэмжлэгийн баг" байгуулан, хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 54 хүүхдийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулсан. Ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй 336 хүүхдээс 2021-2022 оны хичээлийн жилд 148 хүүхэд нэгдүгээр ангид элсэн суралцаж байна. 2022 онд "Боловсролын тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийн онцлог, дэмжих арга замууд, сургалтын орчин, хамтын ажиллагаа" сэдэвт сургалтад 125 удирдах ажилтан, "Тусгай хэрэгцээт боловсролын арга зүйн онол практик" сургалтад 180, "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах, ажиллах арга зүй" сургалтад 271, нийт 3 сургалтад 576 багш, удирдах ажилтан хамрагдсан. 2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 520, сургуулийн өмнөх боловсролд 160 хүүхэд хамрагдсан. 2023 онд "Боловсролд тэгш хамруулах нь" сургалтад 24 сургууль, 38 цэцэрлэгийн 62 захирал, эрхлэгч нар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн 4 удаагийн сургалт давхардсан тоогоор 891 багш, удирдах ажилтан хамрагдсан. 2023-2024 онд хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 538, сургуулийн өмнөх боловсролд 205 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тус тус хамрагдаад байна. 2024 онд Мэргэжлийн байгууллагуудтай хамтран багш нарыг чадавхжуулах 6 удаагийн сургалтад сургууль, цэцэрлэгийн 168, "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах -II" төслийн сургалтад 245, нийт 413 багш, удирдах ажилтан 2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургууль 554, цэцэрлэгт 211, нийт 765 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд боловсролд хамрагдсан. Мөн 1-р ангид элсэн суралцах 98 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг гаргаж 80 хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулсан.	100%
4.2. Нийгмийн халамж								
4.2.1 Зорилтот өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	85	Зорилтот өрхийн 15-34 насны хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийн судалгааг гаргаж, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулна.	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	179 иргэн.	720 иргэн.	ДТ 8.4	2021-2024 онд Зорилтот өрхийн 15-34 насны давхардсан тоогоор 1889 иргэнийг "Эрэлтэд нийцсэн ур чадварын сургалт", хөдөлмөрт бэлтгэх, ажлын байранд бэлтгэх сургалтад, компьютерын анхан шатны сургалтад 99, солонгос хэлний сургалтад 131, оёдол эсгүүрийн сургалтад 97, үсчний сургалтад 51 нийт 378 иргэнийг сургалтад хамруулж, чадамжийн гэрчилгээ олгосон. 2021 онд хүнс тэжээлийн дэмжлэг буюу хүнсний эрхийн бичиг авдаг өрхийн 18-34 насны хөдөлмөр эрхлэх боломжтой 219 иргэдийн дэлгэрэнгүй судалгаа гарган хөдөлмөрт бэлтгэх сургалтад 48 залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй 32 иргэдийг ажлын байранд бэлтгэх сургалтад, залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх "Оролцоо" төслийн 8 ээлжинд Хан-Уул дүүргээс 93 залуучууд нийт 173 иргэнийг хамрууллаа. 2022 онд Зорилтот өрхийн 15-34 насны 900 иргэнд сургалт зохион байгуулах эрх бүхий 4 байгууллагатай гэрээлэн хөдөлмөрт бэлтгэх сургалт, ажлын байрны дадлагын сургалтыг зохион байгуулсан. 2023 онд 2023 онд Дүүргийн ажил хайгч, зорилтот бүлгийн мэргэжлийн болон давтан сургалтад хамрагдах хүсэлт гаргасан 64 иргэний судалгааг гаргаж, чадавхжуулах зорилгоор компьютерын анхан шатны сургалтад 64, солонгос хэлний сургалтад 62, оёдол эсгүүрийн сургалтад 41, үсчний сургалтад 22 нийт 189 иргэнийг хамруулж, чадамжийн гэрчилгээ олголоо. Зорилтот бүлгийн иргэдийг хөдөлмөрт бэлтгэх сургалт зохион байгуулах хүсэлт ирүүлсэн 10 сургалтын байгууллагатай гэрээ байгуулж, зардлын 70 хувь 8,4 сая төгрөгийг олгож, 400 залуучуудыг бүртгэн, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулсан. 2024 онд Зорилтот өрхийн 15-34 насны хөдөлмөр эрхлэх чадвартай 140 иргэнийг бүртгэж Нийслэлийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын "Эрэлтэд нийцсэн ур чадварын сургалт"-д 84 иргэнийг бүртгэж Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сургалт, Үнэлгээ, Судалгааны Институтэд хүргүүлэн сургалтад хамруулж байна. Мөн насан туршийн суралцахуйн төв зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг чадавхжуулах зорилгоор компьютерын анхан шатны сургалтад 35, солонгос хэлний сургалтад 69, оёдол эсгүүрийн сургалтад 56, үсчний сургалтад 29 нийт 189 иргэнийг сургалтад хамруулж, чадамжийн гэрчилгээ олгосон.	100%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
	86	Зорилтот өрхийн ажлын байранд зүүчилж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	Ажлын байранд зүүчилсэн иргэдийн тоо	57 иргэн ажлын байранд зүүчилсэн.	220-оос доошгүй иргэн.		2021-2024 онд Зорилтот бүлгийн 188 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зүүчилж хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлсэн байна. 2021 онд Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх "Оролцоо" төслийн 8 ээлжинд Хан-Уул дүүргээс 93 залуучууд хамрагдан оролцсон. Нийт оролцогчдоос ажлын байран дахь дадлагад 69 залуучууд хамрагдсанаас байнгын ажлын байранд 21 залуучууд зүүчлэгдэн ажилд орсон байна. Мөн 32 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байранд бэлтгэх сургалтад хамруулан тохирох ажлын байранд зүүчилсэн. Нийт 53 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зүүчилсэн байна. 2022 онд "Ногоон ажлын байр хөтөлбөр"-ийн хүрээнд нийтийн эзэмшлийн зам талбай, хашаа хайс тохижуулах, сэргээн засварлах, хог хаягдлыг цэвэрлэх түр ажлын байранд нийт 163 иргэнийг хамруулсан. Ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй, хөгжлийн бэрхшээлтэй, хорих ангиас суллагдсан, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны , хөдөлмөрийн чадвартай иргэн, асрамжийн газраас гарсан иргэн зэрэг 566 иргэнээс 33 иргэнийг ажилд зүүчилсэн. 2023 онд дүүргийн хэмжээнд 3200 бүртгэлтэй ажилгүй иргэдийн 800 нь ажилд зүүчлэгдсэн. Үүнээс 203 (25.3%), 15-34 насны залуус байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй-51 (6.3%), хүнсний талонд хамрагддаг өрхийн-11 (13.7%) иргэнийг тус тус ажлын байранд зүүчилсэн. 2024 онд Зорилтот бүлгийн 311 иргэнд ажлын байр санал болгож, 40 иргэнийг ажлын байранд зүүчилсэн.	85%
4.2.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд нөлөөллийн олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.	87	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн "Уулзалт өдөрлөг", Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах Олон улсын өдөр"-ийг угтсан арга хэмжээ зохион байгуулна.	Арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо	370 иргэн хамруулсан.	1375-аас доошгүй иргэнийг хамруулсан байна	ДТ 169.43	2021-2024 онд "Олон улсын өдөр"-ийг угтсан 26 арга хэмжээнд давхардсан тоогоор 3660 иргэн хамруулж, Дүүргийн Засаг даргын захирамжаар хөгжлийн бэрхшээлтэй нийт 49 иргэнд 69.9 сая төгрөгийн буцалтгүй тусламж дэмжлэг үзүүлсэн. 2021 онд "Хөгжлийн бэрхшээлүүдийн үүсэх шалтгаан, төрлүүд суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх арга зүйтэй танилцах, сургалтын орчин-хамтын үйл ажиллагааны зарим хэсгээр аялах, санал бодлоо солилцох замаар боловсролын тусгай хэрэгцээтэй сурагчдын талаарх мэдлэг ойлголтоо нэмэгдүүлэх" уулзалтыг сургуулиудын удирдлага, менежер, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх зэрэг 130 иргэнийг оролцуулан зохион байгуулж, мэдээллээр хангасан. 150 брошур тарааж ажилласан.Хан-Уул дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл 2021 оны Нийслэлийн төргүүний салбар зөвлөлөөр шалгарсан. 2022 онд "Ээлтэй дүүрэг" аяны хүрээнд "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн уулзалт, өдөрлөг", Ерөнхий боловсролын 63 дугаар сургуулийн 40 сурагчийн тоглосон "Хөөрхөн ертөнц" жүжиг, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоотой хамтран Сэтгэлийн аялгуу хандивын тоглолт, Цагаан таягтны өдөрлөг, дүүргийн тусгай болон пара бочи, суугаа волейболын аварга шалгаруулах тэмцээн, Олон улсын болон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцож буй хөгжлийн бэрхшээлтэй тамирчдад дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээ зохион байгуулж 376 иргэдийг хамруулсан. 2023 онд "Хүслийн жигүүр" урлагийн наадам, Хөгжлийн бэрхшээлтэй эцэг эхчүүдийн "Асуудал шийдэл" уулзалт өдөрлөг, "Тэгш дүүрэн" урлагийн тоглолт, "Хөгжлийн бэрхшээл ба хүний ялгаатай байдал" сургалт, "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асрах, хөгжүүлэх, дэмжих" богино хугацааны сургалт, олон улсад зохион байгуулагдах тэмцээнд оролцогч 9 иргэнд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэнээс гадна Монголын хүүхдийн спортын 7 дугаар наадамд хөгжлийн бэрхшээлтэй 88 тамирчин дасгалжуулагч, нийслэл, дүүргийн өсвөрийн аварга шалгаруулах пара бочи, тусгай бочи, хонхтой бөмбөг гэсэн спортын 3 төрлийн тэмцээнд 92 тамирчин тус тус амжилттай оролцсон бөгөөд нийт 13 томоохон арга хэмжээнд 2650 иргэн хамрагдсан. 2024 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах "Олон улсын өдөр"-ийг угтан 8 арга хэмжээнд 504 хүн хамруулсан. Мөн Дүүргийн Засаг даргын захирамжаар хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнтэй 11 иргэнд 55.7 сая төгрөгийн санхүүжилтээр 5 ханатай гэр, 38 иргэнд 14.2 сая төгрөг, нийт 49 иргэнд 69.9 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.	100%
	88	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нэг цэгийн төвийг байгуулна.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нэг цэгийн төв барилга	Төсөв батлагдсан.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нэг цэгийн төв байгуулсан байна.	УТХО 471.6 ДТХО 75.0	2021-2022 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6 дугаар хороонд байрлах ашиглагдахгүй байсан хуучин халуун усны барилгын дэвэр, фасад засвар болон дотор засварын ажлыг хийж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нэг цэгийн төв болгон засварлаж , шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. 2023 онд дүүргийн төсвийн хөрөнгөөр тус барилгын дотор сантехник, шугам сүлжээний ажлыг хэрэгжүүлж, барилгыг инженер төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь төслийн удирдах нэгжтэй хамтран хэрэгжүүлж үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлийг хангасан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
4.2.3 Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	89	Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох, амьдрах ухаанд сургах төсөл хэрэгжүүлэх	Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	Зорилтот бүлгийн иргэн 55 хамрагдсан.	Зорилтот бүлгийн иргэнийг хамруулна. 260	ХЭДС 344.5 ДТ 110.4	2021-2024 онд Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэнийг нийгэмшүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зорилгоор Бүлгийн төсөл хэрэгжүүлэх удирдамж боловсруулан жил бүр төсөл шалгаруулан нийт 121 бүлгийн 245 иргэний төсөлд санхүүгийн буцалтгүй дэмжлэг үзүүлсэн байна. 2021 онд "Бүлгийн төсөл хэрэгжүүлэх" удирдамжийн дагуу 15 хорооны "Амьжиргааг дэмжих зөвлөл"-өөс дэмжигдсэн 43 бүлгийн төсөл хүлээн авч, төслийн хэрэгжих магадлал, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, шаардлага хангасан, хэрэгжих бүрэн магадлалтай 34 бүлгийн 71 зорилтот иргэний төслийг шалгаруулж, гэрээ байгуулан, нийгмийн халамжийн сангаас 38.000.000 төгрөгийн санхүүгийн буцалтгүй дэмжлэг олгосон. 2022 онд 31 бүлгийн 62 зорилтот иргэний төсөлд санхүүгийн буцалтгүй дэмжлэг олгож, Нийт 8 өрх, 125 иргэдэд нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа үзүүлсэн. 2023 онд "Бүлгийн төсөл"-ийн шалгаруулалтыг 2023 онд 2 удаа зохион байгуулж, шаардлага хангасан 35 бүлгийн 70 зорилтот иргэний төслийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан 60,0 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэг олгосон. 2024 онд "Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах" 21 бүлгийн төслийг сонгон шалгаруулж, 42 зорилтот иргэнд 47,0 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэг олгосон.	94%
4.2.4 Ахмадуудын хөгжлийг дэмжих, тэдний мэдлэг туршлагаа залуу үедээ хуваалцах боломжийг хангах үүднээс "Ахмадаа дээдэлье" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	90	"Ахмадаа дээдэлье" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	24 төсөл арга хэмжээг зохион байгуулсан.	Дэд хөтөлбөр 90% хэрэгжсэн байна.		2021-2024 онд Ахмад настнуудыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах, зорилтот бүлгийн ахмадуудад дэмжлэг үзүүлэх, ахмадын хөгжлийн төвд шаардлагатай төхөөрөмж нийлүүлэх, засвар хийх, олон улсын тэмдэглэлт өдрийн арга хэмжээ зохион байгуулах зэрэг нийт 28 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. 2021 онд Ахмадаа дээдэлье хөтөлбөрийн хүрээнд ахмадуудын дасгал хөдөлгөөн, дархлаажуулалтыг дэмжиж эрүүлээр насжихад дэмжих зорилгоор "Хөлбөмбөг-Эрүүл мэнд", "Дархлаажуулалт" төслүүдийг хэрэгжүүлсэн. 2022 онд "Ахмад настны эрүүл мэндийн гарын авлага" төсөл, "Цагаан сар", "Ахмадын баяр" арга хэмжээг тус тус хэрэгжүүлэн 7000 гаруй ахмад настанд хүрч ажилласан. 2023 онд Сар шинийн баяр, Олон улсын ахмадын баярыг угтсан арга хэмжээ, "Эх орны гурван хэлхээ", "Ахмад үеэ хүндэтгэе", "Хаврын аяз", "Модон бөмбөгийн тэмцээн", "Шугаман бүжиг", лон улсын тэмцээн уралдаанд оролцоход дэмжлэг үзүүлэх, 15 дугаар хорооны "Ахмад хөгжлийн төв"-д гүйлтийн зам болон шаардлагатай эд хэрэгсэл нийлүүлэх зэрэг нийт 12 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, 12,000 гаруй ахмад настанд хүрч ажилласан. 2024 онд Хөдөлмөрийн баатруудын замнал арга хэмжээ, 19 дүгээр хорооны Ахмадын хөгжлийн төвийн тохижилт, 16-р хорооны 300 ахмад настнуудыг эрдэсийн шинжилгээнд хамруулах", Зорилтот бүлгийн ахмадад гэр олгох, "Сар шинийн баяр", Ахмадын баяр" зэрэг нийт 6 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, 15,000 гаруй ахмад настанд хүрч ажилласан.	90%
	91	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулна	Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	17 ахмад.	Зөвлөх үйлчилгээнд 95 ахмад хамруулна.	ХЭДС 166.3	2021-2024 онд "Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ"-нд 222 ахмад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 166.3 сая төгрөг олгосон байна. 2021 онд Нийт 17 ахмад мэргэжилтэнтэй гурвалсан гэрээ байгуулж "Ахмад мэргэжилтний зөвлөн туслах үйлчилгээ" үзүүлсэн ахмадуудад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 14.28 сая төгрөгийг санхүүжилтийг олгосон байна. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ хөтөлбөрт заасны дагуу 35 ахмад настан аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэхээр төсөл ирүүлснээс 13 иргэний төслийг дэмжин 36.0 сая төгрөгийг эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон. 2022 онд Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд боловсрол, эрүүл мэнд, төрийн захиргаа, уул уурхай, хууль эрх зүй, хөдөлмөрийн харилцаа зэрэг 6 чиглэлээр 48 иргэнийг хамруулсан. 2023 онд Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдах 65 иргэний хүсэлтийг хүлээн авч, хамтран ажиллах байгууллагуудтай нь гурвалсан гэрээ байгуулан 51 ахмадад 49,492,000 төгрөгийн урамшуулал олгон зөвлөх үйл ажиллагааг үзүүлсэн. 2024 онд "Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ"-нд 80 ахмад, хүүхэд хамгаалагч арга хэмжээнд 13 ахмад, нийт 93 ахмадыг түр ажлын байраар хангасан.	100%
4.2.5 Дүүргийн "Эко ахмадын сувилал"-ын барилгыг ашиглалтад оруулж, ахмадууд үйлчлүүлэх амралт, сувиллын хүртээмжийг нэмэгдүүлнэ.	92	"Эко ахмадын сувилал"-ын барилгыг ашиглалтад оруулна.	Сувилалын байгуулах ажлын хэрэгжилтийн хувь	Барилгын ажил 90% тай хэрэгжиж байна.	Барилга ашиглалтад оруулна.	ДТХО 2,337.0	2021-2022 онд 2021 оны 3 дугаар сарын 29-нд ажиллан 2021 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн БА-119/2021 тоот дүгнэлтээр дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан "Эко ахмадын сувилал"-ыг ашиглалтад хүлээн авсан. Гадна цахилгаан хангамжийн ажлыг 2022 оны 11 сарын 03-ний өдөр дуусгаж ашиглалтад авсан.	100%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
4.3. Хөдөлмөр эрхлэлт								
4.3.1 "Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээг цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэнэ.	93	Халамжийн нэгдсэн систем /ehalamj.mn/-ыг хөгжүүлж, нийгмийн халамжийн 72 төрлийн үйлчилгээг үе шаттай цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг зохион байгуулах	Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний тоо	6 төрлийн үйлчилгээ нэвтрүүлсэн.	72 төрлийн үйлчилгээ нэвтрүүлнэ.	УТХО 246.9	2021-2024 онд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа "Цахим-Монгол" хөтөлбөрийн хүрээнд төрөөс иргэдэд үзүүлж буй Нийгмийн халамжийн үйлчилгээг үе шаттай цахим хэлбэрт шилжүүлснээр 2024 оны байдлаар иргэдэд 72 үйлчилгээг цахимаар хүргэж байна. 2021 онд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа "Цахим-Монгол" хөтөлбөрийн хүрээнд төрөөс иргэдэд үзүүлж буй Нийгмийн халамжийн үйлчилгээг үе шаттай цахим хэлбэрт шилжүүлж, Ehalamj.mn цахим сайтаар дамжуулан 128,342 иргэн 25 төрлийн халамжийн үйлчилгээг иргэдэд цахимаар үзүүлсэн. 2022 онд ehalamj.mn сайтаар цахим үйлчилгээ үзүүлэх нийгмийн халамжийн 25 төрлийн үйлчилгээ нэмэгдэж, нийт 69 төрлийн үйлчилгээг цахимаар үзүүлж, тайлант хугацаанд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээнд давхардсан тоогоор 156,679 иргэдэд үйлчилсэн байна. 2023 онд ehalamj.mn-ээр 69 төрлийн үйлчилгээг иргэдэд цахимаар үзүүлж, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтөд нийт 167985 иргэнд үйлчилсэн. Шинээр хүнсний эрхийн бичиг олгох үйлчилгээний цахим хөгжүүлэлт хийгдэж байна. 2024 онд Иргэдэд (Ehalamj.mn) халамжийн нэгдсэн системээр дамжуулан нийгмийн халамжийн 72 төрлийн цахим үйлчилгээг хүргэж Нийгмийн халамжийн сангийн үйлчилгээнд нийт 176574 иргэн хамруулсан.	100%
	94	Сурталчилгаа олон нийтийн арга хэмжээ, хөдөлмөрийн яармаг, өдөрлөг, хууль тогтоомж, эрх зүйн актын уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	Зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлгийн тоо	2 удаагийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан.	10-аас доошгүй удаагийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулна.	УТХО 5.7	2021-2024 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийг сурталчлах, иргэдэд таниулах чиглэлээр хөдөлмөрийн өдөрлөг яармагийг 8 удаа, Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтнүүдийг чадавжуулах сургалтыг 3 удаа зохион байгуулж, 450 гаруй иргэнийг хамруулсан байна. 2021 онд нийслэлийн төр захиргааны байгууллагуудын хамтарсан нээлттэй хаалганы өдөрлөгийн хүрээнд 1, 8-р хорооны иргэдэд нээлттэй хаалганы өдөрлөгийг 2 удаа зохион байгуулсан. 2022 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийг сурталчлах, иргэдэд таниулах, төсөл хөтөлбөрүүдэд нөхцөл байдлын үнэлгээ хийхтэй уялдуулан хэлтсийн ажилтан болон хороодын мэргэжилтнүүдийг чадавжуулах сургалтуудыг 3 удаа зохион байгуулсан. 2023 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-г танилцуулах 5 удаагийн хөдөлмөрийн өдөрлөг яармагт 400 иргэн хамруулсан. 2024 онд "Хөдөлмөр, эрхлэлт 2024" өдөрлөг арга хэмжээг Мишээл экспо- д 2024 оны 05 дугаар сарын 01-ны өдөр зохион байгуулж дүүрэгт үйл ажиллагаа эрхэлдэг 8 ажил олгогчийн сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг иргэд олон нийтэд танилцуулсан. Өдөрлөгөөр хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих зорилгоор бизнес эрхлэгч 50 иргэний хамруулж, ажил идэвхтэй хайж байгаа 11 иргэнд байнгын болон түр ажлын байр санал болгосон.	100%
4.3.2 Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтийг дэмжинэ.	95	Шилдэг "Старт-ап" 2 багийг сонгон шалгаруулах, Старт-ап залуучуудад ментор хийх	Шалгарсан багийн тоо	5 баг.	12 баг шалгаруулж, Старт ап залуучуудын бизнесийг дэмжинэ.	ХЭДС 68	2021-2024 онд Залуучуудын гарааны бизнесийг дэмжих хүрээнд сонгон шалгаруулалтад тэнцсэн 7 багийн гарааны бизнесийг дэмжиж 68.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. 2021 онд Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын залуучуудын гарааны бизнес, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2 багийн төслийг илгээн баг тус бүр 10.0 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэг авсан. 2022 онд дүүргийн 48 залуусыг бүртгэн сургалтанд хамруулснаас 2 иргэний төсөл шалгарч санхүүгийн буцалтгүй дэмжлэг авсан. 2023 онд 36 залуучууд бүртгүүлж анхан шатны сонгон шалгаруулалтад тус бүр 2 хүнтэй 5 баг шалгарч дараагийн шатны сургалтад 10 залууг хамруулсан. Үүнээс сонгон шалгаруулалтад тэнцсэн 2 багт тус бүр 10 сая төгрөг буюу 4 залууд 20 сая төгрөгийн санхүүжилт олгосон. 2024 онд "Шилдэг старт ап" шалгаруулах уралдааны хүрээнд дүүргийн хэмжээнд 2 баг шалгаруулахаар төлөвлөсөн бөгөөд хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй 55 залуусд уралдааны талаарх зөвлөгөө мэдээлэл хүргэн 5 баг(10 залуус)-ийн төсөл хүлээн авч, эцсийн шатанд шалгарсан 1 багт эргэн төлөгдөх нөхцөлгүй 18.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон.	60%
	96	"Бизнесээ эхэл", "Бизнесээ хөгжүүл" бүлгээр ажиллах чадвар олгох сургалт зохион байгуулж гэрчилгээ олгоно.	Сургалт, хамрагдсан үйлдвэрлэл эрхлэгчийн тоо	2020 онд "Бизнесээ эхэл", "Бизнесээ хөгжүүл", сургалтад 36 үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулсан.	110-аас доошгүй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг хамруулна.	ХЭДС 195.5	2021-2024 онд Бизнес эрхлэлтийн сургалт, зөвлөгөө үйлчилгээнд 265 залууг хамруулж, 24 иргэнд 195.5 сая төгрөгийн санхүүжилтийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон байна. 2021 онд "Бизнесээ эхэл, Бизнесээ хөгжүүл" сургалтыг цахимаар 2 удаа зохион байгуулж нийт 20 үйлдвэрлэл, эрхлэгчдийг хамруулж гэрчилгээ олгосон. 2022 онд Сургалтын эрх бүхий 6 байгууллагатай гэрээ байгуулан аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд аж ахуй эрхлэлтийн өмнөх болон дараах сургалтад 100 иргэнийг хамруулсан. 2023 онд Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвд 18-36 насны 51 залуусыг сургалтад хамруулж, 20 иргэний төсөлд эргэн төлөгдөх нөхцөлтэй 173 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон. Улсын хэмжээнд шилдэг старт ап шалгаруулах уралдаанд 36 залуу бүртгүүлснээс анхан шатны шалгаруулалтад тус бүр 2 хүнтэй 5 баг (10 хүн) шалгарч, дараагийн шатны сургалтад хамрагдан шалгарсан 2 багт тус бүр 10 сая төгрөгийн санхүүжилт авсан. 2024 онд Дүүргийн хувиараа хөдөлмөр эрхлэгч 84 залуусын "In business-Бизнесээ эрхлье" сургалтын зардлын 2.3 сая төгрөгийн 70%-ийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгоод байна.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
4.3.3 Цагийн ажлын байрыг дэмжиж нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллаж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	97	Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журмын хэрэгжилтийг хангах, цагийн ажилд зуучлах	Цагийн ажилд зуучилсан оюутны тоо	100 оюутанг цагийн ажилд зуучилсан.	470-аас доошгүй оюутанг цагийн ажилд зуучилна.	ХЭДС 7.6	2021-2024 онд нийт идэвхтэй цагийн ажил хайж буй 1812 оюутнаас 692 оюутныг цагийн ажилд зуучилсан. 2021 онд 2021 оны 12 дугаар сард ХААИС, МИС-ын дэргэдэх МСҮТ-ийн 50 оюутныг Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэх цагийн ажилд ажиллуулсан. 2022 онд ХУД-ийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, цагдаагийн хэлтэстэй хамтран Хөдөө аж ахуйн их сургуулийн 292 оюутныг цагийн ажлын байранд зуучилсан. 2023 онд Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 12 аж ахуй нэгж байгууллагын 56 цагийн ажлын байрны захиалгыг бүртгэн, Нийслэлийн хөдөлмөр, халамжийн газарт тухайн бүрт нь хүргүүлсэн бөгөөд 1012 оюутан цагийн ажил эрхлэхээр бүртгүүлснээс 310 оюутныг цагийн ажилд зуучилсан. 2024 онд E job платформд бүртгэлтэй 15-34 насны 800 оюутан, залуучуудаас идэвхтэй ажил хайж буй 40 оюутныг байнгын болон түр ажлын байранд зуучилсан.	100%
4.3.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тохирсон ажлын байрыг дүүргийн ажил олгогч байгууллагуудтай хамтран ажиллах замаар нэмэгдүүлнэ.	98	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх болон аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулах	Сургалтад хамрагдсан болон Санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн тоо	48 иргэнийг сургалтад хамруулж, 25 иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.	400-аас доошгүй иргэнийг сургалтад хамруулж, 80 иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.	ХЭДС 708	2021-2024 онд 8 сургалтын байгууллагыг сонгон шалгаруулж, мэргэшүүлэх, чадваржуулах сургалтад 529 иргэнийг хамруулж, 154 иргэнд 50 хувь нь эргэн төлөгдөх нөхцөлтэй 704.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгож, 98 иргэнийг түр ажлын байранд зуучилсан. 2021 онд 8 сургалтын байгууллагыг сонгон шалгаруулж 100 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сургалтад хамруулж, сургалтын төлбөрт 4.0 сая санхүүжилт олгосон. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох 50%-ийн эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгт 37 төслийг хүлээн авч, 18 иргэн сонгон шалгаруулж, 80,000,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. 2022 онд "Аж ахуй эрхлэлтийн өмнөх болон дараах сургалт"-д хөгжлийн бэрхшээлтэй 138 иргэнийг хамруулж, 43 иргэний төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлж, 65 иргэнийг түр ажлын байраар хангасан. 2023 онд Хөгжлийн бэрхшээлтэй 85 иргэний төслийг хүлээн авч сонгон шалгаруулалтад тэнцсэн 51 иргэний төсөлд 320.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Аж ахуй эрхлэлтийн сургалтад хөгжлийн бэрхшээлтэй 140 иргэнийг хамруулж, ажил хайгч 71 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 22 иргэнийг ажилд зуучилж, нийтийг хамарсан ажилд давхардсан тоогоор 120 иргэн зуучлан ажиллууллаа. 2024 онд Аж ахуй эрхлэлтийн өмнөх болон дараах сургалтад 100 иргэн, И-Монголиа академитай хамтран гар утасны хэрэглээ, цахим ур чадварыг сайжруулах сургалтад 51 иргэн хамруулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 58 иргэний төслийг хүлээн авч танилцсанаас 42 иргэний төсөл шалгарч 50 хувь нь эргэн төлөгдөх нөхцөлтэй 304.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэн авч ажиллуулах хүсэлт ирүүлсэн 50 ААН байгууллагын сул чөлөөтэй 90 ажлын байрны захиалгад ажил идэвхтэй хайж буй 11 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилсан.	100%
4.3.5 Дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд болон хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бий болсон ажлын байрыг бүртгэж, иргэдийг ажилд зуучлах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	99	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хэрэгжүүлэх	Зөвлөгөө мэдээлэл өгсөн болон ажилд зуучилсан иргэдийн тоо	700 иргэнийг ажилд зуучилж, 2880 иргэнд зөвлөгөө.	2880-оос доошгүй иргэнийг ажилд зуучилж, 11200 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлнэ.	ХЭДС 1,319.4	2021-2024 онд хөдөлмөрийн зах зээлийн LMIS, EJOB зэрэг мэдээллийн нэгдсэн санд 820 гаруй аж ахуйн нэгжийн 2928 ажлын байрны захиалгыг 5992 иргэнд санал болгон 2663 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилж, 10497 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлсэн. 2021 онд 215 аж ахуйн нэгж байгууллагаас 1462 ажлын байрны захиалга авч, тохирох ажлын байранд бүртгэлтэй иргэдийг санал болгосноос 495 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилсан байна. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд ганцаарчилсан хэлбэрээр 1000 иргэн, бүлгийн хэлбэрээр 1800 иргэнийг хамруулан эрх бүхий сургалтын байгууллагуудтай гэрээ байгуулан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 20.8 сая төгрөг зарцуулсан. 2022 онд Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад шинээр бий болсон 500 ажлын байрыг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан /LMIS/-д нэмж бүртгэн, 568 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан. Ажил хайгч 2000 гаруй иргэнийг "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр"-ийг танилцуулах арга хэмжээнд, 900 залуучуудыг ажлын дадал, туршлага эзэмшүүлэх сургалтад хамруулсан. 2023 онд 606 аж ахуйн нэгж байгууллага, ажил олгогчдоос сул чөлөөтэй 966 ажлын байрны захиалга хүлээн авч, 3200 иргэнийг мэдээллийн санд бүртгэж, 1500 иргэнд ажлын байр санал болгон 800 ажил хайгч иргэдийг ажлын байранд зуучилж ажилласан. 2024 онд Хөдөлмөрийн зах зээлийн EJOB системд ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт ирүүлсэн 3497 иргэнд профайлинг үйлчилгээнд бүртгэн зөвлөгөө өгч, байнгын ажлын байранд 775, түр ажлын байранд 25, нийт 800 иргэнийг ажилд зуучилсан.	90%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
4.3.6 "Хан-Уулд үйлдвэрлэл" борлуулалтын төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж, төвийн үйл ажиллагаагаар дамжуулан жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллана.	100	"Хан-Уулд үйлдвэрлэл" борлуулалтын төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллана.	Дэмжлэгт хамрагдсан үйлдвэрлэл эрхлэгчийн тоо	2020 онд, 24 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг "Түрээсийн төлбөргүй" борлуулсан.	250-аас доошгүй үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.	ДТ 19.7	2021-2024 онд 497 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг "Их хотын хямдралтай худалдаа", "Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн өдөрлөг", "Бүтээгч Хан-Уулчууд" зэрэг 48 удаагийн үзэсгэлэн худалдаа, арга хэмжээнд түрээсийн хөнгөлөлттэй оролцуулж, 1,722.5 сая төгрөгийн борлуулалт хийхэд дэмжлэг үзүүлсэн. 2021 онд "Хан-Уулд үйлдвэрлэл" борлуулалтын төвд 36 үйлдвэрлэл эрхлэгчийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжин ажилласан. Өргөтгөсөн худалдаанд давхардсан тоогоор дүүргийн 45 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулж, нийт 32 сая төгрөгийн борлуулалтыг дэмжин ажилласан. 2022 онд 12 удаагийн үзэсгэлэн болон өргөтгөсөн худалдаанд үндэсний үйлдвэрлэл эрхлэгч нийт 160 иргэн, аж ахуйн нэгжийг түрээсийн төлбөргүйгээр хамруулж 243.5 сая төгрөгийн борлуулалт хийхэд дэмжлэг үзүүлэн ажилласан. 2023 онд "Бүтээгч Хан-Уулчууд" дэд хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд Хан-Уулд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг дэмжих зорилгоор "Бүтээгч Хан-Уулчууд-2023" арга хэмжээг 5 удаа зохион байгуулж нийт 780 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг сурталчлан борлуулалтыг нь дэмжсэн. Мөн 20 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 187 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг түрээсийн төлбөргүйгээр хамруулж, нийлбэр дүнгээр 433.0 сая төгрөгийн борлуулалт хийхэд нь дэмжлэг үзүүлсэн. 2024 онд олон нийтэд сурталчлах зорилгоор 11 удаагийн үзэсгэлэн худалдаанд 105 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг түрээсийн төлбөргүйгээр хамруулж, нийт 1 тэрбум 14 сая төгрөгийн борлуулалт хийхэд дэмжлэг үзүүлсэн	100%
4.3.7 Дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн дэргэдэх "Бойжуулах төв"-ийн үйл ажиллагааг өргөжүүлэн, үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг нэмэгдүүлж, дэмжлэг үзүүлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.	101	Дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн дэргэдэх "Бойжуулах төв"-ийн үйл ажиллагааг өргөжүүлэн өрхийн үйлдвэрлэлийг дэмжин ажиллана.	Бойжуулах төвөөр үйлчлүүлсэн үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо	12 үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэн.	70-аас доошгүй үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ.		2021-2024 онд Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн дэргэдэх "Бойжуулах төв"-д 53 үйлдвэрлэл эрхлэгчийг ажлын байр, арга зүйгээр ханган жил бүр зохион байгуулагддаг үзэсгэлэн худалдаанд түрээсийн төлбөргүй оролцуулж, 73,2 сая төгрөгийн борлуулалт хийхэд дэмжин ажилласан. 2021 онд 2021 оны жилийн эцсийн байдлаар 6 үйлдвэрлэл эрхлэгчид нийт 13,3 сая төгрөгийн борлуулалт хийж ажилласан. 2022 онд дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн дэргэдэх "Бойжуулах төв"-д 15 үйлдвэрлэл эрхлэгчийг үнэ төлбөргүй ажлын байраар ханган, бүтээгдэхүүнээр нь үзэсгэлэн гарган олон нийтэд сурталчлан 7.0 сая төгрөгийн борлуулалтыг дэмжин ажилласан. 2023 онд Дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн дэргэдэх "Бойжуулах төв"-д 2023 онд өрхийн үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой, ажлын байргүй 26 иргэнийг элсүүлж үнэ төлбөргүй ажлын байраар ханган нийслэл, дүүргээс зохион байгуулсан 8 удаагийн үзэсгэлэн болон өргөтгөсөн худалдаанд түрээсийн төлбөргүйгээр байршуулж, олон нийтэд сурталчлан танилцуулж 13 сая төгрөгийн борлуулалт хийхэд дэмжин ажилласан. Мөн мэргэжлийн байгууллага, сургалтын төвүүдтэй хамтран олон дадлага хосолсон 6 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 202 иргэнийг хамруулсан. 2024 онд 12 дугаар хороонд байгуулсан "Хан-Уул дүүргийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн бойжуулах байр"-нд 13 иргэнийг элсүүлж, ажлын байраар ханган нийслэл, дүүргээс зохион байгуулсан 10 удаагийн үзэсгэлэн худалдаанд түрээсийн төлбөргүй оролцуулж нийт 39.9 сая төгрөгийн борлуулалт хийхэд дэмжин ажилласан.	100%
4.4. Дүүргийн төсөв, санхүү								
4.4.1 Төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг иргэд олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга бат, хариуцлагыг өндөржүүлнэ.	102	Орон нутгийн төсвөөс санхүүжиж буй байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулсан эсэхэд хяналт тавьж, зөвлөмж арга зүйгээр хангана.	Хугацаандаа мэдээлсэн байгууллага (хувь)	нийт 195 байгууллага шилэн дансанд байршуулах шаардлагатай мэдээллээ 87.6% байршуулсан.	Хуулийн хугацаанд 205 байгууллагын шилэн дансанд байршуулах шаардлагатай мэдээллээ 92% байршуулсан байна.		2021-2024 онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 94 байгууллага Шилэн дансны тухай хуулийн 3.1.1 болон 8.2 дахь заалтын дагуу мэдээллэвэл зохих 10566 мэдээллээс 10176 мэдээллийг 96%-ийн гүйцэтгэлтэй хугацаанд нь байршуулж байна. 2021 онд Хуулийн хугацаанд 21 ерөнхий боловсролын сургууль, 28 цэцэрлэг, 18 орон нутгийн төсөвт байгууллага, 15 өрхийн эмнэлэг, 25 хувийн сургууль, 96 хувийн цэцэрлэг нийт 205 байгууллага https://shilendans.gov.mn/ сайтад байршуулах шаардлагатай 7,971 мэдээллээс 7,701 мэдээлэл байршуулан 91.78% гүйцэтгэлтэй байна. 2022 онд нийт 205 байгууллага https://shilendans.gov.mn/ сайтад байршуулах шаардлагатай 2782 мэдээллээс 2451 мэдээлэл байршуулан 88.10% гүйцэтгэлтэй байна. 2023 онд Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний нийт 234 байгууллага шилэн дансанд байршуулах шаардлагатай мэдээллээ 95% байршуулсан. 2024 онд Шилэн дансны тухай хуулийн 3.1.1 болон 8.2 дахь заалтын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 234 байгууллагаас хувийн хэвшлийн 140 орчим сургууль, цэцэрлэгийн хувьсах зардлыг Боловсролын Яамнаас хариуцдаг болсон тул 94 байгууллага нийтэд мэдээлбэл зохих 10566 мэдээллээс 10176 мэдээллийг 96% хугацаандаа байршуулсан.	96%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
4.4.2 Татвар ногдуулах, хураах үйл ажиллагаанд технологийн дэвшил нэвтрүүлэн, хялбаршуулна.	103	Цахим татвар төлөлт, төлбөрийн даалгавар үүсгэх үйлчилгээний талаар сургалт зохион байгуулж үйлчлүүлж байгаа татвар төлөгчийн тоог багасгах.	Цахим татвар төлөлтийн хувь	Төлбөрийн даалгавар үүсгэх цахим систем 100% цахим хэлбэрт шилжсэн боловч цахим хэрэглээний түвшин муу байна.	Цахимаар төлбөрийн даалгавар үүсгэх 90% д хүргэх.		2021-2024 онд татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээг хялбаршуулах хүрээнд төлбөрийн даалгавар үүсгэх үйлчилгээ бүрэн цахимд шилжсэн бөгөөд 2021 онд үүсгэсэн төлбөрийн даалгаврын 60 хувь нь цахимаар төлөгдөж байсан бол 2024 онд 92 хувьд хүрсэн байна. 2021 онд 8 удаагийн сургалтыг цахимаар зохион байгуулж, нийт 22317 хүнд хүрч 246 удаа түгээгдсэн байна. 2020 онд үүссэн 13210 төлбөрийн даалгаврын 40 хувь нь цахимаар гүйлгээ хийгдсэн бол 2021 онд үүссэн 15582 төлбөрийн даалгаврын 60 хувь нь цахимаар төлөгдсөн байна. Үүнээс үзэхэд сургалтын үр дүнд цахим төлбөр төлөлт 20 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 2022 онд Татварын алба нь 100 хувь цахим тайлангийн системд шилжиж, 71 удаагийн сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулж 6031 татвар төлөгчийг хамруулсан байна. 2022 онд төлөлт хийгдсэн 323304 төлбөрийн даалгавраас 233104 буюу 72.0 хувь нь цахимаар төлөгдсөн бол 90200 буюу 28.0 хувь нь банк болон төрийн сангаар гүйлгээ хийгдсэн. 2023 онд Татварын алба нь 100 хувь цахим тайлангийн системийг ашиглан татварын үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй хэрхэн авах, тайлан хэрхэн илгээх сургалтыг татвар төлөгч нарт тогтмол зохион байгуулж байна. Цахимаар татвар төлөлт өмнөх оны мөн үед 72 хувь байсан бол онд 96 хувь буюу 374807 төлбөрийн даалгавраас 360082 нь цахимаар төлөгдөж, 14725 буюу 4 хувь нь төрийн сангаар хийгджээ. 2024 онд 412417 төлбөрийн даалгавараас 379425 буюу 92 хувь нь цахимаар төлөгдөж, 8 хувь буюу 32993 нь төрийн сангийн гүйлгээ хийгджээ.	100%
4.4.3 Дүүргийн орон нутгийн өмчийг бүртгэлжүүлэх, өмч ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	104	Дүүргийн төсвийн хөрөнгөөр бий болж буй хөрөнгийн бүртгэл, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулна.	Тооллого хийгдэж, тайлан ирүүлсэн байгууллагын тоо	Нийт 68 байгууллага хамрагдаж, тооллогын комисст ажлын тайлан ирүүлсэн.	Дүүргийн хөрөнгө оруулалтаар хийж байгаа ажлуудад өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалтыг сайжруулах, чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. 70 байгууллагад хөрөнгийн тооллого хийгдсэн байна.		2021-2024 онд өмчийг бүртгэлжүүлэх, тоолох ажлыг жил бүр зохион байгуулж ашиглалтад хяналт тавьж ажилласан. 2024 оны байдлаар дүүргийн өмчид 206,070 урт метр 232,511,722.513 төгрөгийн өртөг бүхий зам гүүрэн байгууламж, 6445 м.кв 27,845,418,019 өртөг бүхий барилга байгууламж, 282,656 м, 15,023,092,508 төгрөгийн өртөгтэй бусад эд хөрөнгө, 19,371,294,568 төгрөгийн үнэ бүхий 117,757ш тоног төхөөрөмж, тавилга, эд хөрөнгө, 1,557,679,348 төгрөгийн үнэ бүхий 149,962 м.кв газар, нийт 296,309,206,956 төгрөгийн өмч хөрөнгө бүртгэлтэй байна. Өмч хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зорилгоор ашиглагдахгүй байсан халуун усны барилгыг "хүүхэд хамгааллын байр", "камерын хяналтын дэд төв" болгон засварлаж, актлагдсан хуучин байрыг буулгаж, авто машины зогсоол болгон тохижуулж, ашиглалтыг сайжруулсан. 2021 онд дүүргийн хөрөнгө оруулалтаар 3,454.1 сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж ашиглагч талд хүлээлгэн өгч данс бүртгэлд тусгуулсан. 2022 онд дүүргийн өмчийн ашиглалтад хяналт тавьж, 90 байгууллагад хөрөнгийн тооллого хийсэн. 2023 онд Нийт 40 хэлтэс албадын 14 төрлийн өмч хөрөнгийг тоолж, 112 нэр төрлийн 63,299,221 төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийг актласан. Дүүргийн орон нутгийн өмчит газруудад 1 трактор, 10 хог тээврийн автомашин, дүүргийн Татварын хэлтэст 4 нэр төрлийн тоног төхөөрөмж, 48 компьютер, "Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ-т машин тоног төхөөрөмжүүд хүлээлгэн өгч, нийт 2,941,441,366 төгрөгийн өмчийг дээрх байгууллагуудын данс бүртгэлд бүртгүүлсэн. 2024 онд Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны А/52, А/108 дугаар тушаалаар 2 удаа Засаг даргын Тамгын газрын 10 хэлтэс, 25 хороо, дэргэдэх 15 хэлтэс, албадын 14 төрлийн өмч хөрөнгийг тоолж, өмч хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зөвлөмж өгсөн. Энэ онд нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр 2151 у/м 486,754,540.49 төгрөгийн өртөгтэй зам, гүүрэн байгууламж, 71,069,815,896 төгрөгийн өртөг бүхий 1324 ш бусад хөрөнгө хүлээн авч, бүртгэлд тусгасан.	70%
4.4.4 Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.	105	Дотоодын давуу эрх тооцох боломжтой төсөл арга хэмжээнд тухай бүрт тусгаж ажиллах	Дотоодын үйлчилгээг дэмжсэн хувь	Дотоодын давуу эрх тооцох төсөл арга хэмжээ 50%-тай байна.	Нийт арга хэмжээний 70%-д дотоодын давуу эрх тооцохоор тусгасан байна.		2021-2024 онд нийт 479 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас 401 төсөл арга хэмжээ буюу 83.7 хувьд дотоодын давуу эрх тооцох заалтыг тусган 24 төсөл арга хэмжээнд дотоодод үйлдвэрлэгдсэн 204.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалт хийсэн. 2021 онд Тайлант хугацаанд зарлагдсан нийт 70 төсөл арга хэмжээний 50 төсөл арга хэмжээ буюу 71.4%-д дотоодын давуу эрх тооцох заалтыг тусгаж ажилласан бөгөөд оролцсон аж ахуйн нэгжүүд дотоодын давуу эрх тооцох нөхцөл шаардлагыг хангасан тухай нотлох баримт зэргийг ирүүлээгүйгээс тайлант хугацаанд уг заалтаар дотоодын давуу эрх тооцуулсан аж ахуйн нэгж байхгүй байна. 2022 онд Дүүргийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу нийт 149 төсөл арга хэмжээ зарлагдахаас 108 төсөл арга хэмжээнд буюу 72.5 хувь нь дотоодын давуу эрх тооцохоор тусгасан. Үүнээс 21 төсөл арга хэмжээнд дотоодын давуу эрх тооцож 71,400,000 төгрөгийг тоног төхөөрөмж дотооддоо үйлдвэрлэдэг аж ахуй нэгжээс худалдан авалт хийсэн. 2023 онд Нийт 107 төсөл арга хэмжээний 100 төсөл арга хэмжээ буюу 93.4%-д дотоодын давуу эрх тооцохоор тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан. Тайлант хугацаанд дээрх 100 төсөл арга хэмжээнд оролцогчдын зүгээс холбогдох баримт бичгийн бүрдлийг хангаагүй тул давуу эрх тооцох боломжгүй болсон. 2024 онд Худалдан авах ажиллагааны нийт 154 төсөл арга хэмжээгээс дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 143 төсөл арга хэмжээнд 100% дотоодын давуу эрх тооцохоор тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан бөгөөд уг 3 төсөл арга хэмжээг дотоодын үйлдвэрээс худалдан авалт хийсэн.	100%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь	
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)			
4.5. Гэр бүл									
4.5.1 Гэр бүлийн хөгжлийг дэмжих хэрэгжүүлж, Хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага, шилдэг гэр бүлийг шалгаруулан олон нийтэд сурталчилна.	106	Гэр бүл хүүхэд залуучуудад ээлтэй байгууллага, аж ахуйн нэгж, Шилдэг гэр бүлийг шалгаруулан олон нийтэд сурталчилна	Шалгарсан байгууллага, бүлийн тоо	гэр	"Хүүхэд гэр бүлд ээлтэй" байгууллагыг шалгаруулсан.	20 байгууллага, 20 гэр бүлийг шалгаруулан сурталчилна.	HT 6.76	2021-2024 онд Гэр бүлд ээлтэй байгууллага, аж ахуй нэгж, Шилдэг гэр бүл шалгаруулах арга хэмжээний хүрээнд "Гэр бүлд ээлтэй байгууллага"-аар "Говь" ХХК, "Мөнххада" ХХК, 115-р сургууль, 250-р цэцэрлэг, 21-р хороо зэрэг 7 байгууллага, Нийслэл хотын шилдэг гэр бүлээр 11 иргэн шалгарсан. 2021 онд Монголын ахмадын байгууллагын 90 жилийн ойн хүрээнд "Ахмадад ээлтэй байгууллага"-аар 4 байгууллага, "Нийслэл хотын шилдэг гэр бүлийг алдаршуулах" арга хэмжээнд 5 төрөлд 7 гэр бүлийн материалыг хүргүүлж 3 гэр бүл өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулсан.Хүүхэд гэр бүлд ээлтэй аж ахуй нэгж шалгаруулах үйл ажиллагаанд 9 төрөлд 7 байгууллагын материал хүргүүлж, 2 байгууллага шалгарсан. 2022 онд Онцлог гэр бүл шалгаруулах үйл ажиллагаанд 15 гэр бүлийн материал хүлээн авч, Нийслэлд "Оюунлаг гэр бүл", "Авьяаслаг гэр бүл" 2 шагнал, "Хүүхэд гэр бүлд ээлтэй байгууллага"-аар "Говь" ХХК шалгарсан. Хан-Уул дүүргийн "Хүүхэд гэр бүлд ээлтэй байгууллага"-аар "Мөнххада" ХХК, 115-р сургууль, 250-р цэцэрлэг, 21-р хороо тус тус шалгарсан. 2023 онд Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас "Олон улсын гэр бүлийн өдөр"-ийг угтан "Онцлог гэр бүл" шалгаруулах удирдамж баталсан бөгөөд Хан-Уул дүүргийн хэмжээнд Онцлог 8 гэр бүлийг Оюунлаг гэр бүл, Спортлог гэр бүл төрлөөр шалгаруулан цахим мэдээллийн хэрэгслээр алдаршуулж, нийслэлийн онцлог гэр бүл шалгаруулалтад хүргүүлсэн. 2024 онд Онцлог гэр бүлийг 5 номинациар шалгаруулсан бөгөөд Оюунлаг гэр бүлд 22-р хорооны иргэд Г.Ганзоригийн гэр бүл, Бүтээлч гэр бүлд 13-р хорооны иргэд Б.Базарвааний гэр бүл, Эко гэр бүлд 4 дүгээр хорооны иргэд С.Пүрэвсүрэнгийн гэр бүл, Хүмүүнлэгийн гэр бүлд 4 хорооны иргэд Б.Отгонбаярын гэр бүл, Спортлог гэр бүлд 21-р хорооны иргэд А.Гэрэлт-Одын гэр бүл тус тус шалгарсан бол "Нийслэлийн тэргүүний өрх"-д тус дүүргийн 14-р хорооны өндөр настан Д.Өлзийдэлгэрийн гэр бүл шалгарсан.	50%
	107	Гэр бүлийн хөгжлийг дэмжих туршилтын хөтөлбөрт хамрагдаж буй 250 өрхийг хөгжлийн үйлчилгээнд хамруулж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.	Амьжиргааны түвшин дээшилж, төслөөс хасагдсан өрхийн тоо	250 өрх хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан.	250 өрхийн амьжиргаа дээшилж, төслөөс хасагдсан байна.	HT 20.0 ДТ 16.4 ТХГБДСан 33.0	2021 онд Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 4, Тайваний Гэр бүл, хүүхдийн хөгжлийг дэмжих сангаас зорилтот бүлгийн 6, нийт 10 өрхөд 5 ханатай иж бүрэн гэр өгч, 170 өрхийн амьжиргаа дээшлэн төслөөс хасагдаж, 80 өрхийн 429 гишүүд хамрагдсан. Төсөлд хамрагдаж буй 80 өрхүүдэд хүнсний тусламж үзүүлж, 22 өрхийн гишүүдэд "Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга" сургалт 3 удаа зохион байгуулсан. 2022 онд Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөр тус дүүрэгт хэрэгжээгүй тул зорилтот бүлгийн 100 өрхийг сонгон, хэрэгцээний судалгаа авч, дүүргийн Улаан загалмайн хороотой хамтран 75 өрхийн 345 иргэнд, гэр бүлийн хүчирхийллийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалтад 28 иргэн хамруулсан. Цаашид төрийн үйлчилгээ тусламж дэмжлэгт хамрагдах шаардлагагүй, амжиргаа дээшилсэн 50 өрхийг хассан.	100%	
	108	Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан Төрөлт, гэрлэлтийн бүртгэлийг өсөлтийг бүртгэх	Төрөлт, гэрлэлтийн бүртгэлийн үйлчилгээ авсан иргэнийн тоо	2 иргэн хамрагдсан.	350 иргэн хамруулна.	ДТ 7.0	2021-2024 онд Олон Улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан гэрлэлтийн гэрчилгээ гардуулах ёслолын үйл ажиллагааг Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хүндэтгэлийн танхимд жил бүр зохион байгуулж, 200 хос залууд гэрлэлтийн гэрчилгээ гардуулсан. 2021 онд Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу олон нийтийн арга хэмжээг хориглосны улмаас Дэлхийн гэр бүлийн өдрөөр SBN телевизийн "Хайрын хүч" нэвтрүүлэгт ГБХЗХХ-ийн мэргэжилтэн Б.Азжаргал болон 18-р хорооны иргэн Бодибилдингийн дэлхийн аварга н.Мойлоон гэр бүлүүдийг оролцуулсан. 2022 онд Олон Улсын "Гэр бүлийн өдөр"-ийг тохиолдуулан шинээр гэрлэлтээ батлуулсан 1423 хосоос 22 хосын гэрлэлтийн бүртгэлийг өсөлтийг бүртгэх арга хэмжээг зохион байгуулсан. 2023 онд Олон Улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан гэрлэлтийн гэрчилгээ гардуулах ёслолын үйл ажиллагааг Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хүндэтгэлийн танхимд 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж, 25 залуу хос оролцсон. 2024 онд Дэлхийн Гэр бүлийн өдрийг угтан залуу хосуудад гэрлэлтийн гэрчилгээг ёслол төгөлдөр гардуулах үйл ажиллагааг 3 удаа зохион байгуулж 51 хосыг хамруулсан.	57%	
4.5.2 "Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүүхдийн авьяас хөгжүүлэх сургалт, дугуйланг нэмэгдүүлж, хүүхэд залуучуудын чөлөөт цагт зориулсан танхим нээж соёлын үйлчилгээ үзүүлнэ.	109	Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхэд хөгжиж, сурч боловсрох таатай орчин бий болгох, үндэсний хэл соёл, уламжлалаа эрхэмлэдэг иргэн болгон төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	-	Хэрэгжилт 90-ээс доошгүй хувьд хүрсэн байна.	2021-2024 онд хөтөлбөрийн хүрээнд 50 цэцэрлэг, 28 сургуульд зөвлөн эдлэл нийлүүлж, тноног төхөөрөмж хэрэглэгдэхүүнээр хангах, анги танхимын засвар, тохижилт хийх, олон улс, тив дэлхийн 10 удаагийн тэмцээнд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах тэмдэглэлт арга хэмжээ, хүүхдийн урлаг спортын авьяасыг нээхэд чиглэсэн уралдаан зэрэг 11, нийт 99 арга хэмжээ хэрэгжүүлсэн. 2021 онд 6 цэцэрлэг, 3 сургуульд зөвлөн эдлэл, гал тогооны төхөөрөмж, тохижилт хийх зэрэг" төслүүдийг хэрэгжүүлж хүүхдийн сурч боловсрох орчныг сайжруулсан. Юнител ХХК-тай 4 жилийн хугацаанд хамтран ажиллах гэрээ байгуулан, цахим орчинд сурч боловсрох хэрэгцээг хангах зорилгоор 10,000 сурагчид дататай дугаар, хүүхэд нь теле хичээлд хамрагдах боломжгүй 3 өрхөд 32 инчийн зурагт олгов. Хүүхэд хамгааллын 6 арга хэмжээ, хөгжил оролцооны 4 төрлийн арга хэмжээнд 17,233 хүүхэд хамруулсан. 2022 онд 2022 онд 18 сургууль, 22 цэцэрлэгт компьютерийн техник хэрэгсэл, гал тогооны жижиг хэрэгсэл, тоглоом, хивс худалдан авах, 60 дугаар сургууль "Уран хэлхээ" бүжгийн чуулгын сурагчдад дэмжлэг үзүүлэх, Олон улсын хүүхдийн эрхийн өдрөөр зорилтот бүлгийн хүүхдүүдэд бэлэг гардуулах арга хэмжээ зохион байгуулсан.	90%		

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
							2023 онд 10 цэцэрлэгт гал тогооны тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл нийлүүлэх, 5 сургуульд гал тогооны тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсэг нийлүүлэх 15 төсөл хэрэгжүүлж, "Хүүхдийн урлагийн Их надам" зохион байгуулах, 3 удаагийн олон улсын тэмцээнд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлэх, "Өөрийгөө нээн хөгжүүлэх, сэтгэл зүйн ур чадвараа илэрхийлэх сургалт", "Хүүхдийн эрдсийн шинжилгээ", Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хагас өнчин, бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот өрхийн хүүхдүүдэд бэлэг олгох зэрэг 7 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. 2024 онд 2 сургуульд бага ангийн танхим тохижуулах, гал тогооны тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл нийлүүлэх, 12 цэцэрлэгт гал тогоо зөөлөн эдлэл, хивс хивсэнцэр нийлүүлэх болон сургалтын танхимуудыг тохижуулах, олон улсын болон тив, дэлхийн аваргын 7 тэмцээнд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлэх, 89 дүгээр сургуулийн волейболын дугуйлангийн сурагч, багш нарт дэмжлэг үзүүлэх төсөл, "Мэргэжил бүхэн сайхан" "Хүүхдийн баярын бэлэг", "Хүүхдийн баярын өдөрлөг", "Хичээлийн хоцрогдол арилгах" зэрэг 27 арга хэмжээг хэрэгжүүлсэн.	
4.5.3 Төр хувийн хэвшлийн түншлэлээр залуу иргэд гэр бүлээрээ амрах зориулалт бүхий "Эко зуслангийн хотхон, зуслангийн түрээсийн байр" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	110	Залуу иргэд гэр бүлээрээ амрах зориулалт бүхий "Эко зуслангийн хотхон, зуслангийн түрээсийн байр" байгуулж ашиглалтад оруулна.	Зуслангийн түрээсийн байрны барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	-	Эко зуслангийн барилгын ажлыг ашиглалтад оруулна.	ДТ 28.0	2021 онд Эко зуслангийн газрыг дүүргийн 14 дүгээр хороонд төлөвлөж, газар эзэмших эрхийг Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/767 дугаар захирамжаар батлуулан, гэрээ, гэрчилгээ гаргуулсан. 2022-2023 онд Төлөвлөлтийн даалгаврыг батлуулж, сонгон шалгаруулалт зарлан зураг төсвийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр Эрхэс констракшн ХХК шалгаран гэрээ байгуулж загвар зургийг Хот байгуулалт хөгжлийн газраар батлуулсан. 2024 онд Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн 13.5 га газарт уг төслийг хэрэгжүүлэхээр газар эзэмших эрх олгосон бөгөөд зураг төсөв боловсруулагдаж байна.3 блок бүхий зуслангийн сууцнууд, 14 ширхэг ариун цэврийн байгууламж, 5 тоглоомын талбай, 2 сагсан бөмбөгийн талбай, 300 авто машины зогсоол, 95000 м.кв ногоон байгууламж төлөвлөгдсөн. Зураг төсөвт магадлал хийгдэж байна.	10%
	111	Залуучуудын чуулга уулзалтыг зохион байгуулах	Чуулга уулзалтад оролцох залуучуудын тоо	500 залуу чуулга уулзалтад оролцсон.	2000-аас доошгүй залуучуудыг чуулга уулзалтад оролцуулна.	ДТ 8.3	2021-2024 онд нийт 4 удаагийн Залуучуудын чуулга, уулзалт хэлэлцүүлэгт 292 залуусыг хамруулан зохион байгуулж, 50 гаруй санал, санаачлагыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлэсэн. 2021 онд Коронавирусын халдварт (ковид19) цар тахлын улмаас зохион байгуулах боломжгүй болсон. 2022 онд Залуучуудын Үндэсний чуулганы дэд хэлэлцүүлгийг "Залуучуудын оролцоо-Хөдөлмөр эрхлэлт" сэдвээр 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдөр танхим болон цахимаар зохион байгуулж 77 залуучууд хамрагдаж, хэлэлцүүлгээс гарсан 25 санаачлагыг үндэсний чуулганд хүргүүлж, 16 санал дэмжигдсэн. "Нийгмийн хөгжилд эрчүүдийн оролцоо, манлайлал" дүүргийн дэд хэлэлцүүлгийг 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж, 80 залуучуудыг хамруулсан. 2023 онд "Хүний эрхийг дээдэлсэн нийгэм цогцлооход залуусын бүтээлч хамтын оролцоо" уриан дор зохион байгуулагдах залуучуудын хөгжлийн үндэсний IX чуулганы салбар хэлэлцүүлгийг 2023 оны 8 дугаар сарын 18-ны өдөр Хан-Уул дүүргийн Соёлын ордонд зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт 25 хорооны Залуучуудын хөгжлийн зөвлөлийн төлөөлөл, дүүргийн хөгжлийн зөвлөлийн төлөөлөл 35 залуу танхимаар оролцож, цахимаар 30 залуучууд санал хүсэлтээ ирүүлсэн. 2024 онд Хүн бүрт мэдлэг мэдээлэл түгээж, үнэ цэнэ үлдээх зорилготой TEDxKhanUul арга хэмжээг 2024 оны 10 дугаар сард зохион байгуулж, 6 сэдвийн хүрээнд илтгэл хэлэлцүүлж, 100 залуучуудыг хамруулав.	30%
4.5.4 Залуучуудын хөгжлийг дэмжих, нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	112	Дүүргийн хөгжил, нийгэм, эдийн засаг, соёлын амьдралд залуучууд идэвхтэй оролцох, хөдөлмөрлөх орчинг бүрдүүлэн, гэр бүлийн болон нийгмийн төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлж, эх оронч үзлийг төлөвшүүлэх, бүтээлч сэтгэлгээтэй хариуцалагатай иргэн болоход олон талт дэмжлэгийг үзүүлнэ	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	-	Хэрэгжилт 90-ээс доошгүй хувьд хүрсэн байна.		2021-2024 онд Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, зорилтот бүлгийн залуучуудыг нийгэмшүүлэх, хорт зуршлаас сэргийлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, спорт клубуудыг өргөжүүлэх, тэмцээн уралдаан зохион байгуулах, оролцоход нь дэмжлэг үзүүлэх зэрэг нийт 35 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн. 2021 онд Хөтөлбөрийн хүрээнд залуучуудын хөдөлмөрлөх орчныг сайжруулах аян, зорилтот бүлгийн залуусыг нийгэмшүүлэх, хорт зуршлаас татгалзах сургалт, Хан-Уул спорт клубийг өргөжүүлэх, залуус зөв боловсон соёлтой цагийг өнгөрөөх, спортын амжилт гаргасан 3 иргэнийг дэмжих зэрэг арга хэмжээг хэрэгжүүлсэн. Мөн "Эх оронч залуу" үндэсний аяны хүрээнд дүүрэгт байршилтай 4 цэргийн ангийн ажилтнууд болон хугацаат цэргийн албан хаагчдад сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан. 2022 онд "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх сургалт, хэлэлцүүлэг", "Ээж бол ертөнц" төсөл", Зуны диффимпийн XIV наадамд Чөлөөт бөхийн төрөлд оролцох тамирчинд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг тус тус зохион байгуулсан. 2023 онд "Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих", "Ажилтай орлоготой залуус" өдөрлөг, Ажил, мэргэжилгүй боловч хөдөлмөрийн чадвартай 400 залуусыг сонгогч хэл, компьютерийн анхан шат, үсчин, оёдол, эсгүүрийн мэргэжил олгох сургалтад хамруулах, Залуу гэр бүл, тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн "Тусч найзууд" төсөл, "Залуучуудын уулзалт, хэлэлцүүлэг" төсөл, "ЭРТЭЧ ЗАЛУУ" зэрэг 13 удаагийн үйл ажиллагаанд 570 гаруй залуучууд хамрагдсан. 2024 онд Гамшгийн үед ажиллах сайн дуран ажилтан бэлтгэх, "Ээж бол ертөнц", "TedEX" төсөл, "Хан-Уул хөл бөмбөгийн клуб"-ын тамирчдад дэмжлэг үзүүлэх, дүүргийн өсвөрийн шигшээ багийн тамирчдад дэмжлэг үзүүлэх, залуучуудын дундах 2 төрлийн тэмцээн зохион байгуулах болон олон улс тив дэлхийн /4 удаагийн/ тэмцээнд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлэх, нийт 11 төсөл, төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн.	90%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
4.5.5 Хараа хяналтгүй, Хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлэх "Хүүхэд хамгаалал-Хяналт" нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд хамруулж, хараа хяналтгүй, хөдөлмөр эрхэлдэг, хүчирхийлэлд өртсөн, эрх нь зөрчигдсөн хүүхдийн тоог бууруулна.	113	Хараа хяналтгүй хүүхдийг илрүүлэх "Хүүхэд хамгаалал-Хяналт" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ, үйлчилгээ үзүүлсэн хүүхдийн тоо	4 удаагийн арга хэмжээгээр хараа хяналтгүй 54 хүүхдийг илрүүлж асран хамгаалагчид хүлээлгэн өгсөн.	16 удаагийн арга хэмжээ зохион байгуулна.	ДТ 1.8	2021-2024 онд Хүүхэд хамгаалал арга хэмжээг 23 удаа зохион байгуулж, хараа хяналтгүй 284 хүүхдийг илрүүлэн ар гэрт хүлээлгэн өгсөн. Гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор тусгай арга хэмжээ, аян, уулзалт, сургалт, сэтгэл зүйн зөвлөгөө гэх мэт цогц үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж, хараа хяналт сул, гэмт хэрэг зөрчилд өртөж, болзошгүй 175 хүүхдийг илрүүлж, Гэр бүл, хүүхэд залуучуудын хэлтэс, хороодын хамтарсан багт 42 хүүхдийг холбон зуучлах ажлыг зохион байгуулсан. Хүүхдийн эрх ашиг зөрчсөн 137 иргэнийг 41.100.000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж, "Бэлгийн мөлжлөг", "Хүн худалдаалах" гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 11 төрлийн 1650 ширхэг зурагт хуудас, "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдэнд эрх зүйн мэдлэг, мэдээлэл олгох" нөлөөллийн арга хэмжээг 52 бүлгийн 1507 сурагчдад зохион байгуулсан. 2022 онд хүүхдүүд хараа хяналтгүй сэлгүүцэх эрсдэлт газруудад 4 удаагийн илрүүлэг, хяналтын арга хэмжээ зохион байгуулж, 11 хүүхдийг илрүүлж, 9 хүүхдийг ар гэрт нь эргэн нэгтгэж, хяналт тавин ажиллаж байна. Мөн 2 хүүхдийг асрамж халамжийн төвд хүлээлгэн өгсөн. Өмнө оны мөн үетэй харьцуулахад хараа хяналтгүй хүүхдийн тоо 85 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 2023 онд "Хүүхэд хамгаалал" 3 удаагийн арга хэмжээгээр 25 хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг нийт 91 газарт хяналт тавьж, хөдөлмөр эрхлэгч-16, морь унаач-3, эцэг эхийн хараа хяналт сул-5, нийт 24 хүүхдийг илрүүлж, эцэг эх асран хамгаалагчдад хүлээлгэн өгсөн. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхэдтэй холбоотой 8 гомдол, мэдээллийг шалгаж, 8 торгуулийн арга хэмжээ авч, Цагдаагийн байгууллагын нэгдсэн системийн бүртгэлд 6 хүүхдийг бүртгэн хяналт тавьж байна. Нийт 54 сургуульд 15,000 гаруй сурагчдад мэдээлэл өгч, "Гэрэлт ирээдүйд Гар бүү хүр" уриатай 2 төрлийн постер бэлтгэн 25 хороо, 12 сургууль, 6 цэцэрлэгийн цахим хуудсаар 1263 хүнд түгээж, 16 байгууллагын эцэг эхийн зөвлөл, зорилтот бүлгийн 12 гэр бүлд хүүхэд хүмүүжлийн зөвлөгөө өгсөн. 2024 онд "Хүүхэд хамгаалал-2024" арга хэмжээг 4 удаагийн арга хэмжээний хүрээнд дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг 32 сүлжээ дэлгүүр, 12 авто угаалга, 7 цахим тоглоомын газар, 15 баар, караоке, 2 саун, 6 шөнийн цэнгээний газар, нийт 74 аж ахуй нэгж байгууллагад 15 удаагийн эргүүл шалгалт зохион байгуулсан. Хяналт шалгалтын үеэр 18 насанд хүрээгүй, архи согтууруулах ундаагаар үйлчлүүлж байсан 2, хараа хяналт сул, тэнэмэл 2, хөдөлмөр эрхэлдэг 2, бусад-6 нийт 10 хүүхдийг илрүүлж цагдаагийн байгууллагын "Хүүхдийн бүртгэл хяналтын сан"-д бүртгэж, хөдөлмөр эрхлэгч 9, хараа хяналтгүй 65, нийт 74 хүүхдийг илрүүлэн ар гэрт нь хүлээлгэн өгсөн.	100%
4.5.6 Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах бодлогын хүрээнд архи, согтууруулах ундааны хор хөнөөлийг олон нийтэд таниулах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг хангахад чиглэсэн "Архигүй орчин" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	114	"Архигүй орчин" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	"Архигүй орчин" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	-	Хэрэгжилт 90-ээс доошгүй хувьд хүрсэн байна.		2021-2024 онд мэргэжлийн байгууллагуудын сургалт, олон нийтийн хэлэлцүүлэг, төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, сэтгэлзүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр аян өдөрлөгийн арга хэмжээ 2, сургалт нөлөөллийн 10 арга хэмжээ зохион байгуулж 717 иргэнийг хамруулж, 95 иргэнийг архины албадан эмчилгээнд хамруулсан байна. 2021 онд "Архигүй орчин" дэд хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийн төв, Цагдаагийн газар хамтран 4 удаагийн арга хэмжээгээр 26-55 насны нийт 85 хүнийг Согтуурах, мансуурах, донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт илгээсэн. Сайн дураараа сэтгэц, наркологиын кабинетаар амбулаторийн үзлэгээр оношлогдсон 12 хүнийг Наркологиын эмнэлэгт шилжүүлсэн. 2023 онд "Архигүй орчин" дэд хөтөлбөрийн хүрээнд "Архигүй орчин" тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, эргүүлийн баг ажиллуулах, мэргэжлийн байгууллагуудын сургалт, олон нийтийн хэлэлцүүлэг, төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, сэтгэлзүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр арга хэмжээнүүд тус тус хэрэгжүүлж, төсөв шаардлагатай Замын цагдаагийн хэлтсийн "Шинээр томилогдсон албан хаагчдыг техник хэрэгсэлээр хангах төсөл", 6 дугаар хорооны "Архигүй орчин" төслүүдэд 33,159,000 төгрөгийг зарцуулсан. 2023 онд "Архигүй орчин" төрийн бус байгууллага, Цагдаагийн 1, 2-р хэлтэстэй хамтран "Эрүүлжүүлэх байр"-нд удаа дараа албадан эрүүлжүүлэгдсэн 215 иргэнд 9 удаагийн сургалт зохион байгуулан зөвлөмж өгч, "Гэртээ харих зам" хөтөлбөрийн хүрээнд 26, удаа дараа саатуулагдсан 108, нийт 134 иргэнийг нарийн мэргэжил /дотор, мэдрэл, гэмтэл, мас засал, сүрьеэ, эмэгтэйчүүд, зүрх судасны/-ийн эмч нарын үзлэг шинжилгээнд хамруулсан. Мөн аддиклогийн төв, ТВ-9 телевизийн мөрөөдөл биелдэг юм нэвтрүүлэгтэй хамтран "Та амьдарлаа өөрчилмөөр байна уу" зорилтод төсөлд 9 дүгээр хорооны 1 иргэнийг өөрийнх нь хүсэлтээр хамруулсан. 2024 онд "Архины хамааралтай иргэн түүний гэр бүлтэй ажиллах сэтгэл зүйн зөвлөгөө, сургалт" төслийг 2024 оны 06 дугаар сараас 12 дугаар сар хүртэлх хугацаанд хэрэгжүүлсэн. "Урам" төслийн хүрээнд архины эмчилгээнд 10 иргэн, "Гашуунаар төгсөөгүй-Өнөөдрийн итгэл" өдөрлөгт архинаас татгалзах хүсэлтэй 50 иргэн, "Зөвөөр үлгэрлээ" аяныг 154 гэр бүл буюу 308 иргэн тус тус хамрагдсан байна.	70%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
	115	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, дэмжих аян зохион байгуулна.	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалтын тоо	Давхардсан тоогоор хамтарсан багийн 687 гишүүн хамрагдсан.	16-с доошгүй сургалт зохион байгуулсан байна.		<p>2021-2024 онд Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, үйл ажиллагааг дэмжих чиглэлээр сургалт, уулзалт, тэмцээн, хэлэлцүүлэг 16, Гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн эсрэг үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр "төрийн болон төрийн бус 18 байгууллагатай хамтран 1 нэгдсэн, 9 тусгай арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>2021 онд "Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх", "Хороодын хамтарсан багийн үйл ажиллагаа" сэдвээр хороодын "Хамтарсан баг"-ийн гишүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө, кейс менежментийн сургалтыг 5 удаа зохион байгуулж, 241 албан хаагчийг хамруулсан байна. Хамтарсан багуудын эрх зүйн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр "Асуудал шийдэл" тэмцээнийг зохион байгуулж, шалгарсан 16 дугаар хорооны хамтарсан баг нийслэлийн 171 хорооны хамтарсан багуудын дунд явагдсан "Асуудал Шийдэл" илтгэх, ур чадварын уралдаанд оролцож тэргүүн байр эзэлсэн.</p> <p>2022 онд хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах 2 удаагийн сургалт, ажлын байранд нь зөвлөн туслах үйлчилгээг 2 удаа зохион байгуулж, 4 удаагийн арга хэмжээнд хамтарсан багийн 262 гишүүнийг хамруулсан. Гэр бүлийн хүчирхийллийн давтан дуудлагатай 15 иргэнд сэтгэл зүйн бүлгийн болон ганцаарчилсан зөвлөгөө өгсний дүнд архины эмчилгээнд 2 иргэн, урт хугацааны сэтгэл зүйн үйлчилгээнд 5 иргэн сайн дураараа хамрагдсан. Гэр бүлийн хүчирхийлэл болон давтан дуудлагатай нийт 1027 иргэнийг байнгын хяналтад аван ажиллаж байна.</p> <p>2023 онд Хамтарсан багийн албан хаагчдыг "ХТУ-108-ын дуудлагад хариу өгч, мэдээллийн дагуу ажиллах арга зүй" болон үйл ажиллагааг идэвхжүүлж, чадавхжуулах, 3 удаагийн сургалтад хамруулсан. 2023 онд ХТУ 108 утасны дуудлага мэдээллийн шийдвэрлэлт 42 хувиас 68 хувь болж өссөн. Гэр бүлийн хүчирхийллийн давтан дуудлагатай 158 гэр бүлийн 308 иргэн, 26 өсвөр насны хүүхдийг сэтгэцийн эмчийн үзлэгт хамруулж, сэтгэл зүйчийн зөвлөгөө өгсөн. Гэр бүлийн хүчирхийллийн давтан дуудлагад бүргэгдсэн 45 өрхөд 2 удаа нөхцөл байдлын үнэлгээ хийж, эргэн хяналт тавьж байна.</p> <p>2024 онд Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалт, кейс хэлэлцүүлгийг 4 удаа зохион байгуулж, хамтарсан багийн 142 гишүүн, байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн хүрээнд хүүхэд хүмүүжлийн эерэг арга сургалтад 68 иргэнийг тус тус хамруулсан. Гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн эсрэг үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр "төрийн болон төрийн бус 18 байгууллагатай хамтран 1 нэгдсэн, 9 тусгай арга хэмжээг зохион байгуулсан.</p>	100%
4.5.7 Тусгай хэрэгцээт иргэд, ахмад настан болон залуу ээжүүд зэрэг нийгмийн зорилтот бүлэгт чиглэсэн сайн дурын олон талт дэмжлэг үзүүлэх "Тусч найзууд" бүлгэмийг хороо бүрт ажиллуулж, үйл ажиллагааг нь дэмжинэ.	116	"Тусч найзууд" бүлгэмийг хороо бүрт ажиллуулж, үйл ажиллагааг нь дэмжинэ.	Байгуулагдсан бүлгэмийн тоо	-	21-ээс доошгүй бүлгэм байгуулагдсан байна.	ДТ 1.65	<p>2021-2024 онд Тусч найзууд бүлгэмийг 103 залуу ээжийг хамруулан 4 бүсэд байгуулан 200 эмэгтэйд хамруулж сургалт, арга зүйгээр ханган 4, 5, 6, 7, 8, 9, 10, 16, 21, 25 дугаар хороодын дэргэд салбарлуулан үйл ажиллагааг өргөжүүлж, "Бүтээлч ээжүүд", "Бид аялагчид", "Бие биенээсээ суралца", "Сургалтын үйл ажиллагаа", "Шугаман бүжиг" гэсэн 5 бүлгэмийг олон нийтийн санаачлагад тулгуулан шинээр байгуулж, 900 гаруй эмэгтэйчүүдийг эмэгтэйчүүдийг хамруулснаар 19 бүлгэмтэй болоод байна.</p> <p>2022 онд Өсвөр насны эрт жирэмсэлсэн ээжүүд болон залуу ээжүүдэд гэр бүлийн боловсрол олгох, амьдрах ухааны чадвар олгох, бүлгийн уулзалтаар дамжуулан сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх "Тусч найзууд" бүлгийг байгуулан уулзалт, сургалтыг 4 бүсэд зохион байгуулж, 103 залуу ээжийг хамруулж, 4 бүлэг байгуулагдсан. Бүлгийн гишүүдийг багийн болон ганцаарчилсан зөвлөгөөнд хамруулснаар хүүхэд хүмүүжлийн эерэг арга сургалтын сургагч багш болсон.</p> <p>2023 онд Хан-Уул дүүргийн нисэх, яармагийн бүсийн 4, 5, 6, 7, 8, 9, 10, 16, 21, 25 дугаар хороонд "Тусч найзууд" бүлгэмийг байгуулж 200 эмэгтэйд хамруулж сургалт, арга зүйгээр хангасан.</p> <p>2024 онд Тусч найзууд бүлгийн нэгдсэн хурлыг зохион байгуулж, удирдах зөвлөлийг сонгосноор, удирдах зөвлөлийн 16 эмэгтэй 2024 оны 4 дүгээр сард хуралдан арга хэмжээний төлөвлөгөөгөө хэлэлцэн баталсан. Төлөвлөгөөний хүрээнд гэртээ хүүхдээ асарч буй эмэгтэйчүүдийг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, эрүүл амьдралын зөв хэвшил, дадал олгох, идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 1 болон 5 дугаар сард "Үүргэвчтэй аялал" зохион байгуулж 115 эмэгтэйд хамруулсан. Тайлант хугацаанд "Тусч найзууд" бүлгэмийн дэргэдэх "Бүтээлч ээжүүд", "Бид аялагчид", "Биеэ биенээсээ суралца", "Сургалтын үйл ажиллагаа", "Шугаман бүжиг"-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах 5 дэд бүлгэм байгуулагдан 37 арга хэмжээнд 900 гаруй эмэгтэйчүүдийг хамруулсан.</p>	91%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
4.5.8 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	117	Жендэрийн тэгш байдлыг хангах орон нутгийн бодлогыг тодорхойлж, түүний хэрэгжилтийг дэмжих, эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, боломж баталгааг хангаж, жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Үйл ажиллагааны хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгагдсан.	Хэрэгжилт 90-ээс доошгүй хувьд хүрсэн байна.		2021-2024 онд Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах хөтөлбөрийн хүрээнд 9 удаагийн аян, 31 удаагийн сургалт зохион байгуулж 4646 иргэн хамруулж, цахим хуудсанд постер, видео мэдээлэл байршуулж давхардсан тоогоор 38138 иргэнд мэдээлэл түгээсэн байна. 2021 онд Жендэрийн хэвшмэл ойлголтыг бууруулах зорилгоор "Би жендэрийн хэвшмэл ойлголтын эсрэг байна" аян, дүүргийн Хүүхдийн холбоо, Хүүхдийн элч, дуучин С.Гантоогой хамтран "Үе тэнгийнхний ялгаварлан гадуурхалтыг зогсоо" аян, "Монгол эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүтэй байдлын суурь судалгааны зарим тодорхой асуудал" цахим хэлэлцүүлэг, "Жендэрийн үндэсний сургагч багш бэлтгэх" сургалт, Зэвсэгт хүчний 0326 дугаар ангийн "Эцэг эхийн зөвлөл"-өөр тус ангийн 25 албан хаагчдад "Жендэрт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл" сэдэвт цахим сургалт, "жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх нь" сургалт, нийт 3 аян, хэлэлцүүлэг, 8 удаагийн сургалт зохион байгуулж 489 иргэн хамруулж, 3 төрлийн постер бэлтгэн цахим хуудсаар түгээж 5321 иргэнд түгээсэн байна. 2022 онд Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах хөтөлбөрийн хүрээнд "Нандин үерхэл" аян зохион байгуулж, 12 сургуулийн ахлах ангийн 1100 сурагч, "Харилцан хүндэтгэе" аян зохион байгуулж 93 иргэн, нийт Жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр нийт 2 аян, 7 сургалт зохион байгуулж нийт 1699 хүнийг хамруулж, мэдээ, мэдээллийг цахим хуудсанд байршуулж 7817 иргэнд түгээсэн байна. 2023 онд Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах хөтөлбөрийн хүрээнд "Харилцан хүндэтгэе", "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх" 2 удаагийн аяны нөлөөллийн арга хэмжээнд 3600 гаруй иргэн, 11 удаагийн сургалт, хэлэлцүүлэг, илтгэлийн уралдаанд нийт 2458 иргэн хамруулсан байна. Мөн нэгдсэн эмнэлгийн яармаг амбулаторт эрэгтэйчүүдийн кабинетыг шинээр байгуулж, орон нутгийн төсвөөс 22.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн. 2024 онд "Харилцан хүндэтгэе", "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоног" 2 удаагийн аян зохион байгуулж, цахим орчинд болон танхимаар давхардсан тоогоор 25000 гаруй иргэнд мэдээлэл хүргэсэн. 24 дүгээр хороо, "Бадрангуй Мөнх" төвд сэтгэл зүйн кабинет байгуулж, давхардсан тоогоор 250 иргэнд үйлчилсэн. Зэвсэгт хүчний 120 дугаар цэргийн ангид "Жендэрийн мэдээлэл, сургалт"-ын танхим байгуулж, 20,6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Зэвсэгт хүчний 326-р ангид 19,9 сая төгрөгийн Камержуулалт төсөл хэрэгжүүлж, жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн "Эмэгтэйчүүдийн оролцоо байгууллагын хөгжилд нөлөөлөх нь", "Төрийн албанд эрэгтэй, эмэгтэйчүүдийн үүрэг оролцоо түүний эрх тэгш байдлыг хангах арга зам сургалт зохион байгуулж дээрх ангийн албан хаагчдыг хамруулсан.	100%
ДӨРӨВ. НИЙГМИЙН ХӨГЖИЛ - ӨРХ БҮРТ ШААРДАГДАХ ТӨСӨВ					162,212.14		88.2%	
ТАВ. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ - ХОРОО БҮРТ								
5.1 Газрын харилцаа								
5.1.1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг Улсын хаягийн нэгдсэн системтэй холбож, хаягилтын нэгдсэн стандартад шилжүүлэх ажлыг талуудтай хамтран дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна.	118	Хаягилтын нэгдсэн стандартад шилжүүлэх ажлыг талуудтай хамтран хэрэгжүүлнэ.	Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ болон кадастрын зургийн хааг шинэчлэлийн хувь	Дүүргүүдэд дэд ажлын хэсэг байгуулагдсан.	Иргэн, хуулийн этгээдийн хаягийг шинэчлэн дуусгах 100 хувь.		2021 онд "Геокад" ХХК-тай хамтран нийт 21 хорооны гудамжны эхлэл төгсгөл, нэгж талбарын орох гарах цэгийг тодорхойлох ажлыг хийж, 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр ажлын зураглалыг нягталж дуусган, хаягийн зурган дээр зөвшилцөн, ажлын зургийг хүлээлгэн өгсөн. 2022 онд нийт 20 үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, судалгаа, төсөв санхүү, цахим мэдээллийн систем боловсруулалтын шатанд хэрэгжиж байна. 2023 онд Хаягийн нэгдсэн системийг бүрэн ажиллуулахаар нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 10 гэрээт ажилтныг уртасгасан цагаар ажиллуулж, нийслэлийн 8 дүүргийн хаягийн зургийг хийж дуусгасан. 2024 онд Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоолын дагуу Хаягийн мэдээллийн систем хэрэглээнд бүрэн нэвтрээгүй байгаатай холбоотой үүсч байгаа иргэдийн газарт хааг олгох асуудлыг нийслэлийн Газар зохион байгуулалтын албаас ирүүлсэн чиглэлийн дагуу байшин барилга бүртгэхдээ иргэдэд хүндрэл учруулахгүй давхар хааг олгож ажиллаж байна.	80%
	119	Дүүргийн нутаг дэвсгэр дэх геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллого хийж, бүртгэлжүүлэх, хадгалалт, хамгаалалтыг эзэнжүүлэх	Дүүргийн нутаг дэвсгэрт байгаа цэг тэмдэгт бүртгэлжүүлж, эзэнжүүлсэн байдлын хувь	нийт 102 ширхэг цэг тэмдэгт байдаг хамгаалалтыг хариуцах эзэнгүй.	Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн хадгалалт хамгаалалтыг эзэнжүүлж гэрээ байгуулна 100 хувь.		2021-2022 онд Нийт 175 геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллого хийснээс 77 ш геодезийн байнгын цэг тэмдэгт олдож, 95 ш геодезийн байнгын цэг тэмдэгт устсан байсан бөгөөд 3 ш геодезийн байнгын цэг тэмдэгтийг шинээр нэмж суулгасан тухай тайланг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Газрын мэдээлэл технологийн хэлтсээр хянуулан хүлээн авсан. 2023-2024 онд Жил бүр зохион байгуулагддаг тооллогын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэр дэх 150 ширхэг геодезийн байнгын цэг тэмдэгтийн тооллого, судалгааны ажлыг "Оронж Эн Энд Эс" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Ажлын явц 90 хувьтай үргэлжилж байна.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
5.1.2 “Орц-Гарц” арга хэмжээг хэрэгжүүлж, гэр хорооллын мухар гудамж, орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчлийн асуудлыг шийдвэрлэж түргэн тусламж, гал унтраах, аврах ажиллагааг шуурхай хүргэх боломжийг бүрдүүлнэ.	120	Дүүргийн хэмжээний Гэр хорооллын мухар гудамж, орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчлийн судалгаа гаргаж, зөрчлийг арилгуулах "Орц-гарц" арга хэмжээг шат дараатайгаар хэрэгжүүлнэ.	Гарсан зөрчлийн шийдвэрлэлт, гүйцэтгэлийн хувь	Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/513 дугаар захирамжийн хүрээнд 27 байршлаас 20 байршлыг бүрэн чөлөөлж, ажлын явц 93.2 хувьтай.	Зөрчлийн тоо бууруулж, хуулийн хэрэгжилтийг хангуулна.	НТХО 797.0 ДТХО 539.7	2021-2024 онд нийт 318 байршлын 333 гарааш буулгах, 3287 метр хашаа, 17849 метр урт хайс, 140 ширхэг шон гадас буулгаж газар чөлөөлөх, орц, гарц чөлөөх, орчны аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээг хэрэгжүүлснээс гадна нийтийн эзэмшлийн талбай болон орц гарц, явган зам хааж байрлуулсан 129 ТҮЦ, дугуй засвар, контейнер шилжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна. 2021 онд Хан-Уул дүүргийн Засаг даргын А/139 дугаар захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулагдаж, 12 барилгын түр хашааг шинэчлүүлж, 3, 20, 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт орц, гарц хаасан, зөвшөөрөлгүй байршуулсан ТҮЦ, дугуй засвар, контейнер зэрэг 27 объект, 1, 2, 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулж буй болон орчны өнгө үзэмжинд сөргөөр нөлөөлж буй 41 байршлын 521 урт метр хайс, хашлага, 140 ширхэг шон гадсыг буулгаж газар чөлөөлж, орц гарцыг нээсэн. 2022 онд Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/388 дугаар "Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай" захирамжаар Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт 19 байршлын 190 гараж, 58 байршилд 9491 урт метр хайс хашааг бүрэн чөлөөлж орц, гарцуудыг чөлөөлж ажиллалаа. Гараж буулгаж газар чөлөөлсөн талбайг тохижуулах ажлын хүрээнд нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2 байршилд, дүүргийн төсвийн хөрөнгөөр газар чөлөөлсөн 4 байршилд 1185 м.кв талбайд авто зогсоол, явган хүний байгуулж, сургууль, цэцэрлэг орчмын зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлсэн. 2023 онд Дүүргийн нутаг дэвсгэр дэх зөрчлийн судалгааг шинэчлэн гаргаж 2023 онд бүртгэгдсэн нийт 291 зөрчлөөс 257 зөрчлийг холбогдох шийдвэрийн дагуу арилгуулж ажиллалаа. 155 гарааш чөлөөлөхөөр тусгагдсанаас 120 гарааш, төлөвлөгөөнд тусгагдаагүй 8 гарааш, 23 байршилд 1921 м хашаа хайс, 32 байршилд 3137 м урт хашааг тус тус чөлөөлсөн. Наадамчдын зам дагуу 45, Чингисийн өргөн чөлөө гудамж 16, Зайсангийн зам дагуу 23, Түргэн хоолны 18 цэг нийт 102 ТҮЦ нүүлгэн шилжүүлсэн. 2024 онд 34 байршилд 2779 м урт талбайн зөрчлийг арилгасан. Үүнд 23 байршилд 27 түргэн үйлчилгээний цэгийг буулгаж 2197 м урт хашаа, хайс, хаалт чөлөөлж, 3 байршилд 17 гарааш, контейнер буулгаж газар чөлөөлөхөөр төлөвлөснөөс 15 гарааш буулгаж, 307м талбай чөлөөлж, 2 гарааш давж заалдах шатны шүүхэд хянагдаж байна.	90%
5.1.3 Хууль зөрчиж олгогдсон болон газраа зориулалтын дагуу ашиглаагүй зэрэг зөрчилтэй газруудын зөрчлийг арилгуулж, шаардлагатай тохиолдолд газар чөлөөлөх арга хэмжээг холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	121	Хууль зөрчиж олгогдсон болон газраа зориулалтын дагуу ашиглаагүй зэрэг зөрчилтэй газруудын зөрчлийг арилгуулж, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх	Гарсан зөрчлийн шийдвэрлэлт, гүйцэтгэлийн хувь	НЗД-ын захирамжаар 12 иргэн, аж ахуйн нэгж, ДЗД-ын захирамжаар 49 иргэн, аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож шийдвэрлэсэн.	Хуулийн хэрэгжилтийг хангах, газар ашиглалт сайжрах.		2021-2024 онд Холбогдох хууль, журам зөрчин олгосон нийт 299 иргэний газар эзэмших эрхийг хүчингүй болгож, 40035 м.кв талбайд зөвшөөрөлгүй барьсан хашааг албадан буулгаж, нийтийн эзэмшлийн талбайг чөлөөлөх арга хэмжээ авч, зөрчил арилгаагүй 97 хуулийн этгээдэд сонсох ажиллагааны мэдэгдэл хүргүүлсэн. 2021 онд дүүргийн Засаг даргын захирамжаар 8, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 7 байршилд 39,600 м.кв талбайд зөвшөөрөлгүй барьсан хашааг албадан буулгаж, нийтийн эзэмшлийн талбайг чөлөөлөх арга хэмжээ авч ажилласан. Мөн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Эрхэт сулд амралтын газрын хойд талд 3 айлын төмөр хашаа, 15-р хороо Төв цэнгэлдэхийн урд зөвшөөрөлгүй барьсан блокн хашаа, Солонгосын элчингийн баруун талд явган хүний зам хааж барьсан барилгын түр хашаа, 17-р хороо Удирдлагын академийн урд талд орц гарц хаасан иргэн С.Чимэд-Осорын хашаа, 20-р хорооны нутаг дэвсгэрт "Лэц" ХХК-ийн хойд талдаа зохих зөвшөөрөлгүй барьсан хашаа, 21-р хороо Жаргалант –Эко хотхон, Эм Жи Ти Эл Эл ХХК-ийн төмөр хашааг тус тус чөлөөлсөн. 2022 онд Дүүргийн Засаг даргын 2022 оны А/143, А/236, А/254, А/339, А/446, А/479 дүгээр захирамжаар олгосон газрыг зориулалтын дагуу эзэмшиж, ашиглаагүй, газар дээрээ амьдраагүй, татан буугдсан, газар эзэмших эрхийг дуусгавар болгох хүсэлт гаргасан 28 иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг тус тус хүчингүй болгосон. 2023 онд Дүүргийн Засаг даргын захирамжаар Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6 дахь заалтыг үндэслэн 21, Ундны усны хориглолтын бүсэд олгогдсон 29 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох, 22 дугаар хорооны Туул гол дагуу үерийн эрсдэлтэй бүсэд зөвшөөрөлгүй буусан 28 айл өрхийг нүүлгэн шилжүүлсэн. 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт төсөл хэрэгжүүлж буй "Фужи девелопмент" ХХК зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэн нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй барилгын ажил эхлүүлсэн зөрчлийг арилгах арга хэмжээг тус тус хэрэгжүүлсэн. 2024 онд Газрын тухай хуулийн 33.6, 39.1.3, 40.1.6, 61.1-д заасан үндэслэлээр дүүргийн Засаг даргын нийт 6 удаагийн захирамжаар 182 иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож, мэдээллийн сангаас хасалт хийж бүртгэсэн. Нийслэлийн Засаг даргын захирамжаар 435м.кв хашааг чөлөөлөн 84 хуулийн этгээдэд мэдэгдэл хүргүүлж, зөрчил арилгаагүй 97 хуулийн этгээдэд сонсох ажиллагааны мэдэгдэл хүргүүлсэн.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
5.1.4 Гэр хорооллын гэрэлтүүлэг, зам талбай, хайс хашаа, барилгын түр хашаа болон бусад тохижилтын ажлуудад хотын стандарт, жишгийг мөрдүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	122	Гэр хорооллын гэрэлтүүлэг, зам талбай, хайс хашаа, барилгын түр хашаа болон бусад тохижилтын ажлуудад хотын стандарт, жишгийг мөрдүүлэх	Стандартын хэрэгжилтийн хувь	НЗД-ын 2020 оны А/715 дугаар захирамж гарсан.	Гарсан зөрчлийн 55 аас доошгүй хувьд стандарт хангуулж ажиллана.	ДТ 104.5	<p>2021-2024 онд Стандарт аюулгүй байдал хангуулах чиглэлээр 30 барилгын түр хашааг шинэчлүүлэх, Цахилгааны ил гарсан утастай гэрэлтүүлгийн 2411 метр утсыг цэгцлэх, 584 ширхэг гэрэлтүүлгийн шонг тагжуулж аюулгүй байдлыг хангуулах, 128 авто гарааш буулгах, 88 ТҮЦ, контейнер, дугуй засвар шилжүүлэх, 85 А самбар, 109 тулгуурт самбар, 613 халдаасан самбар буулгах, 59 байршилд явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулж буй хайс хашааг буулгах, стандартын шаардлага хангахгүй, хүүхдийн эрүүл мэндэд эрсдэл учруулахуйц нөхцөл байдал үүссэн 66 хүүхдийн тоглоомын талбайг засаж сайжруулах, 21 аж ахуйн нэгжийн барилгын талбайд аюулгүй байдлыг хангуулах ажлыг тус тус зохион байгуулсан байна.</p> <p>2021 онд Стандарт аюулгүй байдал хангуулах чиглэлээр 12 барилгын түр хашааг шинэчлүүлж, 3, 20, 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт орц, гарц хаасан, зөвшөөрөлгүй байршуулсан ТҮЦ, дугуй засвар, контейнер зэрэг 27 объект, 1, 2, 3 дугаар хороонд явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулж 41 байршлын 521 урт метр хайс, хашлага, 140 ширхэг шон гадсыг буулгаж газар чөлөөлж, орц гарцыг нээсэн. Мөн 78 байршлын ил задгай кабелийн болон цахилгааны утасны аюулгүй байдлыг хангуулан, 82 өнгө үзэмжгүй, эвдэрч гэмтсэн самбар, хаалт, хашлагуудыг цэгцлүүлж, стандартын шаардлага хангахгүй, хүүхдийн эрүүл мэндэд эрсдэл учруулахуйц нөхцөл байдал үүссэн 66 хүүхдийн тоглоомын талбайг засаж сайжруулж, эрсдлийг арилгасан. Энэхүү ажлын хүрээнд орчны аюулгүй байдал алдагдсан 369 зөрчлийг илрүүлж, 67 байршилд тухай бүрт зөрчлийг арилгуулан, 122 байршилд зөрчлөө арилгах тухай хугацаатай мэдэгдэх хуудас хүргүүлж нийт 189 байршилд зөрчлийг арилгуулан орчны аюулгүй байдлыг хангуулсан.</p> <p>2022 онд Цахилгааны ил гарсан утастай гэрэлтүүлгийн 2100 метр утас, таггүй гэрэлтүүлгийн 464 ширхэг шонг засварлаж аюулгүй байдлыг хангуулах, нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд зөвшөөрөлгүй барьсан 18 хашаа, хайсыг стандартын шаардлагад нийцүүлэх талаар хугацаатай мэдэгдэл өгч зөрчил арилгуулах, үүсмэл болон хур хог хаягдал үүссэн 43 цэгийн хог хаягдлыг цэвэрлүүлж устгуулах, 157 эзэнгүй золбин нохой устгуулах, барилгын аюулгүй байдлыг хангаж ажиллаагүй захиалагч, гүйцэтгэгч бүхий 20 аж ахуй нэгж байгууллагуудад нийт 80 заалттай 10 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч зөрчлийг арилгуулах арга хэмжээг тус тус хэрэгжүүлжсэн.</p> <p>2023 онд 78 мэдээллийн тулгуурт самбар, 43 ширхэг А самбар, 555 хулдаасан самбар буулгаж, нийт 1775 иргэн, ахуйн нэгжид хаягийн байгууламжийг стандартыг хэрэгжүүлэх мэдэгдэл өгч, 128 авто машины гарааш буулгаж, 61 түргэн үйлчилгээний цэгийг нүүлгэн шилжүүлж, 120 гэрэлтүүлгийн шонг тагжуулж, 20 гэрэлтүүлгийн шонг шилжүүлэн, явган хүний замыг чөлөөлөн ил гарсан 311 метр кабел цэгцэлж, аюулгүй байдлыг хангасан. 11, 22 дугаар хороодод байрлах Архитектур төлөвлөлтийн даалгаваргүй, барилгын ажлын зөвшөөрөлгүй, барилгын суурийн нүх ухсан 3 байршилд зөрчил арилгуулах, аюулгүй байдлыг хангуулсан.</p> <p>2024 онд Тохижилт ажлын засвар, шинэчлэлтийн 117 арга хэмжээний хүрээнд тоглоомын талбай, явган хүний зам талбай, хөшөө дурсгалыг засварлаж, орчны аюулгүй байдлыг ханган стандартад нийцүүлсэн. Гадна хаягжилтын стандарт хангаагүй 189 аж ахуй нэгж байгууллага, иргэнд мэдэгдэх хуудас, 110 газарт зөвлөмж хүргүүлж, 39 газарт хугацаатай үүрэг даалгавар өгч, 31 ширхэг мэдээллийн тулгуурт самбар, 42 ширхэг А самбар, хайс, хашлага дээр байрлуулсан 76 ширхэг хулдаасан сурталчилгааны самбар буулгасан.</p>	100%
	123	Стандартын шаардлага хангасан гэрэлтүүлгийг шаардлагатай байршуулахад байршуулна.	Шинээр байршуулсан болон засварласан гэрэлтүүлгийн тоо	Худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан.	Стандартын шаардлага хангасан 750 ширхэг гэрэлтүүлгийг байрлуулсан байна.	УТХО 70.0 НТХО 80.0 НОНХС 75.6 ДТХО 5679.9 ДОНХС 3685.6	<p>2021-2024 онд нийтийн эзэмшлийн гудамж талбай, авто замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд нийт 3016 гэрэлтүүлэг шинээр суурилуулж, гэрэлтүүлгийн асалтыг сайжруулах ажлын хүрээнд ашиглалтын хугацаа дуусаж, техникийн шаардлага хангахгүй болсон 60 ширхэг алсын удирдлагын самбарыг бүрэн шинэчилж, ашиглалтад орууллаа</p> <p>2021 онд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 12 дугаар хороо Малчины хэсэгт 45, 4 дүгээр хороо, 23 дугаар хороонд хэрэгжсэн авто зам /1.7 км/ дагуух 43, дүүргийн төсвийн хөрөнгөөр 2, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 19, 20, 21 дүгээр хороодод 450, 20 дугаар хороо Эко зурвасын үргэлжлэл хэсэгт 44, нийт 582 гэрэлтүүлгийг тус тус суурилуулж ашиглалтад оруулсан.</p> <p>2022 онд Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй Ривер хиллс хотхоноос Зайсангийн гудамж хүртэлх авто зам дагуу шинээр 30, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн Номин Юнайтед их дэлгүүрийн баруун талын авто замаас Б.Шаравын гудамж хүртэлх авто зам дагуу шинээр 34, дүүргийн төсвийн хөрөнгөөр 1, 2, 3, 4, 11, 13, 14, 15, 19, 20, 21 дүгээр хороонд шинээр 430, нийт 494 ширхэг гэрэлтүүлэг суурилуулсан.</p> <p>2023 онд Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн авто замын байгууламжийн ажлын хүрээнд 76, Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 4, 5, 7, 8, 20 дугаар хороонд 138, нийт 214 ширхэг гэрэлтүүлэг шинээр суурилуулсан.</p>	100%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
							2024 онд Дүүргийн төсвийн хөрөнгөөр 14, 21-р хороодын авто замын зорчих хэсгийн аюулгүй байдлын хүрээнд шинээр 226 ширхэг, 10, 12, 13-р хороодын авто замын зорчих хэсгийн аюулгүй байдлын хүрээнд шинээр 440 ширхэг, 13 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж талбайд 78, 23 дугаар хороо, Наадамчдын авто замаас Нүхт чиглэлийн авто замд 16, 9, 10, 12 дугаар хороонд хэрэгжүүлсэн авто замын ажлын хүрээнд 80, 22 дугаар хороонд хэрэгжүүлсэн авто замын засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд 6, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй 3,4,5,6,7,8,10,11,12,13,14,16,19,23,24-р хороодын нийтийн эзэмшлийн зам талбайд 640, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн Наадамчдын замыг Эрчим хүчний гудамжтай (4, 5-р хороо) холбосон авто зам, гүүрийн ажлын хүрээнд 191, Чингисийн өргөн чөлөөг Тээвэрчдийн гудамжтай холбосон авто зам, гүүрийн ажлын хүрээнд 49, нийт 1726 ширхэг гэрэлтүүлэг суурилуулах ажил тус тус хэрэгжиж дууссан бол дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй 2,5,8,9,10,11,12,13,14,16,21,23,24-р хороодын нийтийн эзэмшлийн зам талбайд 360 ширхэг гэрэлтүүлэг суурилуулах ажлын явц 90%, гүйцэтгэлтэй.	
5.1.5 Биокомбинат, Туул, Өлзийт хороодод нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг суурь судалгаанд үндэслэн боловсруулж, бус нутгийн газар ашиглалтыг сайжруулна.	124	Эзэмшлийн газраа 2-оос дээш жил ашиглаагүй иргэд хуулийн эт-гээдийн газар эзэмших эрхийг хүчингүй бол-гуулж, дахин олголт хийх, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлийн хувь	-	Бус нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн газар ашиглалт сайжруулах дахин төлөвлөлт хийх.	-	Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж төвийн 6 дүүрэг орон нутгийн зэрэглэлтэй хотын статуст шилжих болсон тул 2025 онд хотуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зардлыг нийслэлийн төсөвт тусгуулсан.	-
5.1.6 Туул тосгон Биокомбинат орчмын хайрганы карьераас үүдэлтэй газрын эвдрэл доройтлын судалгааг хийж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран нөхөн сэргээлт хийнэ.	125	Түгээмэл тархацтай ашигт малын олборлолтын улмаас эвдэрсэн газрын хэмжээг тодорхойлох, нөхөн сэргээх ажлын эдийн засгийн тооцоо, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлнэ.	Нөхөн сэргээсэн газрын хэмжээ (га талбай)	310,6 га газар уул уурхайн олборлолтын нөлөөгөөр эвдэрсэн байна.	Нөхөн сэргээх шаардлагатай газрын хэмжээг тодорхойлон, нөхөн сэргээх ажлын техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан нөхөн сэргээлт хийнэ.	ААН 82.4	2021-2024 онд Дүүргийн 12, 13-р хорооны нутаг дэвсгэрт эвдрэлд өртсөн байсан нийт 2,326.48 га талбайгаас 75,2 га талбайд биологийн нөхөн сэргээлт, 56,4 га талбайд техникийн нөхөн сэргээлт, нийт 131,6 га талбайд 33 аж ахуйн нэгж, байгууллага нөхөн сэргээлт хийжээ. 2021 онд Дүүргийн 12, 13-р хорооны нутаг дэвсгэрт байгаа уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй лицензийн талбайн орчимд эвдрэлд сул өртсөн 943.30 га, дунд зэрэг өртсөн 257.04 га, эвдрэлд хүчтэй өртсөн 1,126.48 га нийт 2,326.48 га талбай эвдрэлд өртсөн. Мөн энэ хэсэгт эвдрэлд өртөөгүй 1284.73 га талбай, Туул гол 26.38 га талбай оршиж байгааг тогтоосон. Дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт нэгдсэн зохион байгуулалтаар ногоон зурвас байгуулах ажлын хүрээнд нийт 28 аж ахуйн нэгж 136.37сая төгрөгөөр дүйцүүлэн хамгааллын ажил гүйцэтгэхээр төлөвлөснөөс 23 аж ахуйн нэгж 82.37 сая төгрөгөөр ойн зурвасын цахилгаан болон хашаажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг 14 ААН-үүд 55,8 га талбайд хийж гүйцэтгэсэн. 2022 онд Дүүргийн 12, 13-р хороодын эвдрэлд өртсөн 35,3 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 12,5 га талбайд биологийн нөхөн сэргээлт, нийт 47,8 га талбайд нөхөн сэргээлт хийсэн. 2023 онд "Үйлсийн алтан хэлхээ" ТББ-тай хамтарч дүүргийн 13-р хорооны нутагт хайрга дайрга олборлолтын улмаас эвдэрсэн 1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 7 аж ахуйн нэгж байгууллага 12,6 га талбайд техникийн, 5,4 га талбайд биологийн, нийт 19 га талбайд нөхөн сэргээлт хийсэн. 2024 онд Үйл ажиллагаа эрхэлдэг 10 байгууллагын 5 нь дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтээр 10,0 сая төгрөгийн хөрөнгөөр 12-р хороонд булгийн эхийг, тохижуулж, 5 байгууллага 4,5 га талбайд техникийн, 0,5 га талбайд биологийн нөхөн сэргээлтээр мод тарьсан. Мянганы сорилтын сангийн хөрөнгө оруулалтаар 3-р хороонд хэрэгжиж буй "Баруун бүсийн усны эх үүсвэр" төслийн хүрээнд 3 га газарт техникийн нөхөн сэргээлт хийж, 1 га талбайд 1500 мод тарьсан.	100%
	126	Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд тавих хяналт шалгалтыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ.	Хяналт шалгалтад хамрагдсан ААН, тоо	"Нөхөн сэргээлт 2020" аяны хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 91 аж ахуйн нэгж байгууллагын талбайд хяналт шалгалт явуулсан.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд хяналт тавих ажлыг тогтмол зохион байгуулна.	ДТ 160.5	2021-2024 онд түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож буй аж ахуйн нэгжүүдэд нийт 10 удаагийн хяналт шалгалт зохион байгуулж, 3 байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцлуулж, 33 аж ахуйн нэгжээр 75,2 га талбайд биологийн нөхөн сэргээлт, 56,4 га талбайд техникийн нөхөн сэргээлт, нийт 131,6 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийлгэжээ. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж зөрчил гаргасан 11180 жолоочид 349,179,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилгуулсан. 2021 онд тусгай зөвшөөрөл бүхий 26 аж ахуй нэгжээс 21 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулсан. Нийт 8 удаагийн шалгалт хийж, нөхөн сэргээлтийн ажлыг хийж мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөх талаар мэдэгдэл хүргүүлэн 3 байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцалж, 4 байршлын 4,8 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийлгэсэн. Том оврын ачааны тээврийн хэрэгслийн даацыг шалгах явуулын хэмжих төхөөрөмж /нүү/ ажиллуулж даац хэтрүүлсэн 90 тээврийн хэрэгсэл эзэмшигчид арга хэмжээ тооцсон. 2022 онд тусгай зөвшөөрөл бүхий 38 аж ахуй нэгжид холбогдох ус, газар, байгалийн нөөцийг хуулийн дагуу ашиглаж, нөхөн сэргээж, нөөц ашигласны төлбөр төлөлтөд хамтарсан шалгалт хийж, усны зөвшөөрөлгүй 5 аж ахуй нэгж, хог тээврийн гэрээ байгуулаагүй 4 аж ахуй нэгжийн зөрчил арилгуулсан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
							Тээвэрлэлтэд хяналт тавьж "Ачаа тээвэрлэх" журам зөрчсөн 145 жолоочид 7250 нэгж, нэг тэнхлэгт ноогдох ачааллын хэмжээг хэтрүүлсэн 124 жолоочийг 18600 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгуулж ажилласан. 2023 онд үйл ажиллагаа явуулж буй 17 аж ахуйн нэгж, байгууллагад 2023 оны 03-аас 09 сар хүртэлх хугацаанд хяналт, шалгалт зохион байгуулж, зөрчил арилгах хугацаатай мэдэгдэл өгч, давхардсан тоогоор 11123 тээврийн хэрэгсэл шалгаж, зөрчил гаргасан 9834 жолоочид 206,125,000 төгрөгийн торгууль ноогдуулж, зөрчил арилгуулсан. Хяналт хэрэгжүүлэх хүрээнд 12, 13, 14, 16, 21-р хороодын 10 ширхэг тусгай зориулалтын камер суурилуулах ажил хийгдэж, хяналтын цэгүүдийг дүүргийн камерын хяналтын дэд төвд холбох ажил хүлээгдэж байна. Ажлын явц 95 хувь 2024 онд Дүүргийн хэмжээнд тусгай зөвшөөрөлтэй 33 аж ахуй нэгж байгууллагаас 13 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Таван толгойн хяналтын постод 24 цагаар 3 ээлжинд давхардсан тоогоор 30 алба хаагч үүрэг гүйцэтгэж түгээмэл тархацтай ашигт малтмал тээвэрлэлт хийсэн 20200 тээврийн хэрэгслийг бүртгэж, зөрчил гаргасан 1987 тээврийн хэрэгслийн жолоочийг 117,203,500 төгрөгөөр торгож зөрчлийг арилгуулсан.	
5.2 Орон сууц								
5.2.1 Гэр хорооллын дахин төлөвлөлтийг иргэд оршин суугчдын харилцан ойлголцлын үндсэн дээр талуудтай хамтран хэрэгжүүлнэ.	127	Нисэх, Яармагийн гэр хорооллыг дахин төлөвлөлтөөр бие даасан болон төвлөрсөн инженерийн шугам сүлжээтэй, нам давхрын болон амины сууцны хороолол болгох ажлыг тууштай хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлийн хувь	Нийслэлийн ИТХ-ын 2020 оны 48 дугаар тогтоолоор 4-8 дугаар хороодын 168 га газрыг дахин төлөвлөн барилгажуулахаар баталсан.	Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлээр.		2021-2024 онд Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 7, 8 дугаар хороодод нийт 9 хэсэгчилсэн талбайд дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжиж байснаас 2024 онд 8-р хорооны Б хэсэгчилсэн талбайн төслийн гүйцэтгэгч Ивээлт цамхаг ХХК, 8-р хорооны А хэсэгчилсэн талбайн төсөл хэрэгжүүлэгч Ажнай цэгц ХХК-ийн төсөл хэрэгжүүлэх эрхийг Нийслэлийн Засаг даргын Захиралмаар тус тус цуцалж, 4, 5, 6, 7, 8 дугаар хорооны нийт 7 хэсэгчилсэн талбайд дахин төлөвлөлтийн төсөл үргэлжилж байна. Төслийн хүрээнд: Төлөвлөлтийн нутаг дэвсгэр 242.15 га газрын 4633 нэгж талбар чөлөөлөхөөс 445 нэгж талбарын чөлөөлж, 484 нэгж талбарын гэрээ байгуулсан ба төслүүдийн талбайд 273 барилга, 19910 айл өрх, 7600 хүүхдийн багтаамжтай сургууль, 3350 хүүхдийн багтаамжтай цэцэрлэг, 2 эмнэлэг байгуулахаар баталсан. 2024 оны байдлаар өссөн дүнгээр 5 блок 600 айлын орон сууц ашиглалтад орж өрхүүдийн сууцны нөхцөл сайжирсан.	40%
5.2.2 Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулах ажлыг үргэлжлүүлнэ.	128	Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нийтийн зориулалттай орон сууцны хэрэгжиж буй төслүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран үргэлжлүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлийн хувь	7 багц арга хэмжээ явагдаж байна.	Дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны эрчимжүүлнэ.		Нийслэлийн Орон сууцны бодлогын газар хариуцан хэрэгжүүлж буй төсөл Сууц өмчлөгч иргэдийн 80 аас дээш хувийн санал авч, дахин төлөвлөлтөд хамрагдах саналын хуудас ирүүлсэн 1-р хороонд 12 барилга, 3-р хороонд 1 барилга, 5-р хороонд 2 барилга, 13-р хороонд 6 барилга нийт 21 барилга байна. Хан-Уул дүүрэгт ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай нийт 1076 айлын 46 орон сууцны барилга байснаас 33 орон сууцны барилгад төсөл хэрэгжүүлэгч шалгарч 2,3 дугаар хороонд 1724 айлын 13 орон сууц ашиглалтад өгч, төсөлд хамрагдсан 327 өрхийг шинэ орон сууцанд оруулаад байна. 2024 онд төсөл хэрэгжиж байгаа 18 барилгаас 2-р хороонд 9 барилга, 3-р хороонд 1 барилга, 4-р хороонд 2 барилга, 6-р хороонд 2 барилга, 11-р хороонд 3 барилга, 20-р хорооны 1 барилга тус тус байна. Эдгээр барилгаас 20-р хороо дэвшил 36, 6-р хороо 2-1, 20-2 дугаар байр, 11-р хороо 36а, 36б байр буулгалт хийгдээгүй, гэрээний шатандаа байна. 12-р хороонд 3 давхар 48 айл өрхийн 1 барилга, 3-р хороонд 4 давхар 60 айл өрхийн 1 барилга, 1-р хороонд 4 давхар 30 айлын 2 барилгыг дахин төлөвлөж барихаар төсөл хэрэгжүүлэгчийг шалгаруулахаар 20 гаруй удаа сонгон шалгаруулалт зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй байна. Нийслэлийн орон сууцны корпорациас хариуцан хэрэгжүүлж буй төсөл Дүүргийн 10 -р хороо ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 34,35-р байрыг буулгаж дахин барилгажуулах төслийн гүйцэтгэгчээр Мөнх ариун булаг ХХК ажиллаж байна. 34-р байрны суурин дээр баригдаж буй 16 давхар 2 барилгын цутгалт хийгдэж, цонх суулгалт фасадны ажил хийгдэж байна. 35-р байрны суурин дээр баригдаж буй 16 давхар 2 барилгаас 1-р блокын зоорийн давхар болон 12 давхрын цутгалт хийсэн. 2- р блокын зоорийн болон 5 давхрын бетон цутгалтын ажлыг гүйцэтгээд байна.Төслийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчээр "Мөнх ариун булаг" ХХК, "Эгц шугам ХХК, "Эрчин хайрхан" ХХК-иудын түншлэл шалгаран гадна инженерийн дэд бүтцийн ажлыг гүйцэтгэж байна.	90%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
5.2.3 Нийтийн зориулалттай хуучин орон сууцнуудыг дулаалах, засварлах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, оршин суугчдын эрүүл аюулгүй орчинд амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	129	Нийтийн зориулалттай хуучин орон сууцны дээвэр, фасад, орчны болон түүний шугам сүлжээний ажлыг насжилт, хэрэгцээ шаардлага болон холбогдох байгууллагын дүгнэлтийг үндэслэн хэрэгжүүлнэ.	Дээвэр болон фасадын засвар хийсэн байрны тоо		20-оос доошгүй байрны дээвэр, фасадын ажил хийгдсэн байна.	УТХО 1,051.0 НОНХС 235.0 ДТХО 10065.4	2021-2024 онд Нийтийн зориулалттай орон сууцны 47 байрны дээвэр засварлан ашиглалтын хэвийн байдлыг хангуулж, 25 байрны фасад засвар хийж дулаан алдагдлыг бууруулж, 1 байрны цахилгаан шатыг засварлаж, 13100 орчим оршин суугчдын ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн. 2021 онд Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр 1 дүгээр хорооны 15, 25 дугаар байр, 2 дугаар хорооны Гаалийн 17, 22, 30 дугаар байр, 10 дугаар хорооны 60/1, 62, 66 дугаар байр, 13 дугаар хорооны 1, 6 дугаар байр, 15 дугаар хорооны 53 дугаар байр, 17 дугаар хорооны 104 дүгээр байр, нийт 12 байрны дээвэр засварын ажил, 13 дугаар хорооны 1 дүгээр байр, 2 дугаар хорооны 7, 22 дугаар байрны фасад засварын ажил, нийт 3 байрны фасад засвар дулаалгын ажил хийгдсэн. 2022 онд Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр 3 дугаар хороо 1а байр, 10 дугаар хороо 60, 63, 61/1, 61/2, 67 дугаар байр, 13 дугаар хороо 5 дугаар байр, 15 дугаар хороо 60 дугаар байр, 13 дугаар хороо 2 дугаар байр, нийт 9 байрны дээврийн засварын ажил гүйцэтгүүлж ашиглалтад хүлээн авсан. Улс, дүүргийн төсвийн хөрөнгөөр 2 дугаар хорооны 8а байр, 30 дугаар байр, 10 дугаар хорооны 2, 61 дүгээр байр, 1 дүгээр хорооны 39 дүгээр байр, 2 дугаар хорооны 18 дугаар байрны дулаалгын ажил, нийт 6 нийтийн зориулалттай орон сууцны фасад засварыг хийж дулаан алдагдлыг бууруулсан. 2023 онд дүүргийн төсвийн хөрөнгөөр 2 дугаар хороо 9 дүгээр байр, 3 дугаар хороо 1а байр, 12 дугаар хорооны 38, 53 дугаар байр, 13 дугаар хорооны 2, 5, 6 дугаар байр, нийт 7 байрны фасад засварын ажил хийгдэж дулааны алдагдлыг бууруулсан. 2024 онд Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2-р хорооны 20-р байр, 10-р хорооны 1, 7, 61/1, 61/2, 62, 63, 64-р байр, 12-р хорооны 52-р байр, нийт 9 байрны фасад засварыг хийж дулаан алдаргдлыг бууруулсан бол 1-р хороо 42-р байр, 3-р хороо 50-р байр, 15-р хороо 19, 21, 49-р байр, "Жаргалан хотхон" 2, 49б, 49а, Модерн таун хотхон 25-байр, 24-р хороо, 107-р байр, 19-р хороо 27/1, 15/1, 15/2, 86, 87, 88, 96-р байр, 25-р хороо 703, 706, 714, 715, 719, 722, 725, 726, 727-р байр, нийт 26 байрны дээврийг тус тус засварлаж дууссан. 3-р хороо 20-р байрны дээвэр засварын ажлыг 2024-2025 он дамжуулан хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 19-р хороо 54Д байрны цахилгаан шатыг засварлаж дууссан. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 19-р хороо 15/1, 15/2-р байрны гадна цахилгааны шугамын засварын ажлын гүйцэтгэгчээр Рэйзинг пауэр ХХК шалгарч засварын ажлыг гүйцэтгэж байна. Ажлын явц 10%	100%
5.2.4 Орон сууцны барилгуудын ашиглалтын хугацаа дууссан гадна болон дотор шугам сүлжээний засвар шинэчлэлтийг холбогдох газартай хамтран зохион байгуулж, хэвийн найдвартай ажиллагааг хангана.	130	Шаардлагатай байршлуудад гадна болон дотор сүлжээний шинэчлэлтийг үргэлжлүүлнэ.	Шугам сүлжээний шинэчлэлтийн ажлыг хэрэгжүүлсэн байрны тоо		7 байршилд гадна болон дотор шугам сүлжээний засвар шинэчлэлтийн ажил хийнэ.	УТХО 4,010.0 НТХО 6,000.0 ДТ 443.7	2021-2024 онд 7 цэцэрлэг, 7 сургууль, 10 төсөвт байгууллага, нийтийн зориулалттай 20 байрны инженер хангамжийн шугам засварлаж шинэчлэх, шинэ хэрэглэгчээр холбох, дулааны 3-р цахилгаан станцаас эрчим хүчний яам хүртэлх 668 метр дулааны болон уурын хос шугам өргөтгөн шинэчлэх төсөл арга хэмжээ хэрэгжиж инженер хангамжийн шугам сүлжээний тасралтгүй хэвийн ажиллагааг хангасан. 2021 онд Буянт-Ухаа цогцолбор сургууль болон Усан спорт сургалтын төв ОНӨААТҮГ-ын гадна цэвэр ус, дулааны шугамыг бүрэн шинэчилж, ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангасан. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 29, 67, 71, 134 дүгээр цэцэрлэг, 7, 32, 41, 135 дугаар сургуулийн гадна дулаан, цэвэр усны шугамын засвар, бохирын шугам, сантехникийн засвар, 4, 7, 8 дугаар хорооны дулааны холигч насос, узель, бохирын худгийг засварлах, 16 дугаар хорооны нийтийн зориулалттай орон сууцны цахилгааны 140м урт хос кабел шугам татах ажлыг тус тус гүйцэтгүүлж хяналт тавьж ажилласан. 2022 онд Өвөлжилтийн бэлтгэл хүрээнд 26, 52, 89 дүгээр сургуулийн халаалтын шугам, дулааны узель, бохирын шугам засвар, 29, 134, 144 дүгээр цэцэрлэгийн сантехникийн засвар, хэрэглээний халуун усны шугамын ажил, сантехникийн хэрсэгсэл нийлүүлэх, Нийгмийн даатгалын хэлтсийн гадна дулаан болон цэвэр усны шугам солих ажил тус тус бүрэн хийгдэж дууссан. 2023 онд "Цэвэр агаар төсөл"-тэй хамтран дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжлтээр 6 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх төсөвт 6 байгууллагуудыг инженер хангамжийн төвлөрөөн системд холбох ажлыг хэрэгжүүлсэн. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 13, 14 дүгээр хороо, халаалтын зуухны хуучирч муудсан дулааны шугамыг хэсэгчлэн шинэчилж, өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 13 дугаар хороонд хэрэглэгчдийн дулааны салбар шугам болон 1-5 дугаар байрны барилгын доторх шугам хоолойн, халаах хэрэгсэл, тоноглолуудыг шинэчлэх ажил хийгдэж дууссан. 2024 онд Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 2 дугаар хорооны 28, 29, 30, 17, 21 дүгээр байрнуудын халуун усны 96 метр хос шугам татах, 3 дугаар хороо 51 дүгээр байрны халуун усны задарсан ялтсан дулаан солилцуур шинэчлэн солих, 54 дүгээр байрны халаалтын насос солих, 1,2,3 дугаар хороонд- 12А, 12В, МА51, Үйлчин 24, Цагдаа 27, Осиб 35А-р байрны халуун усны эргэлтийн насос шинэчлэн солих, МА51, НД52-р байрны хүйтэн усны өргөлтийн насос шинэчлэн солих ажлыг гүйцэтгэж хэвийн ажиллагааг хангасан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
5.3 Дэд бүтэц								
5.3.1. Дүүргийн авто замын ачааллыг бууруулах чиглэлээр шинээр авто зам барьж, хороолол доторх авто замд засвар, шинэчлэлт хийнэ.	131	Засварлах, өргөтгөх, шинээр тавих шаардлагатай замын судалгааг гарган авто замын ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Ашиглалтад оруулсан замын урт (км)	Дүүргийн 5, 16, 21-р хороонд 3.1 км авто зам тавих ажлын гэрээ байгуулагдан, ажил хэрэгжиж байна.	Зам өргөтгөх, нөхөөс хийх зэрэг засвар үйлчилгээ хийгдэж, шаардлагатай байршилд шинээр 9,1 км-ээс доошгүй авто зам тавина.	УТХО 4,191.4 НТХО 6008.4 ДТХО 15,983.2	<p>2021-2024 онд дүүргийн авто замын ачааллыг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр 26 байршилд 24.53 км урт авто зам ашиглалтад оруулсан бол 15 байршилд 17.7 км авто зам засвар шинэчлэлтийн төсөл арга хэмжээ хэрэгжүүлж аюулгүй байдлыг хангуулж, ашиглалтыг сайжруулсан.</p> <p>2021 онд 17 дугаар хороо Ривер хиллс хотхоноос Зайсангийн гудамж хүртэлх 1 км авто зам, 20 дугаар хороонд хэрэгжсэн Номин Юнайтед их дэлгүүрийн баруун талын авто замаас Б.Шаравын гудамж хүртэлх 0.8 км авто зам, 21 дүгээр хороо Буянт Ухаа 2 хорооллын урд 0.19 км авто зам, зогсоол нийт 3 байршилд 2 км урт зам тавигдсан байна. Мөн 1, 2, 11, 15, 17, 18, 19, 20, 23 дугаар хорооны нутаг дэвсгэр эвдрэлтэй авто замын 1468 м.кв талбайд нөхөөс хийж, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16 дугаар хороонд ус их хэмжээгээр тогтдог, зорчиход хүндрэлтэй гэр хорооллын 48 гудамж талбайг хусаж тэгшлэх, зохист найрлагатай дайргаар засварласан.</p> <p>2022 онд Дүүргийн төсвийн хөрөнгөөр 5-р хороо "Яармаг" худалдааны төвийн уулзвараас хойших 0.8 км авто зам, 21-р хорооны Иргэний нисэхийн ерөнхий газраас Буянт-Ухаа 2 хороолол хүртэлх 0,9 км авто зам, 16-р хороо Баруун сонсголонгийн гудамжнаас Тайнь 7-р гудамж дагуу Наадамчдын зам хүртэл 1,4 км авто зам, 23 дугаар хороо, /хотын захиргаа орчмын/ ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 1.7 км авто зам, 10 дугаар хороо Наадамчдын замаас "АГАПЕ" эмнэлгийн баруун тал гэр хороолол дундуур Буянт-Ухаа цогцолбор сургууль хүртэлх 1 км авто зам, 17 дугаар хороо Астра худалдааны төвөөс 60 дугаар байр хүртэлх 0,16 км авто зам, 20 дугаар хорооны нутаг дэвсгэр, Мишээл экспогийн баруун талаар 86, 89 дүгээр байр луу орох 0,28 км авто зам, 14 дүгээр хорооны "МТ" шатахуун түгээх станцын уулзвараас 14 дүгээр хорооны байр, 165 дугаар цэцэрлэг хүртэлх хатуу хучилттай 2.6 км авто зам нийт 8 байршилд 8.84 км хатуу хучилттай авто зам ашиглалтад орсон.</p> <p>2023 онд 11-р хорооны Зайсан тойруу, 0.81 км авто замын хэсэгчилсэн шинэчлэлтийн ажил, Рома хотхоны зүүн талд Тэнгэр рашааны гудамжийг Дүнжингаравын гудамжтай холбох 0.18 км туслах замын ажил, "Их тэнгэр цогцолбор"-ын баруун шалган нэвтрүүлэх цэгээс тусгай объект хүртэлх 0.43 км авто замын ажил, 16, 25-р хорооны Нисэхийн эцсийн автобусны буудлаас Сонсголонгийн төв зам хүртэлх 2.2 км авто зам, 17, 18-р хорооны Маршал таун хотхоноос Гэрлүг хотхон хүртэлх 0.3 км авто зам, 19-р хорооны 27 дугаар цэцэрлэгийн хойд уулзвараас Монгол нэхмэл ХХК хүртэл 0.07 км авто зам, 19-р хорооны Богд Жавзандамбын гудамжны 0.47 км авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлтийн ажил, 21-р хороо, "Буянт-Ухаа спортын ордон"-ын баруун хойд талд 0.5 км авто зам, 23-р хороо, Наадамчдын замаас Нэгдсэн эмнэлгийн уулзвар хүртэл 4 эгнээ 0.7 км авто зам, нийт 9 байршилд 5.56 км авто зам ашиглалтад орсон.</p> <p>2024 онд 3-р хорооны Чингисийн өргөн чөлөөнөөс баруун үйлдвэрийн гудамж хүртэлх нийт 2.2 км авто зам, 4-р хорооны наадамчдын авто замаас станцын зам хүртэлх 2.1 км авто зам, 8-р хорооны Чингисийн хүрээний авто замаас Эко ахмадын сувилал хүртэлх 1.7 км авто зам, 9-р хорооны төв замаас гэр хорооллын дундуур шинээр 0.46 км авто зам, 19-р хорооны Ээрмэлийн гудамжийг Туул гол гудамжтай холбох 0.64 км авто зам, 23-р хорооны Наадамчдын замаас Нүхтийн ам чиглэлийн 1.53 км авто зам, нийт 6 байршилд 8.13 км авто зам ашиглалтад орсон.</p> <p>9-р хорооны Баруун Сонсголонгийн гудамжнаас Буянт-Ухаа 23 дугаар гудамж дагуу Центр хүртэлх 0.6 км авто зам, 10-р хорооны "Морингийн 1 дүгээр гудамжнаас хойшоо 0.71 км авто зам, 12-р хорооны 121 дүгээр цэцэрлэг орчмын 1.09 км авто зам, 13-р хорооны Төв замаас 26 дугаар сургууль хүртэлх 0.35 авто зам, 16-р хорооны Тайнь 2 дугаар гудамжнаас Буянт-Ухаа 23 дугаар гудамж хүртэл 1км авто зам, 20-р хорооны Мишээл экспогийн баруун талд орон сууц хороолол доторх 0.4 км зам, "Мишээл экспогийн баруун талд орон сууц хороололруу орох 0.15 км зам, Чингисийн өргөн чөлөөнөөс туул голын гудамж хүртэлх 0,78 км авто зам, нийт 8 байршилд хэрэгжиж буй 5,08 км авто замын ажил 40-80 хувиний гүйцэтгэлтэй 2024-2025 онд он дамжин хэрэгжиж ашиглалтад орно.</p> <p>21-р хорооны Архивчдын гудамжны авто замын засвар, шинэчлэлт, 15-р хорооны Нийслэл хүрээ өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт, 2-р хорооны Тоовангийн гудамжны авто замын засвар шинэчлэлт, 3-р хорооны УБЦТС ТӨХК-ийн баруун талын авто замын засвар шинэчлэлт, 22-р хорооны ХААИС-ийн уулзвараас Яармагийн гүүр хүртэлх Богд уулын авто замын засвар, шинэчлэлт, 11-р хорооны Маршалын гүүрнээс Буган халиун хүртэлх авто замын засвар шинэчлэлт, 24-р хорооны Наадамчдын авто замын засвар шинэчлэлт урд хэсэг, Туул ривер хотхон орчмын зам талбайн засварын ажил, 1, 2-р хорооны Хороолол дундах авто зам засвар, шинэчлэлтийн ажил, 15, 17-р хорооны Хороолол дундах зам засвар, шинэчлэлтийн ажил, 19, 20-р хорооны Хороолол дундах зам засвар, шинэчлэлтийн ажил, 22-р хорооны ХААИС-ийн оюутны 1, 3-р барны урд талын авто замын засвар шинэчлэлт, нийт 15 байршилд 17,7 км авто замын засвар шинэчлэлт хийсэн.</p>	100%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биеэглэлийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
5.3.2 Төмөр бетон гүүрийн байгууламжийг улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барьж, шинэчлэх ажил хэрэгжүүлнэ.	132	Шинээр төмөр бетон гүүрийн байгууламжийн ажлыг гүйцэтгэлийн хувь	Шинээр төмөр бетон гүүрийн ажлын гүйцэтгэлийн хувь		Төмөр бетон гүүрийн байгууламжийн ажлыг үргэлжлүүлнэ.	УТХО 2,287.9 НТХО 109,946.5 ДТХО 9,477.5	2021-2024 онд Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8 гүүрэн байгууламжийн төсөл арга хэмжээ хэрэгжихээс 6 байршилд нийт 1271.1 метр урт төмөр бетон гүүр ашиглалтанд орж авто замын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлсэн бол дүүргийн төсвийн хөрөнгөөр 1 байршилд уулзварын барилгын ажил хэрэгжиж дуусах шатанд, 1 байршилд гүүрийн байгууламжийн ажил 70 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. 2021 онд Дүүргийн 12 дугаар хороонд байрлах Туул голын Сонгинын төмөр бетон 205.1 метр урт гүүр болон гүүрийн 2 талын авто замын иж бүрэн ажил, Шувуун фабрик-Сонгино чиглэлийн авто замын туул гол дээрх 256 метр урт төмөрбетон гүүрийн их засварын ажил бүрэн хийгдэж дууссан. Мөн Яармаг орчмын авто машины түжрэлийг бууруулах зорилгоор Наадамчдын авто замаас Энхтайваны өргөн чөлөө хүртэлх нийт 5.4 км авто зам, гүүрийн байгууламжийн ажил, Зайсангийн төмөр бетон гүүрийн өргөтгөл шинэчлэлтийн ажлыг нийслэлийн 2022 оны төсөвт тусуулахаар Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 06/483 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст санал хүргүүлсэн. 2023 онд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 11 дүгээр хороо "Зайсангийн төмөрбетон гүүрийн өргөтгөл, шинэчлэлт /225 метр/-ийн ажил"-ын хүрээнд гүүрийн барилга угсралтын ажил, 2 дугаар хороонд хэрэгжсэн "Дунд голын 60 метр урт, 2 эгнээ гүүрийн барилгын ажил"-ын барилга угсралтын ажил, 3 дугаар хороонд хэрэгжсэн Баруун үйлдвэрийн гудамжны 42 метр урт, 4 эгнээ төмөр бетон гүүрийн барилга угсралтын ажил дуусаж, зорчих хөдөлгөөнийг нээсэн. Мөн 12 дугаар хорооны Цагаан эргийн модон гүүрийг төмөр бетон гүүр болгон шинэчлэх ажлын зураг төсвийг гүйцэтгүүлж батлуулсан. 2024 онд Нийслэлийн төсвийн 77.8 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Наадамчдын авто замаас Энхтайвны өргөн чөлөө хүртэл 0.48 км төмөр бетон гүүр ашиглалтанд оруулсан. Дүүргийн төсвийн хөрөнгөөр оруулалтаар Нисэхийн тойргийг олон түвшинт уулзвар болгох ажлын нэгдүгээр үе шатны ажлын хүрээнд 4 замын уулварын суурь асфальт хучилт, тэмдэглэгээ хийгдэж дууссан. Уулзварын хөдөлгөөнийг түр нээхээр гэрлэн дохионы удирдлагын тохируулгын ажил хийгдэж байна. мөн 14 дүгээр хороонд хэрэгжих "Түргэний гол дээрх 33 метр урт төмөр бетон гүүр барих ажил"-ын гүйцэтгэгчээр "Тэргүүн саруул зам" ХХК шалгарч, гүүрийн суурь болон дам нурууны цутгалтын ажил хийгдэж ажлын явц 70%-тай үргэлжилж байна.	100%
5.3.3 Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан явган зорчигчийн гүүрэн болон нүхэн гарцыг авто зам дээгүүр барих ажлыг хэрэгжүүлнэ.	133	Наадамчдын авто зам дагуу 1-ээс доошгүй байршилд нүхэн болон гүүрэн гарц байгуулна.	Наадамчдын авто зам дагуу нүхэн гарцны тоо		Наадамчдын авто зам дагуу 1 нүхэн гарцыг ашиглалтад оруулна.	ДТ 3,155.0	2021 онд 1 байршилд гүйцэтгэгч компани шалгарч, 2 байршилд Нийслэлд санал хүргүүлсэн. 2023 онд Дүүргийн төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй 24 дүгээр хороо, Хүннү молл худалдааны төвийн урд "Наадамчдын авто замд 50.7 метр урт, 5.8 метр өргөнтэй явган хүний нүхэн гарц"-ны зорчих хэсгийн ханыг металл хавтангаар бүрж, дотор заслын ажил дууссан нэмэлтээр хяналтын 6 ширхэг камер суурилуулж, ашиглалтад оруулсан.	100%
5.3.4 Сургууль, цэцэрлэгийн гадна талбай болон орон сууцны хотхон доторх шороон хөрс бүхий талбайд авто зогсоолуудыг барьж, байгуулна.	134	Сургууль, цэцэрлэг болон орон сууцны гадна талбайн авто зогсоолыг шинэчлэн сайжруулна.	Шинээр ашиглалтад орсон авто зогсоолын тоо		8-аас доошгүй байршилд авто машины зогсоол байгуулсан байна.	НТХО 797.0 НОНХС 100.0 ДТХО 2314.0	2021-2024 онд нийслэл дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 25 байршилд 781 авто машины зогсоол байгуулж байгуулж хүртээмжийг нэмэгдүүлсэн. 2021 онд Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 10 дугаар хорооны орон сууцны хотхон дунд 20 машины зогсоол, дүүргийн төсвийн хөрөнгөөр 20 дугаар хорооны 43 дугаар байрны гадна талбайд 22 авто машины зогсоол, 20 дугаар хорооны Иргэдэд үйлчлэх төв байрны урд талд 25 авто машины зогсоол, нийт 3 байршилд 67 авто зогсоол ашиглалтад оруулсан. 2022 онд Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд зөвшөөрөлгүй барьсан гараашийн газар чөлөөлж, тохижуулах ажлын хүрээнд нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2 дугаар хорооны 65 дугаар цэцэрлэгийн баруун тал болон 29, 33 дугаар байрны дунд 45 машины авто зогсоол, Дүүргийн төсвийн хөрөнгөөр 1 дүгээр хороо 67 дугаар цэцэрлэгийн зүүн талд, 75 дугаар сургуулийн хойд талд, 8а байрны баруун талд, 15 дугаар сургуулийн зүүн талд, 10 дугаар хороо 60/1 дүгээр байр гадна талд нийт 7 байршилд 105 авто машины зогсоол байгуулсан. 2023 онд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 1 дүгээр хорооны 39 дүгээр байрны ард 500 м.кв талбайд 15 авто машины зогсоол, 11 дүгээр хорооны дугуй цагааны тохижилтын ажлын хүрээнд 1200 м.кв талбайд 36 авто зогсоол, дүүргийн төсвийн хөрөнгөөр 3 дугаар хорооны 4 дүгээр клиник сувиллын гадна 265 м.кв талбайд 10 авто машины зогсоол зогсоол, зам, 9 дүгээр хороо 134 дүгээр цэцэрлэгийн орчмын 694 м.кв талбайд орц, гарц бүхий авто зам, 11 авто машины зогсоол, 10 дугаар хорооны 60/2 дугаар байрны гадна 740.8 м.кв талбайд эко хавтан хучилттай 27 авто машины зогсоол, 61/2 байрны зүүн талд авто зам дагуу 313 м.кв талбайд асфальт бетонон хучилттай 9 авто машины зогсоол, 2023 онд нийт 6 байршилд 118 авто машины зогсоол шинээр ашиглалтад орсон. 2024 онд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 15 дугаар хороо Төв цэнгэлдэх хүрээлэнгийн зүүн хойд талд 241 авто машины зогсоол, дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023-2024 он дамжин хэрэгжүүлж буй 2, 3, 10, 19 дүгээр хороодын гарааш буулгасан 6 байршилд 63 авто машины зогсоол, 21 дүгээр хороо 290 дүгээр цэцэрлэгийн урд талбайд 130 авто машины зогсоол, 20 дугаар хороонд ашиглалтын шаардлага хангахгүй төр захиргааны байрыг буулгаж тохижилт хийх ажлын хүрээнд 57 авто машины зогсоол, нийт 9 байршилд 491 авто машины зогсоол шинээр байгуулсан.	100%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
5.3.5. Сул шороон хөрсийг зүлэгжүүлж, хатуу хучилттай болгон тоосжилтыг бууруулж, иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ.	135	Сул шороон хөрс бүхий талбайг хатуу хучилттай болгон, тохижилтын ажлыг хийж, гүйцэтгэнэ.	Тохижуулсан талбайн хэмжээ (м.кв)	15,653 м2 талбайг зүлэгжүүлж, 48,035 м2 талбайг цардмалжуулж хатуу, хучилттай болгосон.	50,000 м2 -аас багагүй сул шороон хөрс бүхий талбайг зүлэгжүүлнэ.	НТХО 688.7 ДТХО 572.9 ААНБ 180.0	2021-2024 онд улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө, хувийн хэвшлийн хөрөнгөөр болон дүүрэгт хэрэгжүүлсэн тохижилтын ажлын хүрээнд нийт 106,330 мкв талбайг зүлэгжүүлж, ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэн орчны тоосжилтыг бууруулсан. 2021 онд Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн хэмжээнд 16,944 м.кв талбайг зүлэгжүүлж, талбайн тоосжилтыг буурууллаа. 2022 онд Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төсвийн хөрөнгө оруулалтаар болон аж ахуйн нэгж байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 1, 2, 3, 4, 8, 11, 12, 15, 16, 19, 20, 21, 22 дугаар хороонд 46341.2 м.кв сул шороон хөрс бүхий талбайг шинээр зүлэгжүүлж, тоосжилтыг бууруулсан. 2023 онд Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 3, 5, 7, 12, 14, 20 дугаар хорооны 7 байршилд 2199,8 м.кв, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай гэрээт 8 байгууллага нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтын ажлын хүрээнд 13930 м.кв, хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 1, 2, 5, 11, 12, 13, 16, 21, 22, 24, 25 дугаар хорооны 36 аж ахуйн нэгж байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо 8063 м.кв, нийт сул шороон хөрс бүхий 24192.8 м.кв талбайг зүлэгжүүлсэн байна. 2024 онд 15 дугаар хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн гадна, 1 дүгээр хорооны 39 дүгээр байрны хойно, 3 дугаар хороонд Эрчим хүчний яамны зам дагуу 2852 м.кв талбай, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтран Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна талбай, Сурын талбай орчмын 11,000 м.кв талбай, Аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр 8 дугаар хороонд Нүхтийн зам дагуу 5000 м.кв сул шороон хөрс бүхий талбай, нийт 18852 м.кв талбайг зүлэгжүүлсэн.	100%
5.3.6 Стандартад нийцсэн дугуйн болон явган хүний замыг шинээр барьж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	136	Явган хүний замыг стандартад нийцүүлэн шинэчлэх болон шинээр явган хүн, дугуйн зам байгуулах замаар иргэдийн явган болон дугуйгаар зорчих хэсгийг сайжруулж, тоосжилтыг бууруулах арга хэмжээ авна.	Шинээр ашиглалтад оруулсан явган хүний зам, дугуйн замын урт (км)	2020 онд 2.5 км явган хүний зам, 1.6 км дугуйн зам ашиглалтад оруулсан.	10,1 км-ээс доошгүй талбайд явган хүн, дугуйн зам байгуулна.	ДТХО 3,673.0 ДОНХС 315.8	2021-2024 онд нийслэл, дүүрэг, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 65 байршилд 17,81 км урт явган зам, 10 байршилд 8,14 км урт дугуйн зам ашиглалтанд оруулж, 31 байршилд 8,54 км явган зам, 2 байршилд 1,81 км дугуйн зам засварлаж, өргөтгөн шинэчилж, иргэд зорчих зам талбайн хүртээмжийг нэмэгдүүлсэн. 2021 онд дүүргийн 2, 3, 4, 9, 11, 13, 14, 19, 20-р хороодод Нийт 13 байршилд нийслэлийн төсвийн хөрөнгөөр 1,460 м.кв, дүүргийн төсвийн хөрөнгөөр 9300 м.кв, нийт 10760 м.кв (6,3 км) талбайд явган зам, 2 байршилд 3360 м.кв (1,4 км) унадаг дугуйн зам хийгдэж иргэд зорчих зам талбайн хүртээмжийг нэмэгдүүлсэн. 2022 онд Нийслэл, дүүрэг, хувийн хэвшлийн оролцоотой нийт 42 байршилд 2720 м.кв (1,6 км) явган зам шинээр тавьж, 16 байршилд 1946,5 м.кв (1,14 км) явган замыг нөхөж засварлан, 1 байршилд 610 м.кв, 0,21 км дугуйн зам шинэчилж, 1 байршилд 0,44 км дугуйн зам шинээр ашиглалтанд оруулсан. 2023 онд Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 30327,19 мкв (12664,5 м урт) явган хүний зам талбайн засвар, шинэчлэх 11 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс 1, 2, 3, 11 дүгээр хорооны 14 байршлын 9224,1 м.кв (4,9 км) явган замын засвар, шинэчлэлтийн ажил бүрэн дууссан. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 22 дугаар хороо, "Ар зайсангийн гудамжнаас Дугуй цагаан хүртэлх уулын алхалтын замын утгах хэсгийн амралт зугаалгын бүсийн тохижилтын ажил"-ын хүрээнд 0.63 км урт (2990 м.кв) дугуйн зам, 1,5 км (2590 м.кв) явган хүний зам шинээр тавьж, ашиглалтад оруулсан. 2024 онд Нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар 9 байршилд (8,41 км) урт явган зам, 6 байршилд (5,67 км) урт дугуйн зам шинээр тавьж, 1 байршилд 2,5 км явган зам, 1 байршилд 1,6 км дугуйн зам засварлаж, өргөтгөн шинэчилсэн.	100%
5.3.7 Гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах, гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, нэгдсэн удирдлагын автомат системд холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	137	Хүчдэлийн уналттай болон гэрэл цахилгаангүй айл өрхийн судалгааг гарган холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттайгаар цахилгаан, эрчим хүчинд холбоно.	цахилгааны хүчдэл сайжруулсан байршлын тоо	11, 12 дугаар хороонд цахилгааны хүчдэл сайжруулсан.	Шаардлагатай байршилд цахилгааны хүчдэл сайжруулсан байна.	ДТХО 4,740.0	2021-2024 онд Улс, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 12, 13, 14-р хорооны 715 айл өрхийн цахилгааны хүчдэл сайжруулах, найдвартай эрчим хүчний эх үүсвэрт холбох ажлыг хэрэгжүүлсэн байна. 2021 онд дүүргийн алслагдсан хороодын хүчдэлийн уналттай болон гэрэл цахилгаангүй айл өрхийн судалгааг гарган, 12, 13, 14-р хороодод шаардлагатай байршлуудад дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар цахилгааны хүчдэл сайжруулах ажлын зураг төслийг гүйцэтгүүлж батлуулсан. 2022 онд дүүргийн төсвийн хөрөнгөөр 13-р 26 хэсгийн 21 өрх, 14-р хороо 1, 5-р хэсгийн 223 өрх, 14-р хорооны Өнзийт, Ар хөндлөн, 4, 7-р хэсгийн 151 өрх, улсын төсвийн хөрөнгөөр 14-р хороо Гавьжийн шанд хэсгийн 160 өрхийн цахилгааны хүчдэл сайжруулах ажил тус тус хэрэгжиж нийт 534 өрхийг цахилгаан эрчим хүчээр хангасан. 12-р хороо Хайрхан хэсэг Сонгино 27-р гудамжны айл өрхийн хүчдэлийн уналтыг сайжруулах ажлын зураг төсвийг "Чандмань хонгор групп" ХХК-аар гүйцэтгүүлж хүлээн авсан. 2023 онд 12-р хорооны Хайрхан хэсгийн 32 өрх цахилгааны хүчдэлийг сайжруулах, найдвартай эрчим хүчний эх үүсвэрт холбох ажил хэрэгжиж дууссан бол 13-р хорооны 4, 5, 6, 7-р хэсгийн 885 айл өрхийн "Цахилгааны хүчдэл сайжруулах зураг төсөл боловсруулагдаж байна. 2024 онд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 14-р хорооны Гавьжийн шанд хэсгийн 213 өрх, Ар хөндлөн хэсгийн 36 өрх нийт 249 өрхийг цахилгаанаар хангах ажил тус тус хэрэгжиж дууссан бол 13-р хорооны 380 орчим өрхийн цахилгааны хүчдэл сайжруулах, цахилгаан эрчим хүчээр хангах ажлын явц 80 хувь, 10, 12, 14-р хорооны 226 өрхийн цахилгааны хүчдэл сайжруулах, цахилгаан эрчим хүчээр хангах ажлын явц 10 хувьтай үргэлжилж байгаа бөгөөд 2024-2025 онд он дамжин хэрэгжинэ.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
5.4 Хоггүй Хан-Уул								
5.4.1 Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр "Хоггүй Хан-Уул" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	138	Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр "Хоггүй Хан-Уул" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	-	Хэрэгжилт 90-ээс доошгүй хувьд хүрсэн байна.		<p>2021-2024 онд Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр хэлэлцүүлэг 2, дахивар хог авах өдөрлөг 3, хог ангилан ялгах, холбогдох стандартыг танилцуулах чиглэлээр сургалт 3 нийт 8 удаагийн нөлөөллийн арга хэмжээнд 4408 иргэн хамруулснаас гадна дахивар боловсруулах үйлдвэртэй 234 аж ауйн нэгжийг холбон гэрээ байгуулж, дахивар хогоо тушааж хэвшүүлэх, 685 аж ауйн нэгжид орчны талбайн тохижилт цэвэрлэгээг тогтмол хийх 50м талбайг хариуцуулан өгөх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.</p> <p>2021 онд "Хоггүй Хан-Уул 2021" хэлэлцүүлгийг зохион байгуулан төрийн болон ТББ, ОУБ, СӨХ, аж ахуй нэгжийн төлөөлөл 40 хүн оролцсон. Иргэдийн хэрэглэхээ больсон хуучин хувцсыг хэрэгцээтэй байгаа хүмүүст хүргэх зорилгоор хуучин хувцас, гутал төвлөрүүлдэг гурван цэгийг ажиллуулж хэрэглэх боломжтой хувцас хэрэглэлийг ялгаж, хэрэгцээ шаардлагатай хүмүүст хүргэж ажилласан. Туул гол дагуу иргэдийн амарч, салхилдаг хэсгүүдийн 12 байршилд "Байгаль эх дэлхийгээ хайрлая, Хог бүү хая" анхааруулах самбарыг хийж байршуулсан.</p> <p>2022 онд Хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий 30 ширхэг хогийн сав, хог төвлөрүүлэх 13 ширхэг хогийн сав, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн хэрэгцээт газруудад байршуулсан байна. Хог ангилан ялгалтыг эрчимжүүлэх зорилгоор 4 удаагийн сургалт, өдөрлөгийг зохион байгуулж, 120 сууц өмчлөгчдийн холбоодын 200 гаруй иргэнийг оролцуулсан.Хогоо ангилдаг сууц өмчлөгчдийн холбоод 2021 онд 71 байсныг 2022 онд 85 болгож нэмэгдүүлсэн.</p> <p>2023 онд Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх гэрээг шинэчлэн дүүргийн нийт 1235 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулж, 685 ААНБ-ын тохижилт, цэвэрлэгээг хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын зураглалыг гэрээний хавсралтаар баталгаажуулж, Газар зүйн мэдээллийн систем (ArcGIS)-д бүртгэсэн.</p> <p>Дахивар хог хаягдал авах өдөрлөгийг 2 удаа зохион байгуулж, дахин ашиглах боломжтой 13 төрлийн нийт 4974 кг хог хаягдлыг цуглуулж, боловсруулах үйлдвэрүүдэд хүргэсэн. Хуванцар дахин боловсруулах үйлдвэр эрхлэгч "Ти эм эл" ХХК-тай хамтран дүүргийн 234 байгууллага, СӨХ гэрээ байгуулж, 54,214 кг хуванцарыг нийлүүлж, дахин боловсруулсан. Мөн "Өгөөмөр өдөр" арга хэмжээнд төр, хувийн хэвшлийн 50 аж ахуйн нэгж, байгууллагын 440 гаруй иргэд оролцож дахин ашиглах боломжтой 907 ширхэг (5 тн) эд зүйлсийг цуглуулж, зорилтот бүлгийн иргэдэд хүргүүлсэн.</p> <p>2024 онд Нийтийн аж ахуйн чиг үүрэг дүүрэгт шилжиж ирсэнээр нийт 4,225,209 м.кв талбайн цэвэрлэгээ үйлчилгээг 13 байгууллагад хариуцуулан, ажлын явц, гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. "Шинэ Хан-Уул" цэцэрлэгт хүрээлэнгийн талбайд "Дахивар авах явуулын станц"-г Түвшинсайхан төвтэй хамтран зохион байгуулж, 13 төрлийн 9 тонн хог хаягдлыг цуглуулж, дахин боловсруулах үйлдвэрүүдэд хүргүүлсэн. Өдөрлөгт нийт 3500 гаруй иргэд, 18 аж ахуй нэгж байгууллага дэмжиж оролцсон. Зам талбайн цэвэрлэгээ, хог тээвэрлэлт хариуцсан байгууллагуудын нийт албан хаагчдад хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг хангуулах , хог хаягдлын менежментийн бүлгийн хотын стандартыг танилцуулах сургалтыг хог тээврийн байгууллагуудын 210 ажилтан, албан хаагч хамрагдсан.</p>	90%
	139	Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулна.	Зохион байгуулсан бүх нийтийн их цэвэрлэгээний тоо	Дүүргийн хэмжээнд 10 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулсан.	40-өөс доошгүй удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулсан байна.	ДТХО 142.1		<p>2021-2024 онд "Хоггүй Хан-Уул 2021" аяны хүрээнд Бүх нийтийн их цэвэрлэгээг 43 удаа зохион байгуулж, 268-336 сууц өмчлөгчдийн холбоо, 3185-5894 аж ахуй нэгж байгууллага, 6,916-21768 ажилтан албан хаагч иргэдийг хамруулан 330174-5,721,809 м.кв талбайгаас 282.6-1227,2 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн байна.</p> <p>2021 онд Дүүргийн Засаг даргын 2021 оны А/37 дугаар захирамжийн дагуу "Хоггүй Хан-Уул 2021" аяны хүрээнд зохион байгуулсан 10 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 3185 аж ахуйн нэгж байгууллага, 268 СӨХ-ны 21768 ажилтан албан хаагч, иргэд оролцож, 330174 м.кв талбайгаас 282.6 тн хог хаягдлыг цэвэрлэсэн байна.</p> <p>2022 онд Дүүргийн Засаг даргын 2022 оны А/56 дугаар захирамжаар "Хоггүй Хан-Уул 2022" аян зохион байгуулж дүүргийн хэмжээнд 10 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж нийт 7947 аж ахуй нэгж байгууллага, 280 сууц өмчлөгчдийн холбоодын 24920 хүн оролцож, 863,876 м.кв талбайгаас 1227,2 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн байна.</p> <p>2023 онд Дүүргийн Засаг даргын 2023 оны А/54 дүгээр захирамжийн дагуу дүүргийн хэмжээнд 12 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, албад болон дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нийт 8125 аж ахуй нэгж байгууллага, 309 сууц өмчлөгчдийн холбоодын 15,600 хүн оролцож, 215,311 м.кв талбайгаас 451,8 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн.</p> <p>2021 онд "Хоггүй Хан-Уул 2024" аяны хүрээнд дүүргийн хэмжээнд 11 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, албад болон дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нийт 5894 аж ахуй нэгж байгууллага, 336 сууц өмчлөгчдийн холбоодын 6,916 хүн оролцож, давхардсан дүнгээр 5,721,809 м.кв талбайгаас 1053,3 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн.</p>

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
	140	Бохирдол ихтэй нийтийн эзэмшлийн гудамж, талбайг тогтмол ариутгаж халдваргүйжүүлж, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ авна.	Ариутгаж халдваргүйжүүлсэн талбайн хэмжээ (м.кв)	Бохирдол ихтэй нийтийн эзэмшлийн 126,854м2 гудамж, талбайг ариутгаж халдваргүйжүүлсэн.	Бохирдол ихтэй нийтийн эзэмшлийн 600,000м2 гудамж талбайг ариутгаж халдваргүйжүүлнэ.	НТХО 229.0 ДТ 419.4	2021-2024 онд нийт 1327464 мкв (132.7 га) талбайг ариутгаж халдваргүйжүүлсэн. 2021 онд давхардсан тоогоор нийт 694764 м.кв талбайд ариутгал хийсэн байна. 2022 онд нийт 158200 м.кв талбайг ариутгаж халдваргүйжүүлсэн. 2023 онд нийт 117500 мкв талбайг ариутгаж халдваргүйжүүлсэн. 2024 онд нийт 25 хороодын 78 байршлын 357,000 м.кв талбай, 11086 нүхэн жорлон, 5914 бохирын цооног ариутгаж, халдваргүйжүүлсэн.	100%
5.4.2 Хог хаягдлын тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын авто машины парк шинэчлэлийг үе шаттай хийж хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	141	Хог хаягдлын тээврийн машины парк шинэчлэлийг үе шаттай хийж хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Хог тээврийн машины тоо	Хог тээвэрлэлтийн 3 байгууллагад 32 хог тээврийн машин ажиллаж байна.	Хог тээврийн 22-оос доошгүй автомашин худалдаж авна.	ДТХО 13,660.4	2021-2024 онд хог тээврийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор хог тээврийн байгууллагуудад ашиглагдаж байсан ашиглалтын хугацаа дуусаж шаардлага хангахгүй болсон тээврийн хэрэгслүүдийг шинэчлэх хүрээнд нийт 47 хог тээврийн шинэ авто машин, тусгай зориулалтын 13 механизм, 13 зам цэвэрлэгээ үйлчилгээний авто машин, 99 ширхэг цэвэрлэгээний тоног төхөөрөмж, хэрэгслээр хангалт хийж хот нийтийн аж ахуйн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулла. 2021 онд нийслэлийн төсвийн хөрөнгөөр хог тээврийн 4 авто машинаар парк шинэчлэлт хийсэн. 2022 онд Дүүргийн төсвийн хөрөнгөөр Хьондай HD-72 маркийн 6 м3 хог шахаж ачиг зориулалтын 6, зам цэвэрлэгээ усалгааны хосолмол үйлдэлтэй 2, нийт 8 автомашины худалдан авалт хийгдсэн. 2023 онд Дүүргийн төсвийн хөрөнгөөр Хьондай HD78, HD170 маркийн 11 автомашин, Dong Feng XO маркын 5 ширхэг задгай тэвштэй хог тээврийн машин, нийт 16 авто машин худалдан авсан. 2024 онд Хог тээвэр, зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд дүүрэг, нийслэлийн төсвийн хөрөнгөөр нэмэлт тоноглол бүхий /цас хусах, давс бодис цацах/ 21 хог тээврийн авто машин, 9 зам талбай цэвэрлэгээ үйлчилгээний машин, олон үйлдэлт бага оврын ачигч авто машин техникийн худалдан авалт хийгдсэн. Мөн Дүүргийн төсвийн хөрөнгөөр 4 үйлдэлт ковш 12, экскаватор 1, зам цэвэрлэх, услах, шүүрдэх, ариутгаж хосолмол үйлдэлтэй том 2 машин, үлээгч төхөөрөмж 50 ширхэг, цахилгаан мотортой шүүрдэгч 27 ширхэг, бага оврын давс цацагч 15 ширхэг, замын нуух шүүрдэгч бага оврын 7 машин худалдаж авсан. Зам талбайн ажилчдын автобус 4, автокран 3, зам усалгаа, ариутгалын машин 3, нийт 10 машин механизм нийлүүлэгдэх шатанд байна.	100%
5.4.3 Гэр хорооллын айл өрхүүдийг үнс хадгалах, савтай болгох, ангилан ялгах, тусад нь тээвэрлэх ажлыг зохион байгуулна.	142	Гэр хорооллын айл өрхүүдийн үнсийг ангилан хадгалах, савтай болгох, үнсийг дахин боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.	Гэр хорооллын айл өрхүүдийг галлагаанаас гарсан үнсийг тусад нь хадгалах, ангилах савтай болгох ажлын гүйцэтгэлийн хувь	Ажлын хэсэг байгуулагдсан.	Гэр хорооллын айл өрхүүдийн үнсийг ангилан хадгалах, савтай болгох, үнсийг дахин боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох чиглэлээр хол-богдох байгуулла-гуудтай хамтарч ажиллана.	ДТХО 4.9	2021 онд 3000 айл өрхөд мэдээлэл тарааж, гэр хорооллын хороодын 500 өрх үнсээ тусад нь ангилж эхэлсэн. 2022 онд "Эрүүл мэнд, нийгмийн бодлогын хүрээлэн" ТББ-тай хамтран үнсийг тусд нь ангилах зөвлөмж бүхий 500 ширхэг уриалга, тараах материалыг гэр хорооллын айл өрхүүдэд тарааж мэдээлэл хүргэсэн. 2023 онд гэр хорооллын айл өрхүүдийн тусд нь ангилсан үнсийг дахин боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох чиглэлээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас хэрэгжүүлж байгаа үнс дахин боловсруулах үйлдвэр барих төсөлтэй хамтран ажиллахаар бэлтгэл ажил хангаж байна. 2024 онд Гэр хорооллын айл өрхүүдийг галлагаанаас гарсан үнсийг ангилан ялгах, угаарын хийн эрсдэлээс сэргийлэх зөвлөмжийг гэр хорооллын 500 айл өрхөд хүргүүлсэн.	30.0%
5.5 Инженерийн бэлтгэл арга хэмжээ								
5.5.1 Шинээр барих болон өргөтгөн шинэчлэх авто замын дагуу зам, талбайн борооны ус зайлуулах шугам сүлжээг барьж байгуулна.	143	Төсвийн хөрөнгөөр шинээр хийгдэх авто замыг борооны ус зайлуулах шугам сүлжээтэйгээр төлөвлөн хэрэгжүүлнэ.	Шинээр хийгдэх авто замын борооны ус зайлуулах шугамын ажлын хэрэгжилтийн хувь		Шаардлагатай байршилд ус зайлуулах суваг байгуулсан байна.	НТХО 2,659.7 НОНХС 80.0 ДТХО 719.8	2021-2024 онд 1, 3, 5, 8, 16, 17, 19, 20, 21 дугаар хороодын нутаг дэвсгэрт авто зам дагуу болон бусад 19 байршилд 13,18 км урт ус зайлуулах шугам угсрах ажил хийгдсэн. 2021 онд нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 17 дугаар хороонд Сэргээн засах клиник сувиллын зүүн урд талд борооны ус ихээр тогтдог байршилд үерийн ус зайлуулах суваг байгуулсан. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 5-р хороо "Яармаг" худалдааны төвийн уулзвараас хойших 0.8 км авто зам дагуу борооны ус зайлуулах суваг хийгдсэн. 2022 онд нийслэлийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 3 дугаар хороо Ажилчны гудамжнаас Яармагийн гүүр хүртэл 705 метр, 1 дүгээр хороо, Чимэд-Осоорын гудамжинд 199.5 метр авто замын ус зайлуулах шугамын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг хэрэгжүүлсэн. Мөн шинээр 17 дугаар хороо Ханхилс хотхоноос Зайсангийн гүүр хүртэл 1.0 км, 20 дугаар хороо Номин Юнайтедийн баруун талаар Б.Шаравын гудамж хүртэл 0.9 км, Ээрмэлийн гудамжны 0.4 км хатуу хучилттай авто зам, дүүргийн төсвийн хөрөнгөөр 21 дүгээр хороонд 3800 м.кв авто зам, зогсоолын ажлыг ус зайлуулах шугам сүлжээтэй гүйцэтгэсэн.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
							<p>2023 онд дүүргийн төсвийн хөрөнгөөр 16 дугаар хороо нисэхийн авто зам дагуу 762 урт метр "Борооны ус зайлуулах шугам сүлжээний угсралтын ажил, нисэхийн авто замын ус зайлуулах хуучин сувгийг далд шугам болгох ажлын хүрээнд 4 ширхэг шүүрт худаг гаргаж, ф300 мм-ийн голчтой 56 метр ган шугамыг угсрах, наадамчдын автозамын 430 метр урт ус зайлуулах шугам шинэчлэх, 3 дугаар хороо, Үйлдвэрийн гудамжны 497 метр урт ус зайлуулах шугам угсрах ажил тус тус хийгдсэн.</p> <p>2024 онд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 8-р хороо, Архивчдын гудамжинд авто замын борооны ус зайлуулах 0,423 км, 1-р хороо, Наран хотхон, Петровисын шатахуун түгээн станц орчмын авто замын борооны ус зайлуулах шугам, Энхтайваны гүүрэн доорх гаргалгаа шугамыг өргөтгөх ажил хийгдсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 19, 20-р хороо, Туул гол гудамжны 1.7 км авто замын засвар шинэчлэлтийн ажлын хүрээнд борооны ус зайлуулах шүүрт худгийн ажил хийгдсэн. 8-р хорооны "Чингисийн хүрээний авто замаас Эко ахмадын сувилал" хүртэлх авто замын 2 талаар 1 км урт далан, 20-р хорооны Мишээл эксплогийн баруун талд орон сууц хороолол доторх замын 0.23 км урт у зайлуулах суваг, 16-р хорооны Тайнь 2 дугаар гудамжнаас Буянт-Ухаа 23 дугаар гудамж хүртэл авто замын 0.29 км урт нийт 1.52км урт борооны ус зайлуулах далан хийгдсэн.</p>	
5.5.2 Үерийн хамгаалалтын сувгийг шинэчлэх болон шинээр барьж байгуулна.	144	Үер, усны аюулд өртдөг болон өртөх боломжтой бүсийн судалгааг гарган ус зайлуулах далан, сувгийг байгуулна.	Шаардлагатай байршилд байгуулсан ус зайлуулах сувгийн тоо		Шаардлагатай байршилд ус зайлуулах суваг байгуулсан байна.	НТХО 2,659.7 ДТХО 146.2	<p>2021-2024 онд 2, 7, 8, 9, 10, 12, 15, 16, 21, 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үер, усны аюулд өртөх эрсдэлтэй 20 байршилд 4780 метр далан, 2328 метр урт ус зайлуулах суваг барих, 51 шүүрт, 40 үзлэгийн худаг шинэчлэх, шинээр барих ажлыг хийж үерийн эрсдлийг бууруулсан.</p> <p>2021 онд Дүүргийн төсвийн хөрөнгөөр 9 дүгээр хороонд 114 дүгээр сургуулийн зүүн талд үерийн ус зайлуулах суваг байгуулсан. Геодези, усны барилга байгууламжийн газартай хамтарч 16 дугаар хороо, Наадамчдын зам дагуу 376 урт метр ф300 хуванцар хоолой, 69 урт метр ф400 ган хоолой, 11 ширхэг шүүрт худаг, 11 ширхэг үзлэгийн худгийг засварлан шинэчилж, нөхөн сэргээсэн.</p> <p>2022 онд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 8, 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт шинээр 1.8 км урт үерийн хамгаалалтын барилга байгууламж барих, 12 дугаар хороонд 180 урт метр Туул голын далан өндөрлөх, эргийн бэхлэгээ хийх ажил, 10 дугаар хороо 300 урт метр Нисэхийн ус зайлуулах сувгийг засварлан шинэчлэх зэрэг 4 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 7 хороо жаргалантын 17 дугаар гудамжинд туузан хашлага, авто машины орц гарц бүхий 300 урт метр ус зайлуулах сувгийг шинээр байгуулж, 2 талын шороон замыг хусаж, дайргаар засварласан.</p> <p>2023 онд Дүүргийн төсвийн хөрөнгөөр Нисэхийн авто зам дагуу 762 урт метр, 24-р хорооны Вива сити хорооллын ард үерийн даланг хүчитгэх ажлыг хэрэгжүүлсэн. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Жаргалантын амны үерийн далангийн ажлын үргэлжлэл 240 урт метр далангийн ажлыг гүйцэтгэн ашиглалтад оруулж, 2, 9, 10, 15 дугаар хороонд авто замын ус зайлуулах шугамын 12 худгийн тагийг нөхөж шинэчлэх, 3 дугаар хороо Үйлдвэрийн гудамжинд ф400 мм-ын голчтой хуванцар хоолой 440 урт метр, ф500 мм-ын голчтой ган хоолой 70 урт метр угсарч, шүүрт худаг 24 ширхэг, үзлэгийн худаг 14 ширхэг хийх, 21 дүгээр хороонд ф500 мм-ийн голчтой хуванцар хоолой 420 метр, ф600 мм-ийн голчтой ган хоолой 7 метр, ф300 мм-ийн голчтой хуванцар хоолой 48 урт метр, үзлэгийн худаг 15 ширхэг хийх, Нисэхийн замын ус зайлуулах хуучин сувгийг далд шугам болгох ажлын хүрээнд 4 ширхэг шүүрт худаг гаргаж, ф300 мм-ийн голчтой 56 урт метр ган шугам угсрах ажлыг тус тус хэрэгжүүлж, авто зам, явган хүний замын нөхөн сэргээлтийг бүрэн хийсэн.</p> <p>2024 онд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 3 байршилд нийт 2207 метр урт борооны ус зайлуулах суваг, далан байгуулсан. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 9 дүгээр хороонд 1004 м.куб үерийн ус чиглүүлэгч далан барих, 66 метр замын гадаргуугийн ус зайлуулах сувгийн төвш байрлуулах ажил, 146.2 сая төгрөгийн хөрөнгөөр 9 дүгээр хороо, Буянт-Ухаа 23 дугаар гудамжны 272 м урт ус зайлуулах сувгийн төвш байгуулсан.</p>	100%

Дүүргийн ЗДУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
5.5.3 Үерийн хамгаалалтын байгууламжийн хамгаалалтын бүсийг нарийвчлан тогтоож тус бүсэд байгаа айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудыг нүүлгэн шилжүүлж, хамгаалалтын бүсийн газрыг албажуулна.	145	Үерийн аюултай бүсэд өртсөн иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулна.	Үерийн аюултай бүсэд өртөж, газар чөлөөлсөн иргэн, хуулийн этгээдийн тоо	Үерийн аюултай бүсэд зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй буусан нийт 253 айл өрх, албан байгууллага.	Зөрчлийн тоо буурах, хуулийн хэрэгжилтийг хангана.		2021-2024 онд нутаг дэвсгэр дэх үерийн эрсдэлтэй бүсэд зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй амьдарч буй айл өрхийн судалгааг гаргаж, 28 айл өрхийг нүүлгэн шилжүүлж, "Улаанбаатар хотын ус хангамжийн баруун шинэ эх үүсвэр"-ийн трасст өртсөн 109 нэгж талбарыг бүрэн чөлөөлж, 5, 6, 8, 9, 10, 12, 13, 14 дүгээр хороодын 265 айл өрхүүдэд мэдэгдэх хуудас хүргүүлж, 12, 13, 14 дугаар хорооны 11 иргэнд гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн акт, дүгнэлт өгч, 25 нэгж талбарын эзэмших эрхийг хүчингүй болгосон байна. 2021 онд Хорооны нутаг дэвсгэр дэх үерийн эрсдэлтэй бүсэд зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй амьдарч буй 253 нэгж талбарын айл өрхүүдийн судалгаа гарган, зураг авалт хийн баталгаажуулж мэдээллийн сан үүсгэж Нийслэлийн газар зохион байгуулалтын алба болон Газар зохион байгуулалтын албаны Ерөнхий төлөвлөгөөг хийж буй "Газар дэлхий" ХХК болон "Геоботаник" ХХК-д хүргүүлсэн. 2022 онд дүүргийн нутаг дэвсгэрт газрын харилцаатай холбогдон гарч буй зөрчил маргааныг арилгах, таслан зогсоох 47 зөрчлийн дуудлага ирсэний дагуу газар дээр нь тухай бүр очиж зөрчлийг арилгасан. 2023 онд Усан сан бүхий газар, ундны усны эрүүл ахуйн хориглолтын бүсэд өртсөн дүүргийн 12 дугаар хороо Амралтын хэсгийн нийт 113 нэгж талбарын судалгааг шинэчлэн гаргаж, 2023 оны 19/108 дугаар албан бичгээр нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлж, дүүргийн Засаг даргын 2023 онд 15 нэгж талбарыг хүчингүй болгож, 22 дугаар хорооны туул голын эрэг дагуух үерийн эрсдэлтэй бүсэд зөвшөөрөлгүй буусан 28 айл өрхийг 10 дугаар хорооны нутаг дэвсгэр рүү нүүлгэн шилжүүлсэн. 2024 онд шар усны үерт өртөж болзошгүй 76 нэгж талбарын судалгааг 2024 оны 10-17/140 дугаар бичгээр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн. Үерийн эрсдэлтэй бүсэд зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй амьдарч байгаа 5, 6, 8, 9, 10, 12, 13, 14 дүгээр хороодын 265 айл өрхүүдэд мэдэгдэх хуудас хүргүүлж, 12, 13, 14 дугаар хорооны 11 иргэнд гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн акт, дүгнэлт өгч дүүргийн Засаг даргын А/544 дүгээр захирамжаар 10 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож, нийт 88 нэгж талбарын судалгааг шинэчлэн гаргаж, нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн. Үүнээс гадна "Улаанбаатар хотын ус хангамжийн баруун шинэ эх үүсвэр"-ийн трасст өртсөн 109 нэгж талбарыг бүрэн чөлөөлсөн.	90%
5.6 Усан хангамж, ариутгах татуурга								
5.6.1 Аж ахуйн нэгж, байгууллагуудыг хаягдал усаа цэвэршүүлэн дахин ашиглах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	146	Туул голын сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгож, гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллана.	Зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж байгууллагын тоо	5 аж ахуйн нэгж, байгууллагад хаягдал ус хаях зөвшөөрөл олгосон.	Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгож, хяналт тавьж ажиллана.		Дөрвөн жилийн хугацаанд нийт 17 аж ахуйн нэгжид хаягдал ус хаях зөвшөөрөл олгож, Усны газрын дүгнэлтийг үндэслэн "Дулааны 3 дугаар цахилгаан станц" ТӨХК-д хаягдал усны цэг тогтоож, хяналт тавин ажиллаж байна. 2021 онд 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар Туул голын сав газрын захиргаанаас 10 аж ахуйн нэгж байгууллагын "Хаягдал усны дүгнэлт" ирүүлснээс 2 аж ахуйн нэгжид хаягдал ус хаях зөвшөөрөл олгож, мэдээллийн санд бүртгэсэн. 2022 онд Туул голын сав газрын захиргаанаас ирүүлсэн "Хаягдал ус хаях" дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн дагуу 5 аж ахуй нэгж, 1 иргэнд ус хаях зөвшөөрөл шинээр олгож, гэрээ байгуулж, 1 аж ахуйн нэгж, байгууллагын зөвшөөрлийг сунгасан. Усны газрын дүгнэлтийг үндэслэн "Дулааны 3 дугаар цахилгаан станц" ТӨХК-д хаягдал усны цэг тогтоож, хяналт тавин ажиллаж байна. 2023 онд Туул голын сав газраас ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн 4 ХХК-д хаягдал ус хаях зөвшөөрөл олгож, гэрээ байгуулагдсан. 2024 онд Туул голын сав газрын дүгнэлтийг үндэслэн 5 аж ахуйн нэгжид хаягдал ус хаях зөвшөөрөл олгож, гэрээ байгуулсан.	100%
5.6.2 Ундны усны эх үүсвэрийн гүний худаг тоолуургүй айл өрх, аж ахуйн нэгжийг тоолууржуулж усны бодит хэрэглээг тооцно.	147	Холбогдох шатны байгууллагын дүгнэлтийг үндэслэн "Ус ашиглах зөвшөөрөл" олгож гэрээ байгуулж, хяналт тавих, усны мэдээллийн санд бүртгэнэ.	Зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж байгууллагын тоо	11 аж ахуйн нэгж, байгууллагад хаягдал ус ашиглах зөвшөөрөл олгосон.	Ус ашиглах зөвшөөрөл олгож, гэрээ байгуулж, мэдээллийн санд бүртгэж, хяналт тавьж ажиллана.		2021-2024 онд 16 аж ахуйн нэгж иргэнд ус ашиглах зөвшөөрөл олгон гэрээ байгуулсан. 2021 онд 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар Нийслэлийн байгаль орчны газраас 5 аж ахуйн нэгж байгууллагын "Ус ашиглах дүгнэлт" ирүүлснээс 2 аж ахуйн нэгжид ус ашиглах зөвшөөрөл олгож, гэрээ байгуулж, мэдээллийн санд бүртгэсэн. 2022 онд Нийслэлийн Байгаль орчны газраас ирүүлсэн "Ус ашиглуулах дүгнэлт"-ийг үндэслэн 6 аж ахуй нэгжид дүүргийн Засаг даргын захирамжаар ус ашиглах зөвшөөрөл олгож, усны мэдээллийн санд бүртгэн хяналт тавьж ажиллаж байна. 2023 онд Нийслэлийн Байгаль орчны газраас ирүүлсэн "Ус ашиглуулах дүгнэлт"-ийг үндэслэн 2 аж ахуй нэгжид ус ашиглах зөвшөөрөл олгон гэрээ байгуулагдсан. 2024 онд Нийслэлийн байгаль орчны газрын ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн 6 аж ахуйн нэгж, иргэнд ус ашиглах зөвшөөрөл олгон гэрээ байгуулагдсан.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биеэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
5.6.3 Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөн шинэчилнэ.	148	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөн ажлыг үргэлжлүүлнэ.	Үлий ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлийн хувь	Зайсан орчмын сууцнуудыг усан хангамжид холбох ажлын явц 30%-тай.	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх ажлыг үргэлжлүүлнэ.	УТХО 19,907.6 НТХО 3,100.0 НОНХС 300.0 ДТХО 240.0	<p>2021-2024 онд 21 дүгээр хороо, Буянт-Ухаа 2 хорооол орчим, 10 дугаар хороонд хэрэгжих Залуус-1 хорооллын ариутгах татуургын нийт 300-500 мм-ийн голчтой 3 км урт гол шугамын угсралтын ажил, Яармагийн 4-8 дугаар хорооны нутаг дэвсгэрийг дамнансан 600 мм-ийн голчтой 3.4 км урт ариутгах татуургын гол шугам, Яармаг орчмын хотхонуудад хэрэглэгдэж буй цэвэр усны шугам шинэчлэлтийн ажил тус тус хийгдэж дууссан бол Зайсан орчмын хотхонуудын усан хангамжийн ажлын 1 дүгээр ээлжийн ажлын явц 90 хувь, 2 дугаар ээлжийн ажлын явц 40 хувийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>2022 онд 21 дүгээр хороо Буянт Ухаа-2 хороолол орчмын ариутгах татуургын гол шугамын 2 дугаар ээлжийн ажлын гүйцэтгэгчээр "Жаргалант дулаан" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ариутгах татуургын 400, 500 мм-ийн голчтой 1,4 км шугамын ажил хийгдсэн.</p> <p>2023 онд 4, 5, 6, 7, 8 дугаар хорооны нутаг дэвсгэрийг дамнансан 600 мм-ийн голчтой 3.4 км ариутгах татуургын шугам, насос станцын угсралтын II ээлжийн ажил хийгдэж дууссан.</p> <p>2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021-2025 онд он дамжин хэрэгжиж буй Зайсангийн усан хангамжийг төвлөрсөн системд холбох 1-р ээлжийн ажлын гүйцэтгэгчээр "Бумбод" ХХК ажиллаж байгаа бөгөөд 4.8 км урт шугам угсралт хийхээс 219 мм-ийн голчтой 4.6 км урт шугам сүлжээний угсралт, трассын дагуух цахилгааны кабель шугам шилжүүлэх, холбооны шилэн кабель, мөн 1x1000М3 усан сангийн бетоны ажлууд хийгдсэн. Үлдэгдэл шугамын угсралтын ажил хийгдэж байгаа бөгөөд, усан сангийн харуулын байрны ажил болон Хууль зүйн яамны ажилчдын орон сууцны хорооллын хашаанд байрлах цэвэр усны шугам барилгын суурьт орсон тул зөвж шилжүүлэх ажил хийгдэхээр хүлээгдэж байна. 2-р ээлжийн буюу "Баткомплект" ХХК-ийн гүйцэтгэж буй 160-315 мм-ийн голчтой Усан сангийн тэжээх гол шугам, салбар шугам 4711.6 метр цэвэр усны шугамын ажил хийхээс 1056 метр шугамын угсралт, 1x1000м3 усан сангийн байгууламжийн суурь, шал, ханын цутгалт хийгдсэн. Насос станцын барилгын ажил 50 хувьтай хэрэгжиж байна. Үлдэгдэл 3655 метр салбар цэвэр усны шугамын угсралт, насос станцын тоног төхөөрөмжийн суурилуулалтын ажил хийгдэнэ.</p> <p>21 дүгээр хороо, Морингийн даваа, Залуус-1 орон сууцны хорооллын шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчээр "Одкон холдинг" ХХК шалгарсан бөгөөд ф300 мм 1.6 км шугам хоолой тавигдсан. Үүнээс гадна ф400 мм голчтой 1.8 км урт шугам хоолой угсрахаас 1.65 км шугам хийгдсэн бөгөөд үлдэгдэл 150 метр шугам авто замын сэтгэлгээний зөвшөөрөл гарахгүй шалтгаанаар ажил түр зогсоод байна. Ус дулаан дамжуулах төвийн барилга угсралтын ажил дууссан.</p> <p>"Дүүргийн 4,5,6,7,10,16,23,24-р хороо, Яармаг орчмын нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон хотхонуудад хэрэглэгдэж буй цэвэр усны шугам шинэчлэлтийн ажил" төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр УСУГ ОНӨААТҮГ шалгарч гэрээт ажлыг нийт 80 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэсэн. Яармаг орчмын орон сууцны хорооллуудыг усаар хангаж байгаа түгээх горимд ажилладаг ф219-300мм голчтой ган шугамыг унд ахуйн усны зориулалттай HDPE, PE100 маркийн полиэтилен хуванцар ф225-315 мм голчтой 4,8 км (4844 метр) урттай шугамаар бүрэн шинэчлэж ажиллагаанд оруулсан. Шинээр угсралт хийсэн шугам сүлжээний контакт бариулах /72 цаг/ ажилд Яармаг, Буянт-Ухаа, Үйлдвэрийн эх үүсвэрээс нийтдээ 5046 л хлорын уссмалыг татан төвлөрүүлж ариутгал хийсний дараа шинэ шугамын 3 цэгээс авсан дээжинд "Усны төв лаборатори"-иос хими-бактериологийн шинжилгээ хийж дээжний хариу MNS:0900-2018 "Ундны ус"-ны ерөнхий шаардлагыг хангасан тул цэвэр усны шугамыг 2024 оны 11 сарын 25-ны өдөр байнгын ажиллагаанд залгасан. Шинэчлэлийн ажлын хүрээнд Шинэ өргөө, Вива сити, Ханбогд чиглэлийн ф219-250мм голчтой шугамыг ф315мм голчтой болгож өргөтгөсөн тул шугам сүлжээний хүчин чадал 30% -иар нэмэгдсэн.</p>	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
5.6.4 Зөврийн ус түгээх байруудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбож, ухаалаг төхөөрөмж суурилуулна.	149	Смарт ажиллагаатай худаг байгуулна.	Шинээр ухаалаг төхөөрөмж суурилуулсан хугийн тоо	-	7-оос доошгүй смарт ажиллагаатай хугийг байгуулна.	НТХО 300.0 НОНХС 107.0 ДТХО 590.0	2021-2024 онд 9, 10, 11, 12, 13, 14, дүгээр хороодод 13 ус түгээх худаг барих, 16 худгийн барилгыг засварлаж, ухаалаг төхөөрөмж суурилуулах төсөл арга хэмжээг хэрэгжүүлж хэрэглэгчдийг ундны усаар хүртээмжтэй тасралтгүй хангах боломжийг бүрдүүлсэн. 2021 онд Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 12, 13 дугаар хороонд 2 гүний худаг баригдсан. 2022-2023 онд дүүргийн төсвийн хөрөнгөөр 11 дүгээр хороонд 1 худаг, 9 дүгээр хороонд 1 смарт худаг, 13 дугаар хороонд 1 худаг, 14 дүгээр хороонд 2 худаг нийт 5 гүний худгийн барилга угсралтын ажил дууссан. 2024 онд Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 6 гүний худаг шинээр байгуулж, 16 гүний худагт ухаалаг төхөөрөмж суурилуулж смарт ажиллагаатай болгох төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд; 1. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Шинээр гүний худаг байгуулах ажил (13, 14 дүгээр хороо)" төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр "Баялаг говь" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Гүний худгийн өрөмдлөгийн ажил хийгдэж байна. Дээрх төсөл арга хэмжээний хүрээнд 13, 14 дүгээр хороонд 6 байршилд шинээр смарт ажиллагаатай гүний худаг ашиглалтад оруулна. Ажлын явц 70 хувь. 2. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 10, 12, 13, 14 дүгээр хороонд нийт 11 гүний худгийн барилгын гадна, дотор засвар, ухаалаг төхөөрөмж суурилуулах ажлыг "Эйч Ти Эл" ХХК гүйцэтгэж дууссан. Комисс ажиллах шатанд байна. 3. Дүүргийн төсвийн 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх "Гүний худгуудыг смарт ажиллагаатай болгох, засварлах ажил (12, 13 дугаар хороо) төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр Баялаг говь ХХК ажиллаж 5 худагт засварын ажил хийж, смарт ажиллагаатай болгох ажлыг хийж гүйцэтгэсэн. Комисс ажиллах шатанд байна.	100%
5.6.5 Усны эх үүсвэр, цэвэрлэх байгууламж болон шугам сүлжээ, барилга байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоож баталгаажуулна.	150	Усны эх үүсвэр, цэвэрлэх байгууламж болон шугам сүлжээ, барилга байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд өртсөн иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулна.	Усны эх үүсвэр, цэвэрлэх байгууламж болон шугам сүлжээ, барилга байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд өртсөн иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж, газар чөлөөлөх ажлын гүйцэтгэлийн хувь	Яармагийн гүүрнээс маршалын гүүр хүртэлх онцгой хамгаалалтын бүсэд өртсөн 50 нэгж талбар, "Улаанбаатар хотын ус хангамжийн баруун шинэ эх үүсвэр"-ийн трасст өртсөн 109 нэгж талбарын судалгааг гаргасан.	Зөрчлийн тоо буурах, хуулийн хэрэгжилтийг хангах.		2021-2024 онд дүүргийн нутаг дэвсгэрт байрлах усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс /50м-д газар эзэмшиж, ашиглаж буй 259 иргэн, хуулийн этгээдийн судалгааг гарган холбогдох газарт хүргүүлж, 12, 13, 14, 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 176 нэгж талбарыг бүрэн чөлөөлж зөрчлийг бууруулсан байна. 2021 онд дүүргийн нутаг дэвсгэрт байрлах усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс /50м-д газар эзэмшиж, ашиглаж буй 259 иргэн, хуулийн этгээдийн судалгааг Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газарт 2021.05.17-ны өдрийн 16/674 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. 2023 онд "Улаанбаатар хотын ус хангамжийн баруун шинэ эх үүсвэр" бүтээн байгуулалтын ажлын трасст өртсөн тус дүүргийн 13, 12 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 109 нэгж талбарыг бүрэн чөлөөлсөн. Ундны усны эх үүсвэрийн хориглолтын бүс, усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсэд дүүргийн Засаг даргын захиралжаар олгогдсон 12, 13, 14 дүгээр хороодын нутаг дэвсгэр дэх 29 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг дүүргийн Засаг даргын 2023 оны А/507 дугаар захирамжаар хүчингүй болгож, 22 хорооны нутаг дэвсгэр Туул голын хамгаалалтын 50 метрийн бүсэд зөвшөөрөлгүй буусан 28 айл өрхийг 10 дугаар хорооны нутаг дэвсгэр рүү нүүлгэн шилжүүлж зөрчлийг арилгасан. 2024 онд ундны усны эх үүсвэрийн хориглолтын бүс, усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсэд орсон, Газрын тухай хуулийн 40.1.6 заалтаар хүчингүй болгох 41 нэгж талбар, газрын хэлбэр хэмжээнд өөрчлөлт оруулах 6 нэгж талбар тогтоогдсон бөгөөд үүнээс 12 дугаар хороонд байрлах 15 нэгж талбарын өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нарт мэдэгдэх хуудсыг холбогдох журмын дагуу хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын А/544 дүгээр захирамжаар усны сан бүхий газарт газар эзэмших эрх олгогдож газрын тухай хуулийн 40.1.6 дахь заалтын дагуу газраа ашиглаагүй 10 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон.	100%

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2020-2021	2021-2024 он		2021-2024 оны хэрэгжилт, үр дүн	Биелэлтийн хувь
					Зорилтот түвшин	Төсөв (сая.төг)		
5.6.6 Цэвэр, бохир усны зөөврийн болон шугам сүлжээний засвар үйлчилгээний машин механизм аргаар хангалттай засвар үйлчилгээнд зарцуулах хугацааг багасгаж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.	151	Цэвэр, бохир усны зөөврийн болон шугам сүлжээний засвар үйлчилгээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлийн хувь	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлээр.	ДТХО 901.3	2021-2024 онд 7 цэцэрлэг, 7 сургууль, 10 төсөвт байгууллага, нийтийн зориулалттай 19 байрны инженер хангамжийн шугам засварлаж шинэчлэх, шинэ хэрэглэгчээр холбох, дулааны 3-р цахилгаан станцаас эрчим хүчний яам хүртэлх 668 метр дулааны болон уурын хос шугам өргөтгөн шинэчлэх төсөл арга хэмжээ хэрэгжиж инженер хангамжийн шугам сүлжээний тасралтгүй хэвийн ажиллагааг хангасан. 2021 онд Буянт-Ухаа цогцолбор сургууль болон Усан спорт сургалтын төв ОНӨААТҮГ-ын гадна цэвэр ус, дулааны шугамыг бүрэн шинэчилж, ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангасан. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 29, 67, 71, 134 дүгээр цэцэрлэг, 7, 32, 41, 135 дугаар сургуулийн гадна дулаан, цэвэр усны шугамын засвар, бохирын шугам, сантехникийн засвар, 4, 7, 8 дугаар хорооны дулааны холигч насос, уэль, бохирын худгийг засварлах, 13 дугаар хорооны 26 хэсгийн худгийн цахилгааны засварын ажлыг тус тус гүйцэтгүүлж хяналт тавьж ажилласан. 2022 онд Өвөлжилтийн бэлтгэл хүрээнд 26, 52, 89 дүгээр сургуулийн халаалтын шугам, дулааны уэль, бохирын шугам засвар, 29, 134, 144 дүгээр цэцэрлэгийн сантехникийн засвар, хэрэглээний халуун усны шугамын ажил, сантехникийн хэрэгсэл нийлүүлэх, Нийгмийн даатгалын хэлтсийн гадна дулаан болон цэвэр усны шугам солих ажил тус тус бүрэн хийгдэж дууссан. 2023 онд Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн санхүүжилтээр 3 дугаар хороо, дулааны 3 дугаар цахилгаан станцаас ТК -1699 цэг хүртэлх насжилтын хугацаа дууссан 667.8 метр дулаан болон уурын хос шугамыг 2ф1000 мм голчтой болгож өргөтгөн шинэчлэх ажил хийгдэж дууссан. Цэвэр агаар төсөл-тэй хамтран дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 6 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх төсөвт 6 байгууллагуудыг инженер хангамжийн төвлөрсөн системд холбох ажлыг хэрэгжүүлсэн. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 13, 14 дүгээр хороо, халаалтын зуухны хуучирч муудсан дулааны шугамыг хэсэгчлэн шинэчилж, өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 13 дугаар хороонд хэрэглэгчдийн дулааны салбар шугам болон 1-5 дугаар байрны барилгын доторх шугам хоолойн, халаах хэрэгсэл, тоноглолуудыг шинэчлэх ажил хийгдэж дууссан. 2024 онд Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 2 дугаар хорооны 28, 29, 30, 17, 21 дүгээр байрнуудын халуун усны 96 метр хос шугам татах, 3 дугаар хороо 51 дүгээр байрны халуун усны задарсан ялтсан дулаан солилцуур шинэчлэн солих, 54 дүгээр байрны халаалтын насос солих, 1,2,3 дугаар хороонд- 12А, 12В, МА51, Үйлчин 24, Цагдаа 27, Осиб 35А-р байрны халуун усны эргэлтийн насос шинэчлэн солих, МА51, НД52-р байны хүйтэн усны өргөлтийн насос шинэчлэн солих ажлыг гүйцэтгэж хэвийн ажиллагааг хангасан.	100%
ТАВ. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ - ХОРОО БҮРТ ШААРДАГДАХ ТӨСӨВ						243,693.2		94%
БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ						503,521.8		91%

ТАНИЛЦСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ З.БУЯНТ

ХЯНАСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ Л.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛЖ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.АЛДАРМАА

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ "ЭКО-ЭРҮҮЛ ДҮҮРЭГ" ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

2024 оны 12 дугаар сарын 17

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Хариуцагч байгууллага	Суурь түвшин 2020 он	Зорилтот түвшин 2020-2024	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хэрэгжилт				Хүрсэн түвшин	Хэргэжилтийн хувь
							2021	2022	2023	2024		
НЭГ. ЭКО ДҮҮРЭГ – НОГООН ХӨГЖИЛ												
1.1. Ногоон байгууламж												
1.1.1 Нийтийн эзэмшлийн гудамж талбайд эко бичил цэцэрлэгт хүрээлэнг бий болгож иргэд олон нийт чөлөөт цагаа ая тухтай өнгөрөөх амралт зугаалгын бүсийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.												
1	Байгуулсан ногоон байгууламж тохижилт бүхий бичил цэцэрлэгт хүрээлэн	тоо	ТГУХ, ТНААХ	8	16	2020 оны суурь түвшин /өссөн дүнгээр/	9	10	16	22	22	100%
2	Байгуулсан тоглоомын талбай	тоо	ТГУХ, ТНААХ	168	185	2020 оны суурь түвшин /өссөн дүнгээр/	172	186	198	206	206	100%
3	Зохион байгуулсан аян	тоо	ТНААХ	1	4	2020 оны суурь түвшин	1	1	1	1	4	100%
4	Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн мэдээллийн сан үүсгэж, ногоон байгууламжийг тоолж, бүртгэх ажлын хувь	хувь	ТНААХ	-	95	-	-	-	100%	70%	70%	70%
1.1.2 Туул, Дунд голыг түшиглэн иргэд 4 улирлын турш амарч, зугаалах зориулалт бүхий тохилог орчныг бүрдүүлнэ.												
5	Шинээр байгуулсан иргэдийн амарч, зугаалах бүсийн тоо	тоо	ТГУХ, ТНААХ	3	6	2020 оны суурь түвшин /өссөн дүнгээр/	4	6	8	9	9	90%
1.1.3 Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд мод тарих, ногоон байгууламж байгуулахыг дэмжих, "Эко ногоон дүүрэг" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.												
6	Дэд хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжүүлсэн хувь	хувь	ТНААХ	-	90		10	30	80%	90%	90%	100%
7	Шинээр тарих бут, сөөг, мод, тоо	тоо	ТНААХ	21841	80000	2020 оны суурь түвшин	103334	260361	75424	206419	645538	100%
8	Үрслүүлсэн цэцэг, тоо	тоо	ТНААХ	149100	800000	2020 оны суурь түвшин	388,822	269319	479620	478730	1616491	100%
1.2. Агаар, орчны бохирдол												
1.2.1 Гэр хорооллын айл, өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангаж, агаарын бохирдлыг бууруулна.												
9	Байгуулсан хангамжийн бааз, тоо	тоо	ТНААХ	3	3	2020 оны суурь түвшин	1	1	1	1	1	50%
10	Байгуулсан борлуулалтын цэг, тоо	тоо	ТНААХ	57	53	2020 оны суурь түвшин	60	53	50	45	52	98%
1.2.2 Төрийн өмчийн халаалтын зуухнуудыг үе шаттайгаар төвлөрсөн дулаанд холбоно.												
11	Төвлөрсөн дулаанд холбогдоогүй халаалтын зуухны тоо	тоо	ТГУХ, ТНААХ	11	4	2020 оны суурь түвшин /буурсан дүнгээр/	6	6	5	1	1	100%
1.2.3 Агаарын бохирдлын эх үүсвэр, хор уршиг, дэвшилтэт техник технологи, ногоон амьдралын хэв маягийн талаар танин мэдүүлэх, зөв дадал хэвшилд сургах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, зэрэг мэдээлэл сурталчилгааны ажил зохион байгуулна.												
12	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	тоо	ТНААХ	1	8	2020 оны суурь түвшин	3	2	3	1	9	100%
13	"Орчны бохирдлын эх үүсвэрийн мэдээллийн сан бүрдүүлж, зохион байгуулсан тооллого, тоо (2020 онд Ердийн галлагаатай 3-15 кВт хүчин чадалтай 12552 зуухыг тоолсон)	тоо	ТНААХ	1	4	2020 оны суурь түвшин	1	1	1	1	4	100%
14	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	тоо	ТНААХ	6	8	2020 оны суурь түвшин	3	2	3	3	11	90%
15	Хамрагдсан өрх, тоо	тоо	ТНААХ	17464	16350	2020 оны суурь түвшин	17171	16000	17000	15348	16380	100%
1.2.4 Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.												
16	Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо	тоо	ТНААХ	350	3000	2020 оны суурь түвшин /өссөн дүнгээр/	1000	1304	1523	1828	1828	70%
17	Ариутгаж халдваргүйжүүлсэн нүхэн жорлон, бохирын цооногийн тоо	тоо	ТНААХ	21538	22195	2020 оны суурь түвшин	22195	16050	17831	17000	18269	80%
1.3 Хүнс, хөдөө аж ахуй, инноваци												

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Хариуцагч байгууллага	Суурь түвшин 2020 он	Зорилтот түвшин 2020-2024	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хэрэгжилт				Хүрсэн түвшин	Хэргэжилтийн хувь
							2021	2022	2023	2024		
1.3.1 Дүүргийн ерхийн тариалан эрхлэгчдийг дэмжих "Эко хүлэмж" арга хэмжээг хэрэгжүүлнэ.												
18	Нэмэгдсэн тарvas тариалсан хүлэмжийн талбайн хэмжээ, га	га	ХҮХҮХ, ЖДҮДТ	0.3	1.3	2020 оны суурь түвшин /өссөн дүнгээр/	0.91	2.8	4.8	4.5	100%	
19	Сургалтад хамрагдсан газар тариалан эрхлэгч ААН, иргэдийн тоо	тоо	ХҮХҮХ, ЖДҮДТ	20	90	2020 оны суурь түвшин	65	157	150	117	489	100%
20	Үзэсгэлэн худалдаанд хамрагдсан газар тариалан эрхлэгч иргэдийн тоо	тоо	ХҮХҮХ, ЖДҮДТ	20	80	2020 оны суурь түвшин	23	144	115	20	302	100%
1.3.2 Газар тариалан эрхлэгчдэд экологийн цэвэр бордоо ашиглах, экологийн цэвэр тариалан эрхлэхэд нь мэргэжлийн дэмжлэг үзүүлэн "Хан-Уулд тариалав" брэнд бий болгоно.												
21	Брэнд бүтээгдэхүүний тоо	тоо	ХҮХҮХ, ЖДҮДТ	-	15	2020 оны суурь түвшин	2	6	5	2	15	100%
